



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГААНЫ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)



- ◇ **Эдийн засгийн бодлого**
- ◇ **Нийгмийн бодлого**

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

DDC
328015
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (IX боть, 2011)
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор:

Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор:

Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Г. Чулуун, Б. Ариунжаргал

ISBN 978-99929-895-6-4

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

Судалгааны эмхтгэл - IX боть

УИХ -ЫН 2011 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

УДИРТГАЛ ХЭСЭГ

- **ӨМНӨХ ҮГ** 5
- **Бодлогын судалгаа ба бодлогын шинжилгээ** 7
*Ц. Норовдондог (Ph.D),
Ц. Болормаа, О. Нарантуяа*

1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

- 1.1. **Төсвийн дүн шинжилгээ, хяналтын чиг үүрэг бүхий парламент дахь бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи харьцуулсан судалгаа** 30
*Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ, Г. Гэрэл,
О. Нарантуяа, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*
- 1.2. **Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага, экспортыг дэмжих бодлогын судалгаа** 56
*Г. Алтан - Оч (Ph.D), Б. Буяндэлгэр, С. Дорждагва,
Б. Ариунжаргал*
- 1.3. **Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль ба архи, согтууруулах ундааны худалдаа, архидан согтуурахтай тэмцэх асуудлаархи судалгаа, бусад орны туршлага** 90
*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Ц. Батбаяр
Г. Билгээ, Г. Гэрэл, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*
- 1.4. **Монгол Улсад импортоор орж ирж буй гол нэрийн бараа, бүтээгдэхүүний талаархи лавлагаа мэдээлэл (2005 - 2011)** 139
Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа
- 1.5. **Монгол Улсын макро эдийн засгийн 2011 оны эхний хагас жилийн тойм** 149
*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж,
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*
- 1.6. **Монгол Улсын хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарлын судалгаа, дүн шинжилгээ** 161
*Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг,
Ц. Элбэгзаяа*

2. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

- 2.1 **Үйлдвэрлэл, үйлчилгээний буюу мэргэшлийн холбоодын эрхзүйн зохицуулалтын талаархи ХБНГУ -ын туршлага, харьцуулсан судалгаа** 180
Г. Алтан - Оч (Ph.D)
- 2.2 **Цэргийн тэтгэвэр болон нэг удаагийн тэтгэмж авсан цэргийн албан хаагчдын талаархи судалгаа (Лавлагаа мэдээлэл)** 184
Б. Мөнхцэцэг, А. Пагма
- 2.3 **“Алслагдсан бүс” нутгийн шалгуур үзүүлэлт, тэдэнд олгодог хөнгөлөлт, нэмэгдлийн талаархи судалгаа** 187
Г. Алтан - Оч (Ph.D)
- 2.4. **Ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт** 191
Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), Б. Буяндэлгэр, Т. Мягмаржав, О. Нарантуяа, Н. Түвшинтөгс
- 2.5 **Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, стандарт, төсөв санхүүжилт, багшлах боловсон хүчний талаар төрөөс баримталж буй бодлого (Лавлагаа-Мэдээлэл)** 210
Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, А. Пагма, Ч. Базар, Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг
- 2.6 **Тэтгэвэрийн нэрийн дансыг өвлүүлдэг талаархи гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт (Судалгаа - мэдээлэл)** 230
Б. Ариунжаргал, Т. Мягмаржав
- 2.7 **Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулинд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгасан байдал (Лавлагаа, мэдээлэл)** 237
Б. Товуусүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг, А. Пагма, Б. Хатантуул

• ХАВСРАЛТ

- УИХ -ын 2011 оны хаврын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа 254

(Х ботид орсон бусад судалгааны жагсаалт)



ӨМНӨХ ҮГ

УИХ -ын эрхэм гишүүд та бүхний гар дээр УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн 2011 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн судалгааны ажлуудын эмхэтгэл 9, 10 -р цуврал ботийг хүргүүлж байна.

УИХ -ын хаврын ээлжит чуулганаар хэлэлцсэн асуудлууд болон эрхэм гишүүд та бүхний хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл - лавлагаа, судалгааны ажлуудыг тус төв нь шуурхай байдлаар гарган хүргүүлсээр ирлээ. Тайлант хугацаанд нийт 42 судалгааны ажил, мэдээлэл лавлагааг тус төв эрхэм гишүүд та бүхний захиалгын дагуу гүйцэтгэн хүргүүлсэнээс эдгээр эмхэтгэлд 30 судалгааны ажлыг эмхэтгэн хэвлүүллээ.

Судалгааны төвд хаврын чуулганы хугацаанд ирүүлсэн нийт захиалгын 80% орчим нь УИХ -ын гишүүдийн захиалгаар, 20% орчим нь Судалгааны төвийн санаачлага болон Байнгын хороод, УИХ-ын Тамгын газрын хэлтэс албадын захиалгаар хийгдсэн байна.

2011 оны УИХ -ын хаврын чуулганаар улс орны нийгэм, эдийн засагт чухал ач холбогдол бүхий олон чухал асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөж, хэлэлцсэн асуудлууд 81,2% -ийн биелэлттэй гарсаныг УИХ-ын дарга Д. Дэмбэрэл хаврын чуулганы хаалтан дээр цохон тэмдэглэсэн. Эдгээр хэлэлцсэн асуудал бүрээр тус Судалгааны төв судалгаа, мэдээлэл гаргаж өгч байсныг та бүхэнд уламжлахад таатай байна. Тухайлбал, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль, Эрүүгийн хууль, Монгол улсын 2011 оны төсвийн тухай хууль зэрэг гол гол хуулиуд, бодлогын чанартай томоохон арга хэмжээнүүдийн талаархи тогтоолын төслийг хэлэлцэхэд мэдээллийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Түүнчлэн УИХ -ын эрхэм гишүүд УИХ -ын ээлжит чуулганаар хэлэлцсэн асуудлуудаас гадна нийгэмд тулгамдсан зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлуудаар хэд хэдэн томоохон судалгаа хийлгэсэн байна. Тухайлбал, Гадаадын зарим орнуудын 2 танхимтай парламентын талаархи судалгаа, Нийслэл хот дундуур урсан өнгөрдөг гол мөрний ашиглалт, хамгаалалт, менежментийн асуудал, Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах бодлого, Монгол улсын жижиг дунд үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, Хараа хяналтгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тулгамдсан асуудлууд, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар олон нийтээс гарч байгаа санал шүүмжүүд гэх мэт.

УИХ -ын эрхэм гишүүдээс ирүүлж буй захиалга өргөжихийн хэрээр тус Судалгааны төвийн үүрэг роль, ажлын ачаалал нэмэгдэж байна. Тус төв нь зөвхөн чуулганаар хэлэлцэх асуудлууд төдийгүй гишүүдийн хүсэлтээр цаг үеийн асуудлууд, хууль болон тогтоолын төсөл санаачлахтай холбоотой судалгаануудыг гүйцэтгэж байна. Мөн Хуулийн ажлын хэсгүүдийг мэдээлэлээр хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр шаардлагатай үед УИХ болон УИХ -ын Тамгын газрын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

УИХ -ын Тамгын газрын зүгээс гишүүдэд үзүүлж буй үйлчилгээг боловсронгуй болгох, мэдээлэл түгээлт, хүртээмжийг сайжруулах зорилгоор бүх гишүүдийг iPad бичил компьютерээр хангасан. Цаашид УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг эрхэм гишүүд та бүхэн MyParliament дотоод сүлжээнээс цаг тухай бүрт нь бүрэн эхээр нь уншиж ашиглах боломжтой болсоныг дуулгахад таатай байна.

Тус төв нь УИХ-ын дараа дараагийн чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байгаа асуудлуудын ач холбогдол, онцлогийг харгалзан төсөв, санхүү, уул уурхай зэрэг салбарын асуудлууд, мөн нийгэм - эдийн засгийн тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллаж байна.

УИХ-ын эрхэм гишүүд та бүхэнд мэдээлэл, судалгааны шуурхай үйлчилгээ үзүүлэн төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэх нь тус төвийн үүрэг бөгөөд эдгээр судалгааны цуврал эмхэтгэл нь та бүхэнд гарын авлага, мэдээллийн эх сурвалж болон ашиглагдана гэдэгт найдаж байна.

Номын арвин цагаан буян дэлгэрэх болтугай.

Ц. Норовдондог (УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Ph.D)



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА БА БОДЛОГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

(Арга зүйн зөвлөмж)

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Болормаа, О. Нарантуяа

УДИРТГАЛ

“Хууль тогтоогчдод Тамгын газраас зайлшгүй үзүүлэх ёстой үндсэн үйлчилгээний нэг нь ач холбогдол бүхий нийгэм-эдийн засгийн асуудлаар найдвартай судалгаа шинжилгээ хийх, шинээр гарах хуулийн төсөлд холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийж тухайн хуулиас үүдэн гарах эдийн засаг, нийгэм, хүйс хоорондын харьцаа, соёл, төсвийн үр дагаврыг судлан шинжлэх явдал юм” /НҮБХХ-ийн “Ардчилсан засаглалыг бэхжүүлэх” төслийн зөвлөмж /

“Монгол Улсын парламентаас хууль тогтоох буюу бодлого тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бодлогын шинжилгээ, эрсдэлийн менежментийг өргөнөөр ашиглаж, гаргах гэж буй хууль, тухайн хуульд оруулах гэж буй нэмэлт өөрчлөлтийн эерэг, сөрөг тал, гарч болох эрсдэл, түүнийг даван туулах арга замыг тодорхойлж, чухамхүү “Долоо хэмжиж, нэг огтол” гэсэн зарчмыг баримтлах нь зүйтэй юм” /НҮБХХ-ийн “Ардчилсан засаглалыг бэхжүүлэх” төслийн зөвлөмж/

“Академик судалгаа нь хүн төрөлхтөний (үндэстний) мэдлэгийн санг баяжуулж шинэ мэдлэг, загвар бүтээх зорилго агуулдаг бол бодлогын судалгаа нь нийгэмд бодитойгоор оршиж байгаа асуудлыг шийдэх хувилбарт арга замуудыг харуулж, тэдгээрээс оновчтой нэгийг нь бодлогын шийдэл болгож тавих зорилготой.” /Бодлогын судалгааны арга зүйн зөвлөмж, ННФ/

“Судалгаа бол баримт, баттай мэдээнд үндэслэсэн нотолгоотой дүгнэлтэд хүрэх үйл явц бөгөөд гарсан дүгнэлтийг хэрхэн ашиглахаас судалгааны төрөл, хэлбэр хамаарна”

“Бодлогын судалгаа нь бодлогын өөрчлөлт хийх замаар тодорхой нөхцөл /хувьсагч/-ийг өөрчлөхөд гарч болох үр нөлөөг таамаглан танилцуулахад чиглэгддэг бол бодлогын дүн шинжилгээ нь тодорхой асуудлыг шийдэх бодлогын хувилбаруудыг системтэйгээр танилцуулж, үнэлэхэд чиглэгддэгээрээ онцлогтой”

“Бодлогын судалгаа болон бодлогын дүн шинжилгээ нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад зориулан хязгаарлагдмал хугацаанд, тодорхой асуудлыг тогтсон арга зүйгээр задлан шинжлэх, өмнө нь хийгдсэн судалгаа, гаргасан онолуудыг тоймлон ашиглаж бодлогын хувилбаруудын үр дагаврыг тооцоолох үйл ажиллагаа юм”

“Академик судалгаа гэдэг бол нийгмийн харилцааг ойлгох үүднээс онол боловсруулах, “үнэн”-ийг олж тогтоох үйл ажиллагаа бөгөөд бусад судлаач, эрдэмтдийн хэрэгцээнд нийцүүлэн цаг хугацааны хязгаарлалтгүйгээр онол боловсруулах болон шалгах нарийн аргуудыг ашиглан хийгддэг учраас шийдвэр гаргагчдын мэдээллийн хэрэгцээнд нийцэхгүй байх магадлалтай”

СУДЛААЧ, ШИНЖЭЭЧ НАРТ ЗӨВЛӨМЖ

УИХ-аар хэлэлцэн батлах хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, бодлогын баримт бичиг болон хуулийн төсөл боловсруулах, УИХ-аар хэлэлцэх үйл ажиллагааны явцад шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл, судалгаа, бодлогын шинжилгээний санал зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын Тамгын газарт Судалгааны төв байгуулан ажиллаж байна.

Судалгааны төв нь бусад улс орнуудын судалгаа шинжилгээний байгууллагуудын нэгэн адил шийдвэр гаргах одоогийн тогтолцоог өөрчилж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийгмийн хэрэгцээг хангасан, олон нийтийн сэтгэлд нийцсэн бодлого шийдвэрийг УИХ-аар хэлэлцэн батлахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Судалгааны төвийн үндсэн үйл ажиллагаа нь бодлогын шинжилгээ байх ба хууль болон бодлогын баримт бичгийг боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд УИХ-аар шийдвэр гаргах явцад тулгамдсан асуудлуудыг судалж, бодлогын шинжилгээний санал, зөвлөмжийг гаргахад чиглэгдэнэ.

Төв нь бодлогын хүрээнд тулгамдсан тодорхой асуудлуудаар хавсарга судалгаа хийж тухайн асуудлын стратеги мөн чанарыг судлах, улс төрийн бодлого чиглэлийн өнгөрсөн ба одоо үеийн үр дүнг тодруулан шинжилж үнэлгээ өгөх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувилбарыг боловсруулах ретроспектив, перспектив болон нэгтгэсэн /Integrated/ шинжилгээг хийх зорилготой.

Иймд Судалгааны төвийн референт-шинжээч, референт-судлаач нар судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ дараахь зарчим, шаардлагыг баримталж ажиллах нь зүйтэй.

Бодлогын шинжилгээний зохион байгуулалт

Харьцуулах үзүүлэлт	Онолын судалгаа /political analysis/	Хавсарга судалгаа /policy analysis/
Судалгааны зорилго	Улс төрийн үзэгдэл юмсын мөн чанар, хэрэгжүүлэх механизмыг илрүүлж тайлбарлах	Улс төрийн үйл явцад оролцогчдын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх
Судалгааны объект	Цаг хугацаа, орон зайн хувьд хязгаарлагдаагүй улс төрийн үйл явц	Тодорхой хугацаанд шийдвэрлэх ёстой бодлогын тулгамдсан асуудал
Судалгааны субъект	Эрдэмтэд, шинжлэх ухааны байгууллага	Мэргэшсэн төв болон төрийн захиргааны бүтцэд ажилладаг шинжээчид
Захиалагч	Нийгэм	Улс төрчид, шийдвэр гаргагчид

Бодлогын шинжилгээний зорилт:

1. Бодлогын стратегийн асуудлын мөн чанарыг судлан шинжлэх
2. Улс төрийн бодлого, чиглэлийн өнгөрсөн ба одоо үеийн үр дүнг тодруулан шинжлэх
3. Эдгээр үр дүн нь тухайн бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ямар ач холбогдолтой болохыг үнэлэх
4. Стратегийн бодлогын шинэ хувилбарууд, тэдгээрийн болзошгүй үр дүнг тооцох
5. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбарыг боловсруулах

Бодлогын шинжилгээний зарчим:

- Шуурхай, шинэлэг
- Тухайн цаг үеийн бодлогын тулгамдсан асуудалд хариу өгдөг
- Уян хатан, төрөл бүрийн нөхцөл байдалд зохицох чадвартай

- Тоон мэдээллийг чанарын шинжилгээний дүгнэлттэй хослуулсан
- Цаг хугацаа, зохион байгуулалт, санхүүгийн зардлыг хэмнэсэн

Гарах бүтээгдэхүүн:

- Санал
- Зөвлөмж

Бодлогын шинжилгээний үе шат

- ❖ Асуудал шийдвэрлэх шаардлагатай нөхцөл байдлыг үнэлэх
- ❖ Бодлогын шийдвэрлэх асуудлыг тодорхойлох
- ❖ Илүү сайн хувилбар гаргах үүднээс асуудлыг судлах
- ❖ Улс төрийн шийдвэр гаргах
- ❖ Шийдвэрийн хэрэгжилт
- ❖ Гаргасан шийдвэрийн үр дүн, үр ашгийг үнэлж дүгнэх

Бодлогын шинжилгээний төрөл:

1. Дескриптив буюу ретроспектив шинжилгээ-бодлогын хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдлыг тодорхойлон үнэлж, үүссэн нөхцөл байдлын учир шалтгааныг тодруулан, урьд нь гаргасан шийдвэрийн үр дагаварыг судлах
2. Перспектив шинжилгээ - Цаашид хэрэгжүүлэх бодлогын альтернатив хувилбарын үр дагаварыг урьчилан дүгнэх /аль нэг шийдвэрийг хэрэгжүүлэх эсэх талаар зөвлөмж гаргах/
3. Үнэлгээ өгөх шинжилгээ - Улс төрийн үнэлгээний бие даасан салбар

Бодлогын шинжилгээ нь улс төрчдийг нийгмийн тусын тулд шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхүйц улс төрийн шийдвэрийн хувилбар боловсруулах шатанд чухал ач холбогдолтой судалгаа, шинжилгээний цогц үйл ажиллагаа юм.

Улс төрийн шийдвэр гаргах үе шат:

- Асуудлыг ойлгох
- Зорилгоо сонгож тайлбарлах
- Асуудлыг дэвшүүлж, түүний талаар мэдээлэл цуглуулах
- Асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах
- Бодлогын аль хувилбарыг сонгосон тохиолдолд ямар үр дагаварт хүрч болох талаар тогтоосон шалгуурын дагуу үнэлэх
- Бодлогын хувилбаруудаас хамгийн сайныг нь сонгох
- Зөвлөмж гаргах
- Улс төрийн шийдвэр гаргах
- Шийдвэрийн үр ашгийг үнэлэх
- Шийдвэрийг шинэчлэх, дахин хянаж үзэх, өөрчлөх

Бодлогын шинжилгээний шат дараалал:

- Нөхцөл байдлын шинжилгээ
- Прогноз дэвшүүлэх
- Шийдвэр гаргах

Улс төрийн шийдвэрийн үр ашгийг тооцох шалгуур:

- Эдийн засаг, улс төрийн ашиг /баялаг, мэдээлэл, эрх мэдэл, нөлөөлөл олж авах/
- Зардал
- Зарцуулах цаг
- Зорилгод хүрэх магадлал
- Эрсдлийн түвшин
- Шийдвэр нь нийгмийн үнэт зүйлсийн системд тохирч байх
- Гарч буй шийдвэрийг олон нийт хүлээн авахаар байх
- Олон түмэнд дэвшигдэж буй зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийцтэй оролцооны баримтлалыг төлөвшүүлэхэд тус дөхөм үзүүлэх

Дээрхи зарчим, үечлэлийн дагуу судлаачид болон бодлогын шинжээчид судлагдаж буй асуудлыг шинжлэн шийдвэрлэх арга зам, хамгийн оновчтой гэсэн бодлогын хувилбарыг боловсруулан захиалагчид хандан санал, зөвлөмж гаргана.

БОДЛОГЫН СУДАЛГАА**I. Бодлогын шинжилгээ гэж юу вэ?**

Бодлого судлалын өлгий нутаг болсон АНУ -ын эрдэмтэд бодлогын шинжилгээг маш өргөн хүрээнд судалж тодорхойлсон байдгаас бодлого судлалын ухааны гол төлөөлөгч болох профессор У.Данн болон Е.С.Кауд нар дараахь байдлаар тодорхойлсон байдаг.

Тодорхойлолт:

- Бодлого боловсруулагчдын шийдвэр гаргах суурь нөхцлийг сайжруулах мэдээллүүдийг үүсгэж буй бүх төрлийн шинжилгээг бодлогын шинжилгээ гэнэ.

*Ранд Корпорацийн математикийн тэнхимын анхны тэргүүн,
Бодлого судлаач доктор профессор Е.С. Кауд*

- Бодлогын шинжилгээ нь бодлого боловсруулах үйл явц болоод уг үйл явц дахь мэдлэгийг бүтээх үйл ажиллагаа юм.

*АНУ -ын Питсбургийн Их Сургуулийн бодлого судлаач,
доктор профессор Уилльям Данн*

Бодлогын шинжилгээний онцлог:

Бодлогын шинжилгээ нь тайлбарын, үнэлгээний болон зөвлөгөөний чанар бүхий олон талт шинжлэх ухаануудын оролцоотой. Бодлогын шинжилгээ нь нийгмийн болон харилцааны шинжлэх ухаануудаас гадна олон нийтийн удирдлага, хуульзүй, философи, ёсзүй, хэрэглээний математик болон бусад анализын системүүдийг хэрэглэнэ. Дээрх салбаруудын тусламжтайгаар бодлогын шинжээч нь ерөнхийдөө гурван төрлийн асуултад хариулах дараахь мэдээллийг бий болгодог:

- Тулгамдаж байсан асуудал шийдэгдсэн эсэхийг харуулах ололт амжилт, үнэ цэнэ
- Дээрх ололт амжилтыг биелүүлэхийн өмнө тулгарч буй эсвэл биелэлтийг нь хялбаршуулж буй байдал
- Асуудлуудыг амжилттайгаар шийдэх арга замууд


Дээрх гурван асуултанд хариулахын тулд бодлогын судлаач нь

- Туршилтын /empirical/,
- Үнэлгээний /Valuative/,
- Норматив /normative/ гэсэн гурван арга замын нэгийг юмуу бүгдийг нь хэрэглэх шаардлагатай болдог.

Хандлага	Үндсэн асуулт	Мэдээллийн төрөл
Туршилтын	Тухайн асуудал оршин бий юу, ирээдүйд бий болох уу (Facts)	Тайлбар, таамаглал
Үнэлгээний	Асуудлыг шийдэх нь хэр чухал болох, үнэ цэнэ (values)	Үнэлгээний
Норматив	Юу хийх хэрэгтэй болох (action)	Зөвлөгөөний

Бодлогын систем:

Бодлогын систем нь гурван элементийн хоорондын харилцаанаас тогтоно. Энэ гурван элемент нь **бодлого**, **сонирхлын бүлгүүд** болон **бодлогын орчин** юм. Бодлого нь төр болон түүний байгууллагаас боловсруулсан бүх салбарт хамааралтай сонголтууд юм. Сонирхлын бүлгүүд нь төрийн бодлого чиглэгдэж буй хувь хүн болон бүлэг хүмүүс юм. Бодлогын орчин нь бодлогын асуудлуудыг тойрсон үйл явдлуудыг багтаах бөгөөд уг үйл явдлууд нь сонирхлын бүлгүүдэд нөлөөлөн, сонирхлын бүлгүүд ч мөн дээрх үйл явдлуудад нөлөөлж байдаг. Бодлогын системийн гурван элементийн харилцан хамааралыг У.Данн доорхи маягаар схемчилсэн байдаг.



Бодлогын орчин	Сонирхлын бүлгүүд	Бодлого
Гэмт хэрэг	Бодлогын шинжээчид	Хуулийн албадлагын
Инфляци	Иргэд	Эдийн засгийн
Ажилгүйдэл	Үйлдвэрчний эвлэл	Нийгмийн халамжийн
Ялгаварлал	Улс төрийн намууд	Ажилтан, албан хаагчийн
Хотын ядуурал	Агентлагууд	Хотын

Бодлогын шинжилгээний төрлүүд:

- Проспектив – Prospective
- Ретроспектив – Retrospective
- Нэгтгэсэн – Integrated гэсэн гурван үндсэн хэлбэр байна.

Перспектив бодлогын шинжилгээ нь бодлогын арга хэмжээг эхлэн гүйцэтгэхээс өмнө мэдээллийг бүтээх түүнийг хувиргах явдал бөгөөд эдийн засагч, системийн аналит, үйлдэл судлаачдын ажиллах стилийг /загварыг/ перспектив анализаар тайлбарлаж болно.

Перспектив бодлогын шинжилгээ нь бодлогын холбогдолтой мэдээллүүдийг синтезлэн, бодлогын давуу талт сонголтуудыг санал болгож, бодлого шийдвэрлэх үйл явцад туслах зорилготой үйл ажиллагаа юм. Бодлогын шинжилгээ нь зарчмын хувьд мэдээлэл цуглуулахаас ялгаатай юм. Харин бодлогын судалгаа нь шинжлэх ухааны аргачлал ашиглан бодлогын холбогдолтой мэдээллүүдийн хоорондох уялдаа холбоог тайлбарлах юм гэжээ.

Перспектив бодлогын шинжилгээ нь асуудлыг шийдвэрлэхэд илүү тохиромжтой гэж тооцогдож буй шийдвэр болон төрийн тухайн асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлтын хооронд завсар үүсгэдэг сул талтай.

Ретроспектив бодлогын шинжилгээ нь бодлогын арга хэмжээ гүйцэтгэгдэж эхэлсний дараа бодлогын холбогдолтой мэдээлэл бүтээх, хувиргах үйл явц юм.

Ретроспектив шинжилгээ нь **бодлогын шалтгаан, үр дагаварыг тайлбарлаж, бодлого боловсруулагчдын зорилгыг тодорхойлж** өгнө. Бодлого боловсруулагчдын зорилгыг тодорхойлсноор тэдэнд бодлогын үр дүнгийн талаар хяналт болон үнэлгээ хийх боломж олгох ба дахин асуудал тодорхойлж, бодлогын шинэ хувилбарууд боловсруулан, асуудлыг шийдвэрлэх тал дээр авах арга хэмжээг санал болгоно.

Энэ нь перспектив бодлогын шинжилгээ рүү буцна. Өөрөөр хэлбэл, үр дүнг хянаж дүгнэх бөгөөд дараа нь дахин бодлого боловсруулах шаардлага гарвал бодлогын арга хэмжээ авахаас өмнө бодлогын мэдээллийг бүтээнэ. Энэ шинжилгээний сул тал нь хэрэгжээд дууссан бодлогын хэрэгжилтүүд, туршлагаудыг хамардаггүй тул асуудлыг шийдвэрлэх шийдвэр гаргахад тийм ч үр бүтээлтэй байж чаддаггүй байна.

Нэгтгэсэн бодлогын шинжилгээ нь бодлогын арга хэмжээ авагдахаас өмнө болон авагдсаны дараа бодлогын холбогдолтой мэдээлэл бүтээх, түүнийг хувиргах үйл явц юм. Нэгтгэсэн бодлогын шинжилгээнд шинжээч ретроспектив, перспектив бодлогын шинжилгээг нэгтгээд зогсохгүй бодлогын холбогдолтой мэдээллийг тасралтгүй тогтмол боловсруулах шаардлагатай байдаг.

Энэ нь шаардлага хангасан, хамгийн тохиромжтой бодлогыг олж хэрэгжүүлэх хүртэл бодлогын шинжилгээний үйл явц буюу бодлогын мэдээлэл боловсруулж, бодлогын арга хэмжээ авах процедур нь тойрог хэлбэрээр үргэлжилнэ гэсэн үг юм. Тиймээс энэ төрөл нь бодлого хэрэгжүүлэхийн өмнө болоод хойно мэдээлэл бүтээж байгаа буюу перспектив, ретроспектив анализын хоёуланг нь явуулж байгаагаараа онцлог ажээ. **Нэгтгэсэн шинжилгээ нь дээрх хоёр төрлийн шинжилгээнүүдийн давуу талуудыг агуулахын хажуугаар ямар ч сул талыг нь агуулаагүйгээрээ хамгийн их давуу талтай юм.** Нэгтгэсэн шинжилгээний үед бодлого боловсруулах үйл явцыг байнга хянаж, тогтмол дүгнэлт хийх боломжтой байдаг.

Бодлогын судалгаа, бодлогын дүн шинжилгээ болон академик судалгааны ялгаа:

	Бодлогын судалгаа	Бодлогын дүн шинжилгээ	Академик судалгаа
Үндсэн зорилго	Бодлогын өөрчлөлт хийх замаар тодорхой нөхцөл /хувьсагч/-ийг өөрчлөхөд гарч болох үр нөлөөг таамаглан танилцуулах	Тодорхой асуудлыг шийдэх бодлогын хувилбаруудыг системтэйгээр танилцуулж, үнэлэх	Нийгмийн харилцааг ойлгох үүднээс онол боловсруулах, “үнэн”-ийг олж тогтоох
Хэнд зориулсан	Бодлого боловсруулах үйл явцад оролцогч талууд, холбогдох мэргэжлийн хүмүүс	Шийдвэр гаргагч хүн, байгууллага	Бусад судлаач, эрдэмтэд
Ерөнхий хэлбэр маяг	Асуудлыг тогтсон аргазүйгээр авч үзэн боловсруулалт хийнэ. Асуудлаа шийдэх арга замыг олох зорилго, анхнаасаа сайтар тодорхойлогдсон байх	Өмнө хийсэн судалгаа, гаргасан онолуудыг тоймлон, бодлогын хувилбаруудын үр дагаврыг тооцоолно.	Онол боловсруулах болон шалгах нарийн аргуудыг ашиглана. Гол төлөв өмнө нь цуглуулсан байсан бэлэн баримтыг ашигладаг.
Цаг хугацааны цар хүрээ	Тухайн асуудлын амьдралд үүсэх давтамжаас хамааран заримдаа хугацаа хязгаарлагдмал байна	Тодорхой шийдэл олох зорилгоотой тул хугацаа маш хязгаарлагдмал	Цаг хугацааны хязгаарлалт бага
Сул тал	Судалгааны үр дүнг төрийн бодлого, шийдвэр болгох, шийдвэр гаргагчдад хүргэхэд хүндрэлтэй	Судалгааны захиалагч, цаг хугацааны шахалтаас болж хамрах хүрээ явцуу болох магадлалтай	Шийдвэр гаргагчдын мэдээллийн хэрэгцээнд нийцэхгүй байх магадлалтай

Дүгнээд хэлбэл, академик судалгаа нь хүн төрөлхтний үндэстний мэдлэгийн санг баяжуулж шинэ мэдлэг, загвар бүтээх зорилго агуулдаг бол бодлогын судалгаа нь нийгэмд бодитойгоор оршиж байгаа асуудлыг шийдэх хувилбарт арга замуудыг харуулж, тэдгээрээс оновчтой нэгийг нь бодлогын шийдэл болгож тавих зорилготой байна.

II. Бодлогын судалгаа гэж юу вэ?

- ❖ Энэ контекстэнд, дүн шинжилгээ гэдэг нь асуудлыг хэрхэн шийдвэрлэх зарим хувилбаруудыг гаргахыг хэлнэ.
- ❖ Конгрессийн судалгааны төв илүү нарийвчилсан судалгаа хийх зорилго бүхий бодлогын шинжилгээ хийдэг. Бодлогын судалгаа нь нийгмийн ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэх системчилсэн стратеги юм.
- ❖ Энэ үйл явцын хүрээнд шинжилгээ нь дараахь 3 алхамаас бүрдэнэ. Үүнд:
 - Асуудлыг тодорхойлох
 - Асуудлыг шийдвэрлэх альтернатив арга замыг боловсруулах
 - Эдгээр альтернативуудын үр нөлөөг тооцох

- ❖ Зөвлөмж гаргахаас татгалзах. Учир нь зөвлөмж гаргах нь “Ямар арга зам улс оронд сайн нөлөө үзүүлэх вэ” гэсэн үнэлгээ хийхэд хүргэнэ.

III. Дүн шинжилгээний түвшин:

- Дүрсэлсэн тайланд дүн шинжилгээний үр дүнг оруулах шаардлагагүй.
- Асуудлыг үнэлэхдээ мэдлэгийн хүрээг бага зэрэг тэлэх нь ашигтай байдаг.
- Үүнийг та хэрхэн гүйцэтгэж болох тухай зарим санааг авч үзье.
- Дүн шинжилгээний жишээнүүд
 - Судалгааны асуудлын шалтгааныг бусад экспертүүд хэдийнээ судалсан байж болно.
 - Тэдгээр шалтгааныг та судалгаандаа оруулснаар тэдний өмнөөс хариуцлага хүлээх ёсгүй.
 - Гэхдээ та үзэл бодлын ялгааг гаргах хэрэгтэй.
- Бусад гадны экспертүүд тухайн асуудлыг шийдвэрлэх арга зам хэмээн тодорхойлсныг олж мэдээл. /уламжилж авсан альтернативууд/ Үүнд асуудлыг шийдвэрлэх арга замуудыг аль болох өргөн хүрээтэйгээр авах.
- Хэрэв асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон ганц арга зам байвал тэрхүү арга замын давуу ба сул талын дүн шинжилгээг гаргах
 - Асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон арга замын давуу ба сул тал нь юу вэ?
 - Шударга бай. /давуу ба сул талыг аль болох адил тоогоор гаргах/
- Таныг судалгаа хийх явцад хэд хэдэн чухал бодлогын асуудлууд урган гарч болно.
 - Эдгээр асуудлуудыг үйлчлүүлэгчтэйгээ Бодлогын асуудал, Бодлогын асуулт эсвэл бодлогын үр дагаварын хэлбэрээр хуваалцах
- Эдгээр арга хэрэгслийг бүхэлд нь буюу зармыг нь “шинжилгээ” хэмээх тодорхойлолтонд оруулах боломжтой.

Судлаачийн эцсийн бүтээгдэхүүн:

- Бодлогын судалгааны тайлан. Энэ нь судалгааны ажлын гол бүтээгдэхүүн байх ба уг баримт бичигт бодлого, шийдвэрээр зохицуулж болох бодит проблем, асуудлыг тогтсон аргачлалаар задлан шинжлээд, бодлогын хувилбаруудыг танилцуулсан тайлан байна.
- Бодлогын дүн шинжилгээний тойм. Энэ нь дээрх судалгааны тайлан болон хоёрдогч мэдээллийн бусад эх сурвалжууд (жишээлбэл, бусад судалгаа)-ыг ашиглан тухайн асуудлаар хэрэгжүүлж болох бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлсэн баримт байх юм. Энэ товч тоймоор судлаач өөрийн боловсруулсан бодлогын хувилбарыг бусад хувилбартай харьцуулан үнэлснээ тоймлон харуулах бөгөөд бодлого боловсруулагч, шийдвэр гаргачдад танилцуулна.
- Бодлогын судалгааны чиглэл тус бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн сан. Судалгааны явцад судлаач тодорхой асуудлаар баялаг мэдээллийн сантай болдог. Эдгээр тоон болон чанарын өгөгдлүүд нь судлаачийн хийсэн судалгаа, хүрсэн дүгнэлтийн цаадах нотолгоо болохоос гадна дараа дараагийн судалгаанд суурь мэдээлэл болгон ашигласнаар цаг хэмнэх ач холбогдолтой материал юм. Тиймээс өгөгдлүүдийг нэгтгэн, ангилж мэдээллийн сан байгуулаад, цахим хэлбэрээр хадгалах хэрэгтэй.

Бодлогын дүн шинжилгээний бүрэлдэхүүн хэсэг:

Бодлогын судалгаа, дүн шинжилгээг тусдаа гэж ойлгож болох ба судалгааны баримтад дүн шинжилгээг бүрэн гүйцэд хийж, харин түүний хураангуйг тусад нь бодлого боловсруулагчдад зориулсан бүтээгдэхүүн болгох юм. Өөрөөр хэлбэл судлаач бодлогын судалгааны аргууд дээр үндэслэн бодлогын дүн шинжилгээ хийх юм. Тиймээс бодлогын дүн шинжилгээ ямар бүрэлдэхүүнтэй байхыг дор товч тайлбарлая.

Дүн шинжилгээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- Бодлогын асуудал проблемыг ойлгомжтой тодорхойлсон байх
- Өнөөгийн бодлогыг тоймлон тайлбарласан байх
- Бодлогын боломжит хувилбаруудыг гаргасан байх
- Хувилбаруудыг үнэлэх багц шалгуурыг сонгосон байх
- Бодлогын сайжруулах, илүү оновчтой болгоход чиглэсэн тодорхой алхамуудыг санал болгон зөвлөсөн байх

Асуудлын тодорхойлолт

Асуудлыг аль болох ойлгомжтой, тодорхой томъёолон тавих нь чухал. Үүнд мөн асуудлын мөн чанар, цар хүрээ, хэнд нөлөөлж байгаа зэргийн талаар хийгдсэн холбогдох судалгааны товч тоймыг оруулах хэрэгтэй. Түүнчлэн уг асуудлын нөлөөлөлд өртөж байгаа буюу ашиг, сонирхол нь хөндөгдөж байгаа сонирхлын бүлгүүд, хувь хүмүүсийг тодорхойлох ач холбогдолтой.

Өнөөгийн бодлого

Өнөөгийн хэрэгжиж байгаа бодлогыг тоймлож өгнө. Үүнд хэзээнээс хүчинтэй болсон хэн дэмждэг, хэний эсэргүүцэлтэй тулгардаг, өөрчлөлт орвол хэнд сайнаар, хэнд муугаар нөлөөлөх, ямар төрийн болон төрийн бус байгууллагууд уг бодлоготой холбогдож байгаа зэргийг гаргаж өгнө.

Бодлогын хувилбаруудын тодорхойлолт

Бодлогын хувилбаруудаас бусад орны болон дотоодын туршлага, бусад салбарын бодлогын туршлага зэргээс хайж болох юм. Наад зах нь хоёр бодлогын хувилбар гаргасан байх хэрэгтэй. Эдгээр хувилбар нь тухайлбал томоохон өөрчлөлт шинэтгэл, эсвэл шат дараалсан бага зэргийн өөрчлөлтийн хоёр хувилбар байж болох юм.

Үнэлэх шалгуурын сонголт

Хувилбаруудыг тодорхой шалгууруудаар үнэлэн сонгох нь сонголтыг зөв хийхэд чухал. Эдгээр шалгуурт үр ашиг, үр дүн, тэгш байдал, хэрэгжих боломж, уян хатан байдал буюу сайжруулах боломж, улс төрийн хувьд хүлээн авах боломж, гол сонирхлын бүлгүүд хүлээн зөвшөөрөх байдал зэрэг орж болох юм.

Хувилбаруудын үнэлгээ

Дээрх сонгосон шалгууруудыг ашиглан хувилбар бүрийг үнэлэх хэрэгтэй. Ингэхдээ хувилбар бүрийн давуу болон сул талыг онцлон харуулах хэрэгтэй. Гол сонирхлын бүлгүүдийн сонирхлыг үнэлэхийг мөн оролдох хэрэгтэй.

Аль нэг хувилбарын сонголт

Үнэлгээний шалгуур дээрээ үндэслэн тодорхой хувилбарыг дэмжсэн зөвлөмж гаргах хэрэгтэй. Уг сонголтын давуу болон сул талыг тодорхой дурьдсан байх шаардлагатай.

ШИНЖИЛГЭЭ
СУДАЛГААНЫ САН

ХУУЛЬ ТОГТООХ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГАА**Үндсэн концепци****I. Хууль тогтоох байгууллагад судалгаа шинжилгээний ажил ямар ач холбогдолтой вэ?**

- Хууль тогтоох байгууллага үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулах нь ардчилалын үндэс
- Хууль тогтоох байгууллага үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулахын үндэс нь хэрэгцээтэй мэдлэг ба мэдээлэл болно. Үүнд:
 - ✓ Тодорхой бодлогын асуудлаар ухаалаг шийдвэр гаргах
 - ✓ Улс орныг удирдахад илүү идэвхитэй үүрэг гүйцэтгэх
- Иймээс судалгаа, шинжилгээ нь хууль тогтоох байгууллага ба ардчилалд чухал ач холбогдол бүхий ажил болно.


II. Уламжлалт академик судалгаа болон бодлогын судалгаа шинжилгээний ялгаа юунд оршдог вэ?

Судалгааны хэмжүүр	Уламжлалт академик судалгаа	Бодлогын судалгаа
Зорилго	“Эцсийн үнэн”-ийг олж тогтоох	Тодорхой асуудлыг шийдвэрлэх
Хамрах хүрээ	Тодорхой нэг салбарын гүнд орох	Олон салбарыг хамран, гэхдээ дор хаяж нэг салбарыг нарийвчлан судална.
Хугацаа	Эцсийн үнэн”-ийг олж тогтоох хүртэл	Шаардлагатай үед /ихэнхидээ тэр дор нь/ парламентын чуулганы хэлэлцэх асуудалтай цаг хугацааны хувьд холбогдоно. Гарч болзошгүй асуудлуудад бэлэн байна.
Хэрэглэх хүрээ	Голчлон мэргэжилтнүүд л уншиж ойлгоно.	Техникийн бус уншигчдад зориулсан тодорхой, товч, асуудлыг шийдэхэд чиглэсэн тайлан байна. Тайлан нь хугацаагүй хэсэг, график зураг ба хүснэгттэй байна.
Орчин	Бие даасан судлаач ганцаарчлан ажиллах нь нийтлэг	Багаар ажиллах нь илүү нийтлэг болж байна.

III. “Судалгааны брокер”-ийн үүрэг ба дүн шинжилгээний процесст түүний эзлэх байр суурь

- ❖ Нийгмийн шинжлэх ухааны судалгаа ба мэдлэг хэрхэн хууль тогтоох байгууллагын шийдвэр гаргагчид хүрдэг вэ?
- ❖ Энэ үйл явц нь академик судлаачаас эхэлнэ. Академик судлаачийн бүтээлийг хууль тогтоох байгууллагын судалгааны брокер авч, парламентад шийдвэр гаргах бодлогын баримт болгоно.

Академик судлаач → Судлаач брокер → Бодлого тодорхойлогч

Судалгааны брокерийн үүрэг:

- ❖ Судалгааны брокер нь санаа бодлын ерөнцийг шийдвэр гаргагчийн ертөнцтэй холбох чухал концепцийг нэвтрүүлсэн.
- ❖ Судалгааны брокер/шинжээч/ нь дээрх 2 ертөнцийг холбох гүүр болдог.
- ❖ Ажил үүргээ амжилттай гүйцэтгэхийн тулд судалгааны брокер доорхи шаардлагыг хангана. Үүнд:
 - Дээрхи хоёр ертөнцөд эксперт хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байх /академик ба хууль тогтоох хүрээнд/
 - Дээрхи хоёр ертөнцийн “хэл”-ийг эзэмшиж тэдний хооронд “орчуулагч”-ийн үүрэг гүйцэтгэх
 - Хууль тогтоох байгууллагад шаардлагатай байгаа мэдээллийн хэрэгцээг ойлгож академик ертөнцөд уламжлах
 - Академик ертөнцийн тодорхой концепцийг авч хууль тогтоогчид ойлгохуйц практик хэлбэр, тодорхойлолтонд оруулах
 - Академик судлаачдыг хууль тогтоох байгууллагынхантай харилцан санал солилцуулах /жишээ нь, нээлттэй сонголд гэрчийн хувьд урих, мэдээлэл хийлгэх, эсвэл гэрээгээр судалгаа хийлгэх/

АЛЬТЕРНАТИВ ХУВИЛБАРУУДЫГ БОЛОВСРУУЛАХ

- Судалгааг иж бүрэн эхлүүлэх-байж болох бүх хувилбаруудыг жагсаах
- Олон хувилбаруудын давуу ба сул талуудыг шинжлэн гаргах
- Туйлширлаас зайлсхийх
- “Арга хэмжээ авах хэрэггүй” гэсэн нь хувилбар мөн үү гэдэгт анхаарлаа хандуулах
- Асуудлын “идэвхижилт”-ийн циклийг анхаарах. Альтернатив хувилбарыг гаргах тохиромжтой цаг үе нь хэзээ болохыг анхаарах.
- Шинэ санаа гаргах боломжтой юу? Шинэ санааг хаанаас гаргах вэ гэх зэрэг асуудлыг анхаарах.
- Нийтлэг алдаа гаргахаас зайлсхийх. Бүтэшгүй альтернатив хувилбарууд ба үндэслэлгүй дүгнэлтүүд гаргахгүй байх.
- Альтернатив хувилбаруудыг өрсөлдүүлж болно.
- Хувилбарууд нь улс төрийн нөхцөл болон нөөц хөрөнгийн хувьд хэрэгжих бололцоотой байх ёстой.
- Хувилбаруудыг 3-4 шилэгдмэл хувилбар гаргатал шүүн сонгох

АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ**I. Асуудлыг тодорхойлохын ач холбогдол**

- ! Асуудлыг анхнаас нь зөв тодорхойлох нь чанартай судалгаа шинжилгээний

тайлан гаргах үндэс болно.

- Асуудлыг тодорхойлох үйл явц нь таны судалгааны хүрээг хумих, гол асуудлууд дээр төвлөрөх ач холбогдолтой.
- Мөн таны үйлчлүүлэгчид асуудлыг ойлгоход туслах ач холбогдолтой.
- ! Судалгааны үйл явцын эхэнд судалгааны асуудлыг тодорхойлоход анхаарал хандуулах хэрэгтэй.
- ! Тодорхойлсон асуудлыг хянаж, шаардлагатай бол засвар оруулах
- ! Хэрэв гол асуудлын талаархи таны ойлголт өөрчлөгдвөл энэ тухай үйлчлүүлэгчдээ мэдэгдэх

II. Асуудлыг тодорхойлох үйл явцад учрах бэрхшээл

- ! Асуудлыг тодорхойлох нь амархан санагдавч нилээд ээдрээтэй байж болно.
- ! Асуудлыг буруу томъёолж тодорхойлох нь алдаатай дүгнэлтэнд хүргэж болзошгүй.
- ! Үндсэн асуудлыг хоёрдогч асуудал, шинж тэмдэг, шалтгаантай андуурах эрсдэлтэй.
- ! Зарим хувилбаруудыг огт анхааралгүй орхих, зарим хувилбарыг үндэслэлгүй дөвийлгөх маягаар асуудлыг тодорхойлох нь нийтлэг ажиглагддаг.
- ! Асуудлыг тодорхойлох сайн арга нь асуудлыг шийдвэрлэх ямар ч хувилбарыг орхигдуулах ёсгүй.

III. Асуудлыг тодорхойлох алхамууд.

- ! Судалгааны тайлангийн эхэнд асуудлыг тодорхойлох бөгөөд энгийн үг хэллэгээр томъёолох.
 - Асуудлын мөн чанар, агуулга болон цаг хугацааны факторыг тайлбарлах
 - Асуудлыг тодорхой тайлбарлах
 - ✓ Цар хүрээ
 - ✓ Цаг хугацаа
 - ✓ Цаашдын хандлага /Асуудал газар авч байгаа эсэх/ /Богино хугацаанд эсвэл урт хугацаанд/
- ! Асуудлыг үүсгэгч шалтгааныг тодорхойлолтонд олж тусгах
- ! Үүсч болзошгүй зарим хоёрдогч болон бусад асуудлуудыг тогтоох
- ! Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд хууль тогтоох байгууллагын үүргийг тодорхойлох
- ! Уг асуудалд эрх ашиг нь хөндөгдсөн гол талуудыг олж тогтоох
- ! Хэлэлцүүлгийн цаана байгаа зорилго, ашиг сонирхолыг тогтоох

ЗАСГИЙН ГАЗРААС ӨРГӨН БАРЬСАН ХУУЛИЙН ТӨСӨЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1/ Хуулийн төслийн зорилго ба түүх

- Хуулийн төслийн танилцуулгыг бэлтгэх

1. Хуулийн төслийн санаачлах болсон шалтгаан
2. Хэрэв хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгаа бол уг хуулийн талаархи мэдээлэл
3. Хуулийн төслийн түүх

4. Энэ асуудлаархи бусад хуулиуд

2/ Хуулийн төслийн заалт бүрийн дүн шинжилгээ

1. Хуулийн төслийн чухал бүлгүүдэд дүн шинжилгээ хийх /бүх бүлгүүдэд дүн шинжилгээ хийхгүй/
2. Бүлгийн дүн шинжилгээ: Энэ хуулийн төсөл нь юу хийх эсвэл юу хийхгүй байхыг санал болгож байгаа; томъёоллын асуудал байх эсэх; бүлгийн үзүүлэх нөлөө гэх мэт
 - Хуулийн бүлгийн заалтуудыг хуулж бичихгүй байх
 - Хуулийн төслийн бүтцийг давтах албагүй
 - Асуудлыг ач холбогдолын дарааллаар нь шинжлэх
 - Хуулийн төсөл болон чухал бүлгүүдийг тодорхой, ойлгоход хялбар байдлаар тайлбарлах
 - Бусад холбогдох мэдээллийг нэмж оруулах

3/ Санал

1. Эрдэмтэн, бие даасан хүрээлэнгүүд, судалгааны байгууллагууд, сонирхлын бүлгүүд болон хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч зэрэг гадны мэргэжилтнүүдийн дүн шинжилгээ, саналыг оруулах
2. Үүнд энэ хуулийн төслийг дэмжигч болон шүүмжлэгчдийн аль алины санал шүүмжлэлийг оруулахыг анхаарна уу.
3. Хуулийн төслийн талаар засгийн газар болон хууль тогтоох байгууллагын албанаас өгсөн мэдээллийн ялгааг ойлгох.

ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ**I. Үр нөлөөний дүн шинжилгээ**

- Өргөн барьсан хуулийн төслийн болзошгүй үр нөлөөний талаархи мэдээлэл нь хууль тогтоогчдод маш чухал.
- Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийн үр нөлөөний тооцоо нь аль болох эерэг байхаар гаргасан байдаг.
- Судлаач нь дүн шинжилгээний тайландаа өргөн барьсан хуулийн төслийн үр нөлөөг бие даан тооцож гаргахыг оролдох нь хууль тогтоох үйл явцад оруулах чухал хувь нэмэр болно.
- Үр нөлөөг мөнгөн хэлбэрээр гаргах боломжгүй тохиолдолд тооцох нь маш хэцүү байж болно.
- Хэдий тийм ч, үр нөлөөг тооны бус буюу мөнгөн бус хэлбэрээр тооцох нь чухал ач холбогдолтой.
- Судлаач нь хуулийн төслийн үр нөлөөний талаар дор хаяж асуудлыг хөндөх хэрэгтэй.

II. Үр нөлөөний төрлүүд:**1. Санхүү, төсвийн үр нөлөө**

- ✓ Засгийн газрын төсвийн орлого болон зарлагын үр нөлөөгөөр хязгаарлагдана.

2. Эдийн засгийн үр нөлөө

- ✓ Өргөн утгаараа эдийн засгийн үр нөлөөний дүн шинжилгээ нь өргөн барьсан хуулийн төсөл нь эдийн засгийн байдлыг сайжруулах эсвэл муутгах үр нөлөөтэй эсэхийг тодорхойлоход оршино.
- ✓ Хуулийн төслийн үр нөлөөг улсын эдийн засгийн макро түвшинд, эсвэл салбарын буюу бүс нутгийн түвшинд тооцож тодорхойлж болно.
- ✓ Чухал арга хэмжээний үр нөлөө байж болно. Жишээ нь: ажлын байр, орлого, үйлдвэрлэл, худалдаа гэх мэт.

3. Нийгмийн үр нөлөөний жишээнүүд

- ✓ Тодорхой нийгмийн бүлэг, хүйс, хүүхдүүдэд үзүүлэх үр нөлөө.
- ✓ Нийгмийн эрүүл мэнд болон дундаж наслалтанд үзүүлэх үр нөлөө.
- ✓ Олон нийтийн аюулгүй байдалд үзүүлэх үр нөлөө.
- ✓ Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.
- ✓ Гадаад харилцаанд үзүүлэх үр нөлөө.

III. Судлаачид ямар үр ашигтай үйлчилгээ үзүүлж болох вэ?

- Аль болох тоон үзүүлэлт бүхий тооцоог гаргах.
- Тооцооны хэлбэлзэх хүрээг гаргах.
- Өртөг болон ашгийг тооцох, эерэг ба сөрөг үр дүнг гаргах.
- Мөнгөн хэлбэрээр тооцох боломжгүй чанарын үр нөлөөг гаргах.
- Хэдийгээр тодорхой мэдээ, мэдээлэл байхгүй нөхцөлд ч судлаач өргөн баригдсан хуулийн төслийн болзошгүй үр дагаварыг тодорхойлох бололцоотой.
 - Энэ хуулийн төслийг дэмжигч, эсэргүүцэгчдийн харьцааг гаргах.
 - Өргөн баригдсан хуулийн төслийн эдийн засгийн үр дагавар, өртгийн талаархи Засгийн газар болон бусад экспертүүдийн хийсэн тооцоо, судалгааг тайланд оруулах.
 - Бусад улс орны ижил төрлийн хуулийн харьцуулсан судалгааг гаргах.
 - Эдийн засагт үзүүлэх үр дагаварыг асуулт хэлбэрээр нягтлах.
- Тооцоог гаргахад дараах бэрхшээлүүд тохиолдоно. Үүнд:
 - Ихэнх тохиолдолд холбогдох мэдээллүүд байхгүй байх.
 - Урьдчилан тооцоогүй үйл явдлууд үнэлгээг үнэ цэнэгүй болгох.
 - Төлөвлөөгүй хийгээд гэнэтийн үр дагавар гарах.

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД (СОНГОГЧИД) ХҮРЧ АЖИЛЛАХ НЬ**Урьдчилсан нөхцөл**

- Хариуцаж буй асуудал, парламент дээр юу болж байгаа талаар байнга сонсож мэдэх, шинэ соргог мэдээлэл авч ажиллах.
- Хууль тогтоох асуудлыг урьдчилан харж, асууж лавлаж болох асуултад хариулах бэлтгэлтэй байх.
 - Хүсэлт тавихыг хүлээхгүйгээр дүн шинжилгээ хийх ажлыг цаг ямагт хийж байх.
 - Хэрэв боломжтой бол танд хандаж ийм хүсэлт тавихаас өмнө тайлан гаргаж байх.

Хууль тогтоох хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийг олж мэдэж хариу арга хэмжээ авах

- Судлаачид сайн үйлчилгээ үзүүлэх нь УИХ түүнийг өргөнөөр ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Өөрийн нөөц бололцоо (юуны өмнө байнгын хороод)-нд анхаарлаа хандуулах.
- Хууль тогтоох нөлөөтэй асуудлуудад төвлөрч ажиллах.
- Сонгогчдын санал хүсэлтийн мөрөөр бодитой, үр дүнтэй хариу арга хэмжээ бага хугацаанд авах нь таныг нэр хүндтэй болгоно.
- Санал хүсэлт тавьсан хүнтэй байнга эргэж холбоо барьж байх (бодит асуудлыг олж тогтооход нь тусалж, түүнийг хэрхэн ашиглах бодолтой байгааг нь асууж, хэрэгжих боломжтой хугацааг товлож, түүнийг баримталж ажиллах).

Сонгогчид заримдаа ойлгоход бэрхшээлтэй буюу чухам юу хэлэх гээд байгаа нь мэдэгдэхгүй асуулт тавьдаг. Иймд:

- Сонгогчдын санал хүсэлтэд хариу өгөхдөө тэдэнд өөр ямар нэгэн санал хүсэлт байгаа эсэхийг асууж байх.
- Сонгогчдын санал хүсэлтэд хэзээ ч “үгүй” гэсэн хариу өгөхгүй байх. Гэхдээ өөрт байгаа нөөц бололцоо, цаг хугацаанд тохируулан санал хүсэлтийг шийдвэрлэх.

Сонгогчид дандаа хэрэгжих боломжгүй хугацаанд хэтэрхий олон асуудлыг шийдэж өгөх санал хүсэлт тавьдаг. Иймд:

- ❖ Өөрийн хийж чадахгүй зүйлийг амлахгүй байх.
- ❖ Эмзэг ба санал хуваагдаж туйлшралд хүргэж болох асуудлыг мэдэж, нилээд болгоомжтой хандаж байх.
- ❖ Сонгогчид танаас юу хийх талаар зөвлөмж өгөхийг хүссэн боловч зөвлөмж өгөхгүй байх (түүний оронд ижил төстэй хувилбар гаргах, хувилбар тус бүрийн давуу ба сул талуудын талаар ярилцах).

МЭДЭЭЛЛИЙГ ОЛЖ АВАХ БА АШИГЛАХ**I. Шинэ мэдээллийг хаанаас хайх вэ?**

- Хамтран ажиллагсад, бусад судлаач болон байгууллагынхаа номын санч нараас
- Парламентын гишүүн ба байнгын хорооны ажилтнууд
 - Чуулганаар хэлэлцэх асуудлын талаар мэдээлж байх,
 - Тамгын газрын чиг үүрэгт заасан бусад
- Яам, Тамгын газрын мэргэжилтнүүд
- Их, дээд сургуулийн багш, судлаач нар
- Бие даасан судалгааны байгууллага /Think tanks/
- Төрийн бус байгууллага
- Сонирхлын бүлгүүд
- Гадаадын судлаачид ба манай улсад суугаа Элчин сайдын яамны мэргэжилтнүүд

II. Интернэт, сонин, сэтгүүл ашиглах нь

- Өөрийн судалгаанд хэрэгцээтэй мэдээллийн эх сурвалжийг сайн мэдэж байх нь чухал. Мөн та мэдээллийн эх сурвалжийг хайж байх хэрэгтэй.

- Мэдээллийн эх сурвалж бүрийн давуу ба сул тал, туйлшралын талаар сайн мэддэг байх ёстой.
- Мэдээллийн тухайн эх сурвалжийг хэзээ, хэрхэн ашиглах нь зохимжтойг мэдэж байх хэрэгтэй.
- Мэдээллийн эх сурвалж бүрт итгэж болохгүй. Учир нь зарим эх сурвалж нь мэдээллийг өөрийн ашиг сонирхлын өнцгөөс тайлбарладаг.
- Баталгаатай хоёрдогч мэдээллийн эх сурвалж таны судалгааны ажлыг үндсэн эх сурвалж руу хүргэх ач холбогдолтой.
- Интернет нь судлаачийн ажлын чухал хэрэгсэл боловч түүнийг болгоомжтой ашиглах ёстой.
 - Олны итгэл хүлээсэн вэб сайтыг хайх.
 - Үйлчлүүлэгчээ баталгаатай, бодит мэдээллээр хангах.

III. Ажил хэргийн өргөн холбоотой байхын ач холбогдол

- Таны ажил хэргийн холбоо сүлбээ нь хамгийн чухал бөгөөд баталгаатай мэдээллийн эх үүсвэр байдаг.
- Ажил хэргийн холбоо сүлбээ нь зарим тохиолдолд мэдээллийг богино хугацаанд олж авах цорын ганц арга зам байж болно.
- Хэрэв та мэдээлэл авах шаардлагатай байгаа албан тушаалтныг таньдаг бол түүнээс албан ёсны мэдээлэл авах нь хялбар болно.
- Хэрэв зарим байгууллагууд таны мэдээлэл авахыг хүссэн хүсэлтэд хариу өгөхгүй бол та тэвчээртэй хүлээж, шаардах хэрэгтэй.
- Бие биенээ танихгүй учраас албаны хүнээс мэдээлэл авах нь эхний үед бэрхшээлтэй байж болно.
 - Өргөн холбоо сүлбээтэй хамтран ажиллагаадаасаа туслалцаа ав.
 - Засгийн газрын болон бусад байгууллагын шинжээч нар танд мэдээлэл өгөхдөө тухайн асуудалд хандах өөрсдийн өнцгийг хууль тогтоогч нарын сонорт хүргэх хүсэлтэй байдаг.

IV. Ажил хэрэг, мэргэжлийн сүлжээг хэрхэн бий болгох вэ?

- Таны судалгааны чиглэлийн сэдвээр зохиогдох бага хурал, семинар болон уулзалтуудад оролц.
- Бусад байгууллагын судлаач нартай Парламентын ордонд уулзалтуудыг зохион байгуул.
- Парламентын гаднах байгууллагуудын шинжээч судлаач нарт өөрийгөө таниулах уулзалтуудыг зохион байгуул.
- Засгийн газар, төрийн бус байгууллага, их сургууль болон олон улсын байгууллагын судлаач шинжээч нартай тогтмол уулзалтуудыг санаачлан зохион байгуул.
- Хамтран ажиллах нь харилцан ашигтай гэдгийг ойлгуул.
 - Бусад байгууллагын шинжээч нарт Парламентын талаархи мэдээллийг танаас авч болно гэдгийг ойлгуул.
 - Тэд танаас асуулт асуух бүрт нь туслаж, хариуг цаг тухайд нь өгөөрэй.
 - Мэдээж та нууцын зэрэглэл бүхий мэдээллийг тэдэнд өгөх боломжгүй.

- Таны ажилладаг судалгааны байгууллагын удирдлага, менежерүүд танд туслах боломжтой ч судлаач бүр өөрийн ажлын холбоо сүлбээ, танилын хүрээг өргөсгөж байхад анхаарч байх хэрэгтэй.

БАГААР АЖИЛЛАХ НЬ.

- ❖ Бусдын мэдлэгийг ашиглах
- ❖ Салбар хоорондын хамтын ажиллагааг судалгаанд нэвтрүүлэх
- ❖ Мэргэжлийн туйлшрал гарч болзошгүйг анхаарах
- ❖ Хамтран ажиллагсад харилцан бие биенээ хүндэтгэх
- ❖ Багийн гишүүдийн ажлын газрын байршлыг харгалзах
- ❖ Бие биенээ таньж мэдэх, харилцан ойлголцох
- ❖ Байнгын хорооны ажлыг сайжруулах
- ❖ Судалгааны алба болон үйлчлүүлэгчийн сонирхолд нийцнэ.
- ❖ Өөрийнхөө ажлын хариуцлагыг үүрэх

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛЖ СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧИХ

I. Судалгааны тайлангаас хууль тогтоогчид юу мэдэх ёстой вэ?

Хууль тогтоогчид бол тусгай үйлчлүүлэгчид юм.

- Тэд ихэвчлэн маш завгүй байдаг ба өргөн хүрээтэй асуудлуудыг хэлэлцэж санал өгдөг.
- Тэд зарим нэг салбарын асуудлаар мэргэшсэн байж болох авч бүх салбарын асуудлаар мэргэших боломжгүй.
- Тэд сайтар боловсруулсан мэдээллийг үндэслэн хамгийн зөв шийдвэр гаргахыг хүсдэг

Дээрх онцлогт зарим шинэ судлаач шинжээчид богино хугацаанд зохицдог бол заримд нь илүү хугацаа шаардагддаг. Асуудлыг зөв шүүн тунгаах, асуудлыг шийдвэрлэх оновчтой хувилбар боловсруулахын тулд судлаач өргөн мэдлэгтэй, дүн шинжилгээ хийх чадварыг сайтар эзэмшсэн байх ёстой. Хууль тогтоогчдод тухайн асуудлын юун дээр анхаарахыг шүүж гаргаагүй, түүхий мэдээллээр дүүрэн нуршуу тайлан бичдэг судлаач нь парламентад сайн үйлчилгээ үзүүлж чадахгүй.

II. Хууль тогтоогчдод зориулж тайлан бичихэд тавигдах шаардлага

- Хууль тогтоох байгууллагын хэрэгцээг цаг тухайд нь хангасан байх.
- Асуудлын голыг тодорхойлсон бөгөөд товч байх.
- Хураангуй хэсгийг тайлангийн эхэнд оруулах нь хэрэглэгчдэд ойлгоход хурдан бөгөөд хялбар байна.
- Бичгийн найруулга нь зохих зиндаанд нийцсэн байх
- Мэдээлэл үнэн, баталгаатай байх.
- Аль нэг улс төрийн хүчнийг дэмжсэн, туйлширсан байхгүй байх.
- Ишлэл, эх сурвалжийг бичсэн байх
- Хянагдсан байх.

III. Тайлангийн бүтэц, зохион байгуулалт

- Батлагдсан нэг загвар байхгүй
- Тодорхой, товч ба ойлгоход хялбар
- Ердийн товч тайлан нь доорх хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - ✓ Хураангуй
 - ✓ Асуудлыг томъёолсон удиртгал хэсэг
 - ✓ Дүн шинжилгээ
 - ✓ Дүгнэлт /зөвлөмж биш/

IV. График зураг, хүснэгт зэргийг ашиглах

УЛСЫН ИХ ХУРАЛ БА ХУУЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хууль тогтоох танилцуулга

- Засгийн газраас өргөн мэдүүлсэн ихэнхи хуулийн төсөлд ийм танилцуулга бэлтгэх.
- Энгийн, хуулийн бус, ойлгомжтой үг хэллэгээр бичих.
- Асуудал, баримт дэвшүүлж тавих.
 - Хуулийн төсөл боловсруулагчид урьдчилан таамаглаагүй үр дагавар
 - Хуулийн төслийн талаар гаргаж болох адилтгах тайлбар.
 - Хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж гишүүдэд хэлэлцэх үндэслэлийг гаргаж өгөх.

Байнгын хороонд ажиллах

- Хуульчид нь хуулийн зөвлөгөө юм уу эсвэл тайлбар авах шаардлагатай байгаа аливаа байнгын хороонд туслалцаа үзүүлэх.
 - Хуулийн хэрэгцээ шаардлагатай үед үүрэг даалгавар авч ажиллах.
 - Хуулийн байнгын хороодод тогтмол туслалцаа үзүүлэх.

Гишүүдийн хуулийн төсөл

- Асуудалд хуулийн дүн шинжилгээ хийх.
 - Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг авч үзэх
 - Бусад холбогдох хууль тогтоомж
 - Хуулийн төслийн зорилгыг хэрхэн хангах

Гишүүдэд үзүүлэх туслалцаа

- Хуулийн үг хэллэгийг тайлбарлах
- Тухайн асуудал эрх зүйн зарчим, үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хэлэлцэх.
- Үг хэллэгийн хувьд хуулийн төслийг хэрхэн боловсруулах талаар ижил төстэй хувилбаруудыг санал болгох

Бусад хэвлэл нийтлэл

Судлаачид юуг хийхгүй вэ!

- Гишүүнд хувийн хуулийн зөвлөгөө өгөх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Хууль эрхийн асуудлаар сонгуулийн тойрогт туслалцаа үзүүлэх
- Хуулийн төсөл боловсруулах
- Парламентад хэрэгжүүлэх ажил үүрэгтэй холбоогүй ажил хийх.

БЭРХШЭЭЛТЭЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

Нийтлэг бэрхшээлтэй асуудлууд

- Хэтэрхий ихийг хэт богино хугацаанд хүсэх
- Тодорхой бус асуултанд хариу авахыг хүсэх.
- Таны хийж буй судалгааны ажилд өөрийнхөө дүгнэлт саналыг оруулж дэмжүүлэхийг хүсэх, шаардах (өөрийн үзэл бодол, байр суурийг таны судалгааны ажил болон таны нэр хүндийг ашиглан хүлээн зөвшөөрүүлэх).
- Тэнцвэртэй, аль нэг тал руу туйлшраагүй судалгааг үл хүсэх (тодорхой бодлогыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн баримт, үндэслэлийг гаргахыг хүсэх).
- Асуудлыг шийдэх цөөн хувилбаруудыг гаргахыг хүсэх, гол саналуудыг орхигдуулах.
- Зөвхөн итгэл даасан судлаачаар судалгаа хийлгэхийг хүсэх (тэр итгэл даасан судлаач нь тухайн асуудлаар мэргэшсэн эсэх нь хамаагүй).
- Таныг өөрийн намыг дэмжигч гэж бодох, тиймээс өөрийнх нь саналыг дэмжинэ гэдэгт итгэх.
- Танаас ямар шийдвэр гаргах асуудлаар зөвлөлгөө авах.

Зарим зөвөлгөө

- Объектив судалгаа хийдэг гэсэн нэр хүндийг олж ав (Энэ нэр хүндээ хадгалж үлдэхийн тулд бүхнийг хий. Удирдлагаараа зохих удирдамжийг батлуулан мөрд).
- Нийгмийн давхраажилт, бүлгүүдийн талаар ойлголттой байж тэдний эрх ашгийг судалгаандаа адил тусга. (яс үндэс, шашин шүтлэг, бүс нутаг, улс төр, философи, хүйсийн байдал, эдийн засгийн статус гэх мэт).
- “Зорилгот мэдээлэл”-ийг зөвхөн тодорхой нэг байр суурийг сонсохыг хүссэн захиалагчид бэлтгээрэй (захиалагчийн хүссэн ёсоор энэ мэдээллийг тэнцвэртэй байх зарчмаар бэлтгээгүй гэдгийг ойлгуулах).
- Асуудлын зөвхөн нэг талыг харахыг хүсэгчдэд тэдний байр суурьтай зөрчилдөгч талын байр суурь ямар үндэслэлтэй байж болох талаар сонсох хүсэлтэй эсэхийг асуух.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ СЕКТОРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БА ҮЙЛЧИЛГЭЭ

1. Өргөн хүрээнд тараагдах тайлангууд:

- **Факт хуудас** нь тодорхой бөгөөд үндсэн мэдээлэл өгнө.
- **Богино хугацааны тайлан** нь яаралтай хэлэлцэх тодорхой нэг асуудлын тухай мэдээллээр хангана.
- **Богино хугацааны дүн шинжилгээний тайлан** нь хэд хэдэн асуудлын талаархи мэдээллээр хангана.
- **Урт хугацаанд хийх дүн шинжилгээний тайлан** нь хууль тогтоох эсвэл хяналтын асуудлаар судалж үр дүн нь удаан хугацаанд гарна.
- **Хууль бүртгэх ба хуульд харьцуулсан судалгаа** хийсэн тайлан.
- Бусад бүтээгдэхүүн

2. Нууц санамж бичиг ба тайлан:

- Тухайн гишүүн болон байнгын хорооны захиалгаар хийх нууцын зэрэглэлийн судалгааны ажил нь үйлчилгээний чухал хэсэг.
 - Захиалгыг зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээлэх, вэб хуудас дээр ил тавих ёсгүй мэдээлэл.
 - Хязгаарлагдмал хүрээнд ашиглах мэдээлэл
- Байнгын хороонд захиалгаар хийх судалгаа
 - Хууль тогтоох эсвэл хуулийн хэрэгжилтийн хяналтын асуудлын дүн шинжилгээ ба танилцуулах мэдээ
 - Гэрчийн мэдүүлэг авах зорилгоор боловсруулсан асуулт хариулт
 - Гэрчийн нэрсийн жагсаалт
 - Байнгын хорооны тайлан

1. Байнгын хорооны гэрчийн мэдүүлэг

3. Үйлчилгээний төрлүүд:

- Зөвлөлгөө ба амаар танилцуулга хийх,
- Байнгын хорооны ажилд шууд дэмжлэг үзүүлэх
- Шинээр сонгогдсон гишүүний сургалтыг явуулах
- Хуралдааны дэг болон бодлогын асуудлаар гишүүдэд зориулан семинар хийх
- Ажилтнуудад зориулсан семинар, сургалтуудыг явуулах,
- Судалгааны албаны вэб сайт ба мэдээллийн санг ажиллуулах,
- Бусад үйлчилгээ үзүүлэх,

СУДАЛГААНЫ АЛБАНЫЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ**Судалгааны албыг зохион байгуулах нь**

- Ихэнх тохиолдолд хууль тогтоох байгууллага нь бие даасан мэдээлэл шинжилгээний төвүүдийг буй болгодог. Энэ төвүүдийг ихэвчлэн доорх үүрэгтэйгээр зохион байгуулна. Үүнд:
 - ❖ Судалгаа
 - ❖ Номын сан
 - ❖ Сургалт
 - ❖ Төсвийн дүн шинжилгээ
 - ❖ Хуулийн дүн шинжилгээ
- Энэ нь дээрх төвүүд ихэнхдээ давхардсан үйлчилгээ үзүүлэх болон парламентын гишүүд хэнд хандахаа мэдэхгүй будилах зэрэг сөрөг үр дагавартай байдаг.
- Энэ хүндрэл нь судалгаа, сургалт болон номын сан зэрэг ойролцоо үйлчилгээ үзүүлдэг нэгжүүд дээр илүү ажиглагддаг.
- Иймээс дээрх тусдаа нэгжүүдийг хэсэгчлэн эсвэл бүрэн нэгтгэх хандлага ажиглагдаж байна. Хэсэгчлэн нэгтгэх нь судалгаа, мэдээлэл хариуцсан нэг менежерийн удирдлаган дор номын сан, судалгааны төвийг оруулахыг хэлнэ. Мөн парламентын гишүүд зөвхөн нэг албан тушаалтанд судалгааны захиалгыг өгнө. Бүрэн нэгтгэх нь дээрхи менежерийн удирдлага дор сургалтын нэгжийг оруулахыг хэлнэ.

- Судалгаа мэдээллийн хэлтсийн үйл ажиллагааг нягтруулах, сайн зохицуулалтанд оруулах хувилбаруудыг судлах шаардлагатай болно.
- Судалгааны алба өргөжин бэхжих тусам түүний дотоод зохион байгуулалтыг салбар, мэргэжлээр нь хуваах эсвэл нэгдмэл байлгах асуудлыг шийдэх хэрэгтэй болдог.
- Судалгааны албаны бүтэц зохион байгуулалтаас үл хамааран тус албын хамгийн чухал үйлчлүүлэгч нь парламентын байнгын хороод байна.

Судалгааны албыг хөгжүүлэх нь

- Судалгааны албыг байгуулахдаа чанартай үйлчилгээ үзүүлэхэд ямар нөөц хөрөнгө байгааг анхаарах
- Судалгааны албаны хөгжлийн үе шат бүрийн санхүүжилт нь парламентын шууд дэмжлэгээс хамаарна. Өөрөөр хэлбэл парламент хэдий хэмжээний чухал мэдээллийг судалгааны албанаас авч байна төдий чинээ тус албыг дэмжих нөхцөл бүрдэнэ.
- Судалгааны алба парламентын дэмжлэгийг сайн үйлчилгээ үзүүлснээр олж авахын зэрэгцээ парламентын гишүүд судалгааны албаны нөөц боломжийг аль болох үр дүнтэй ашиглах мэдлэг чадварыг эзэмших хэрэгтэй.
- Судалгааны албыг хөгжүүлэх зорилгоор парламентруу хандсан чухал алхамууд:
 - Төгс нөхцөл нь судалгааны албыг байгуулах эрх зүйн орчныг буй болгох
 - Хүлээн зөвшөөрөгдсөн Ёс зүйн дүрэм батлуулах
 - Парламентын хяналтын хороог байгуулах
 - Мэдлэг чадварыг үндэслэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх
- Бага хэмжээнд эхлэх гэхдээ удаан хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй байх:
 - Эхний үе шатанд сайн бэлтгэгдсэн цөөн тооны судлаачыг ажиллуулах
 - Дунд үе шатанд судалгааны алба бүрэн хэмжээнд ажиллаж хууль тогтоогчдын дэмжлэгийг хүлээсний үндсэн дээр орон тоогоо нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөсгөх
 - Алсын зорилго нь хөгжин бэхжсэн судалгааны төвийг буй болгох.
- Хөгжлийн үе шат бүр нэн шаардлагатай байгаа мэргэжлийн ур чадварыг сайжруулахад анхаарах
- Сургалт болон ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ тогтмол авах.

НОМЫН САН, СУДАЛГААНЫ АЛБЫГ НЭГТГЭХ НЬ

Лавлагааны номын санчид тавих шаардлага

- ❖ Номын сангийн шинжлэх ухааны эрдмийн зэрэг эсвэл ажлын туршлага
- ❖ Тухайн шинжлэх ухааны баклавын зэрэгтэй байж болно.
- ❖ Эх сурвалж болон мэдээллийн санг ажиллуулах, мэдээллийг олж тогтоох чадвар эзэмшсэн байх
- ❖ Парламентын гишүүд болон байнгын хороодоос мэдээлэл хүссэн хүсэлтэд шууд хариу өгөх

Судлаачид тавих шаардлага

- ✓ Шинжлэх ухааны эрдмийн зэрэг

- ✓ Хэд хэдэн салбарын судалгааны ажлыг гүйцэтгэх чадвар
- ✓ Тодорхой салбарын талаархи мэдлэгтэй байх
- ✓ Судалгааны тайлан бичих чадвартай байх
- ✓ Парламентын гишүүд болон байнгын хороодоос захиалах судалгааны ажлыг гүйцэтгэх

Хоорондын харилцаа

Парламентын номын сан болон судалгааны алба нь тус тусын ажил үүргийн дагуу парламентын гишүүд болон байнгын хороодоос ирэх хүсэлтийг хүлээн авч ажиллана.

Хамтран багаар ажиллах

- Номын санчид мэдээллийн эх сурвалж, баримт материалаар хангах,
- Судлаачид мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судалгааны тайлан бичнэ.

Бүтэц зохион байгуулалтын хувилбарууд:

- ❖ Хууль тогтоох байгууллага дахь бие даасан нэгжүүд
- ❖ Номын сан дахь бие даасан нэгжүүд, өөр өөр менежерт захирагдана.
- ❖ Нэг менежерт захирагдах тусдаа нэгжүүд
- ❖ Нэгдсэн алба

* * *

Ашигласан материал

1. “Хууль тогтоох чиглэлийн судалгаа ба дүн шинжилгээ” АНУ-ын Конгрессийн сургалтын гарын авлага, АНУ.,2009.
2. “СШОНХТ-ийн судлаач, шинжээч нарт зөвлөмж”, Ц.Норовдондог, УБ.,2009.
3. “Судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулах удирдамж” ННФ, УБ.,2011.
4. “Хууль бүтээх ажиллагаан дахь бодлогын шинжилгээ, ач холбогдол”, Ц.Болормаа, магистрын ажил,УБ.,2010.



UIN.MN

СУДАЛГААНЫ САН

1

БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ТӨСВИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ПАРЛАМЕНТ
ДАХЬ БҮТЦИЙН НЭГЖҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа,
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*

Гарчиг

Судалгааны дүгнэлт

1. Төсвийн судалгааны алба (СВО)

1.1. АНУ-ын Конгресс

- Эрх зүйн орчин
- Конгрессийн төсвийн алба
- Конгрессийн төрийн хариуцлагын алба
- Конгрессийн судалгааны алба

1.2. БНСУ-ын Төсвийн алба

1.3. Канадын Парламентын төсвийн алба

1.4. Гүржийн Парламентын төсвийн байгууллагууд

- Парламентын төсвийн газар
- Төсөв Төлөвлөлтийн Газар
- Сенатын Төсөв Үнэлгээний Газар
- Сенатын Төсөвлөлтийн Хороо
- Нийтийн Танхимын Төсвийн Газар
- Төсвийн Хууль Тогтоох Газар

2. Төрийн хариуцлагын хороо (РАС)

- 2.1. Их Британи
- 2.2. Австрали
- 2.3. Шинэ Зеланд
- 2.4. Канад

3. Монгол Улсын нэгдсэн төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үе шатуудад оролцох төрийн байгууллагуудын чиг үүрэг

Ашигласан материал, эх сурвалж

Хавсралт 1.

- АНУ-ын Конгрессийн төсвийн албаны судалгаа шинжилгээ хийх цагийн хуваарь

Хавсралт 2.

- АНУ-ын Конгрессийн Судалгааны төвийн судалгааны салбар, дэд салбарууд

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Судалгаанаас үзэхэд, сүүлийн үед парламентын төсөв хэлэлцэх чадавхийг сайжруулахад бусад орнууд ихээхэн анхаарч байгаа нь харагдаж байна. Учир нь хууль тогтоох байгууллагын зүгээс шаардлагатай бол өргөн барьсан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, эрх бүхий зарим байгууллагыг төсвийн хувьд Засгийн газраас хараат бус байлгах, улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэх үүднээс төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, төсвийн судалгаа шинжилгээ болон хэлэлцүүлэгт бэлтгэх үйл ажиллагаа, төсөв батлагдсаны дараахь хяналт шинжилгээ гэх зэрэг функциональ үйл ажиллагаануудыг тодорхой бүтцийн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

Ялангуяа шинэ тутам байгуулагдсан парламентуудын хувьд энэхүү бүтэц, үйл ажиллагаа дутагдалтай байгаагаас сонгогчид парламентын гишүүдийн төсөв баталж байгаа арга хэлбэр, оролцоонд сэтгэл дундуур байх, шүүмжлэх өнгө аяс давамгайлж байна. Нөгөө талаас парламентад өөрт нь төсвийн хэлэлцүүлэг хийхэд техник зохион байгуулалт, мэргэжил, арга зүй, судалгаа шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг нэгж байхгүй, эсвэл чадавхи сул байгаагаас Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийг тооцоо судалгаагүйгээр батлах, эсвэл үндэслэл тооцоогүйгээр өөрчлөлт оруулах, оруулсан өөрчлөлтийнхөө үндэслэл хангалтгүй байх, батлагдсан төсвийг хэрхэн зарцуулж байгаад парламентаас хяналт тавих боломж бүрдээгүй зэрэг сөрөг дүр зураг харагдаж байна.

Ялангуяа парламентын засаглалыг шинэ тутам төлөвшүүлж байгаа орнуудын хувьд энэ бол нийтлэг асуудал бөгөөд бусад орнууд нэгэнт бий болгосон бүтэц, дэлхий нийтийн жишгийг даган зохион байгуулалтын арга хэмжээ авч, чадавхижуулах талаар анхаарч байгаа юм байна.

Манай орны хувьд мөн ялгаагүй дээрхи асуудлууд тулгарч байгаа учраас ядаж одоо байгаа бүтэц дээрээ тулгуурлан бага зэргийн өөрчлөлт хийж, чадавхижуулах арга хэмжээ авбал зохимжтой болох үүднээс судалгааг гүйцэтгэлээ. Одоогоор УИХ-ын бүтцэд Төсвийн байнгын хороо, Төсвийн Зарлагын дэд хороо, УИХ-ын Тамгын газрын бүтцэд Судалгааны төв (Макро эдийн засаг, Төсвийн шинжилгээний сектор), мөн УИХ-ын харьяанд Үндэсний Аудитийн газар тус тус ажиллаж байна. Эрхэлж байгаа ажлын чиг үүргийн хүрээнд:

1. Тамгын газрын бүтцэд байдаг Төсвийн байнгын хороо нь 4 ажилтантай, Төсвийн Зарлагын дэд хороо нь УИХ-аар төсөв хэлэлцэх үед Байнгын хороо болон Чуулганаар хэлэлцэх бэлтгэл ажлыг зохион байгуулах, Байнгын хорооны санал болон тэмдэглэл хөтлөх хэмжээнд техник-зохион байгуулалт, протокол, тэмдэглэлийн ажлыг хариуцан хийж байна.
2. Тамгын газрын Судалгааны төвийн хувьд УИХ-ын төсөв хэлэлцэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Макро эдийн засаг, төсвийн судалгааны сектор/ 3-5 хүнтэй/ -ыг дотоод бүтэцдээ ажиллуулж судалгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа боловч Засгийн газар, Сангийн яам, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо зэрэг холбогдох байгууллагуудаас мэдээллийг шуурхай авах боломжгүй, өндөр түвшний математик анализ хийх, дүгнэлт гаргах чадавхи сул байна. Гэвч өнгөрсөн 2 жилийн төсвийн хэлэлцүүлгийн явцад Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийг хялбаршуулан, ойлгомжтой байдлаар гарын авлага болгож гишүүдэд хүргүүлэх, бусад орнуудын туршлагыг судлах, өргөн барьсан болон батлагдсан төсөвт дүн шинжилгээ хийх, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах зэргээр өөрсдийнхөө боломжоор ажиллаж байна.
3. Үндэсний Аудитийн газар нь УИХ-ын харьяанд төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Одоогоор ҮАГ нь зөвхөн төсөвт байгууллага, төрийн өмчит компаниудад санхүүгийн аудит хийх хэмжээнд хяналт шалгалтын байгууллага мэт ажиллаж байгаа нь хангалтгүй юм. Зүй нь энэ байгууллага төсвийн зарцуулалтанд хяналт тавихаас гадна төсвийн төлөвлөлт, төсвийн зарлагын бодлогын

талаар судалгаа, тооцоо хийж УИХ-ын мэдээлэл, судалгаагаар хангах ёстой боловч энэ чиглэлийн үүргээ орхигдуулж байна.

4. Бусад орнуудын туршлагаас үзэхэд, парламентыг төсвийн талаархи хараат бус мэдээлэл, шинжилгээгээр хангах бие даасан нэгж байгуулах энэ асуудлыг шийджээ. Тухайлбал, Бельги, Канад, Унгар, Солонгос, Нидерландад PBO / Parliamentary Budget office)-100 орчим хүнтэй, эсвэл Австри, Шведэд Fiscal Council, АНУ-д CBO (Congressional budget office)-235 хүнтэй гэх мэтээр нэрлэдэг, нэлээд томоохон бүтэцтэй нэгж бие даан ажилладаг байна. Энд макро эдийн засгийн шинжээч, татварын шинжээч, төсвийн шинжээч, Засгийн газар хариуцсан шинжээч, тойрог хариуцсан шинжээч, аналитик шинжээчид, программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан гэх мэтийн томоохон бүтэцтэй. Иймд дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:
 - Одоо үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн хэлэлцүүлэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээний, Үндэсний аудитийн газрын болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны эрх, үүрэг, ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхийг сайжруулах.
 - PBO (Parliamentary Budget office) гэдэг нь үндсэндээ парламентыг төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй. Хамгийн гол үүрэг нь Төсвийн шинжилгээний болон зохион байгуулалтын үүрэг юм. Засгийн газрын төсөвт хяналт тавих, парламентыг үндэслэл тооцоо бүхий мэдээллээр хангахын тулд Засгийн газар (Сангийн Яам)-тай өрсөлдөхүйц хэмжээнд чадавхи сайтай, мэдээллийн сайн баазтай, намаас ангид, хараат бус байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Бүтэц, харьяалалын хувьд парламентын Тамгын газрын бүтцэд, Судалгааны албаны бүтцэд, бие даасан хэд хэдэн хэлбэр байна. (PBO, CBO, Fiscal council)

Нэг. ТӨСВИЙН СУДАЛГААНЫ АЛБА (СВО)

1.1. АНУ-ын Конгресс

Эрх зүйн орчин

АНУ нь Холбооны Бүгд найрамдах, Үндсэн хуульт, Ерөнхийлөгчийн засаглалтай улс. Тус улсын Конгрессийн эрх үүргийг Үндсэн хуулиараа зохицуулсан бөгөөд Сенат болон Төлөөлөгчдийн танхим гэсэн хоёр танхимтай. Дээд танхим болох Сенат нь 100 гишүүнтэй. Доод танхим болох Төлөөлөгчдийн танхим 435 гишүүнтэй. Конгрессийн бүрэн эрх нь хууль батлах ба тодруулбал Төлөөлөгчдийн танхим улсын төсөв болон татварын хуулийн төслийг, Сенат бусад хуулийн төслийг тус тус хэлэлцэнэ.

Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн (Budget and Accounting Act, 1921) дагуу Ерөнхийлөгчийн улам бүр нэмэгдэж байсан нөлөөллөөс болгоомжилж Конгресс уг хуульд томоохон өөрчлөлт оруулахыг хүсэх болсон. Учир нь уг хуулийн дагуу байгуулагдсан Төсвийн товчоо нь төсвийн талаархи мэдээллийг Ерөнхийлөгчид бэлтгэн өгдөг бөгөөд энэ нь Ерөнхийлөгчид улсын төсвийн талаархи мэдээллийг “өмчлөх” бололцоог олгож байв. Тухайн үед зарим гишүүд нь гүйцэтгэх засаглалын боловсруулан Конгресст өргөн барьж байсан төсөвтэй холбоотой мэдээллүүдийн үнэн зөвт эргэлзэж байв.

Эдгээр болон бусад шалтгаанаар 1974 онд **Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хуулийг** (Congressional Budget and Impoundment Control Act, 1974) баталжээ. Энэхүү хуулиар Ерөнхийлөгчийн төсөв хөрөнгийг захиран зарцуулахад хяналт тавих шинэ процедуруудыг хуульчилжээ. Мөн Ерөнхийлөгчөөс хамаарахгүйгээр Конгресс шаардлагатай гэж үзэж байгаа төсвийн тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлж, хэрэгжүүлэхэд нь хяналт тавих боломжтой болсон байна. Тодруулбал,

төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, Засгийн газраас хараат бус, төвийн сахисан, үнэн зөв, шинжлэх ухааны үндэслэл, тооцоо бүхий судалгаа, шинжилгээ хийдэг, Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод төсөвтэй холбоотой мэдээлэл гаргаж өгдөг хүчирхэг нэгж шаардлагатай гэж үзсэн тул Конгрессийн дэргэд төсвийн шинжилгээ, судалгаагаар мэргэшсэн аппарат, нэгжүүдийг ажиллуулах болсон. Мөн Конгрессоос баталсны дагуу Ерөнхийлөгчийн зүгээс төсвийг захиран зарцуулахгүй байгаад тавих хяналтын системийг бий болгосон, хоёр танхимд тус бүрд нь зөвхөн төсвийг боловсруулах ажлыг хариуцах хороодыг байгуулсан, Конгресст төсвийн тэргүүлэх чиглэлийг Ерөнхийлөгчийн төсөвт баригдахгүйгээр тодорхойлох боломжийг олгосон байна.

Зураг 1. Холбооны улсын 2011 оны төсвийн үйл явц

Гүйцэтгэх засаглалын төсөв боловсруулах үе												Конгрессын төсөв хэлэлцэх үе								Төсвийн гүйцэтгэлийн үе												Аудит						
2009.III–2010.I												2010.II–2010.IX								2010.X–2011.IX												11.X–12.XII						
I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII			
2009												2010												2011														


Төсвийн удирдлагын газар нь төсвийг удирдан гүйцэтгэх засаглалын хүрээнд олон сарын турш боловсруулна. Хуулиар Ерөнхийлөгч холбооны улсын дараа жилийн төсвийг Конгресст 2-р сарын эхний Даваа гарагт өргөн барина. Конгресс төсвийг хүлээж авсанаас хойш олон сарын турш судалгаа хийж, хэлэлцэж, батлах (Хүснэгт 2.) бөгөөд энэхүү ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дараах албууд ажилдаг:

1. Конгрессийн төсвийн алба
2. Конгрессийн номын сангийн Судалгааны алба
3. Конгрессийн төрийн хариуцлагын алба

Конгрессийн төсвийн алба (CBO – Congressional budget office)

Бүтэц: Энэхүү холбооны агентлаг нь 1974 онд Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хуулийн дагуу байгуулагдсан. 250 гаруй ажилтантай, тэдгээрийн 70 хувь нь эрдмийн зэрэг цолтой төсвийн мэргэжлийн шинжээч, эдийн засагчид болон нийгмийн бодлогын шинжээчид ажилладаг Тус алба нь дараахь хэлтэст хуваагдана:

Зураг 2. Төсвийн албаны зохион байгуулалт



Сенатын ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын спикер нар Конгрессийн төсвийн албаны даргыг 4 жилийн хугацаатай хамтран томилдог ба аль ч танхим түүнийг тогтоолоор өөрчилж болдог.

Чиг үүрэг: Конгрессийн хоёр танхимаас нилээд хэдэн жилийн нэгдсэн төсвийг батлах бөгөөд энэ нь хууль болж ёсчлогдохгүй, зөвхөн орлого, зарлагатай холбоотой хууль батлах үйл ажиллагаанд гарын авлага болно. Үүнд Конгрессийн төсвийн алба нь Конгресс болон Сенат, Танхимын Төсвийн хороонд судалгаа, шинжилгээ хийж өгөх бөгөөд ингэхдээ улс төрийн ямар нэгэн зөвлөмжийг баримтлахгүй.

Алба нь жил бүрийн 1-р сарын сүүлээр хуульд заасны дагуу дараагийн 10 жилийн орлого, зарлагын тооцоог багтаасан төсөв, эдийн засгийн төлөв байдлыг гаргаж өгдөг. Мөн Ерөнхийлөгчийг АНУ-ын нэгдсэн төсвийг Конгресст өргөн барьснаас хойш нэг сарын хугацаанд уг төсөвт бие даасан, хараат бус шинжилгээ тооцоолол хийж төсвийн асуудал хариуцсан байнгын хороодод хүргүүлдэг. Үүний зэрэгцээ Конгрессийн санал болгосон төсвийн төсөлд ч үнэлгээ тооцоолол хийнэ. Конгрессын хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тооцооллыг боловсруулж, хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрүүдийн явцын үнэлгээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх зэргийг хийж сонирхогч талуудад хүргүүлдэг.

Конгрессийн төрийн хариуцлагын алба (GAO – Government accountability office)

Бүтэц: Конгрессийн төрийн хариуцлагын алба нь 1921 онд *Төсөв болон Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн* дагуу байгуулагдсан. Төв оффис нь Вашингтон хотод байх ба салбарууд нь АНУ-ын 11 гол хотуудад үйл ажиллагаагаа явуулдаг. Эдийн засагч, социологч, нягтлан бодогч, төрийн бодлогын шинжээч, өмгөөлөгч болон эрүүл мэндийн бодлогын мэргэжилтэн зэрэг 3300 гаруй албан хаагчидтай³ бөгөөд тэдний 2/3 нь төв оффист ажилдаг байна.

Албаны дарга буюу Ерөнхий хянагчийг Конгрессоос дэвшүүлсэн нэрсээс Ерөнхийлөгч 15 жилийн хугацаатайгаар томилдог. Төрийн албанд ховор байдаг ийнхүү урт хугацаагаар томилж байгаа нь тасралтгүй үргэлжлэх удирдлагыг хангаж байгаа хэрэг. Одоогийн Ерөнхий хянагчийн албыг Жин Л.Додаро хашиж байна.

Чиг үүрэг: Төрийн хариуцлагын албаны зарчим нь Конгрессийг цаг үеийн тулгамдсан асуудалтай холбогдсон бодит, баримт дээр тулгуурласан, нам бус, олон талт, шудрага, тэнцвэртэй мэдээллээр хангах явдал. Тус албаны эрхэм зорилго бол Конгрессийг Үндсэн хуулийн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад нь туслах бөгөөд америкийн ард түмний ашиг сонирхолын тулд Холбооны байгууллагуудын хариуцлагад баталгаа өгөх явдал юм.

Конгрессийн хороод, дэд хороодын хүсэлтийн дагуу дараахь үндсэн үүрэг, эрх мэдлийг хэрэгжүүлнэ:

- Улсын агентлагууд төсвийн хөрөнгийг хэр үр ашигтай зарцуулж байгааг тогтоохоор аудит хийх,
- Хууль бус болон буруу үйл ажиллагаа явуулж байгаа талаархи мэдэгдлийн дагуу шалгах,
- Төрийн бодлого, хөтөлбөрүүд зорилгодоо хүрч байгаа эсэхийг шалгах,
- Бодлогын судалгаа хийх ба Конгресст орж байгаа асуудлуудын хувилбарыг гаргаж өгөх.

Конгрессийн судалгааны алба (Congressional research service)

Бүтэц: “Конгрессийн тархи” гэгдэх энэхүү алба нь 1914 онд байгуулагдсан. Нийт 700 гаруй

ажиллагсадын 450 гаруй нь шинжээч, хуульчид бөгөөд дараахь судалгааны 5 хэлтэст хуваагдан ажиллаж байна (Бүтцийн дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү):

Хүснэгт 1. Судалгааны албаны зохион байгуулалт


1) Америкийн хуулийн хэлтэс	Хууль эрх зүйн орчинд бий болж байдаг олон мянган асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Зарим асуудал нь Үндсэн хуулийн хүрээнд Конгрессийн зохион байгуулалтын онцгой эрхэд хамаардаг.
2) Дотоодын нийгмийн бодлогын хэлтэс	<ul style="list-style-type: none"> • боловсрол, ажиллах хүч болон тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал; • эрүүл мэнд болон санхүүгийн даатгал; эрүүл мэндийн үйлчилгээ; • хүн амын наслалтын бодлогын судалгаа; • нийгмийн хамгаалал, тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдасны тэтгэмж; • цагаачлал, муж улсуудын аюулгүй байдал; • дотоодын мөрдөн шалгалт, эрүүгийн шүүн таслах ажиллагаа; • халамж, хоол хүнс, орон сууцны нөхцөл.
3) Гадаад харилцаа, батлан хамгаалах, худалдааны хэлтэс	<p>Гадаадын бүх улс орны улс төр, эдийн засгийн хөгжлийн судалгаа хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • олон улсын байгууллага; • АНУ болон бусад улс үндэстний хоорондын улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын харилцаа холбоо; • терроризм болон дүрвэгчид зэрэг улс үндэстэн хоорондын асуудал; • үндэсний аюулгүй байдал: <ul style="list-style-type: none"> • дайны стратеги, • АНУ-ын батлан хамгаалахын төсөв, • байлдааны хэрэгсэл, • дайны нөхөн олговор, • цэргийн бааз. • худалдаа: худалдааны гэрээ, экспорт, импорт, гаалийн тариф зэрэг эдийн засгийн асуудлууд.
4) Удирдлага, санхүүгийн хэлтэс:	<ul style="list-style-type: none"> • байгууллагууд, бүтэц, үйл ажиллагаа, Конгрессийн менежмент болон түүний агентлагийн дэмжлэг, шүүхийн удирдлага; • конгрессийн төсөв болон зарцуулалт, хууль тогтоох үйл ажиллагаа болон конгрессийн түүх; • улс орны аюулгүй байдал болон онцгой нөхцөл байдлын үеийн удирдлага, харилцаа холбооны хөгуил, сонгууль, Америкийн федерализм; • санхүү <ul style="list-style-type: none"> • банк, • санхүүгийн байгууллагууд, • даатгал болон үнэт цаас, • татвар, • иргэдийн санхүү, • санхүүгийн болон валютын бодлого, • улсын өр, • ДНБ, инфляц, хадгаламж зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүд.
5) Эрдэс баялаг, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> • үндэсний байгалийн нөөц, • байгаль орчны удирдлага, • шинжлэх ухааны болон технологийн дэвшил, • аж үйлдвэр, дэд бүтэц.

Эдгээр нь зөвхөн судалгааны хэлтэсүүд бөгөөд “арын албанд” Захирлын хэлтэс; Харилцаа холбооны хэлтэс; Конгрессийн мэдээлэл, хэвлэлийн хэлтэс; Захирлын зөвлөхүүдийн

хэлтэс; Санхүү, захиргааны хэлтэс; Мэдээллийн менежмент, технологийн хэлтэс; Хүний нөөцнүү менежмент, хөглийн хэлтэс зэрэг нийт 7 захиргааны хэлтэсүүд ажилладаг.

Чиг үүрэг: Конгрессийн номын сангийн харьяанд ажиллах Судалгааны алба судалгаа шинжилгээ хийхдээ объектив, нам бус, үнэн зөв, найдвартай зарчмыг баримтлана. Конгрессийн хууль тогтоох болон шийдвэр гаргах бүхий л үйл явцад сүүлийн үеийн, бүх талын хууль эрх зүйн орчны судалгаа, шинжилгээ, лавлагаа-мэдээлэл, хангана.

Зураг 3. АНУ-ын Төсвийн тө шатын схем



9

1.2. БНСУ-ын Төсвийн алба

Солонгос нь Парламентын Бүгд найрамдах улс боловч Ерөнхийлөгөийн засгийн хэв шинжийг зарим талаараа агуулсан тогтолцоотой. Үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдэл Үндэсний Ассамблейд хадгалагдах бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ. 1948 онд байгуулагдсан Үндэсний Ассамблей нь нэг танхимтай, 299 гишүүнтэй, бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд 17 байнгын болон тусгай хороотой. Үндэсний Ассамблейн нь хууль тогтоох, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

Бүтэц: БНСУ-ын төсвийн алба нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл, Үндэсний Ассамблейн төсвийн албаны тухай хуулийн дагуу 2003 онд байгуулагдсан. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь Үндэсний Ассамблейн даргын шууд удирдлаган дор ажилладаг.

Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь Үндэсний Ассамблейн **Төсвийн албаны тухай хууль** болон **Төсвийн албаны дүрмийн** дагуу үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь дараах бүтэцийг Зураг 6-аас харна уу.

Зураг 4. Үндэсний Ассамблейн даргын удирдлаганд ажилладаг байгууллагууд



Чиг үүрэг:

Төсвийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн алба нь улсын төсвийн тайлан гаргах, мөнгөн хуримтлал болон төсөв санхүүгийн зарцуулалттай холбоотой **дараах ажил үүргийг** гүйцэтгэнэ:

1. Төсвийн төсөл, тайлан гаргах, мөнгөн хуримтлалын хэрэглээний төлөвлөгөөний төсөл болон мөнгөн хөрөнгийн тайлан гаргахад шаардлагатай судалгаа, анализ
2. Төсөв болон мөнгөн хөрөнгийн хэлбэр, арга хэмжээ, дагалдах дүрэм журмын төсөл, хуулийн төсөлд холбогдох хэрэгцээт зардлыг тооцох
3. Улсын эдийн засгийн байдал, макро эдийн засгийн чиг хандлагын анализ болон хэтийн төлөв
4. Улсын гол /чухал/ ажлуудын талаархи анализ, үнэлгээ, дунд болон урт хугацааны эдийн засгийн хэрэгцээ шаардлагын анализ
5. ҮА хороо болон ҮА гишүүний хүссэн судалгаа, анализ

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтэц

Төлөвлөлт, менежментын хэлтэс: Төлөвлөлт, менежментын хэлсэт нь ҮА төсвийн албаны бусад хэлтсүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг бөгөөд төсөв болон санхүү, хүний нөөц, мэдээллийн нөөцийн менежмент, номын сангийн үйлчилгээг гүйцэтгэдэг.


Төсвийн анализын хэлтэс: Төсвийн анализын хэсэг нь зургаан хэсэгт хуваагдах бөгөөд төсвийн анализын зөвлөх нь туслалцаа үзүүлнэ. Хэлтэс нь:

- Төсвийн төлөвлөгөө болон нөөцийн үйл явцын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн үр дүн болон нөөцийн гүйцэтгэл
- Төсөв болон нөөцийн тооцоонд зориулан үнийн үнэлгээ болон дүгнэлт зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Мөн ҮА гишүүн эсвэл хорооноос судалгаа болон анализид зориулан хүсэлт гаргавал түүнд хариулах үүрэгтэй.

Эдийн засгийн анализын хэлтэс: Эдийн засгийн анализын хэлтэс нь 5 хэсэгт хуваагдах бөгөөд татварын анализын зөвлөх туслалцаа үзүүлнэ. Хэлтэс нь:

- Макро эдийн засгийн худалдаа болон үндэсний санхүүгийн бодлогод анализ хийх, урьдчилсан таамаглал гаргах
- Эдийн засгийн бодлогын анализ, санхүүгийн нэгдсэн тайлан

Зураг 5. БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албаны бүтэц



- Үндэсний өр зээл, орлого болон татварын систем
- Орон нутгийн болон олон улсын санхүүгийн системийн судалгаа
- Мөн үндэсний ассамблейн гишүүн болон хороонд хүсэлт гаргавал судалгаа, анализ гаргаж өгөх.

Программ үнэлгээний хэлтэс: Программ үнэлгээний хэлтэс таван хэсэгт хуваагдана. Хэлтэс нь:

- Үндэсний чухал программуудын үнэлгээ болон анализ
- Үндэсний чухал программуудын хэрэгжилтийн үнэлгээ, мониторинг
- Үндэсний чухал программ болон дунд хугацааны санхүүгийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, анализ
- Төсвийн илүүдэл зардлын төлөв байдлын үнэлгээ, анализ
- Олон нийтийн институтын менежмент болон гүйцэтгэлийн программ, төсвийн тайлан, олон нийтийн институтад Засгийн газраас олгосон төсвийн үнэлгээ, анализ


1.3. Канадын Парламентын төсвийн алба

Канад Улс нь Парламентын засагтай ардчилсан, Үндсэн хуульт хаант улс юм. Төрийн тэргүүн нь Хатан хаан II Элизабет. Канадын Ерөнхий сайд Засгийн газрын тэргүүн юм. Гүйцэтгэх эрх мэдэл нь албан ёсоор, үндсэн хуулийн дагуу Хатан хаанд хамаардаг. Гэхдээ үндсэн хуулийн концепцийн дагуу Хатан хаан ба түүний томилсон төлөөлөгч болох Канадын Амбан захирагч их төлөв ёслолын шинжтэй, улс төрийн бус үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх нь Канадын Засгийн газрын танхимд байдаг. Канад Улсын хууль тогтоох байгууллага нь 2 танхим бүхий парламент юм. Дээд танхим – Сенат 105 гишүүнтэй, Доод танхим – Нийтийн танхим 308 гишүүнтэй.

Бүтэц: Парламентын Төсвийн алба (The Parliamentary Budget Officer – PBO)-ны орон тоог 2006 оны 12 -р сард Канадын Парламентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Парламентын номын санд байгуулсан. Парламентын төсвийн алба нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимын спикерт ажлаа тайлагнадаг Парламентын номын санд ажлаа тайлагнах ёстой. 2008 оны 3 сард Канадын хамгийн анхны Парламентын төсвийн албаар Mr. Kevin Page Парламентын Номын санд томилогдсон. Одоогоор Парламентын төсвийн алба нь эдийн засаг төсвийн шинжилгээ, орлого зарлагын шинжилгээ гэсэн хоёр хэлтсийг хянадаг. Үүнд нийт 13 албан хаагч ажиллаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 7. Канадын Парламентын төсвийн алба



Чиг үүрэг: Төсвийн албаны зорилго нь төсвийг улам ил тод болгох. Энэ нь парламентын гишүүдэд цагаа олсон системтэй холбогдох эдийн засаг төсвийн судалгаа шинжилгээг гаргаж өгөх юм.

- Холбооны хариуцлагын тухай актаар (Federal Accountability Act) тусгайлан Төсвийн алба нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимд улсын төсөв, засгийн газрын ба үндэсний эдийн засгийн талаар урьдчилсан тооцоолсон биеэ даасан судалгаа шинжилгээг гаргаж өгөх. Үүнд:
 - Улсын эдийн засаг төсвийн чиглэлээр судалгаа хийх
 - Засгийн газрын урьдчилсан тооцоонд (төлөвлөсөн зарлага г.м) судалгаа хийх
 - Парламентын хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой аль ч саналын санхүүгийн өртгийг урьдчилан тооцоолох.
- Төсвийн алба мөн дараах парламентын хороодод мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ:
 - Сенатын Үндэсний санхүүгийн байнгын хороо
 - Төлөөлөгчдийн танхимын санхүүгийн байнгын хороо
 - Төлөөлөгчдийн танхимын олон нийтийн санхүү бүртгэлийн байнгын хороо
 - Эрх зүйн зохицуулалтанд нэр нь тусгагдаагүй засгийн газрын үйл ажиллагааны бусад байнгын хороо
- Төсвийн алба нь дараах бүтээгдэхүүн ба үйлчилгээг гарган нийлүүлнэ. Эдийн засаг төсвийн судалгаа шинжилгээ болон Орлого зарлагын судалгаа шинжилгээ гэсэн хоёр категорин дагуу гурван төрлийн судалгааны бүтээгдэхүүн гаргана.

Эдийн засаг төсвийн судалгаа шинжилгээ

- Ердийн: улирлын эдийн засаг санхүүгийн шинэ мэдээлэл
- Судалгаа: эдийн засаг төсөвт гол үүсэж буй асуудлуудын талаар суурь мэдээлэл ба судалгаа мэдээлэл.
- Хүсэлтээр: хороодын хүсэлтээр товч болон дэлгэрэнгүй судалгаа шинжилгээнүүд

Орлого зарлагын судалгаа шинжилгээ

- Ердийн: парламентын төсөвлөлтийн цуврал, парламентын мэдээллийн цуврал, засгийн газрын төсвийн шийдвэр гаргагчийн цуврал
- Судалгаа: төсвийн ил тод байдал, зарлагын менежмент, санхүүгийн мэдээлэл, засгийн газрын үйл ажиллагааны суурь мэдээлэл
- Хүсэлтээр: хороодын эсвэл парламентын гишүүдийн хүсэлтээр товч болон дэлгэрэнгүй судалгаа шинжилгээнүүд

Бүх бүтээгдэхүүн Төсвийн албаны олон нийтийн вэбсайт болох www.parl.gc.ca/pbo-dpb дээр шууд тавигдана.

2.4. Гүржийн Парламентын төсвийн байгууллагууд

Гүрж улс нь Ерөнхийлөгчийн засаглалтай Бүгд Найрамдах улс юм. Төрийн тэргүүн Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаатай сонгогдох ба гүйцэтгэх засаглалыг тэргүүлнэ. Хууль тогтоох дээд байгууллага нь нэг танхимт дээд зөвлөл. Одоогийн Үндсэн хуулиа 1995 онд батласан. Үндсэн хууль нь парламентын бүтэц, бүрэн эрхийг баталгаажуулсны зэрэгцээгэр ирээдүйд Гүржийн нутаг дэвсгэрийн нэгдмэл байдлыг сэргээсний дараа Гүрж улс нь Улсын зөвлөл болон Сенат гэсэн хоёр танхимаас бүрдсэн парламенттай болох тухай Үндсэн хуулийн 4-т заажээ.

Энэ тохиолдолд парламентын доод танхим болох Улсын зөвлөл нь зөвхөн сонгуулийн пропорциональ тогтолцоогоор сонгогдох болно. Сенатын бүрэлдэхүүнд Гүржийн нутаг дэвсгэрийн нэгжүүдээс сонгогдсон сенатчид, Абхазаас сонгогдсон сенатчид, Ажараас сонгогдсон сенатчид, Ерөнхийлөгчөөс томилогдсон 5 сенатч багтах юм.

Гүржийн үндсэн хуулийн дагуу улсын засгийн газар тэнцвэрт төсөвтэй байна. Энэ нь улс төсвийн алдагдалтай байхгүй ба зээл авч төсвийн хөрөнгийг бүрдүүлэхгүй гэсэн үг. Гүрж улс улсын төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон батлах гүйцэтгэл хүртэл ерөнхий дөрвөн үе шаттай (Зураг 2) байх ба энэхүү ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дараах албууд ажилладаг:

1. Парламентын Төсвийн Газар (Parliament Budget Office)
2. Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office)
3. Нийтийн Танхимын Төсвийн Газар (House Budget Office)
4. Сенатын Төсөвлөлтийн Хороо (Senate Appropriations Committee)
5. Сенатын Төсөв Үнэлгээний Газар (Senate Budget and Evaluation office)
6. Төсөв Төлөвлөлтийн Газар (The Office of Planning and Budget) OPB

Зураг 7. Гүржийн төсвийн процесс



Зураг 8.



Парламентын төсвийн газар (Parliament Budget Office)

Гүржийн Парламентын төсвийн газар нь Гүржийн парламентын Санхүү-төсвийн хороонд (Parliament Budget Office of Georgia existing with Finance and Budget Committee of parliament of Georgia) Гүржийн хороод, парламентын гишүүдэд болон парламентын албан хаагчдад төсөв санхүүгийн ба эдийн засгийн мэдээллийг гаргаж өгөх зорилгоор байгуулагдсан. Энэ нь анх 1997 оны 8-р сарын 25-нд Гүржийн парламентын бюयोगийн (Bureau of Parliament of Georgia) шийдвэрийн дагуу байгуулагдсан ба хамгийн сүүлд 2008 оны 11сарын 3-нд парламентын төсвийн газрын бүтцийн шинэчлэл хийгдсэн. Үүнд: **USAID** (United States Agency for International Development) нь Парламентын төсвийн газрын үйл ажиллагаа болон үүсгэн байгуулалтанд чухал хэсгийг гүйцэтгэсэн.

Төсвийн газар нь Гүржийн үндсэн хууль, Гүржийн парламентын эрх зүйн зохицуулалт, бусад эрх зүйн акт, Гүржийн парламентын албан хаагчдын тогтоол, Төсөв санхүүгийн хороо ба төсөв санхүүгийн хорооны албан хаагчдын тогтоол, Гүржийн парламентын удирдагчийн бусад акт мөн парламентын төсвийн газрын тогтоолын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Бүтэц: Төсвийн газрын гол зорилго бол Гүржийн парламентад төсөв санхүүгийн, эдийн засгийн мөн бусад төрлийн шинжилгээ мэдээллийг гарган өгөх юм. Төсвийн газар энэ зорилгоо мониторинг болон эдийн засгийн судалгаа шинжилгээ хийх замаар гүйцэтгэнэ. Одоогоор 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Чиг үүрэг: Төсвийн газар дараах чиглэлээр судалгаа шинжилгээ хийнэ.

- Гүржийн улсын төсөв түүнчлэн гүржийн бусад нутаг дэвсгэрийн нэгжийн төсөв

байгуулалт, хэлэлцүүлэг, батлах ба гүйцэтгэх талаар, мөн төсвийн санхүүжилт зарлагын үр ашиг болон тэдгээрийн гүржийн хуулийн нийцэмж зэргийн талаар

- Улсын макро эдийн засгийн хөгжлийн нөхцлүүд болон төслийн үзүүлэлтүүд
- Суурь мэдээлэл болон удирдан чиглүүлэх албан бичгийн үндсэн дээр төсвийн болон мөнгөний бодлогын үндсэн чиглэл ба дунд хугацааны стратегээ тодорхойлох.
- Улсын төсвийн төслийг Гүржийн макро эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлттэй нийцүүлэх.
- Гүржийн төлбөр тооцооны тэнцлийн байр суурь
- Гүржийн мөнгөний бодлого, татварын бодлого ба ёс заншлын бодлого
- Улсын өрийн асуудал
- Төсвийн илүүдэл / дутагдлын асуудал

Төсөв Төлөвлөлтийн Газар (The Office of Planning and Budget – OPB)

Төсөв Төлөвлөлтийн Газар нь 1972 оны Executive Reorganization Act-ийн дагуу засгийн эрх баригчийн газарт төсөв төлөвлөлтийн үйлчилгээ үзүүлэхээр албан ёсоор байгуулагдсан.

Бүтэц: Төсөв Төлөвлөлтийн Газар нь хоёр нэгж, гүйцэтгэх салбар болон бусад зургаан салбартай. Ойролцоогоор 60 албан хаагчтай. Дараах салбар нэгжүүдэд хуваагдана:

- Захиргааны салбар
- Хөрөнгө төсвийн нэгж
- Боловсролын салбар
- Гүйцэтгэх газар
- Ерөнхий засгийн газар салбар
- Эрүүл мэнд, хүний үйлчилгээний салбар
- Мэдээлэл технологийн салбар
- Эдийн засгийн хөгжлийн салбар
- Төлөвлөлт ба үнэлгээний нэгж

Чиг үүрэг: Төсөв Төлөвлөлтийн Газар нь засгийн эрх баригч болон бусад бодлого боловсруулагчдад улсын засгийн газрын үйл ажиллагааг дээшлүүлэхэд үнэ цэнэтэй, бодитой, цагаа олсон мэдээллүүдийг гарган өгөх үүрэгтэй. Мөн Улсын төсвийн удирдагчийн хувьд засгийн эрх баригч жил бүр улсын төсвийн төслийг Ерөнхий Ассамблейд танилцуулах үүрэгтэй. Төсвийн саналыг хүргүүлэхээс өмнө, Төсөв Төлөвлөлтийн Газар агентын төсвийн төслүүд болон бодлогын асуудалд шинжилгээ хийнэ. Түүнчлэн засгийн эрх баригчийн хэлэлцүүлэгт дэлгэрэнгүй төсвийн төслийг боловсруулна.

Гүйцэтгэх засаглалын салбарын агент бүр төсвийн жил (7 -р сарын 1 өдөр) эхлэхээс өмнө Төсөв Төлөвлөлтийн Газар руу жил бүрийн үйл ажиллагааны төсвөө хүргүүлэх ёстой. Төсөв Төлөвлөлтийн Газар эдгээр зарлагын төлөвлөгөөг төсөвлөлтийн акттай нийцэж байгаа эсэхийг хэлэлцэнэ. Мөн эдгээр агентуудын зарлагад үргэлжлүүлэн мониторинг хийх ажлыг хариуцна. Төсөв Төлөвлөлтийн Газар нь мөн улсын хөгжлийн стратегийн төлөвлөгөөнүүдийг боловсруулдаг гол агент юм.

Сенатын Төсөв Үнэлгээний Газар (Senate Budget and Evaluation office)

Сенатын Төсөв Үнэлгээний Газар нь 2003 оны чуулганаар үүсгэн байгуулагдсан.

Чиг үүрэг: Улсын төсвийг бүрдүүлж байгаа програм болон улсын жил бүрийн төсвийг хөгжүүлэхэд биеэ даасан чадавхыг олгох зорилготой. Улсын Сенатын гишүүдэд бодитой, үнэн зөв, нарийн нягт, үзэл суртлын бус цагаа олсон мэдээллийг гарган өгөх.

Мэдээлэл хэрхэн олж авах: Мэдээллийн хүсэлтийг утсаар, и-мэйлээр, захидлаар гаргаж болно. Мэдээллийн хүсэлтийн дагуу мэдээлэл болон судалгааг хоёр долоо хоногийн дотор гаргаж өгнө. Бүх мэдээлэл болон судалгааны үр дүнг и-мэйл, уян диск, эсвэл бичиг баримтаар мэдээллэнэ. Түүнээс гадна төсөвлөлтийн баримт бичиг болон бусад төсөвтэй холбоотой баримтуудыг онлайнгаар үзэх боломжтой байдаг.

Сенатын Төсөвлөлтийн Хороо (Senate Appropriations Committee)

Сенатын Төсөвлөлтийн Хороо нь Jack Hill-аар удирдуулдаг ба ойролцоогоор 30 гишүүнтэй үйл ажиллагаа явуулдаг.

Чиг үүрэг: Төсөвлөлтийн Хороо нь жил бүрийн үндсэн суурин дээр засгийн газрын агентууд, яам, байгууллагуудын төсвийн хуваарилалтын хууль тогтоох саналыг гаргах ажлыг хариуцдаг. Мөн өөрийн 9 дэд хороодтой чуулган зохион байгуулах ажлыг хариуцна.

Нийтийн Танхимын Төсвийн Газар (House Budget Office)

Чиг үүрэг: Гүрж Улсын Төлөөлөгчдийн Танхимын (Georgia House of Representative) 180 гишүүд болон тэдний албан хаагчдад үнэн бодит, цагаа олсон төсвийн мэдээлэл болон шинжилгээг хүргэх ёстой.

Нийтийн Танхимын Төсвийн Газрын төсвийн шинжээчид улсын бүх яамны санхүү төсвийн ажилчидтай хамтран Нийтийн Танхимын хүсэлтийн дагуу намын бодлогоос ангид мэдээлэл туслалцааг үзүүлнэ. Энэ газар нь түүхэн, одоо үеийн, урьдчилан төлөвлөсөн төсөвлөлт, орлого зарлагын мэдээллийн бааз юм. Түүнчлэн энэхүү газар нь төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, төсвийн Нийтийн Танхимын хуулийн төсөл боловсруулах, мөн төсвийн хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулах ажлыг хариуцдаг. Ер бусын санхүүгийн үйлчилгээ үзүүлэх мөн татвар долларын менежментээр өөрийн иргэдэд үйлчлэхийн тулд улсын засгийн газрын үр ашгийг боломжит хамгийн их түвшинд хүргэх зорилготой.

Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office)

Төсвийн Хууль Тогтоох Газар (The Legislative Budget Office) нь 1970 онд Төлөөлөгчдийн Танхим ба Сенатад зөвлөх үйл ажиллагааг үзүүлэхээр хамтарсан газраар байгуулагдсан. Энэ газар нь төсвийн хууль тогтоох шинжээч Robert Hobbs-аар удирдуулдаг ба ойролцоогоор 10 албан хаагчтай ажилладаг.

Чиг үүрэг: Төсөв боловсруулах шатны турш Төсвийн Хууль Тогтоох Газар нь ОРВ-тай мөн хууль тогтоох засгийн эрх баригчтай хамтран ажиллана. Төсөвт шинжилгээ хийнэ. Энэ газар нь чуулган болгоны дараа ажлын байранд гэнэтийн шалгалт хийн, зарим тохиолдолд тухайн салбарын төсвийн зарлагыг тодруулахын тулд илүү гүнзгий судлана. Хууль тогтоох төсвийн шинжээч болон Хууль Тогтоох Төсвийн Газрын албан хаагч жил бүрийн төсвийн чуулганд оролцон, төсвийн хууль тогтоох хэлэлцүүлэгт бэлэн байдаг.

Хоёр. ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО (PAC)

Төрийн хариуцлагын хороо (PAC – The Public Accounts Committee) нь Үэстминистрийн загварын¹ улсууд буюу Их Британи, Канад, Шинэ Зеланд, Ирланд, Энэтхэг, Хонконг, Малта, Сингапур зэрэг орнуудаас үүсэлтэй. Үэстминистрийн системийн үед гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох засаглалынхаа салшгүй хэсэг нь байдаг ба засгийн газрын өргөн барьсан

¹ Тусгай хороо (вэстминистрийн систем) – Ардчилсан парламентийн нэг загвар болох Вэстминистрийн системээс үүссэн бөгөөд онцгой салбар, асуудлуудыг хэлэлцэх үүрэгтэй парламентийн цөөхөн гишүүдээс бүрдэнэ. Тусгай хороо нь Их Британийн парламентаас гадна Үэстминистрийн загвартай орнууд болох Австрал, Шинэ Зеландад байдаг.

төсвийн төсөлд засгийн газрын зөвшөөрөлгүйгээр парламентын зүгээс өөрчлөлт оруулах нь засгийн газартаа үл итгэх саналыг парламент гаргаж байна гэж ойлгодог. Харин конгрессийн системийн үед гүйцэтгэх засаглалаас Конгрессийн бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцооллыг өргөн барьдаг. Конгрессоос эцсийн байдлаар батлагдсан төсөвт Ерөнхийлөгчийн өргөн барьсан бүх төсвийг заавал хамруулах шаардлагагүй байдаг. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсвийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн батлаагүй нь Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл болдоггүйгээрээ конгрессийн систем нь Уэстминстерийн системээс ялгаатай байна. Анхны Төрийн хариуцлагын хороог 1861 онд Их Британийн Нийтийн танхимын тогтоолоор Төрийн хариуцлагын хороо байгуулагдсан.

2.1. Их Британи

Их Британн нь Үндсэн хуульд, Эзэн хаант, нэгдмэл улс. Төрийн эрх нь Уэстминистерийн систем бүхий Парламент бөгөөд Лордуудын танхим, Нийтийн танхимаас бүрддэг. Нийтийн танхим ихэнхи үүргийг гүйцэтгэнэ, тодруулбал, ямар ч шинэ хууль, хээлийн нэмэлт, өөрчлөлт, хориг, татвар ногдуулалт Нийтийн танхимын шийдвэргүйгээр гардаггүй. Нийтийн танхим өүх ард түмнээс дээд тал нь 5 жилээр шууд сонгогддог 650 гишүүнтэй. Лордын танхим нь Английн сүм хийдийн хамба нар, угсаа залгамжлагчид, язгууртнуудаас Хаан томилдрг 733 гишүүдийн бүрэлдэхүүнтэй.

Бүтэц: Нийтийн танхимын энэхүү тусгай хороо нь одоогийн байдлаар Нийтийн танхимын 14 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хорооны даргаар нь сөрөг хүчнээс сонгодог байна.

Чиг үүрэг: Энэхүү байнгын хороо нь төрийн зардлагыг үр ашигтай, үнэн зөв, хариуцлагатай байлгахын тулд төсвийг хянаж байсан. 1983 онд Үндэсний аудитын тухай хуулийн дагуу тус хорооны үндсэн үүрэг нь Ерөнхий хянагчийн тайланд шалгалт хийхдээ бодлогын асуудлыг бус харин төсвийн зардалын үнэ, чанарыг зах зээлийн бодит ханштай нийцсэн, үр ашигтай, бүтээмжтэй байгаа эсэхийг хяналт шалгалтаа хийнэ. Ерөнхий хянагчийн хувьд тарийн байгууллагуудын зардлыг хянаж тайлагнана.

2.2. Австрали

Үндсэн хуульт хаант засагтай парламентын холбооны улс. 1856 онд Өмнөд шинэ Уэльс, Виктори, Тасмани мужид, 1857 онд Өмнөд Австрали, 1860 онд Куинсленд, 1890 онд Хойд Австрали мужид анхны парламентууд тус тус байгуулагдсан.

1901 онд Австралийн колониуд нэгдэхэд Холбооны парламентийг байгуулжээ. Холбооны парламент хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг бөгөөд хоёр танхимтай. Доод буюу Төлөөлөгчдийн танхим нь 3 жилийн хугацаатай сонгогдох 150 гишүүнтэй, Дээд танхим буюу Сенат нь 6 жилийн хугацаатай сонгогдох 76 гишүүнтэй. Хууль хэлэлцэн батлахдаа хоёр танхим ижил боловч Сенат нь санхүүтэй холбогдолтой хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй. Австралийн Хамтын нөхөрлөлийн улс нь засаг захиргааны хувьд 6 муж улс, 2 эх газар болон бусад жижиг арлаас бүрддэг. Муж улс бүр өөрийн Үндсэн хуультай бөгөөд тус бүрдээ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалтай.

Бүтэц: 1951 онд *Төрийн хариуцлага, аудитын хорооны тухай хуулийн* (1951 он) дагуу Төрийн хариуцлага, аудитын хамтарсан хороо (Joint Committee of Public Accounts and Audit – JCPAA) байгуулагдсан. Тус хорооны зарим эрх зүйн асуудлыг *Ерөнхий аудиторын тухай хуулиар* (1997 он) зохицуулна. Төлөөлөгчдийн танхимаас удирдана. 16 гишүүдийн бүрэлдэхүүнтэй, тэдний 6-г нь Сенатаас, 10-г нь Төлөөлөгчдийн танхимаас томилно. Мөн Австралийн Хамтын нөхөрлөлийн 6 муж улс, 2 эх газар нь тус бүрдээ Төрийн хариуцлагын хороотой.

Чиг үүрэг: Дээр хэлсэнчлэн Төрийн хариуцлагын хорооны үндсэн үүрэг нь төрийн байгууллагуудын санхүүгийн удирдлага, ялангуяа төсвийн гүйцэтгэлийг шинжлэн судлах замаар засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх гэсэн гол зорилготой. Австралийн Төрийн хариуцлага, аудитын хороо нь төсвийн хөрөнгийг хуулийн дагуу, үр ашигтай, бүтээмжтэй байгааг хянах үүрэгтэй. Тухайлбал:

- төсвийн ороgo, зарлагын тооцоог хянаж шалгана,
- мужуудын захиргааны санхүүд шалгалт хийнэ,
- парламентад танилцуулагдсан бүх аудитын тайланд шалгалт хийнэ,
- Парламентад танилцуулагдсан төсөвтэй холбоотой бүхий л асуудлуудыг хянаж шалгах,
- хяналт, шалгалтын үр дүнг Парламентын хоёр танхимд танилцуулах,
- Парламентын сонирхсон асуудалд хариу өгөх,
- Парламентад зөвлөмж гаргах,
- Ерөнхий сайдын Ерөнхий аудитад санал болгосон нэр дэвшигчийг дэмжих, татгалзах бүрэн эрхтэй,
- мужуудын захиргааны жилийн төсвийн удирдлага болгож байдаг үзэл баримтлалд Парламентын өмнөөс дэмжих эрхтэй², Мөн 2 жил тутам Австралийн Татварын алба нь тус хорооны татвартай холбоотой асуулгад хариу өгөх³.

2.3. Шинэ Зеланд

Бүтэц: Төлөөлөгчдийн танхимын тогтоолоор 1890 онд Санхүү, зардлын хороо (Finance and Expenditure Committee – FEC) байгуулагдсан бөгөөд Шинэ Зеландын Парламентын байнгын бөгөөд 13 тусгай хороодын⁴ нэг. 12 гишүүнтэй.

Чиг үүрэг: Санхүү, зардлын хороо бол улсын салбарын санхүүгийн менежментийг хянан шалгах үүрэгтэй гол сонгогдсон хороо. Уг хороо нь урьдчилсан тооцоо болон Засгийн газрын гаргасан жилийн эцсийн санхүүгийн тооцоог бүхэлд нь хянан үзэж, Төлөөлөгчдийн танхимыг төлөөлөн хяналт тавина. Тус хороо нь улсын төсвийг батлах явцад Санхүүгийн стратеги тайлан, төсвийн тодотголд хяналт шинжилгээ хийх бөгөөд сайд нар болон холбогдох салбаруудын хуваарилалтын хүсэлт буюу эрэлт хэрэгцээг хянан үзэж ба Төлөөлөгчдийн танхимд 2 сарын дотор тайлагнана. Мөн Ерөнхий аудитортой холбоотой асуудлаар дараахь эрх, зэргийг хэрэгжүүлнэ:

- **Ерөнхий аудитрын судалгаа ба мэдэгдэл:** Хороо нь Ерөнхий аудитрын мэдэгдлүүдийг болон түүнтэй холбогдолтой асуудлуудыг хянан шалгах эрхтэй.
- **Ерөнхий аудитрын томилгоо:** Хороо Ерөнхий аудитрын томилолгооны хориг тавих, эсвэл санал өгөх зэргээр зөвлөлдөнө.
- **Ерөнхий аудитрыг чөлөөлөх:** Ерөнхий аудитрыг чөлөөлөх санал оруулахын өмнө Хороотой заавал зөвлөлдсөн байна.
- **Аудитын газрын санхүүжүүлэлт ба төлөвлөлтийн ажил:** Хороо нь Аудитын газрын санхүүжүүлэлт, төсвийн урьдчилсан тооцоог хянах үүрэгтэй. Аудитын газрын

² Уг эрхийг 1999 оноос олгосон.

³ Уг эрхийг 2007 оноос олгосон.

⁴ **Тусгай хороод** нь Төлөөлөгчдийн танхимаас томилогдсон Парламентийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд онцгой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах эрх бүхий нэгж юм.

жил бүрийн төлөвлөлтийн тодотгол хийхэд зөвлөлдсөн байх ёстой.

2.4. Канад

Төрийн хариуцлагын хороо нь Shawn Murphy –ын удирдлаган доор одоогоор 14 хүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөгчдийн танхимын байнгын хорооны дэгийн 108 (3) (Standing Order 108(3)) дагуу, олон нийтийн санхүүгийн тайлангийн байнгын хорооны эрх үүрэг бол доорх мэдэгдэлд хяналт шалгалт хийх болон мэдэгдэл хийнэ:

- Канадын олон нийтийн санхүүгийн тайланд
- Канадын ерөнхий аудитын бүх мэдэгдэлд
- Ерөнхий аудитын газрын төлөвлөгөө ба эрхүүд болон жил бүрийн гүйцэтгэлийн мэдэгдэлд
- Төлөөлөгчдийн танхимын хороод руу явуулсан бусад ямар ч асуудалд

Төлөөлөгчдийн танхимд Ерөнхий аудитын тайлан мэдэгдэх үед, энэ нь автоматаар Олон нийтийн санхүүгийн тайлангийн хороо ба Парламентын байнгын аудитын хороо руу хүргүүлнэ. Тэгээд Ерөнхий аудитын дүгнэлт тайлбар гарахаас өмнө, хороо мэдэгдлээс өөрийн нягтлан үзэх шаардлагатай хэсгийг сонгон аудит хийсэн байгууллагаас олон нийтийн ажилчныг дуудан уулзана. PAC мөн холбооны Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлан, Канадын олон нийтийн санхүүгийн тайланд шалгалт хийнэ. Мөн Ерөнхий аудитын мэдэгдэлд гарч ирсэн асуудлуудын засгийн газрын санхүүгийн дутагдлуудыг олж тогтоохыг оролддоно. Үүний дараа хороо нь засгийн газарт зарлагыг сайжруулах арга хэмжээнүүдийн талаар зөвлөмж хийнэ. Тиймээс, PAC нь голлон анхаарна:

- Эдийн засаг, Засгийн газрын захиргааны бүтээмж ба үр ашигтай байх
- Холбооны программын гүйцэтгэлд захиргааны арга хэмжээнүүдийн чанар
- Парламентад холбооны зарлагын талаар засгийн газрын тооцоолох боломж

Сүүлийн хэдэн парламент, хороо нь түүний 90-95 хувийн цагийг Ерөнхий Аудитын мэдэгдлүүдийн хяналт эзэлсэн байна. Энэ нь бусад асуудлыг мөн нягтлан үзнэ. Үүнд: Канадын засгийн газрын санхүүгийн тайлан, улсын корпорацуудын гүйцэтгэл болон зарим яам эсвэл агентуудын зарлагын чухал программ гэх мэт.

Гурав. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУДАД ОРОЛЦОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

Улсын төсөв боловсруулахад Сангийн сайд, бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Сангийн яам болон салбарын яамд эсвэл төсөв боловсруулах үүрэгтэй холбогдох агентлаг, байгууллага голлох үүрэгтэй. Энэхүү процесс нь улсын төсвийн баримт бичгийн төсөл УИХ-аар батлагдсанаар дуусгавар болох ба дараахь үе шатуудыг хамарна:

- **Дунд хугацааны төсвийн хүрээ бэлтгэх** (дунд хугацааны төсвийн таамаглал буюу макро эдийн засаг, төсвийн зорилтот үзүүлэлтүүд болон тооцоо танилцуулга, судалгааг гаргаж, Дунд хугацааны төсвийн хүрээний төсөл боловсруулах)
- **Дунд хугацааны төсвийн зарлагын хязгаар бэлтгэх** (Засгийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн төсвийн зарлагын хязгаарыг хэлэлцэн батална)
- **Дунд хугацааны төсөв бэлтгэх** (Төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн дунд хугацааны төсвийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж УИХ-д өргөн мэдүүлэх, Улсын төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэж батлах)
- **Төсвийн хуваарь батлах, хүргүүлэх** Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулах үйл явц – Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл нь УИХ-аар батлуулахаар санал болгож буй Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх

асуудлын хүрээний бодлогыг хэрэгжүүлэхийн тулд явуулах үйл ажиллагаа болон түүнд шаардагдах төсвийн хөрөнгийг харуулсан бодлогын чухал баримт бичиг юм.


- *Дунд хугацааны төсөв бэлтгэх* – Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг, төсөв боловсруулах удирдамжийн хамт ТЕЗ-д хүргүүлсний дагуу ТЕЗ нь төсвийн зарлагын хязгаарыг аймаг нийслэл болон төрийн захиргааны байгууллага бүрээр боловсруулна. ТЕЗ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийг төсвийн зарлагын хязгаарт багтааж боловсруулсний үндсэн дээр ТЕЗ бүр Сангийн яамтай хэлэлцэн тохиролцож МУ-ын дунд хугацааны төсвийн төслийг боловсруулна.
- *Төсвийн хуваарь батлах, хүргүүлэх үе шат* – Төсвийн Ерөнхийлөн Захирагч бүр аймаг нийслэлийн засаг дарга нар болон төсвийн ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн гэрээ байгуулж, тухайн жилийн төсвийн багцын сар, улирлын санхүүжилтын хуваарийн төслийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам нь Төсвийн ерөнхийлөн захирагчид бүрийн төсвийн төслийг нэгтгэн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт мэдүүлж, хуралдаанаар хэлэлцэнэ.
- *УИХ-аар Улсын нэгдсэн төсвийг хэлэлцэж батлах журам* – Монгол Улсын төсвийг хэлэлцэн батлах бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал эдэлнэ. *Зураг 9-т Монгол Улсын төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналтын үе шатуудад оролцох байгууллагуудын үндсэн чиг үүргийг тусгав. Зураг 10-т Засгийн газраас Улсын Их Хурал төсвийн төслийн хэлэлцэх батлах үе шатуудыг тусгав/*

Зураг 9.


Монгол Улсын төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналтын үе шатуудад оролцох байгууллагуудын үндсэн чиг үүрэг (Дараагийн хуудаснаас үзнэ үү)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 9. Монгол Улсын төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналтын үе шатуудад оролцох байгууллагуудын үндсэн чиг үүрэг



Зураг 10.

УИХ-д Монгол Улсын төсвийн төслийг өргөн барих болон төсөв хэлэлцэх, батлах үе шат

- Төсвийн тухай хуулийн 5.2.1. улсын төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын Засгийн газар байна.
- ТБУСТХ -ийн 7.1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төслийг боловсруулах

УИХ -ын дэгийн тухай хуулийн 25.14. Нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулах үед зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар тайлбар хийх, түүнтэй холбогдуулан гишүүд асуулт асууж болох бөгөөд өөр аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

ТБУСТХ-ийн 6.1.1. Засгийн газрын өргөн мэдүүлснээр улсын төсвийн орлого, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилт, бусад санхүүжилтийг хэлэлцэж батлах;

* * *

Ашигласан материал, эх сурвалж

АНУ

- Senate Budget Committee. **Эх сурвалж:** budget.senate.gov/
- House Committee on the Budget. **Эх сурвалж:** budget.house.gov/
- Congressional Budget Office. **Эх сурвалж:** www.cbo.gov/
- Government Accountability Office. **Эх сурвалж:** www.gao.gov
- Office of Management and Budget. **Эх сурвалж:** www.whitehouse.gov/omb

БНСУ

- Үндэсний Ассамблейн тухай хууль
- Үндэсний Ассамблейн Төсвийн албаны тухай хууль
- Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас. **Эх сурвалж:** www.NABO.co.kr
- Үндэсний Ассамблейн цахим хуудас. **Эх сурвалж:** www.assembly.go.kr


Бусад

- **Их Британи:** Public Accounts Committee. **Эх сурвалж:** <http://www.parliament.uk/>
- **Шинэ Зеланд:** Joint Committee of Public Accounts and Audits. **Эх сурвалж:** <http://www.aph.gov.au/>
- **Канад:** Public Accounts Committee. **Эх сурвалж:** www.parl.gc.ca/pbo-dpb
- Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газар. УБ., 2010 он.
- Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал. *Харьцуулсан судалгаа*. УИХ-н Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв. 2009 он.

* * *

Хавсралт 1.

АНУ-ын Конгрессийн төсвийн албаны судалгаа шинжилгээ хийх цагийн хуваарь



Хавсралт 2. АНУ-ын Конгрессийн Судалгааны төвийн судалгааны салбар, дэд салбарууд

1) American Law (Америкийн хуулийн хэлтэс)

- Administrative Law
- Business
- Congress
- Courts and International
- Natural Resources

2) Domestic Social Policy (Дотоодын нийгмийн бодлогын хэлтэс)

- Children and Families — coverage includes
 - issues facing children and families
 - low-income populations
 - housing
- Domestic Security and Immigration — coverage includes
 - criminal justice
 - domestic intelligence activities
 - border security
 - immigration
- Education and Labor — coverage includes

- elementary and secondary education
- postsecondary education and job training
- labor
- Health Insurance and Financing — coverage includes
 - Medicare
 - Medicaid and State Children's Health Insurance
 - health insurance access, coverage and reform
- Health Services and Research — coverage includes
 - medical research and health care services
 - public health
 - health issues for the aging
 - veterans' health care
- Income Security — coverage includes
 - Social Security
 - income support for the disabled
 - unemployment compensation
 - retirement savings and pensions

3) Foreign Affairs, Defense and Trade (Гадаад харилцаа, батлан хамгаалах, худалдааны хэлтэс)

- Asia — coverage includes
 - U.S. policy and economic, political and security developments across the region
 - East Asia
 - South Asia
 - Southeast Asia
 - Australasia and the Pacific Islands
- Defense Policy and Arms Control — coverage includes
 - U.S. Armed Forces
 - conventional and nuclear weapons systems
 - weapons of mass destruction
 - proliferation and counter proliferation
 - ballistic missile defense programs
 - military space systems
- Defense Budget, Manpower and Management — coverage includes
 - authorization and appropriation
 - acquisition policies
 - intelligence
 - military bases
 - military pay and benefits
- Europe and The Americas — coverage includes
 - political, economic and security developments
 - North Atlantic Treaty Organization
 - Organization of American States
 - European Union
 - Russia and central Asia
- Foreign Policy Management and Global Issues — coverage includes
 - transnational issues (such as, terrorism, international narcotics and crime and economic sanctions)
 - Department of State
 - human rights

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

- international institutions
- International Trade and Finance — coverage includes
 - bilateral and multilateral trade agreements
 - exchange rates and foreign currency
 - global economic institutions
 - trends involving the U.S. trade deficit, investment and balance of payments
- Middle East/Africa — coverage includes
 - Middle East peace process
 - conflicts in Iraq and Afghanistan
 - African conflicts, foreign aid and economic prospects
 - illicit diamond trade

4) Government and Finance (Удирдлага, санхүүгийн хэлтэс)

- Banking, Insurance, Securities and Macroeconomic Policy — coverage includes
 - economic conditions and trends
 - U.S. income and wealth distribution
 - banks and banking
 - insurance industry oversight and regulation
 - monetary policy formulation and stances
- Congress and Judiciary — coverage includes
 - Congress's history, organization and operations
 - legislative branch budget
 - federal judiciary's organization, activities, and budget
 - nomination and confirmation process for federal judges and justices of the Supreme Court
- Executive Branch Operations — coverage includes
 - presidential office and powers
 - presidential nominees
 - federal workforce
 - U.S. Postal Service
 - rulemaking and regulatory management
 - sports
- Federalism and Emergency Management — coverage includes
 - state and local governments
 - homeland security
 - regional affairs (District of Columbia, U.S. territories)
 - community development
 - emergency management
- Government Finance and Taxation — coverage includes
 - federal taxation
 - budget and spending policy
 - federal debt
 - impact of federal policies on state and local government finances
- Legislative and Budget Process — coverage includes
 - legislative procedure and budgetary legislation
 - congressional organization

5) Resources, Science and Industry (Эрдэс баялаг, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн хэлтэс)



- Agriculture and Food Supply — coverage includes
 - farm commodity support programs
 - agricultural trade and international food aid
 - farm credit and disaster assistance
 - conservation
 - food marketing and regulation
 - rural development
- Energy and Minerals — coverage includes
 - conventional energy supply, prices and security
 - energy efficiency and conservation
 - renewable and alternative energy
 - emerging energy technology
 - environmental effects of energy production and consumption
 - energy infrastructure, taxation and regulation
 - mineral production and use
- Environmental Policy — coverage includes
 - Environmental Protection Agency policies, budget and regulation
 - air quality standards and regulations
 - water quality
 - chemical safety and toxic substances
 - hazardous waste clean-up and disposal
 - climate change and other international environmental issues
 - environmental justice
- Natural Resources and Earth Sciences — coverage includes
 - water resources policy
 - public lands and natural resource management
 - fisheries, marine life, marine sanctuaries
 - wildlife and ecosystems
 - natural hazards
 - climate change impacts and mitigation strategies
- Science and Technology Policy — coverage includes
 - national research and development funding priorities and the role of the federal government
 - space exploration
 - homeland security research and development initiatives and support of the U.S. critical infrastructure
 - telecommunications policy and regulatory reform
 - Internet and its impact on privacy, security and electronic government
 - Science, Technology, Engineering, and Mathematics (STEM) Education
- Transportation and Industry Analysis — coverage includes
 - federal transportation policies, budgets and programs
 - transportation security, safety and research and development programs
 - structure and market dynamics of the aerospace, rail, trucking and maritime industries, and passenger and commuter rail
 - industrial organization issues
 - impact of public policies on functioning of markets



МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН СУДАЛГАА

Г. Алтан - Оч (Ph.D), Б. Буяндэлгэр, С. Дорждагва, Б. Ариунжаргал

АГУУЛГА

1. Судалсан байдал
2. Монгол улсад Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, өнөөгийн байдал
3. Нийслэл болон хөдөө орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлд хийсэн шинжилгээ, тэднийг дэмжиж хөгжүүлэх эдийн засгийн хөшүүрэг
4. Экспортыг дэмжих бодлогын хэрэгцээ, импортыг орлох үйлдвэрлэлээс давуу болохын учир
5. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортод чиглэсэн үйл ажиллагааг дэмжихэд төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар гадаадын зарим орны туршлага (Польш, Чех, Болгар)
6. Жижиг дунд үйлдвэрлэлийн эрх зүйн орчин
7. Ашигласан материалын жагсаалт

НЭГ. СУДАЛСАН БАЙДАЛ

УИХ-ын гишүүн С.Бямбацогтын захиалгын дагуу Монгол Улсын жижиг дунд үйлдвэрийн хөгжил, цаашдын чиг хандлага, баримталж байгаа бодлого, гадаадын зарим орны туршлагын талаар судалгаа хийлээ. Судалгааг хийхдээ холбогдох яамдын судалгаа мэдээлэлд тулгуурлан өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж цаашид төр, захиргааны байгууллагуудаас ямар арга хэмжээ авах, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр ямар бодлого баримталж байгаа, ямар үйлдвэрүүдийг байгуулахаар төлөвлөж байгаа талаар судалж харьцуулан түүнд зарим дүгнэлт хийлээ.

Монгол улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг түүвэрлэн авч хэрэгжилтийн талаар зарим судалгаа, мэдээллийг оруулахын зэрэгцээ Засгийн газрын 2009 оны 178 дугаар тогтоолоор баталсан “ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ” -д тусгагдсан орон нутагт байгуулахаар төлөвлөсөн үйлдвэрүүдийн жагсаалтыг хүснэгтээр үзүүлж түүнийг аймгуудын “Хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан “Боловсруулах үйлдвэрлэлийн” салбарыг хөгжүүлэх хэсэгт тусгагдсан үйлдвэрүүдийн төлөвлөгөөг мөн нэгтгэж харьцуулж үзлээ. Энэ нь жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын уялдааг харуулах зорилготой хийсэн харьцуулалт юм.

Харьцуулалт хийх үүднээс зарим хуучин социалист тогтолцоотой байсан улсууд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ экспортын бодлогыг хэрхэн дэмжиж өгч байсан, тэр нь ямар үр дүнд хүрсэн талаар тоймлон авч үзсэн. Мөн, “2010 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн тайланд тусгагдсан мэдээллээс УИХ-аас баталсан зорилтыг хэрэгжүүлэхдээ ямар хэмжээний өөрчлөлт (гажуудал) гаргасаныг зарим нэг баримтаар харуулсан болно.

Судалгааны ажлын 2, 4, 5 дугаар бүлгийг судлаач Г.Алтан-Оч, С.Дорждагва нар, 3 дугаар бүлгийг судлаач Б.Буяндэлгэр, 6 дугаар бүлгийг судлаач Б.Ариунжаргал нар тус тус боловсрууллаа. Төгсгөлд нь, тус Судалгааны төвөөс 2010 онд хийсэн “Монгол улсад импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүнүүдийн хамгийн их хэмжээтэй 100 нэр төрлийн бараа болон тэдгээрийг дотоодод орлон үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдийн талаархи судалгаа” -г хавсаргалаа.

ХОЁР. МОНГОЛ УЛСАД ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын аж үйлдвэрийн салбар 1980 -аад оны туршид харьцангуй эрчимтэй өсч байсан салбар бөгөөд хугацааны эхний хагаст жилийн дунджаар 9% өсч сүүлийн хагаст жилийн 5%-иар өсч байсан байна. Шилжилтийн дараа нийт эдийн засагт эзлэх аж үйлдвэрийн салбарын хувь хэмжээ 1990 онд ДНБ -ий 40 орчим хувьтай тэнцэж байсан бол 2000 он гэхэд 20 хувь хүртэл буурч тэр дундаа боловсруулах үйлдвэрийн салбарын хувь хэмжээ 1995 онд ДНБ-ий 12%-тай тэнцэж байсан бол 2000 он гэхэд 6 хувь хүртэл буурч харин өнөөгийн байдлаар 5% хүрэхгүй болсон байна⁵. Үнэн хэрэгтээ ашигт малтмалын үйлдвэрлэлээс (зэс, нүүрс болон алт олборлолтоос) бусад ихэнх боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ ихээхэн буурч ирсэн (Хүснэгт 1). Үүний зэрэгцээ аж үйлдвэрлэлийн салбар дахь нийт ажлын байрны тоо нэгэн адил цөөрсөн болно.

Хүснэгт 1: Монгол улсын аж үйлдвэрийн салбарын гүйцэтгэл (1993 - 2004)

Бүтээгдэхүүн (Бусдаар тодорхойлоогүй бол 1000 тонн)	1993	2001	2002	2004
Зэсийн баяжмал	334	381	376	371
Алт (кг)	1.117	13.675	12.097	19.417
Тоосго (сая)	33	21	13	12
Цемент	82	68	148	62
Шохой	51	30	42	30
Зүсмэл мод (1000 м3)	85	21	10	18
Самнасан ноос	4	2	1	2
Эсгий (1000 метр)	241	110	113	68
Ноосон бүтээгдэхүүн (1000 метр)	290	38	32	59
Хүрэм (1000)	1	-	-	-
Бэлэн хувцас (1000)	3	-	-	-
Савхин гутал (1000 хос)	1.031	17	9	3
Савхин хүрэм (1000)	9	0	0	0
Нэхий бүтээгдэхүүн (1000)	87	2	2	4
Мах, гахайн мах эс оролцуулсан байдлаар	17	12	7	4
Гурил	176	38	50	58
Гурилан бүтээгдэхүүн	46	8	6	7
Сүүн бүтээгдэхүүн (1000литр)	13	1	3	6
Саван	171	-	-	-
Хивс (1000 м2)	100	615	534	690

Энэ хүснэгтээс харахад Монгол улсын аж үйлдвэрийн салбар 2000 оны эхэн үеийг хүртэл тогтмол буурч ирсэн бөгөөд энэ үеэс жижиг дунд үйлдвэрийг сэргээх чиглэлээр олон олон хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж эхэлсний үндсэн дээр эргэж сэргэх хандлагатай болсон. Монгол Улсын импортын барааны бүтцийг мөнгөн дүнгээр нь харьцуулж үзвэл

⁵ 2011 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 6/42 тоот

дараах байдлаар тодорхойлогдож байна⁶. Үүнд:

№	Ангилал	Импортод эзлэх хувь
1.	Эрдэс бүтээгдэхүүн	26,6%
2.	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	19,8%
3.	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	12,6%
4.	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	8,5%
5.	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	7,7%
6.	Химийн болон химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн	6,0%
7.	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	4,6%
8.	Бусад	14,1%
	НИЙТ	100%

Нийт импортын барааг 126 орноос худалдан авсан байна. Үүнээс, хүнсний гол нэрийн импортын бараанд ургамлын тос, гурил, гурилан бүтээгдэхүүн, лаазалсан төрөл бүрийн мах, хүнсний ногоо, шар айраг, жимс жимсгэнэ орж байна. Гэтэл эдгээрийн ургамлын тосноос бусад бүтээгдэхүүн нь бүгд Монголд тодорхой хэмжээгээр үйлдвэрлэж, боловсруулж байгаа юм. Жимсний хувьд дотоодод бэлтгэх нь харьцангуй бага байгаа. Тэгвэл, гурил болон гурилан бүтээгдэхүүнийг Атрын III аяны үр дүнд дотоодод бүрэн үйлдвэрлэх боломжтой гэж дүгнэж байгаа нь статистик үзүүлэлттэйгээ төдийлөн нийцэхгүй байгааг анхаарах шаардлагатай болов уу.

ХХААХҮЯ-наас 2009 онд хийсэн судалгаагаар манай оронд нийтдээ 1090⁷ хүнсний үйлдвэр, аж ахуйн газар үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийг ангилж авч үзвэл Монгол улс нийт 64 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас малын гаралтай (мах, өрөм, өлөн гэдэс, өтгөн цөцгий буюу гүзээтэй тос) уламжлалт аргаар боловсруулж бэлтгэсэн хүнс нь 10 нэр төрөл байна. Тус судалгаанд Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний үйлдвэрүүдийн хүчин чадлын хэмжээний талаар мэдээлэл тусгагдаагүй тул тоо, нэгжээр нь авч үзлээ. Дотоодын хүнсний үйлдвэрүүдийг тооны хувьд бүлэглэн авч үзвэл:

№	Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн	Үйлдвэрийн тоо			
		Орон нутагт	Улаанбаатарт	Нийт	Эзлэх хувь
1	Талх, Нарийн боов, бялуу	259	114	373	34.22%
2	Ундаа, цэвэр ус	68	71	139	12.75%
3	Архи, пиво, дарс	59	44	103	9.45%

⁶ “Өнөөдөр” сонины 2010 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №149(4012) дугаарт нийтлэгдсэн Ж.Тэгшжаргалын “Бид хэнийг, биднийг хэн тэжээдэг вэ?”

⁷ Хүнсний үйлдвэрүүдийн судалгаа. 2009 оны дүнгээр. ХХААХҮЯам.

Судалгааны эмхтгэл, IX боть

4	Бууз, банш, Хэрчсэн гурил	29	53	82	7.52%
5	Зайрмаг	43	30	73	6.70%
6	Гурил	54	8	62	5.69%
7	Мах, махан бүтээгдэхүүн	37	10	47	4.31%
8	Сүү, сүүн бүтээгдэхүүн	35	11	46	4.22%
9	Хиам	13	32	45	4.13%
10	Бусад	47	73	120	11.01%
	НИЙТ	644	446	1,090	100%

Тайлбар:

Зарим аж ахуйн нэгж хэд хэдэн бүтээгдэхүүн зэрэг үйлдвэрлэж байгаа юм. Аж ахуйн нэгжийн хувьд тоог нь ХХААХҮЯ-ны мэдээлэлд тулгуурлан гаргах боломжгүй байна. Дэлгэрэнгүй жагсаалтыг уг судалгаанд хавсаргасан болно. Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг “орхичихолгүй” арга хэмжээ авсаар ирсэн ч тодорхой үр дүнд хүрч чадахгүй явж ирсэн гэж болно.

Хүснэгт 2: Үйлдвэрлэлийн салбарын өсөлт ба ДНБ-ий өсөлтийн харьцаа. 1996-2008⁸

Он	Үйлдвэрлэлийн салбарын өсөлтийн хувь	ДНБ-ий өсөлтийн хувь	ДНБ-д Үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь
1996	-14.6	2.3	8.4
1997	-13.8	4.0	6.9
1998	3.5	3.5	6.9
1999	-3.0	3.2	6.5
2000	-3.2	1.1	6.2
2001	33.0	9.4	8.2
2002	18.8	3.8	9.4
2003	-	-	5.6
2004	-3.7	10.6	4.9
2005	-19.4	7.2	3.7
2006	13.3	8.6	3.8
2007	28.8	10.2	4.5
2008	4.5	8.8	4.3

Үүний учир шалтгааныг тодорхойлохдоо эдийн засгийн системийн шилжилтийн явцын талаар 2002 оны сүүлээр “Монгол улсын аж үйлдвэр болон худалдааны хөгжлийн бодлого” (UNDP/UNIDO, 2002) гэх сэдвээр хийсэн судалгааны тайланд дурьдсан байна.

⁸ Strategic Directions on Industrial Policy in Mongolia. United Nations Industrial Development Organization 2011. Vienna, Austria.

Шилжилтийн явцад Монгол улс төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хувьчлах явцад үндсэн 2 томоохон алдаа гаргасан болохыг тэмдэглэсэн бөгөөд энэ алдаагаа өнөөг хүртэл засч залруулж чадахгүй байгаа нь үйлдвэрлэл хөгжих явцад саад бэрхшээл болсоор байна. Үүнд:

1. Урьд өмнө байсан түүхий эд бэлтгэлийн тогтолцоо нурж, үүний дүнд ялангуяа мал аж ахуй болон хөдөө аж ахуйн салбарын түүхий эд бэлтгэх тогтолцоо устсан; Мал аж ахуй, газар тариалангийн эмчилгээ, эрүүл ахуйн хяналтын систем устсанаар үндсэн түүхий эд болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар эрс муудаж гадаадын зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангахаа больсон
2. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж байсан хуучин социалист тогтолцоотой орнуудын зах зээл үндсэндээ “устсан” учраас шинэ зах зээлийг эрж хайж олж чадаагүй, энэ талаар арга, мэдлэг дутмаг байсан, төрөөс энэ тал дээр дэмжлэг үзүүлээгүйгээс борлуулалт үндсэндээ зогссон.

UNIDO-ийн 2011 онд гаргасан судалгааны тайланд дурьдсанаас авч үзвэл Монгол улсад жижиг дунд үйлдвэрлэлийн салбарыг экспортын баримжаатай хөгжүүлэхэд хамгийн ихээр саад болж байгаа үндсэн шалтгаануудад

- Тээврийн өртөг өндөр учир бүтээгдэхүүний үнэ өндөрсдөг
- Зам тээвэр, дэд бүтцийн харилцаа нь Азидаа хамгийн сул хөгжсөн улс
- Төрийн байгууллагуудын хүнд суртал, авилга үйлдвэрлэл эрхлэгчдэд сул хөгжсөн дэд бүтцээс дутахгүй хүндрэл учруулдаг

хэмээн дүгнэсэн байна. Эдгээр хүндрэлүүд нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэлхийд хамгийн томд тооцогдох 2 зах зээлийн дунд байгаа боломжоо ашиглан экспортын чиг баримжаатай хөгжихөд саад учруулсаар байна гэжээ⁹.

Өнөөгийн нөхцөлд хөрөнгө мөнгийг олон аргаар шийдвэрлэж чадах болсон тул тус байгууллагын 2002 онд хийж байсан дүгнэлтэд дурьдсан 2 гол “алдааг” засах бодлогыг ажил хэрэг болгоход төрийн зүгээс зайлшгүй анхаарах ёстой байгаа юм. Энэ нь үйлдвэржилтийг сэргээхэд гол суурь нь болж өгнө. Өөрөөр хэлбэл, төрөөс экспортын баримжаатай, наад зах нь импортыг бүрэн орлох хэмжээний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түүхий эд бэлтгэлийн иж бүрэн тогтолцоог бий болгох, түүхий эдийг эрүүл, чанартай бэлтгэх нөхцлийг бүрдүүлж өгөх, үйлдвэрлэгчдэд шинэ зах зээлд гарахад нь бодлогын хувьд идэвхтэй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй болж байна.

Сүүлийн жилүүдэд авч байгаа арга хэмжээ идэвхжиж үйл ажиллагааны цар хүрээ өргөжихийн хэрээр хэрэгжүүлэх байгууллагуудын ажлын уялдаа холбоо илт дутагдаж байгааг дараах үндэслэл, үйл ажиллагаанууд нотолж байна.

3. Бодлогын хувьд төрөөс гаргасан баримт бичгүүд болон аймаг тус бүрийн ИТХ-аас гаргасан “Хөгжлийн цогц бодлого”-ын “Боловсруулах үйлдвэрийг салбар”-ыг хөгжүүлэх зорилтын хооронд харьцуулалт хийж үзэхэд уялдахаасаа илүүтэйгээр уялдахгүй байх нь “их” байгаа нь харагдаж байна.

Тухайлбал, **Мах боловсруулах үйлдвэрийг** “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-д зүүн бүсээс бусад 3 бүсэд нийт **3 ширхэгийг байгуулахаар төлөвлөсөн**.

⁹ Strategic Directions on Industrial Policy in Mongolia. United Nations Industrial Development Organization 2011. Vienna, Austria.

Гэтэл аймаг тус бүрийн зорилтоос харахад 18 аймаг¹⁰ бүгд мах боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөсний 11 нь гадаадад мах экспортлох хэмжээний хүчин чадалтай үйлдвэр байгуулна гэжээ

Засгийн газраас тодорхойлсон зорилт аймаг орон нутагт энэ мэтээр зөрүүтэй төлөвлөгдөж уялдаж чадахгүй байгаа бол **УИХ-аас баталсан “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгасан зорилт, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүрийн улсын төсөвт тусгасан хөрөнгө мөн л гол хэрэгжүүлэгч газар болох Яам, агентлаг дээрээ зөрүүтэй хэрэгжиж байна.**

Тухайлбал, “2010 онд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлан”-гаас үзэхэд ХХААХҮЯ-аас илтгэхдээ уг төлөвлөгөөний **1.14.3. Улс, бүсийн чанартай томоохон боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх** гэсэн зорилтын хэрэгжилтийн талаар Хүрэх түвшин нь: **Шинээр ашиглалтад орсон үйлдвэрийн тоо 7-оос доошгүй байна** гэж заасан байна.

Биелэлт: Засгийн газраас 2009 онд баталсан “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийн хүрээнд Төсөл сонгон шалгаруулах комисс 96 төслийг дэмжин гэрээ байгуулсан арилжааны банкуудад судлуулахаар хүргүүлсэн. 2010 оны 09-р сарын 10-ны байдлаар арилжааны банкууд 57 төсөлд 11 202,0 сая төгрөгийн зээл олгосон нь нийт олгох зээлийн 65,1 хувь болж байна.

Төсөл сонгон шалгаруулах комиссын 2 дугаар хуралдаанаар 9.985 сая төгрөгийн 62 төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулахаар дэмжин банкуудаар судлуулахаар шилжүүлээд байна¹¹.

Энэхүү тайлангаас үзэхэд **Улс, бүсийн чанартай томоохон үйлдвэр 7 ширхэгийг** байгуулахад хангалттай гэж үзэн түүнд зориулж улсаас 11,2 тэрбум төгрөг төсөвлөсөн байтал энэ хөрөнгийг 57 төсөлд 200 сая хүрэхгүй төгрөгөөр хуваан олгосон байна. Энэ жишгээр дунд хэмжээний үйлдвэр 7 байгуулагдах боломжтой байдал 57 ширхэг жижиг төслийг санхүүжүүлсэн нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулсан нэг үндэслэл болж байна.

Гэтэл, Жижиг дунд үйлдвэрийн газрын гаргасан тайлангаас үзэхэд “2009 оны эхний байдлаар Монгол улсад 60535 аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 36498 ААН үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Жижиг, дунд үйлдвэрт хамаарах нь 35789. Харин тогтмол татвар төлдөг ЖДҮ 12556 байна. Хэдийгээр жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хувийн хэвшилд тоо хэмжээгээрээ давамгайлж байгаа боловч татвар төлөгчдийн тооноос харахад санхүүгийн байдал хүндхэн байгааг илтгэж байна” гэжээ.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхээр төсөвлөсөн бага ч гэсэн хөрөнгийг бүрэн санхүүжүүлэх боломжтой байдлаар олгох нь эргээд үйлдвэрлэгчиддээ хэрэгтэй байх болов уу. 2010 онд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хуваарилсан зээлийн хөрөнгийг Улаанбаатарт 50-100 сая, орон нутагт 15-30 сая төгрөгөөр хуваан олгосон байна¹².

¹⁰ Аймаг тус бүрт байгуулахаар төлөвлөсөн үйлдвэрийн жагсаалтыг хавсаргав. Энэ судалгаанд Орхон, Дархан-Уул, Дорноговь аймгуудыг оруулалгүй үлдээсэн. УИХ-аас баримталж байгаа бодлогоор эдгээр 3 аймаг бол бусад аймгуудаас “томоохон үйлдвэрлэгч” аймаг болох юм.

¹¹ 2010 онд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан. 2010 оны 3 дугаар улирлын байдлаар. Монгол Улсын Засгийн газар.

¹² “Жижиг дунд үйлдвэрийн газрын мэдээлэл” 2010 он. Мөн “2010 онд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх

1. Дараагийн нэг нөхцөл нь жижиг дунд бизнес эрхлэгчид **барьцаа хөрөнгө хүрэлцэхгүйгээс болж авах зээлийн хэмжээ хүссэн дүнгээс нь буурч байна.** Ерөнхийдөө зээл хүсч төслөө ирүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийн нилээдгүй хэсэг нь барьцаа хөрөнгийн хувьд банкны шаардлага хангаж чадахгүй байна.

Хэрэгжүүлэхээр боловсруулсан төслүүд нь ихэвчлэн байгаа барьцаанаасаа давсан хөрөнгө оруулалт хүсч байна. Эргээд банк түүнд нь хүрсэн хэмжээнд хөрөнгө оруулалт хийхээс татгалзсан хариу өгдөг байна.

2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхээр үйл ажиллагаагаа эхэлж байгаа болон эхлэхээр төлөвлөсөн төслүүдэд **“олон улсын ... [тийм] стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ” гэж төлөвлөх байтугай дотоодын аль нэг стандартыг хангасан ийм бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэж зорилт дэвшүүлсэн тохиолдол ховор байна.** Үүнээс харахад жижиг дунд бизнес эрхлэгчдийн мэдлэг дутмаг, нөгөө талаар энэ талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажил хомс байгааг илэрхийлж байна.

Магадгүй эдгээр шалтгаан хоорондоо шууд холбоотой байгаа. Үүнээс гарах хамгийн гол арга бол хорших, хамтрах байдлыг сайжруулах, түүнд нь зориулж сургалт хийх, ямар нэгэн урамшууллын механизм бий болгоход анхаарах хэрэгтэй байна. Мөн зээлийн баталгаа гаргахад төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Үйл ажиллагааны түвшин нь тогтворжиж чадахгүй байгаагаас шалтгаалж тэнд ажиллагсдын цалингийн хэмжээ төдийлөн сайн өсч чадахгүй, зөвхөн төрийн албан хаагчдын цалингаар баримжаа болгож нэмэгдэж явж байгаа гэж болно. Үүнийг 2001 оноос хойших цалингийн дундаж¹³ хэмжээнээс харж болох юм.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн хөлсний түвшинг авч үзэхэд өнөөдөр улсын дундажтай ойролцоо, төрийн албан хаагчдын цалингаас ялимгүй өндөр байгаа юм.

Хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ 2001-2010 (мян.төг)


Он	Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй	Уул уурхайн олборлох аж үйлдвэр	Боловсруулах аж үйлдвэр	Санхүүгийн зохицуулалт	Төрийн захиргаа, батлан хамгаалах, нийгмийн даатгал	Эрүүл мэнд нийгмийн хангамж	Нийгэм хамт олон, хувь хүний үйлчилгээ	Улсын Дундаж
2001	36.9	58.5	73.6	70.6	59.7	47.9	46.6	63.3
2002	50.3	81.4	73.3	98.6	71.5	53.9	55.6	74.0
2003	42.9	93.6	82.8	123.5	76.2	61.1	53.9	80.5
2004	49.8	92.4	97.1	125.1	96.5	80.8	62.7	96.0
2005	56.7	137.2	104.9	201.2	110.0	90.1	76.3	105.4
2006	69.8	152.2	136.3	260.4	156.7	128.4	98.5	137.7
2007	120.6	238.7	178.9	412.2	258.0	206.7	182.1	205.9

үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан”. 2010 оны 3 дугаар улирлын байдлаар. Монгол Улсын Засгийн газар.

¹³ Цалингийн дундаж хэмжээ. 2010 оны байдлаар. Монгол банк

Судалгааны эмхтгэл, IX боть

2008	173.3	351.8	294.4	579.8	346.5	303.4	223.1	291.1
2009	197.4	402.9	277.7	621.1	350.1	303.4	223.1	308.1
2010	174.7	568.9	347.9	714.9	324.3	303.2	250.2	333.4



UNIDO-ийн хийсэн судалгаагаар 2008 оны байдлаар Монгол улсад 1 сая орчим хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас ердөө 48,0 мянган хүн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна гэжээ.

Энэ тоог орон нутагт авч үзвэл бүр ч бага тоо гарч байгаа аж. Харин эдийн засаг эрчимжиж эхэлсэн сүүлийн 1-2 жилд энэ тоо “бага зэрэг” өсч 2010 оны байдлаар 54,3 мянгад хүрсэн байна. Үүний 16,4 мянга нь “Уул уурхай, олборлох” үйлдвэрлэлийн салбар, 14,2 мянга нь “Цахилгаан, эрчим хүч”-ний салбарт ногдож байгаа бөгөөд “Боловсруулах аж үйлдвэр”-ийн салбарт 23,7¹⁴ мянган хүн ногдож байна. Өөрөөр хэлбэл, нийт 1,1 сая гаруй хүн байнгын хөдөлмөр эрхэлж байгаа гэж үзвэл үүний **ердөө 2,1 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт ажиллаж нэмүү өртөг бий болгож** баялаг үйлдвэрлэж байна. Харин гадаадаас Монгол улсад албан ёсоор ажиллаж байгаа 9900 иргэдийн 970¹⁵ нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Үлдсэн хэсэг нь барилга, зам, уул уурхайн салбарт ихэвчлэн ажилладаг.

3. НИЙСЛЭЛ БОЛОН ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ТЭДНИЙГ ДЭМЖИЖ ХӨГЖҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРЭГ

3.1. Аймаг, нийслэлд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
-----------	---------

¹⁴ Статистикийн бюллетень. 2010 оны 12 дугаар сар. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо.

¹⁵ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл. 2010 он

Аймгууд	Аймгууд
Хямд ажиллах хүчин	Зах зээлийн багтаамж бага
Хямд түүхий эд	Тоног төхөөрөмж, технологи хоцрогдолтой
Уул уурхай хөгжиж байгаа	Тээврийн зардал хэт өндөр
Төр засгийн дэмжлэгтэй	Мэргэжилтэй боловсон хүчин дутмаг
Өрсөлдөгч бага	Татварын ялгавартайтай бодлого байхгүй
Орон нутгийн нөөц боломж их	Сургалтанд хамрагдах мэдээлэл дутмаг
Түрээсийн төлбөр хямд	Бизнес эрхлэх мэдлэг туршлага муу
	Хөрөнгийн үнэлгээ бага
	Хяналт шалгалтын давтамж их
	Дэд бүтцийн хөгжил муу
	Цахилгаан дулааны үнэ өндөр
	Санхүүгийн төрөл бүрийн дэмжлэг хөгжөөгүй
Нийслэлд	Нийслэлд
Мэдээлэл хурдан авах	Ченжээр дамжин түүхий эдийн үнэ өндөр
Гадаад дотоодын зах зээлд ойр	Өрсөлдөгч олон
Технологи , тоног төхөөрөмж сайтай үйлдвэрүүд олон	Бизнес эрхлэх мэдлэг дутмаг
Санхүүгийн олон төрлийн үйлчилгээ авах	Ченжээр дамжин түүхий эдийн үнэ өндөр
Экспортыг дэмжих	Хөрөнгийн үнэлгээ өндөр

БОЛОМЖ	АЮУЛ \эрсдэл\
Аймгууд	Аймгууд
Уул уурхай дагасан ЖДҮ хөгжүүлэх	Шилжилт хөдөлгөөн их/ зах зээл багасах
Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Худалдан авах чадвар муу
Экспортыг дэмжих	Бэлэн мөнгөний хомсдол их
Түүхий эдийн сонгол хийх боломж сайн	Импортын болон том үйлдвэрийн бүтээгдэхүүн хэрэглэх сэтгэлзэг бага
Нийслэлд	Нийслэлд
Зах зээлд ойрхон	Инфляцийн өсөлт
Эдийн засгийн өсөлт их	Шаардлагатай сав баглаа боодлын үйлдвэр цөөн учир ихэнх компаниуд Хятадад захиалгаар хийлгэдэг
Уул уурхай дагасан ханган нийлүүлэлт хийх	Төгрөгийн ханш өөрчлөлт
Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Түрээсийн байрны үнэ өндөр

Экспортыг дэмжих	
Зах зээлд ойрхон	

3.2. Хөдөөд жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл

1. Зах зээлийн багтаамж бага, хүн амын худалданавах чадвар сул зэргээс шалтгаалан үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ ихэвчлэн зээлээр борлуулдаг;
2. Гадаад дотоод зах зээлд бүтээгдэхүүн борлуулах сүлжээ бүрэлдэн тогтоогүй;
3. Санхүүгийн хувьд дутагдалтай, барьцаа хөрөнгөгүйгээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж хязгаарлагдмал;
4. Хөрөнгө санхүү, дэвшилтэт техник технологийн талаархи мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан өндөр технологи бүхий тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгддэггүй;
5. Үйлдвэрлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын арга хэлбэр төлөвшөөгүй;
6. Алслагдсан бүс нутагт шатахууны үнэ 400-500 төгрөгөөр өндөр, эрчим хүч, ус, дулааны үнэ 20-40 төгрөгөөр илүү байгаа нь суурь үнийн өртөгийг нэмэгдүүлдэг

3.3. Жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжиж байгаа эдийн засгийн хөшүүрэг, арга зам

1. Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлөх хуулийн хэрэгжилт

Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль хэрэгжснээр 8.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг 1200 гаруй үйлдвэрлэгчид эдэлсэн.\ 2010 оны ЖДҮ-ийг дэмжихээр 30,8 тэрбум төгрөг баталсажээ. Үүнээс:лизингийн тоног төхөөрөмж худалдан авахад 9,0 тэрбум, даатгалынүйлчилгээнд1,5 тэрбум, зээлийн баталгааны санд 1,5 тэрбум, хөрөнгө оруулалт 3,0 тэрбум, хөнгөлөлттэй зээлд 15,8 тэрбум төгрөг тус тус хуваарилсан байна.\

2. Лизингийн үйлчилгээ

Санхүүгийн түрээс лизингийн үйлчилгээг нэвтрүүлэхэд 4,6 тэрбум төгрөгийг эх үүсвэр бүрдүүлж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг олгож байна. Цаашдаа тоног төхөөрөмжийг лизингээр олгохдоо төрийн оролцоотой “Лизингийн үйлчилгээний төв” шинээр байгуулан олгох боломжтой.

3. Зээлийн батлан даалт гаргах

Батлан даалт гаргах хууль эрх зүйн орчин бий болсон тохиолдолд эх үүсвэрийг ББСБ-д байршуулж, дамжуулан олгох ба хүү, шимтгэлийн нөхцлөөр эх үүсвэрт зориулсан хөрөнгийг 3 дахин үржүүлж олгох боломж бүрдэнэ. Одоогийн байдлаар төсөл хөтөлбөрийн байгууллагууд үйлдвэрлэгчидэд бага хэмжээний хөрөнгөөр батлан даалтын үйлчилгээ үзүүлж байна.

4. Даатгалд хамруулах

Зээл авсан аж ахуйн нэгж, иргэний хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг зээлийн даатгалын үйлчилгээнд хамруулах боломжтой. Үүнд:

- а) Лизингээр олгох тоног төхөөрөмжийг даатгах,
- б) Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчийн барьцаа хөрөнгийг даатгах.
- в) Даатгалын тогтолцоог дэмжих хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай.

5. Төвөөс алслагдсан бүс нутагт үйлдвэрлэл эрхлэгчдийг татварын ялгавартай бодлогоор дэмжих

Төвөөс 1000 км-ээс дээш алслагдсан бүс нутагт шатахууны үнэ 400-500 төгрөгөөр өндөр, малын гаралтай түүхий эдийн үнэ тухайн бүс нутагтаа хямд харин Улаанбаатарын зах зээл дээр түүхий эдийн үнэ өндөр байдаг. Үүний үр дагавараар алслагдсан бүс нутгаас гаралтай түүхий эд, баялаг, мөнгө төв рүү төвлөрч харин тэнд амьдарч байгаа иргэд орлого нэмэгдүүлэх боломжгүй, худалдан авах чадвар сул, бага орлоготой амьдарч байна. Мөн төвөөс холдох тусам тээврийн зардал нэмэгддэг, үүнийгээ дагаад бараа, үйлчилгээний үнэ 1.5-2.5 дахин өсдөг учраас төвөөс ихэнх бараа бүтээгдэхүүнээ татаж, өндөр өртөгтэй үйлчилгээ авч байна. Иймд алслагдсан бүс нутагт үйлдвэрлэл эрхлэгчдийг татварын ялгавартай бодлогоор дэмжих шаардлагатай.

6. Зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх

2009-2010 онд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 60.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосны үр дүнд нийт 2761 аж ахуйн нэгж иргэн хамрагдаж 839 үйлдвэр шинээр байгуулагдаж, 1813 үйлдвэр техник технологи, тоног төхөөрөмжөө шинэчилэн үйл ажиллагаагаа өргөтгөж, 9205 гаруй ажлын байр шинээр бий болж, 18400 гаруй хүн ажлын байраа хадгалсан. Зээлийн эргэн төлөлт өндөр хувьтай байгаа боловч дотоод зах зээлийн багтаамж бага, хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул, импортын бараа бүтээгдэхүүнийг шүтэх иргэдийн сэтгэхүй өөрчлөгдөөгүй нөхцөлөөс шалтгаалж дотоодын үйлдвэрлэгчдийн борлуулалт бага байна. орон нутгийн үйлдвэрлэгчид ирэвчлэн зээлээр бараа бүтээгдэхүүнээ борлуулж байгаа нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа нь доголдоход хүргэж өөрийн хөрөнгийн хангалттай байдал, санхүүгийн хувьд тогтворгүй болох магадлалтай. Иймд тодорхой хугацаанд зээлийн хүүг төрөөс татаас хэлбэрээр олгох мөн зээлийн хугацааг 5-10 жил, жилийн хүүг 5-6 хувь хүртэл нь бууруулах чиглэлээр төрөөс бодлого явуулах хэрэгтэй.

7. Хөдөө орон нутагт ажлын байр бий болгосны урамшуулал олгох.

Хөдөө орон нутагт нийт 16175 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байгаагаас 54.6% буюу 9,628 нь иргэн, өрхийн аж ахуй эрхлэгчид, 46.4 хувь нь аж ахуйн нэгж байгууллага байгаа бөгөөд нэг үйлдвэрлэгч дундажаар 1-5 хүнийг л ажлын байраар хангаснаар 37560 гаруй хүн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Олон улсын байгууллагаас хийсэн судалгааны дүнгээс харахад хөдөө орон нутагт ядуурлын төвшин 41 орчим хувьтай байгаа нь улсын дундажаас 12 хувиар их байгаа нь ажилгүйдэлтэй холбоотой. Үүнээс шалтгаалан иргэдийн төв рүү шилжих хөдөлгөөн нэмэгдсээр байна. Иймд орон нутагт ажлын байр бий болгосны урамшуулал олгох тогтолцоо үүсгэх.

8. Орон нутагт хөнгөлөлттэй тарифийн бодлого хэрэгжүүлэх

Алслагдсан бүс нутагт эрчим хүч, ус, дулааны үнэ 20-40 төгрөгөөр илүү байгаа нь суурь үнийн өртөгийг нэмэгдүүлж байгаа бөгөөд үүнээс шалтгаалан амжиргааны зардал өндөр байна. Иймээс алслагдсан бүсийн иргэдийн тэгш бус байдлыг арилгах үүднээс бараа, үйлчилгээний өртөг нэмэгдсэн хувиар тооцож хөнгөлөлттэй тарифийн бодлогоор дэмжих.

9.Татварын хөнгөлөлт үзүүлэх

Импортыг орлох үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжих, шинээр үйлдвэрлэл эрхлэгчдийг эхний 3-5 жилд орлогын албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл боловсруулах

10. Сургалт

Үйлдвэрлэгчдэд зориулсан сургалтыг орон нутагт жил бүр 2-3 үе шаттайгаар явуулах хөтөлбөрийг баталж хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

4. ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХЭРЭГЦЭЭ, ИМПОРТЫГ ОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГООС ДАВУУ БОЛОХЫН УЧИР

Экспортыг дэмжих аргачлал, арга хэмжээнүүд гэдэгт экспортын үйл явцтай шууд, онцгой холбоо харилцаатай экспортын баримжаатай бодлогын хүрээнд хэрэгжүүлэх аливаа нэгэн арга хэмжээг ойлгоно.

Экспортын баримжаатай бодлого нь нөхцөлийг бүрдүүлж, хэмжээнээс үл хамааран бүх компаниудад дэмжлэг үзүүлэх байгууллага, арга хэмжээг тогтоодог байна. Жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих арга хэмжээг жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогод тодорхойлсон байдаг

Олон улсад жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлсэн туршлагаас харахад **импортыг орлох хэмжээнд үйлдвэрлэл явуулахыг дэмжих бус экспортод чиглэсэн үйлдвэрлэл явуулахыг дэмжих бодлого явуулах нь илүү сайн амжилт олдог** байна. Энэ хоёр бодлогын хувьд том зөрүү харагдана. Үүнд:

- Импортыг орлох үйлдвэрлэл явуулна гэдэг нь дотоодын хэрэгцээнд зориулж байгаа учраас тавигдах стандарт шаардлага сулардаг ба тэр хэрээр үйлдвэрлэлийн чанар буурах, ажиллах хүчний чадавхи сулрах хандлага илэрдэг
- Экспортыг дэмжиж байгаа үед бүтээгдэхүүний чанар олон улсын шаардлага хангасан үйлдвэрлэл явуулах нөхцөл бүрдэнэ. Тэр хэрээр бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн технологи сайжрах, боловсон хүчний чадавхи дээшлэх, хөдөлмөрийн хөлсний хэмжээ нэмэгдэх, түүний үнэлэмж бодитой болох гэх мэт давуу талыг бий болгодог.

Эдийн засагт гүйцэтгэх үүрэг, эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийн хувьд жижиг дунд үйлдвэрийн салбар нь ихээхэн чухал тул төр засгийн анхаарлыг ихээр татаж байдаг. Олон улсын эдийн засгийн байгууллагуудын хийсэн судалгаагаар хөгжсөн улс орнуудад жижиг дунд үйлдвэрийн салбарын бүтээсэн нэмүү өртөг нь ДНБ-ий 40 гаруй хувийг бүрдүүлж тэнд ажиллаж байгаа хүний тоо нь нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүний 50-иас илүү хувийг эзэлдэг байна. Энэ ч үүднээс дэлхийн ихэнх улс орнууд жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих олон хувилбартай бодлогыг хэрэгжүүлэх болсон байна.

Тухайлбал, хуучин социалист тогтолцоотой улс орнууд зах зээлийн эдийн засагт шилжих явцдаа жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогодоо ихээхэн анхаарал тавьж ажилласны хүчинд хүндрэлийг богино хугацаанд давж гарах суурь нь болж өгч байжээ¹⁶.

Эдгээр улс орнуудын төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрүүд нь санхүү, технологи, шинэ санаачилга, менежмент, гадаад улс орнуудтай харилцах гэх зэрэг асуудлаар жижиг дунд үйлдвэрт тулгамдаж буй бэрхшээлийг арилгахад чиглэгдсэн байдаг. Жижиг дунд үйлдвэрийг экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулахад төрөөс багагүй туслалцаа хэрэгтэй болдог байна.

Экспортыг дэмжих бодлогын ач холбогдол нь:

- Эдийн засгийн өсөлт, ашгийг бий болгож, үндэсний ДНБ-д хувь нэмрээ оруулах
- Татварын орлого, бааз суурийг нэмэгдүүлэх
- Дотоодын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх
- Компаниудыг өрсөлдөх чадвараа хадгалах, өсгөх нөхцөлийг бүрдүүлэх

¹⁶ http://www.exporthelp.co.za/modules/21_export_management/intro.html

- Бүс нутагт улс орны байр суурийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах
- Тус орон/бүс нутаг руу ирээдүйн хөрөнгө оруулалт татах зэрэг болно.

Австралийн худалдааны агентлагийн¹⁷ (AUSTRADE) хийсэн судалгаанаас үзэхэд экспорт-логчид нь:

- Ажилчдын хөгжиж, дэвших боломж сайн
- Экспортлогч аж ахуйн нэгжийн цалин бусдаас өндөр байдаг
- Ажлын орчин нөхцөл сайн
- Тогтмол хөрөнгө оруулалт хийж шинэ технологи ашиглаж байдаг
- Өрсөлдөх чадвар өндөр байдаг

Экспортлогч үйлдвэрлэгчид давхар дотоодын хэрэгцээг хангаж байдаг учраас дотоодын эдийн засаг түүнийг дагаад инфляци зэрэг эдийн засгийн сөрөг үр дагаварт өртөх явдал хамгийн бага түвшинд байж чаддаг байна. Экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхлэхэд учирч болох саад бэрхшээл нь дотоодын болон олон улсын зах зээлээс ихээхэн хамаардаг юм. Үүнд,

- гадаад зах зээлийн талаар мэдлэг хомс,
- боловсон хүчин муутай,
- эрсдлээс хэт их эмээдэг байна.

Хөгжиж байгаа орнуудын жижиг дунд үйлдвэрлэгчид гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ экспортлоход учрах бэрхшээлийг төрийн дэмжлэггүйгээр шийдвэрлэж чаддаггүй бөгөөд үүнд төрөөс аливаа саад бэрхшээлийг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгцээ гардаг.

Төрөөс экспортыг дэмжих чиглэлээр үндсэн гурван төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж өгөх хэрэгцээтэй. Үүнд:

- Экспортлогч, экспортын бодлогын шийдвэр гаргагчдад хэрэгцээтэй мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх,
- Экспортлогч, экспортын үйл ажиллагаа эрхлэх бололцоотой аж ахуйн нэгжүүдийг олж тогтоохын зэрэгцээ тэдгээрт экспортын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөгөө үзүүлэх,
- Гадаадын зах зээлд экспортлогчдын санал болгож буй бүтээгдэхүүнийг сурталчилж, үр дүнг хянах.

Дан дотоодын зах зээлд үйлдвэрлэл эрхэлж байсан аж ахуйн нэгжүүд ихэвчлэн импортын бараатай өрсөлдөхөд чиглэж тэдгээртэй үнийн хувьд өрсөлдөх тактик хэрэглэж байдаг. Монгол улсын хувьд дэд бүтцийн хөгжил сул байгаагаас үнийн хувьд өрсөлдөх нөхцөл боломж муу байдаг тул энэ байдал эсрэгээрээ буюу үнийн хувьд ихэвчлэн илүү буюу ойролцоо үнэтэй гарч байна. Гэтэл үйл ажиллагаа тогтмол явуулж чадаад байгаагийн учир шалтгаан нь:

- Ажиллах орчин нөхцлийн шаардлагыг төдийлөн өндөрт тавьдаггүй, тэр хэрээр зардлаа хэмнэдэг
- Аливаа стандартад төдийлөн баригдаад байдаггүй
- Хөдөлмөрийн хөлсний хэмжээ эрс бага
- Түүхий эдийн үнэ харьцангуй хямд

зэрэг “боломж”-оо ашиглан үйл ажиллагаа явуулж чадаж байгаад оршиж байна.

¹⁷ Мөн тэнд

5. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН ЭКСПОРТОД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХЭД ТӨРӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

5.1. ПОЛЬШ УЛС

Экспортын бүтэц: Польшийн Засгийн газраас явуулсан бодлогын үр дүнд экспортын хэмжээ нь 2003 онд 1990 онтой харьцуулахад 3,7 дахин нэмэгдэж 53,567.9 сая ам.долларт хүрсэн байна. Экспортын бодлогоо шилжилтийн явцад шинэчлэх, шинэ зах зээл олоход үйлдвэрлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлж өгсөний нөлөөгөөр 1980 онд экспортын 50 гаруй хувь нь социалист улсад ногдож байсан бол 2004 он гэхэд экспортын 50% нь Европын холбооны өндөр хөгжилтэй улсууд болжээ.

Польш улс экспортоор гаргадаг бүтээгдэхүүний бүтцийг мөн сайжруулж чаджээ. 1980-аад онуудад гол бүтээгдэхүүний бүлэг нь зэс, нүүрс зэрэг түүхий эдээс бүрдэж байв. 1995 онд экспортын гол бүтээгдэхүүн нь аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн байсан бөгөөд эдгээр нь Польш улсын нийт экспортын 69%-ийг эзэлж байжээ. 2003 онд тэдгээрийн хувь нь 85.2%-д хүрч нэмэгджээ. Польшийн экспортод эзлэх түүхий эд материалын хувь нь 1995 онд 12.7%-тай байсан бол 2003 онд 6.9% болж буурчээ.

Хүснэгт 1: Компанийн хэмжээтэй дүйцүүлсэн ЖДҮ-ийн экспортын хэмжээ ба бүтэц

Зүйл анги	1995		2001		2002	
	Сая.ам доллар	Экспортод эзлэх хувь %	Сая.ам доллар	Экспортод эзлэх хувь %	Сая.ам доллар	Экспортод эзлэх хувь %
Нийт ЖДҮ-ийн экспорт. Үүнд :	8,815.4	100	15,847.6	100	18,242.0	100
1-9 ажилтантай	2,774.9	31.5	3,886.4	24.5	4,228.8	23.2
10-49 ажилтантай	2,451.6	27.8	4,136.0	26.1	4,571.4	25.1
50-249 ажилтантай	3,589.0	40.7	7,825.3	49.4	9,441.8	51.8

Жижиг дунд үйлдвэрлэлд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьсанаар 2000 оны орчим ийм компани экспортын 50%-ийг бүтээж байсан ба дотоодын буюу экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй компаниас өсөлтийн хувьд 2 дахин илүү байжээ.

ЭКСПОРТЫГ ДЭМЖСЭН БОДЛОГО:

Шилжилтийн үеийн эхэн үеэс эхлэн ЖДҮ-ийн экспортыг дэмжих, хөгжүүлэх бодлогын талаар Засгийн газраас гаргасан зарим баримт бичгүүдийг доор танилцуулж байна.

1. 1995 онд Засгийн газраас “Үндэсний эдийн засаг дахь жижиг дунд үйлдвэрийн талаар бодлого” гэж баримт бичгийг батлан гаргасанаар энэ салбарт баримтлах бодлогоо олон нийтэд тодорхой болгосон байна.

Энэ баримт бичгээр Польш улс дотоодын жижиг дунд үйлдвэрт Европын холбооны холбогдох дүрэм, шаардлагуудыг баримтлахыг тодорхойлсон ба тэдгээрийн өрсөлдөх чадварын шаардлагыг боловсруулсан байна.

Энэ баримт бичгээр

- “Жижиг дунд үйлдвэрийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх”,
- “Жижиг дунд үйлдвэрийн экспортыг нэмэгдүүлэх”,
- “Европын холбооны шаардлагад нийцсэн үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх”

гэсэн үндсэн 3 зорилт дэвшүүлсэн байна.

Үүнийг хэрэгжүүлэхдээ, “Санхүүгийн бүхийл асуудлыг шийдвэрлэх”, “Европын холбооны стандартыг хангахад чиглэсэн төрөл бүрийн сургалтанд хамрагдах боломжийг бүрдүүлэх”, “Шаардагдах төрийн үйлчилгээг хөнгөвчлөх, мэдээллээр хангах, технологийн шинэчлэлд туслах” арга хэмжээнүүдийг авсан байна. Мөн нэг онцгой арга хэмжээ нь ажиллах хүчний мэргэжлийн бүтцийг харгалзаж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх бодлого баримталсан байна.

2. 2002 он хүртэл Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төрийн бодлогыг 1998 онд батлан гаргасан.

Энэ арга хэмжээний хүрээнд өмнө нь бий болгосон мэдээлэл, сургалтын системийг улам төгөлдөржүүлэх, үйлдвэрлэлийн болон экспортын худалдааны даатгалын үйлчилгээнд хамруулах, олон улсын үзэсгэлэн яармагт олноор зохион байгуулалттай хамруулах, жижиг дунд үйлдвэрлэлд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, замыг улам өргөжүүлсэн.

3. 2003-2006 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх Засгийн газрын удирдамжийг батлан гаргасан.

Энэ бодлогын баримт бичгийн агуулгаас харахад Польш улсын жижиг дунд үйлдвэрлэлийн салбар харьцангуй өргөжиж Европын зах зээлд өөрийн байр сууриа эзлэх болсон тул илүү өргөн хүрээтэй том алхамыг хийж эхэлсэн байна. Үүнд:

- ЖДҮ-ийн хөгжилд үр нөлөө үзүүлэх санаачилгыг дэмжих
- ЖДҮ-ийн салбарын байгууллагын орчинг хөгжүүлэх
- Олон улсын түвшинд компани, пүүс тэдгээрийн үйл ажиллагааг нэгтгэх асуудлыг дэмжих
- ЖДҮ-ийн салбарын эрх зүйн, захиргааны орчинг сайжруулж, нийгэмд бизнес эрхлэх хандлагыг хөгжүүлэх

Өөрөөр хэлбэл, Польш улсын үйлдвэрүүдийг олон улсын брэнд үйлдвэрүүдийн салбар болгох, улмаар тэдний Европын зах зээлд нэвтрэх гүүр нь болох бодлого баримталж байна. Үүний зэрэгцээ, өөрийн улсын олон улсад танигдсан брэндүүдийг зөвхөн Европод бус дэлхий нийтийн хэмжээнд бүтээгдэхүүнээ экспортлоход дэмжлэг үзүүлж эхэлсэн байна.

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХЭД АВСАН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Экспортыг дэмжих ЭКСПРОМ I хөтөлбөр: 1993 оноос хэрэгжиж эхэлсэн хөтөлбөр бөгөөд гол агуулга нь үйлдвэрлэгчдийн уялдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн. Тухайн үед судалгаа хийж үзэхэд уялдаатай ажиллаж чадахгүйгээс багагүй ашгийг алдаж байсан байна. Тухайлбал, оёдлын үйлдвэрлэгчид импортолсон даавуу хэрэглэдэг байжээ. Нөгөөтэйгүүр, даавуу үйлдвэрлэгчид өөрийн бүтээгдэхүүнээ шууд гадаадын зах зээлд экспортолдог байв. Үүнээс гадна оёдлын ч бас даавууны ч үйлдвэрлэгчид мэргэжлийн хувцасны буюу даавууны дизайнеруудын үйлчилгээг ашигладаггүй байжээ. Байгаа боломж, бололцоог тэд ердөө л мэдэхгүй байв. “Хүмүүсийг хооронд нь холбох” хөтөлбөрийг оёдол, арьс шир, гутлын үйлдвэрийн салбаруудад хэрэгжүүлж эхэлжээ.

Үүний үр дүнд экспортын гол салбар оёдол, даавуу үйлдвэрлэл, арьс ширний салбарт томоохон ахиц өгсөн байна.

Хөтөлбөрийг зохицуулах нэгж нь Польш улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтцэд хамаарч байжээ. Уг хөтөлбөрийг 1996 онд хэрэгжүүлэн дуусгавар болгожээ. Хөтөлбөрийн эхэн үед цөөн тоотой компани хамрагдсан ч сурталчилгааны үр дүнд олон компанийг хамруулж хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хөрөнгийн дийлэнхийг (80%) Европын холбоо санхүүжүүлжээ.

ЭКСПРОМ II хөтөлбөр: 1997 онд хэрэгжиж эхэлсэн энэ хөтөлбөр агуулгын хувьд өмнөх хөтөлбөртэй төстэй боловч тодорхой салбаруудыг сонгон авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Эмийн хэрэгсэл, тоног төхөөрөмж
- Оёдол
- Хөнгөн тэрэгний сэлбэг, хэсэг бүрэлдэхүүн
- Ган цутгах үйлдвэрийн бүтээгдэхүүн
- Хуванцар бүтээгдэхүүн
- Тавилга

Энэхүү хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Баруун Европт ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг сонгож авсан салбаруудын харьцуулсан дүн шинжилгээ.

2. Экспортыг хөгжүүлэх төлөвлөгөө, стратегийг боловсруулахад салбар бүрийн экспортын туршлагатай 30 ЖДҮ-т дараах 2 чиглэлээр дэмжлэг үзүүлэх:

- Компаниудын экспортын баримжаатай хөгжил. Зорилтот зах зээлд шаардагдах чанарын удирдлагын ISO-9000 стандарт, бүтээгдэхүүний гэрчилгээ зэрэгт хүрэх зорилготой зөвлөгөө өгөх явдал гол ажлуудын нэг нь байжээ. Үүнээс гадна, гадаадын зах зээлийн шаардлагад бүтээгдэхүүн, савлагаа зэргийг нийцүүлэх талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлжээ.
- Олон улсын зах зээлд хүрэх хүртээмж. Компаниудад гадаадын үзэсгэлэнд оролцох, гадаад орнуудад боломжийн үйлчлүүлэгчдийг тодорхойлох, хамтран ажиллах түншийг тогтоох, Интернэтээр сурталчилгаа хийх зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлжээ.

Энэхүү хөтөлбөрт хамрагдсан компаниуд нь зардлыг хуваах үндсэн дээр экспорттой холбогдолтой (экспортын бүтээгдэхүүний технологи ба чанарыг сайжруулахад) хөрөнгө оруулалтад буцалтгүй тусламж авах эрхтэй байжээ. Хөтөлбөр 2000 онд хэрэгжиж дууссан.

Үндэсний экспортын хөгжлийн хөтөлбөр: Хөтөлбөрийн ерөнхий зорилго нь ЖДҮ-ийн салбарын экспортын өсөлтийг эрчимжүүлэхэд оршиж байв. 2000 онд эхэлж 2003 онд дууссан байна. Энэхүү хөтөлбөр нь 2 хэсгээс бүрдэж байв. буцалтгүй тусламж болон техникийн тусламж:

1. Эхний хэсэг нь ЖДҮ, тэдгээрийн экспортын чадавхыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлжээ – Энэ хэсэгт компаниудын экспортын зардлын 60 хүртэл хувийг санхүүжүүлэх, түүнд зориулсан төрөл бүрийн сургалтыг үнэ төлбөргүй явуулж зардлыг төрөөс хариуцдаг байсан байна.
2. Техникийн тусламжийн төсөл: зорилго нь экспортын бодлого, байгууллагын

бүтцийг сайжруулах, үндэсний болон бүс нутгийн түвшинд зохион байгуулалттай замаар экспортын өсөлтийг эрчимжүүлэх арга хэмжээ, механизмыг нэвтрүүлэх зэрэгт оршиж байв.

Экспортыг дэмжих эдгээр үндсэн бодлогын зэрэгцээ бусад төрийн байгууллагуудын хүрээнд “жигжиг” арга хэмжээнүүдийг нилээд өргөн хүрээтэйгээр хэрэгжүүлсэн. Тухайлбал,

- Гадаадын яармаг худалдаанд оролцсон зардлын зарим хэсгийг нөхөн төлөх
- Гадаадын худалдааны үзэсгэлэнд явахдаа худалдааны аялалд оролцсон зарим зардлын нөхөн төлбөр
- Бүтээгдэхүүний гэрчилгээний зардалд зориулсан татаас
- Сурталчилгааны түүвэрлэсэн хөтөлбөр
- Экспортын мэдээлэл
- Ноён Экспорт уралдаан
- Экспортлогчдыг хөгжүүлэх хөтөлбөр
- Экспортын авлагын даатгал – Евро бодлого
- Зах зээлийн бус эрсдэлийн эсрэг экспортын авлагын даатгал –эргэлтийн хөрөнгө ба ганцаарчилсан даатгалын гэрээ
- Экспортын зах зээл хайх зардлыг даатгуулах
- Экспортын зээлийн хүүгийн хөтөлбөрт зориулсан татаас
- Экспортын зээлийн баталгааны сан

ПОЛЬШ УЛСЫН ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГОЛ ОНЦЛОГ:

Польш улс эдийн засгийн шилжилтийн явцад жигжиг дунд үйлдвэрүүдийн экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлж экспортын дийлэнх хувийг бүрдүүлэх болсон ч дотооддоо хийсэн дүгнэлтээс харахад төдийлөн өндөр амжилт олж чадаагүй байна гэж дүгнэжээ. Тиймээс Польш улсын Засгийн газар шилжилтийн үеийн эхэн үеэс эхлэн экспорт, жигжиг дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих механизмыг бий болгох асуудалд онцгой анхаарал хандуулж ирсэн байна.

Польшийн ЖДҮ-ийн экспортыг дэмжих бодлого нь дараах гол асуудлаас бүрддэг юм. Үүнд:

- Эдийн засгийн яам нь экспортыг дэмжих ажлын гол зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж, экспортыг дэмжих зарим арга хэмжээг шууд хэрэгжүүлдэг юм.
- ЖДҮ-ийн экспортыг дэмжих нь ЖДҮ-ийн хөгжлийн тогтолцоо болон бүх компаниудад чиглэсэн экспортыг дэмжих тогтолцооны хэсэг бүрэлдэхүүн.
- Польш улсын экспортыг дэмжих тогтолцооны экспортын баримжаатай бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажилладаг ганцхан төрөлжсөн байгууллага байхгүй билээ. Хэмжээнээс үл хамаарч бүх компаниудад зориулсан хэрэгслүүд болон арга хэмжээг Эдийн засгийн яамны Гадаадын хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих газар хэрэгжүүлдэг юм. ЖДҮ-т чиглэсэн хэрэгсэл болон хөтөлбөрийг ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр төрөлжсөн Польшийн Аж ахуйн нэгжийн хөгжлийн агентлаг санал болгодог.
- Экспортыг дэмжих бодлогод төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг найдвартай, түргэн шуурхай, уян хатан байхаар зохицуулалт хийж ажилласан.
- Гадаадад суугаа Польш улсын Элчин сайдын яамдын Худалдааны хэлтэс нь Польшийн компаниудыг, тэр дундаа жигжиг дунд үйлдвэрийг сурталчлахад

гүйцэтгэх үүрэг нь улам чухал болж байгаа билээ.

- Гадаадын үзэсгэлэнд оролцох, экспортын менежментийн сургалтын хөтөлбөрийг тус тус хамтран санхүүжүүлэх нь Польш улсын жижиг дунд үйлдвэрт экспортыг дэмжих хэрэгсэл дундаас хамгийн түгээмэл хэрэглэдэг нэгэн арга хэмжээ байгаа юм.
- Банкны зээл авах жижиг дунд үйлдвэрлэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Экспортын зээлийн баталгааны санг бий болгосон байна. Мөн Экспортлогчдод зориулсан тусгай банк байгуулахаар төлөвлөж байна.

5.2. ЧЕХ УЛС

Чех улсын экспорт нь ДНБ-ийн ойролцоогоор 58%-ийг бүрдүүлдэг байна. Нэг хүнд ноогдох экспорт нь 2002 онд 3,250 ам. доллар хүрсэн нь Польш улстай харьцуулахад ойролцоогоор 3 дахин өндөр байжээ. Худалдаа үйлдвэрийн яамны мэдээллийн дагуу 2003 онд жижиг дунд үйлдвэрлэгчийн тоо нь нийт компаниудын 99%-ийг эзэлж байсан бөгөөд нийт ажилтнуудын 63%-ийг ажиллуулж байжээ.

Үндэсний эдийн засгийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 52%-д хүрчээ. Энэхүү хувь нь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа. 2002 онд энэ нь 52.2%-тай байв. Экспортын 19.9%-ийг 50-249 ажилчидтай дунд хэмжээтэй компаниуд гаргасан бөгөөд 49 хүртэлх ажилчидтай жижиг компаниуд нь 11.5%-ийг гаргасан байжээ. 249 хүртэлх хүмүүсийг ажиллуулдаг бизнес эрхэлдэг хувь хүмүүс нь 2003 онд нийт экспортын 2.6%-ийг гаргажээ.

ЭКСПОРТЫГ ДЭМЖСЭН БОДЛОГО: Чех улсын Засгийн газрын экспортын баримжаатай бодлогыг дараах 3 стратеги зорилтоор тодорхойлсон. Үүнд:

- Европын орнуудтай харьцуулж болохуйц хэмжээнд нэг хүнд ноогдох экспортын хэмжээг хүргэх
- Экспортын өсөлт, нэн ялангуяа илүү өндөр нэмүү өртөг бүхий экспорт, худалдааны балансын үр дүнд эерэг нөлөө бий болгохыг дэмжих
- Нийт экспортод эзлэх жижиг дунд үйлдвэрийн хувийг нэмэгдүүлэх

Экспортын баримжаатай гол байгууллага болох “Экспортын зээлийн даатгалын компани ЭГАП” 1992 онд, “Экспортын банк ГЕБ” 1995 онд, “Худалдааг дэмжих агентлаг” 1997 онд тус тус байгуулагджээ. 1999 онд Худалдаа, үйлдвэрийн яам нь Чех улсын “Худалдаа, экспортыг дэмжих зөвлөл” -ийг санаачилжээ.

Экспортын баримжаатай бодлого нь экспортын баримжаатай аргачлал, арга хэмжээг улсын экспортыг дэмжих загварын үндсэн 5 чиглэлээр тодорхойлжээ. Үүнд:

- Экспортын тариф, тарифын бус саад бэрхшээлийг арилгах, гадаад худалдааны стратегийг боловсруулах, экспортын баримжаатай төрийн бодлогыг зохицуулах
- Төрийн дэмжлэгтэйгээр экспортыг санхүүжүүлэх, даатгуулах болон хөгжлийн тусламжид хандах
- Мэдээллийн технологи, зөвлөгөө өгөх, тусламж ба мэргэжлийн боловсрол
- Чех улсын бүтээгдэхүүн ба компаниудыг гадаадад сурталчлах ба таниулах
- Богино хугацааны экспортын баримжаатай арга хэмжээг нэмэх

Чех улсын жижиг дунд үйлдвэрийг дэмжих бодлогын урт хугацааны зорилтыг “нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн нөхцөл болох үндэсний эдийн засгийн бүтээгдэхүүн, технологийн өсөлт, өрсөлдөх чадвар, ажилгүйдэл болон бүс нутгийн, нийгмийн, эдийн засгийн ялгаатай байдлыг бууруулах түвшинд хувь нэмэр оруулах боломжтой байхаар

жижиг ба дунд үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж болох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” хэмээн тодорхойлсон байна.

Чех улс жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих бодлогоос дурьдвал

- “Маркет” хөтөлбөр: Энэхүү хөтөлбөрийн зорилго нь гадаадын болон дотоодын зах зээл дахь жижиг дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулахад оршиж байв. Дэмжлэгийг чанарын удирдлагын гэрчилгээ авсан тохиолдолд буцалтгүй тусламж (татаас) хэлбэрээр үзүүлж байжээ.

Эдгээр татаасыг 50-250 ажилчинтай дунд зэргийн хэмжээтэй компаниудад итгэмжлэгдсэн гэрчилгээ олгодог байгууллагаас ISO:14001-ны дагуу орчны удирдлагын гэрчилгээ буюу ISO:9001-2001 ба ISO:14001-ны дагуу хамтран хэрэгжүүлэх ба баталгаажуулсан чанарын хяналтын тогтолцооны гэрчилгээг олгоход зориулжээ. Жижиг хэмжээний компани буюу 0-50 ажилчинтай компаниудын хувьд татаасыг ISO:9001-2001-ны дагуу чанарын хяналтын тогтолцооны гэрчилгээг баталгаажуулдаг байгууллагаас авахад олгож байв.

Экспорттой холбоотой мэдээлэл, зөвлөгөө, боловсролын үйлчилгээгээр дэмжих МАРКЕТИНГ хөтөлбөр: Энэхүү хөтөлбөрийн зорилго, зорилт нь Чех улсын жижиг дунд үйлдвэрийн гадаадын зах зээлд гарах хүртээмжийг хөнгөвчлөх, Чех улсын жижиг дунд үйлдвэрт болон бусад орнуудад үйлчилж буй мэдээлэл, зөвлөгөө ба боловсролын үйлчилгээний хүрээ, чанарын ялгааг бууруулахад оршиж байв. Энэ хөтөлбөрийн үр дүнд жижиг дунд үйлдвэрүүд дэлхийн зах зээл дээр байгаа боломжийг ашигласнаар өөрийн эргэлтийн хөрөнгө, ашгийг нэмэгдүүлж чаджээ. Энэ хөтөлбөрт дараах үйлчилгээ хамрагдаж байсан байна. Үүнд:

- Маркетингийн мэдээлэл
- Маркетингийн боловсрол
- Маркетингийн сурталчилгааны материал, Интернэт маркетинг
- Илтгэл, үзэсгэлэн худалдааны шоунд зориулсан татаас

Дизайны үйл ажиллагааг дэмжих ДИЗАЙН хөтөлбөр: Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь Чех улсын бүтээгдэхүүний дизайн болон өрсөлдөх чадварыг сайжруулахад оршиж байв. Энэхүү хөтөлбөр нь дизайныг бизнесийн стратегитай нэгтгэхэд аргачлалын туслалцаа үзүүлэх, дизайнерыг сонгоход туслах, дизайнер болон бизнесмэнүүдийн хоорондын үр өгөөжтэй хамтын ажиллагааг өрнүүлэх оновчтой нөхцөлийг бүрдүүлэх, чанартай дизайны ажлыг худалдан авах зэрэг боломжийг ЖДҮ-т олгожээ.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд компаниуд нь дизайн бүтээх төлбөрийн 50%-тай дүйцэх хэмжээний дизайны үйлчилгээний татаас авах боломжтой байжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд уг татаасыг жилдээ нэг л удаа авах боломжтой байв.

ЧЕХ УЛСЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ҮНДСЭН АСУУДАЛ

Чех улсын экспортод эзлэх жижиг дунд үйлдвэрийн хувь нь харьцангуй бага байгаа. Тиймээс засгийн газар нь Чех улсын жижиг дунд үйлдвэрийн экспортыг эрчимжүүлэн дэмжихэд ихээхэн хүчин чармайлт зарцуулж байгаа билээ.

Чех улсын жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих бодлогын үндсэн асуудал:

- Шилжилтийн эхэн үеэс эхлэн Худалдаа, үйлдвэрийн яамны гүйцэтгэх үүргийг зөвхөн бодлого боловсруулах төдийгүй экспортын баримжаатай үйл ажиллагааг зохицуулах болон зохион байгуулах асуудал руу эрчимтэй чиглүүлж байв,

- Жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих бодлогыг экспортын баримжаатай бодлогын хүрээнд Чех улсын бүх компаниуд болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогод чиглэн хэрэгжүүлдэг,
- Зах зээл болон бүтээгдэхүүний боловсруулалт, санхүүгийн үйлчилгээ зэрэг жижиг дунд үйлдвэрт чиглэсэн экспортын баримжаатай өргөн цар хүрээтэй дэмжлэгийг өөрчлөгдөж буй зах зээл, компаниудын нөхцөл байдал болон улсын төсвийн санхүүгийн байдалтай уялдуулах хэлбэрээр хэрэгжүүлдэг,
- Төр болон хувийн хэвшил хоорондоо санал бодол, сэтгэгдэл, төсөөллөө харилцан солилцох үндэс суурь болох Худалдаа, Экспортыг Дэмжих Чех улсын Зөвлөлийн үүргийг чухалчлах,
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих болон сурталчлах тогтолцоонд гадаадад суугаа Чех улсын Элчин сайдын яамдын Худалдааны хэлтсийг идэвхтэй оролцуулах. Худалдааны хэлтэс нь Гадаад хэргийн яамны шууд харъяа байгууллагын хувьд ЖДҮ-ийн экспортын баримжаатай үйл ажиллагаанд тэдгээр албыг үр өгөөжтэйгөөр ашиглах зорилгоор Худалдаа, үйлдвэрийн яам болон Гадаад хэргийн яамдын хооронд тусгай гэрээ байгуулсан билээ.
- Тусгай байгууллагыг байгуулах - Чех улсын компаниуд болон Чех улсын нийлүүлэгчдийг хайж буй гадаадын үйлдвэрлэгчдэд нэгэн зэрэг экспорттой холбогдсон үйлчилгээг үзүүлэх Чех улсын агентлаг гэдэг байгууллагыг бий болгосон. Чех улсын Худалдааг дэмжих агентлаг нь бүс нутгийн болон олон улсын төлөөлөгчдөөс бүрдсэн өргөн цар хүрээтэй сүлжээг байгуулж чаджээ. Тус байгууллагын үйлчилгээ нь компаниудын хэмжээ болон экспортын туршлагаас хамааран ялгаатай байдаг байна. Чех улсын агентлаг нь экспортын баримжаатай үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд болон экспортыг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах төрийн өмчийн бусад байгууллагуудтай нягт хамтран ажилладаг юм.
- Чех улсын Экспортын банк болон Экспортын зээлийн даатгалын компани зэрэг экспортлогчдод зориулан санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг төрийн дэмжлэгтэй, идэвхтэй болон үр өгөөжтэй байгууллагуудыг шилжилтийн эхэн үед байгуулсан билээ.
- Жижиг дунд үйлдвэрийн экспортыг дэмжих тогтолцоонд экспорттой холбогдсон үйлчилгээ үзүүлдэг хувийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулдаг.
- Улсын төсөв, бүс нутгийн төсөв, компаниудын хөрөнгө, Европын Холбооны Фар хөтөлбөр болон Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага хөтөлбөрөөс экспортыг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлдэг.

5.3. БОЛГАР УЛС

Тус улсын экспортыг дэмжих ажиллагааны гол байгууллага Худалдааг дэмжих агентлаг нь 2002 - 2003 онд 2 жил дарааллан “Шилжилтийн эдийн засгийн Худалдааг Дэмжих шилдэг байгууллага”-аар тодорсон байна.

2001 онд Болгар улсын Засгийн газар нь Эдийн засгийн яамны харъяа нэгдсэн худалдааг дэмжих байгууллага болох Болгар улсын Худалдааг дэмжих агентлагийг/БХДА/ байгуулжээ. БХДА эрхэм зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ: “Гадаадын болон Болгарын аж ахуйн нэгжүүдийн олон улсын хамтын ажиллагааг дэмжин, олон улсын борлуулалт болон зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэхэд Болгарын компаниудад тусламж үзүүлэх замаар Болгар улсын эдийн засгийг бэхжүүлнэ” гэжээ. Үүнтэй холбогдуулан БХДА нь дараах нэн тэргүүний салбарт гол анхаарлаа хандуулж байгаа болно. Үүнд:

- Эдийн засгийн худалдаатай холбоотой гадаад бодлого болон эдгээр бодлогын хэрэгжилт

- Гадаад худалдааны харилцааны салбар дахь төр-хувийн хэвшлийн түншлэл,
- Өргөн цар хүрээтэй эдийн засгийн болон худалдааны мэдээллийг цуглуулах, түгээх
- ЖДҮ-т зориулсан үйлчилгээг хөгжүүлэх зэрэг төрөл бүрийн бизнесийн асуудлаар зөвлөгөө үзүүлэх
- Болгарын компаниудын экспортын стратегийг боловсруулж, тэдгээрийг Европын болон дэлхийн зах зээлд нийцүүлэх
- Салбарын нийгэмлэг болон танхимуудтай хамтран ажиллаж үндэсний эдийн засаг дахь тэдгээрийн үүргийг сайжруулах

БХДА-ны үйл ажиллагаа

Компаниудад экспорт болон худалдааны талаар ерөнхий мэдээлэл, зөвлөгөө өгч, экспортын шинэ зах зээлийг ойлгох, сонгох болон нэвтрэхэд нь туслалцаа үзүүлдэг байна. Өргөн цар хүрээтэй үйл ажиллагааны менежментийг явуулахдаа ажлаа дараах гурван газраар дамжуулан гүйцэтгэдэг. Үүнд:

Гадаад судалгаа, зөвлөгөө өгөх газар

Уг агентлаг нь олон улсын худалдааны хөгжил, өөрчлөлтийг нарийн судалж байдаг байна. Тиймээс энэ газар нь бүтээгдэхүүний болон тухайн орны талаар судалгаа явуулахаас гадна худалдааны орчны дотоод болон дэлхийн хөгжлийн явцад дүн шинжилгээ хийж олон улсын тавцан дахь Болгарын экспортлогчдын гүйцэтгэлийг сайжруулахад ашиглаж болох боломж болон учирч болзошгүй аюул зэргийг үнэлэх талаар төрөлжсөн судалгааны тайланг боловсруулж гаргадаг байна. Мөн түүнчлэн, уг газар нь олон улсын хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх, Болгарын компаниудын талаар мэдээлэл дээр нарийвчилсан зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, Болгарын үйлдвэрлэгчтэй хэлэлцээр зохион байгуулах, олон улсын үйлчлүүлэгчид дараагийн шатны ганцаарчилсан үйлчилгээ үзүүлдэг.

Олон улсын хөтөлбөр, хамтын ажиллагааны газар

Олон улсын хөтөлбөр болон хамтын ажиллагааны газар нь олон улсын худалдааг дэмжих байгууллагууд болон бусад байгууллагуудтай хамтран худалдааг дэмжих төслийн хэрэгжилтийг хариуцдаг. Мөн экспортлогч болон импортлогчдод зориулан богино хугацааны бизнесийн сургалт зохион байгуулах, бизнесийн чуулган явуулах, илтгэл бэлтгэх зэрэг болно.

Олон улсын үзэсгэлэн, сурталчилгааны газар

Олон улсын үзэсгэлэн болон сурталчилгааны газрын зорилго нь гадаадад Болгарын бүтээгдэхүүн болон компаниудыг сурталчлахад чиглэнэ. Энэ нь Болгарын компаниудын олон улсын худалдааны яармаг, үзэсгэлэнд оролцох оролцоог зохион байгуулдаг. Үүнээс гадна уг газар нь мэдээллийг дэлхий даяар түгээдэг бөгөөд Болгар улсын санал болгож буй боломжийг гадаадын бизнесмэнүүдэд мэдээлэх үүрэгтэй төрөл бүрийн хэвлэмэл материалыг боловсруулах, хэвлэх ажлыг хянадаг байна

6. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд боловсруулагдан, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийг дараахь хүснэгтэд тоймлон үзүүлэв.

№	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ
---	---

1. ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ /1998/

2. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2007/

Хуулийн зорилт нь төрөөс **жижиг, дунд** үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг **дэмжих** талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангах.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай, Хоршооны тухай, Нөхөрлөлийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2006/

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай /6.4.4/ байхыг заасан бөгөөд Улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, жижиг, дунд бизнес (аж ахуйн үйл ажиллагаа)-ийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт /9.2.2./

14 дүгээр зүйлд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн хөрөнгө, тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого/14.1.1/, олгосон зээлийн буцаан төлөлтийн орлого/14.1.2/, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох /14.5.1/ талаархи харилцааг зохицуулсан байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодит өсөлт, мөнгөний ханшны өөрчлөлтийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална. /14.3./ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд орон нутгийн төсвөөс хөрөнгө олгож болох бөгөөд түүний хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж баталхаар тус тус заасан байна. /14.4./

4. ГААЛЬ БОЛОН НӨАТ-ААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ

Жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг 2009 оны 7 дугаар сарын 16-аас 2012 оны 12 дугаар сарын 31-ыг дуустал хугацаанд Гааль болон НӨАТ-аас 683 төрлийн тоног төхөөрөмжийг чөлөөлөх жагсаалт гарсан байна.

/ЗГ-2009-316/

5. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР /ЗГ-1999-10/ /ЗГ-2005-64/

Хөтөлбөрийн зорилго: Жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэх. 2005-2010

Хэрэгжилтийн байдал:

Улаанбаатар хотын ЖДҮ-ийн судалгааг гаргаж, мэдээллийн санг байгуулан бүрдүүлж байна. Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулсан байна. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Гаалийн татварын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулсан байна. ЖДҮ-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулсан. Жижиг, дунд үйлдвэрийн шалгуур үзүүлэлт, ЖДҮ-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулсан. Бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зорилгоор “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн

газрын 222 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, 127 дугаар тогтоолоор батлуулсан байна. Үйлдвэр, худалдааны Сайд, УБ хотын захирагч, “Улаанбаатар” Банкны гүйцэтгэх захирал нарын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулж, Улаанбаатар хотод Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан байгуулав. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох.

Өнгөрсөн жил **жижиг дунд үйлдвэрийг дэмжих** хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймгийн иргэд, хувиараа бизнес эрхлэгчид 730 сая төгрөгийн зээл авчээ. “Энэ зээл үр ашгаа өгч эхэлсэн. Нутгийн брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх явдал сэргэж эхэлж байна. Тухайлбал, Баянлиг суманд ингэний сүүний үйлдвэр, Эрдэнэцогт суманд сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэр ашиглалтанд орсон. Шинээр үйлдвэрлэл эрхлээд зогсохгүй, хөрөнгө санхүүгийн улмаас сөхрөхөд хүрээд байсан олон аж ахуйн нэгж сэргэж байгаа нь энэ бодлогын нэг сайн үр ашиг болж байна.

Хөтөлбөр зохих үр дүнд хүрч байгаа боловч санхүүжилт хугацаандаа олгогдохгүй, жижиг дунд үйлдвэрийг /ЖДҮ/ дэмжих зээлийн эх үүсвэр урт хугацаат хөнгөлөлттэй зээлийн асуудлын шийдвэрлэгдэх хугацаа удаашралтай, ЖДҮ эрхлэгчдийн мэдлэг, боловсрол, чадвар дутмаг зэргээс хамаарч уг хөтөлбөрийн зарим арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх хандлага ажиглагдсан байна.

6. НЭГ СУУРИН-НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨТӨЛБӨР /ЗГ-2005-138/

Хөтөлбөрийн зорилго: Орон нутгийнхаа боломж, давуу талыг ашиглан оршин суугчдынхаа бахархал болохуйц чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж бүс нутаг, улсын хэмжээнд борлуулан улмаар экспортод гаргах, гадаад, дотоодын иргэдийн сэтгэл татам шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх замаар орон нутгаа сэргээн хөгжүүлэх, эдийн засгийн харьцангуй бие даасан мужлал, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн цогцолбор бий болж, төрөлжиж хөгжихөд дэмжлэг үзүүлэх

I үе шат 2005-2008

II үе шат 2009-2012

Хэрэгжилтийн байдал:

Нэгдүгээр үе шат: 2005-2008 онд хөтөлбөрийг сурталчлах, орон нутагт мэргэжил арга зүйн удирдлага, туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах, үзэсгэлэн зохион байгуулах, туршлага солилцох, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах зэрэг үйл ажиллагааг зонхилон хэрэгжүүлэхээр заасны дагуу үндсэн үйл ажиллагаа явуулжээ.

Шадар сайдын 2007 оны 3 дугаар сард баталсан удирдамжийн дагуу “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж буй ажлын явцтай танилцахаар Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Баян-Өлгий, Ховд, Увс, Хэнтий аймгуудад ажилласан байна. Шилдгээр шалгарсан ААН-ийн эзэдтэй уулзахад ЗГ-ын “Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн хөтөлбөр”-ийн хэрэгжилт, иргэд, ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа эрчимтэй, орон нутгийн идэвхи, санаачлага сайн, ард иргэд үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээгээ өргөтгөхийн тулд мөнгөн тусламж, хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах хүсэл эрмэлзлэлтэй болсон байна. Дархан-Уул аймгийн “Дархан дээжис” ХХК-ны талх нарийн боовны үйлдвэрлэл, “Орхон жимс”-ын төмс хүнсний ногоо, жимс жимсэн бүтээгдэхүүн, Увсын чацаргана, чулуун давс, Дорнод аймгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Найнги” ХХК, талхны үйлдвэрлэлийн “Онхоодой” ХХК, Дорноговь аймгийн ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн буцалгаа, Хамрын хийдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ, Баян-

Өлгий аймгийн Үндэсний гар урлал, Каз, Булган аймгийн Сайханы айраг болон Могодын удаан хугацаанд хадгалах боломжтой савалгаатай айраг, Хэнтий аймгийн Чингис хааны өлгий нутгийг түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ, Дадалын сүү, сүүн бүтээгдэхүүн, Өмнөговийн байгалийн аялал жуулчлал, Ингэний буцалгаа, Баянхонгор болон бусад аймгуудын гар урлал, эсгий эсгий эдлэлийн бүтээгдэхүүнүүд зэрэг хүнс, ХАА, гар урлал, аялал жуулчлалын чиглэлээр аймаг бүрт орон нутаг болон улсын хэмжээнд танигдсан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, бүтээгдэхүүн үйлчилгээ олноор бий болсны зэрэгцээ, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, хамрах хүрээ өргөжсөн байна.

Хангайн бүсд 2007 онд зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдааны үеэр зөвхөн эхний өдрийн байдлаар 120-130 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулагдсан бөгөөд энэ нь жижиг дунд үйлдвэрлэл өсөж байгаагийн үр дүн гэж үзэж байна.

Зарим аймгууд орон нутгийг хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулж тухайлбал Булган аймаг шилдгээр шалгарсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд 2005 онд 10.0 сая, 2006 онд 40.0 сая, 2007 онд 200.0 орчим сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгуулж ажилласан нь дотоод нөөц бололцоондоо тулгуурлаж төрөөс дэмжлэг үзүүлсэн бодитой алхам, ингэж ажиллаж болохыг харуулсан сайн туршлага болжээ. Олон аймаг 2007 оноос эхлэн банкны байгууллагатай хамтран ажиллаж хөнгөлөлттэй зээл олгох ажлыг эхлүүлж, бодит үр дүнд хүргэхээр ажиллаж байгаа юм байна.

Аймгуудад 2006, 2007 онд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үзэсгэлэн зохион байгуулах, сургалт сурталчилгаа явуулснаар үр дүнд тус бүр 10-30 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутгийн шилдэг брэнд бүтээгдэхүүнээрээ шалгаруулж өргөмжлөл хүртээн, мөнгөн шагналаар урамшуулж олны хүртээл болгосны дүнд тухайн бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлага, борлуулалтын хэмжээ жил ирэх тутам өссөн байна.

БХҮХ-ны Ажлын алба болон Бүсийн зөвлөл, уг хөтөлбөрийг хариуцан зохион байгуулах орон нутгийн салбар зөвлөлүүдтэй хамтран 2006, 2007 онд аймаг тус бүрт үзэсгэлэн худалдаа зохион байгуулж аймаг бүрээс шилдгүүдийг шалгаруулж бүсийн түвшинд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж шилдгийн шилдэг бүтээгдэхүүн шалгаруулж өргөмжилсөн нь иргэд, ААН-ийг урамшуулсан ажил болжээ. Бүсийн хэмжээнд аймгуудын шилдэг үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулсан үзэсгэлэнгээр борлуулалтын шинэ сувгийг нээх, хоорондоо туршлага, мэдээлэл солилцох бололцоо бий болгож өгчээ. Шилдэг бренд бүтээгдэхүүн, үйлчилгээ чанар, стандартын шаардлага хангасан байх, аймаг бүсийн хэмжээний шилдгүүдийг үндэсний чанарын сертификат, тохирлын үнэлгээтэй болгох /чанар, сав баглаа боодол, хадгалалтын хугацаа, стандарт гэх мэт/ шаардлагатай гэдэг нь тодорхой байна. Энэ талаар холбогдох газруудтай хамтран ажиллаж байна.

Хоёрдугаар үе шат: Үйл ажиллагааг орон нутаг, бүсийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх талаар санал боловсруулж үндэсний зөвлөлд хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

Монгол Улсын СХЗҮТ, ОӨГ, МҮХААТ-ийн (Патент барааны тэмдгийн товчоо болон бусад) зэрэг төрийн болон ТББ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага байна гэж үзсэний дагуу 2008 онд хамтран ажиллах чиглэлийг тогтоож ажлаа уялдуулах, мэдээлэл солилцох нөхцөл бүрдээд байна.

Шилдэг бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээг сурталчлах сүлжээ бий болгох, нөхцөл байдлын судалгаа хийх, тодорхой арга хэмжээг авч, ажил зохион байгуулж болох эсэхийг хөтөлбөр хариуцсан ажилтнууд, ҮХЯ-ны Монголд үйлдвэрлэл хөгжүүлэх төслийн мэргэжилтнүүд болон иргэд, аж ахуйн эрхлэгчидтэй ярилцаж саналуудыг нэгтгэж байна. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, хэрэгжүүлж буй ажилтнуудыг сургалтанд хамруулах, үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх, сургалт

явуулах, гарын авлагаар хангах талаар GTZ, Mercy Corps зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. 2008 оны 1-р улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний тухай мэдээлэл хийж шийдвэр гаргуулахаар бэлтгэж байна.

7. ЭКОЛОГИЙН ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН ХӨТӨЛБӨР /ЗГ-2006-50/

Хөтөлбөрийн зорилго: Өөрийн орны онцлог давуу талаа түшиглэн олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх замаар “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”-ий монгол брэндийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд гарган сурталчилж, эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэх

I үе шат 2006-2008

II үе шат 2009-2015

Хэрэгжилтийн байдал:

Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай, эхлэлийн төдий байгаа бөгөөд экологийн цэвэр бүтээгдэхүүний стандарт, шалгууруудыг боловсруулж гаргаагүй байна. Үндэсний хороо гүйцэтгэх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, салбар хоорондын уялдаа муу байсан зэрэг нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлжээ. ХХААЯ, ҮХЯ, БОЯ, Худалдаа аж үйлдвэрийн танхимын ажлын уялдаа муу байсан гэж дүгнэсэн байна.

8. НОГООН ХУВЬСГАЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-1997-169/

Хөтөлбөрийн зорилго: Ажилгүйдэл ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд 1997 онд баталсан Ногоон хувьсгал хөтөлбөрийн үзүүлж байгаа нааштай нөлөө, орон нутгийн удирдлага, иргэдийн хүсэлтийг харгалзан II үе шатыг хэрэгжүүлэхээр баталсан байна. Хөтөлбөрийн эхний үе шатанд олсон ололтоо бататгах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний усалгаатай тариаланг хөгжүүлж, өрх фермерийн аж ахуй болон жижиг хоршоод хамгаалагдсан хөрсний аж ахуйг эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах

I үе шат: 1997-2005

II үе шат: 2005-2012

Хэрэгжилтийн байдал:

Хөтөлбөрийн 1-р үе шат: 1998-2004 онд улсын төсөв, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийт 1.77 тэрбум төгрөг зарцуулан бага оврын 225 трактор иж бүрдлийн хамт, 210 га талбай услах бороожуулах төхөөрөмж, 1.3 га талбай бүхий 255 хүлэмж, 17600 м2 нийлэг хальсан бүрхүүл, 660 га талбайг хамгаалах торон хашаа, хүнсний ногоо тарих, арчлах иж бүрдэл 300 гаруй багаж зэрэг техник тоног хэрэгслийг 2000 гаруй өрх, агропаркад хөрөнгө оруулалтаар болон хөнгөлөлттэй үнээр хуваарилан олгож үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ. Мөн жимсний 15000 ширхэг суулгац, 500 тонн төмсний үр, байцаа, манжин, лууван, сонгино, хүрэн манжин, өргөст хэмх, улаан лооль зэрэг 8 тонн үрийг үнэгүй буюу гэрээгээр олгож, тусламжаар ирсэн 20 гаруй тонн 100 гаруй төрлийн цэцгийн болон хүнсний ногооны үрийг үнэгүй олгосноор таримлын нэр төрөл нэмэгдэж, тариалах талбай, хураан авах ургацын хэмжээ жил бүр өсчээ. 2003 онд улсын хэмжээгээр 14.3 мянган га талбайгаас 138.2 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөр анх батлагдсан 1997 оноос 50.1 мянган тонноор буюу 56.6 хувиар нэмэгдэж, ногооны үйлдвэрлэл эрхэлж байгаа өрхийн тоо 1997 оноос 2.5 дахин өссөн байна.

Хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд 2003 оны байдлаар 154 агропарк орон нутагт байгуулагдан ажиллаж 2700 удаагийн сургалт явуулж, гарын авлага зөвлөмж 24086 ширхэгийг иргэдэд түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулж хэвшжээ. ЗГ-аас 2004 онд хөтөлбөрийн эхний шатыг 90 хувийн биелэлттэй зохих түвшинд сайн ажилласан гэж дүгнээд хөтөлбөрийн 2-р үе шатыг шинэчлэн баталсан байна

Хөтөлбөрийн 2-р үе шат: Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн эхний болон эцсийн шатны төлөвлөсөн түвшинтэй харьцуулж гаргасан бөгөөд энэ зорилтуудын нэгээс бусад нь төлөвлөсөн түвшинд хэрэгжиж байна. Хэдийгээр төсвөөс зарцуулсан хөрөнгө хангалттай сайн биш ч гэсэн байгаль цаг уурын таатай орчин бүрдсэнээс 11 үзүүлэлтээс 7 нь 2006 онд гарах түвшинд хангалттай сайн хэрэгжжээ. Түвшинг хангаагүй 4 үзүүлэлтийн хувьд төлөвлөлт бодитой бус, эхний шатанд хэрэгжилт удаан, одоогоор экспортод гаргах хэмжээний илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байгаа юм байна. ЗГ-аас 2005 онд тус хөтөлбөрийг үе шатандаа 40 хувийн биелэлттэй гэж дүгнээд сэргээсэн талбайн ашиглалтын болон хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийг сайжруулахыг зөвлөмж болгожээ.

9. ЦАГААН ХУВЬСГАЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-1999-105/

Хөтөлбөрийн зорилго: МАА-н үйлдвэрлэлийн дотоод нөөц бололцоог дайчлан ашиглаж, сүү, цагаан идээний үйлдвэрлэл эрхэлж ирсэн уламжлалыг сэргээх, боловсруулах жижиг үйлдвэрийг хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх замаар хүн амын сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах, малчид, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэн орон нутагт ажлын байр шинээр буй болгох

I үе шат 1999-2000

II үе шат 2001-2004

Хэрэгжилтийн гол үр дүн:

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сүү үйлдвэрлэлийн гүйцэтгэл 2004 онд 82.1 хувьд хүрсэн байна. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуй эрчимтэй хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг ХХААЯ-наас явуулж байгаагаас тоо нь нэмэгдэж төлөвлөсөн хэмжээнээс 47.3-иар илүү гарчээ. Сүүний ЖДҮ-ийн тоо өссөн нь ажлын байрыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулахад нөлөөлжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Японы ЗГ-ын санхүүжилттэй Сүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулах төсөл 2004 оноос хэрэгжиж эхэлсэн.

Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй нь мал сүрэг ган зудад нэрвэгдэж тэр тусмаа үхэр сүргийн тоо толгой их хорогдсон нь нөлөөлжээ. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тус хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэхээр тусгагдсан учраас 1998-2004 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, сургамжийг харгалзан илүү бодитой шинэ хөтөлбөр боловсруулахаар шийдвэрлэн ЗГ-ын 2006 оны 239-р тогтоолоор “Сүү” үндэсний хөтөлбөр баталсан.

10. СҮҮ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2007-239/

Хөтөлбөрийн зорилго: Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, нэр төрлийг нэмэгдүүлэх, түүний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн түвшинг дээшлүүлэх, дотоодын хэрэгцээгээ хангах, экспортлох нөхцөлийг бүрдүүлэх

I үе шат 2007-2012

II үе шат 2013-2016

Хэрэгжилтийн байдал:

Тус хөтөлбөр нь 1999-2004 онд хэрэгжүүлж дууссан цагаан хувьсгал хөтөлбөрийн

үргэлжлэл гэж хэлж болно. Учир нь цагаан хувьсгал хөтөлбөрийн хүрээнд 2004 онд НҮБ-ийн ХХААБ-ын Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрт Монгол Улсын сүүний салбарыг сэргээн хөгжүүлэх зорилгоор 1.9 сая ам.долларын санхүүжилт бүхий “Сүү үйлдвэрлэлийн явцад гарах алдагдлыг багасгах замаар сүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх” төслийг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхэлсэн боловч цагаан хувьсгал хөтөлбөр 2004 онд дууссан учраас тус төсөл нь сүү үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа юм байна.

11. ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР / ЗГ- 2003 - 160/

Хөтөлбөрийн зорилго: Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн МАА-г зохистой хослон ХАА-н үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах

I үе шат: 2003-2008 он.

II үе шат нь: 2009-2015 2002-2005

Хэрэгжилтийн гол үр дүн:

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах талаар Аймгууд өөрийн орон нутгийн онцлогт тохируулан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрүүдийг боловсруулан баталж хэрэгжүүлж байгаа бөгөөд “Фермерийн аж ахуйн” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. 2003 онд ХХАА-н сайдын А/85-р тушаалаар “ХАА-н жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан”-гаас эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 13 ААН, иргэнд 36.4 сая төгрөгийн, 2004 онд ХХАА-н сайдын №55,56 тоот тушаалаар эрчимжсэн аж ахуйн чиглэлээр ирүүлсэн 130-аад төслүүдээс сонгон шалгаруулж улсын төсвөөс 11 төсөлд 30.0 сая төгрөгийн, 2005 онд 180 гаруй төсөлд сонгон шалгаруулалт хийж ХХААС-ын А/71-р тушаалаар 51 төсөлд 120.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв.

Мөн онд саалийн үхрийн “Цөм сүргийн аж ахуй” сонгон шалгаруулах тендэр зарлан дүгнэж ОХУ-аас симменталь үүлдрийн 66, БНХАУ-аас Канадын хар тарлан үүлдрийн 30 үхэр оруулан ирсэн байна. Гэрээгээр 2008 оноос эхлэн жил тутам 10 гунж нийлүүлэх замаар төсвөөс олгосон 146.0 сая төгрөгийн зээлийг барагдуулах юм байна.

Эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, загвар нэгж бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар Эрчимжсэн МАА-н судалгааг бүх аймаг, орон нутагаас авсан дүнг харуулбал: 2006 онд улсын хэмжээгээр саалийн үхрийн 244 аж ахуйд 6128 үхэр үржүүлж байгаа нь өмнөх оныхоос 39.5 хувиар өссөн байна. 2004 онд Франц улсаас Хар тарлан, Бруно, Абондансе үүлдрийн 1860 тун үр, 2005 онд 11000 тун үр оруулан ирж нийт 1800-аад үнээнд зохиомол хээлтүүлэг хийн хээл авал 82.3 хувьтай байна. Одоо 1-р үеийн тугал 458 тугал бойжиж байна. Махны үхрийн 12 аж ахуйд 1438 үхэр үржүүлж байгаа нь 2005 оноос өсөөгүй байна. Махны үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Итали улсын махны чиглэлийн Пьемонте үүлдрийн бухны үр, хөврөл үр, симменталь үүлдрийн бухны үр, АНУ-ын Red Angus бухны үрийг ашиглаж байна. Мах-ноосны хонины 12 аж ахуйд 6500 үржүүлж байна.

Махны хэвшлийн хонь бий болгох зорилгоор Дархан-Уул аймагт үржүүлж байгаа АНУ-ын Суффолк, Дорсет үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг монгол хонинд суулган гарган авсан 1-р үеийн эрлийз нь Дорсетийн эрлийзээс илүү торниун манай орны

байгаль, цаг уурын нөхцөлд илүү дасан зохицох боломжтой болох нь тогтоогдож одоо нийт 1-р үеийн 181 эрлийз хоньтой болсон байна. 2006 онд 45 фермерийн аж ахуйд 5578 гахай үржүүлж байгаа нь өмнөх оноос 2.8 дахин өссөн, шувууны 61 аж ахуйд 90147 шувуу үржүүлж байгаа нь өмнөх оноос 2.1 дахин өссөн байна. Дархан-Уул аймагт өндөг дарагч Украин-15000 маркын 2 инкубаторыг ашиглан дэгдээхэй бойжуулан ард иргэдэд үйлчилдэг болжээ. 2005 онд зөгийн 25 аж ахуйд 1046 бүл зөгий үржүүлж байгаа нь хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2004 оноос аж ахуйн тоо 2 дахин өссөн байна.

Эрчижсэн МАА-г эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар Хөтөлбөр батлагдсанаас хойш Голланд улсын Барневельдын их сургуульд шувууны аж ахуйн чиглэлээр 2, гахай, шувууны чиглэлээр 2 хүн суралцаж байна. Малайз улсын шувууны аж ахуйн чиглэлээр 2 хүн мэргэжил дээшлүүлсэн.

Франц улсын МАА-н хөгжил болон малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах дуудлага худалдааны үйл ажиллагаатай танилцах, судлах ажлаар 5 хүнийг хамруулсан бөгөөд дотоодын эрчимжсэн МАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 дээд сургуульд 120 цагийн хичээл заагдаж байгаа юм байна. Саалийн үнээ, хонинд зохиомол хээлтүүлэгчийн техникч бэлтгэх сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 97 техникч бэлтгэгдсэн байна. ЗГ-аас 2005 онд тус хөтөлбөрийг 70 хувийн биелэлттэй гэж дүгнэжээ.

12. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР /ЗГ-1998-103/

Хөтөлбөрийн зорилго: Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт гурил, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангахаар заасан бодлогын хүрээнд тариалан эрхэлдэг ААН-ийн төрийн өмчид ногдох хэсгийг хувьчилж дуусгах, тариалангийн газрын харилцааг шинэчлэх, газар тариаланд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нөхцөлийг бий болгох үндсэн дээр үр, техник шинэчлэх, экологийн тэнцвэрийг хадгалж, хөрсний эвдрэлээс хамгаалах, хөрсөнд чийг, шим тэжээлийн бодис хуримтлуулах, нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр технологийн дэвшилтэт арга нэвтрүүлэх бодлого баримталж, түүнийг төрөөс бүхий л аргаар дэмжиж, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг энэ арга хэмжээнд ашиглах замаар хувийн хэвшлийн байр суурийг бэхжүүлэх, үйлдвэрлэгчид газар тариалангийн үйлдвэрлэлээ бие даан, үр ашигтай явуулах зах зээлийн эдийн засгийн чөлөөт өрсөлдөөн бүхий орчинг бүрдүүлэн, тус салбарыг зах зээлд бүрэн шилжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх

I үе шат 1998-2000

II үе шат 2001-2005

Хэрэгжилтийн гол үр дүн:

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд 96 хувийн биелэлтэй гэж дүгнэгдсэн боловч гол үйл ажиллагааны гарц нь туйлын хангалтгүй байна. Хүнсний ногоо, төмсний үйлдвэрлэл нь Ногоон хувьсгал хөтөлбөр, гадаадын зээл тусламжийн төслүүдийн үр дүнд 1997 оныхтой харьцуулахад 2005 онд 52.3-88.2%-иар нэмэгдэж 2007 оны хүрэхээр төлөвлөснөөс 17.4%-иар илүү гарсан байна. Харин үр тарианы үйлдвэрлэлийг 1997 оныхоос 3.2 дахин буурч 2005 онд хүрэхээр төлөвлөсөн түвшингийн дөнгөж 25.1%-ийг хангасан байна.

Үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх зорилгоор 2001-2002 онд уринш, үр дэд хөтөлбөрүүд боловсруулж 5 орчин тэрбум зарцуулсан боловч ямар ч үр дүн гараагүй байна. Тухайн үед үр тарианы үйлдвэрлэлийн талаар гаргаж байсан шийдвэрүүд нь үр тарианы үйлдвэрлэлд нөлөөлөх хүчин зүйлийг иж бүрэн авч үзээгүй, ХХААЯ-ны холбогдох албад хөтөлбөрийн тайланг гаргаж байгаагүй зэргээс хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдсэн байна. Хөтөлбөр хэрэгжиж дууссан.

13. ЭКСПОРТЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР /ЗГ-1998-158/

Хөтөлбөрийн зорилго: Хөтөлбөрийн зорилго нь экспортын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, улмаар дотоодын мөнгөн хуримтлалыг бий болгон, валютын нөөцийг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн чадавхийг сайжруулж, цаашдын тогтвортой хөгжлийг хангахад оршино.

1998-2010

Хэрэгжилтийн байдал:

Монгол улс 2005 онд дэлхийн 70 оронд бараа, түүхий эд экспортолжээ. 2000 оны зэрэгцүүлэх үнээр тооцоход өмнөх оны мөн үеэс 2005 онд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 11.3 хувиар өсч, эрдэс бүтээгдэхүүний экспорт үнийн дүнгээр 2005 онд 449949.1 мянган ам. долларт хүрсэн. 2001-2005 онд нийт экспорт үнийн дүнгээр 21.1 хувь өсчээ.

Экспортын чиглэлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмыг импортын гаалийн болон НӨАТ-аас чөлөөлж байгаагийн зэрэгцээ гадаадын захиалагчийн материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргадаг үйлдвэрүүдийн захиалагчийн материалыг гааль, НӨАТ-аас чөлөөлж байна.

Төмөртийн овооны цайр, Олон овоотын алтны үндсэн ордыг ашиглах, Тавтын алтны, Тосонгийн алтны шороон ордын 2-р драг, “Шим технологи” компанийн Молибдены баяжмал боловсруулах, Эрдмин компанийн дэргэдэх зэс утас цувих зэрэг үйлдвэрүүд 2005 онд ашиглалтанд орж, экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Тамсагт явуулж буй хайгуулын ажлын хөрөнгө оруулалт нэмэгдэж 2005 онд шинээр 5 цооног өрөмдөөд байна.

2005 онд Нарийн сухайтын ордоос 2 сая тонн нүүрс, Таван толгойн ордоос 500 мян. тонн нүүрс, Хустайн ордоос 100 мян тонн төмрийн хүдэр экспортолдохоор ажиллаж байна. Төмөртийн овооны орд дээр байгуулах үйлдвэрээс цайрын баяжмал туршилтаар экспортолно. “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн тухайд Засгийн газар, Улсын Их Хурлын тогтоол гаргасан байна. Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүдийг сурталчлах, ДХБ-ын тариф-үйлчилгээний электрон мэдээллийг ашиглах сургалтыг зохион явууллаа.

2004-2005 онуудад Чикаго, Берлин, Сөүл, Токуо, Утерихт, Лондон зэрэг хотод зохион байгуулсан аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцон Монголын нээлттэй өдөрлөгүүдийг Токуо, Сөүл хотод зохион байгуулсан. “International Travel Mart” үзэсгэлэнг гадаад, дотоодын аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын үйлчилгээний компаниудыг оролцуулж 6 дахь жилдээ “Мишээл Экспо” төвд зохион явуулав. Аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах Засгийн газар хоорондын гэрээг Франц, Хятад улстай байгуулсан.

Монгол Улс 2005 он Европын Холбооны (ЕХ) худалдааны тусгай хөнгөлөлтөд урьдчилан хамрагдсан. Уг хөнгөлөлтөд 2006-2008 онд хамрагдах хүсэлтээ албан ёсоор гаргаж, зохих шалгууруудыг хангасны дагуу 2006 оны 1 дүгээр сарын 1-нээс монголын экспортын бараа, бүтээгдэхүүний ихэнх нь гаалийн татваргүйгээр ЕХ-ны зах зээлд гарч байна. 2005 оны байдлаар нийт экспортын бүтцийг (БТКУС-ийн барааны хэсгээр) авч үзвэл, нийт экспортын дүнд эрдэс бүтээгдэхүүн 42.3, үнэт металл, үнэт ба хагас үнэт чулуу, гоёлын зүйлс, зоос 31.2, нэхмэл ба нэхмэл бүтээгдэхүүн 17.6, арьс ширэн түүхий эд болон боловсруулсан

арьс, шир, ангийн үсээр хийсэн эдлэл 2.8, бусад бүтээгдэхүүн 6.1 хувийг тус тус эзэлж байна.

Зэсийн баяжмалын экспорт нийт экспортын 2005 онд 30.8 хувийг эзлэх болж 584.7 мян. тонныг экспортлосон нь өмнөх оны мөн үеийнхээс экспорт биет хэмжээгээр 3.9 хувиар, үнийн дүнгээр 14.2 хувиар буюу 40348,3 мян. ам. доллараар өсчээ. Өөрөөр хэлбэл, 40348,3 мянган ам. долларын 72 гаруй хувийг үнийн, 28 орчим хувийг тооны өсөлтийн хүчин зүйлсээр хангав. 2005 онд нийт 331410.6 мянган ам. долларын 23.8 тонн “Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт”-ыг экспортод гаргасан нь өмнөх оныхоос биет үзүүлэлтээр 23.4 хувь, үнийн дүнгээр 36.8 хувь өссөн нь манай нийт экспортын үнийн дүнгийн 31.45 хувь болж байна.

Сүлжмэл хувцас болон хувцсанд хэрэглэх сүлжмэл зүйлсийн экспортын жил бүрийн бууралт, өсөлтийн хандлагыг авч үзвэл 2003-2004 онд 43.0 хувиар өсч байсан бол 2005 онд 36.6 хувиар буурсан. Оёмол хувцас ба хувцасны оёмол тоног хэрэглэл 2005 онд өмнөх оныхоос 18 хувиар буурч, дэлхийн тухайн зах зээлд хээрийн жонш, хайлуур жоншны манай экспорт 2.3 хувийг эзэлж байна.

2005 оны байдлаар нийт импортын дүнд Монгол улсад ОХУ-аас импортлосон бараа 34.8 хувийг, БНХАУ-аас импортлосон бараа 26.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт экспортын дүнд Монгол улсаас ОХУ-д экспортлосон бараа дөнгөж 2.5 (1.1) хувийг, БНХАУ-д экспортлосон бараа 48.0 (58.95) хувийг тус тус эзэлж байна. Экспортын бодлого, зах зээлийн судалгаа, хөгжлийн хурд зэргийг харгалзан, ойрын хугацаанд нөхөгдөх нөөцтэй цэвэр экологийн ноос, мод, арьс ширээр хийсэн хүүхдийн тоглоом, бэлэг дурсгалын зүйлс, жижиглэн савласан цэвэр ус, сүүн бүтээгдэхүүн, махан бүтээгдэхүүн, мэдээлэл-программ хангамж, угсрагдах модуль цех-ажлын байр, модуль эд анги гэх мэт экспортын үйлдвэрийг ба импорт орлохуйц үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр, төслүүд батлуулж хэрэгжүүлэх.

Цаашид шинжлэх ухаан-технолги-үйлдвэрийн парк, экспортын үйлдвэрийг орон нутагт байршуулж байгуулах төсөл, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулж хэрэгжүүлэх хамтын ажиллагаа хангаж ажиллах.

14. ОЙ, МОД БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ СЭРГЭЭХ, ТУХАЙН ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАГДСАН ТОСГОНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2000-30/

Хөтөлбөрийн зорилго: Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тэргүүн ээлжинд мод бэлтгэх, боловсруулах аж ахуйн нэгжийг түшиглэн байгуулагдсан Бугант, Хялганат, Тосонцэнгэл, Түнхэл, Дулаанхаан, Батширээт, Эрээн зэрэг тосгон хамаарна.

I үе шат- 2000-2005

II үе шат- 2006-2010

Хэрэгжилтийн байдал:

Байгаль орчин, Үйлдвэр, худалдааны ба Мэргэжлийн хяналт эрхэлсэн сайдуудын баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Дорнод, Хэнтий аймгийн нийт 40 сум дахь 199 ой модны аж ахуйн нэгжүүдийг аттестатчилахад мод бэлтгэлийн 31, зөвхөн арчилгаа-цэвэрлэгээний огтлол хийдэг 37, мод боловсруулах 20, үүнээс савхны 7 үйлдвэр тэнцсэн байна. Үйлдвэр, худалдааны яам, Мэргэжлийн улсын хяналтын газар хамтран “Ойн нөөц ашиглалтанд тавих хяналтыг

сайжруулах, ойн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих нь” ярилцлагыг зохион байгуулж нийт 100 орчим төлөөлөгчдийг оролцуулж, зөвлөмж гаргав. Мод боловсруулалтын загвар үйлдвэр байгуулах төслийг UNIDO-д болон Австри улсын талд хамтран хэрэгжүүлэхээр санал тавиад байна.

Иргэдээс хулгайн мод авч үйлдвэрлэл явуулдаг дүгнэлт гаргуулаагүй гадаадын хөрөнгө оруулалттай зарим нэг үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоож, мөн технологи, хөдөлмөр хамгааллын зөрчлүүдийг илрүүлж, арилгуулах арга хэмжээ авчээ. 76 аж ахуйн нэгжүүдэд 39.9 мянган шоометр модны зөвшөөрөл олгов.

2000-2005 онд өссөн дүнгээр Бугант, Түнхэл, Дулаанхаан, Хялганат, Тосонцэнгэл, Батширээт, Эрээн зэрэг 7 тосгонд нийт 8483 хүн ажлын байртай болж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 2005 онд 484 хүн хамрагдсан. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд мод, модон эдлэлийн үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 онд 0.1 пунктээр нэмэгдэж 0.5 хувийг, мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн 0.1 хувийг тус тус эзэлсээр байна.

Ойгоос мод огтлох зөвшөөрлийг зөвхөн мэргэжсэн ойн аж ахуйн нэгжид олгож байх. Ойн нөөцийг хулгайд алдахгүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, мод бэлтгэх техник-технологийн чадваргүй аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөл олгохгүй байх. Ойн аж ахуйн нэгжүүдэд мод бэлтгэх технологийн картыг нэвтрүүлэх. Ой мод боловсруулах үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ хөтөлбөрт улсын төсвөөс 120 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 420 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн байна.

Хөтөлбөрт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг нь ой ашиглах, хамгаалах тогтвортой менежмент байхгүй явдал гээд, энэ нь ойгоос мод бэлтгэх, ойг нөхөн сэргээх, мод боловсруулах үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн байна. Үүнээс гадна Засгийн газрын 1998 оны 125 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай журам”-ын дагуу ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа газарт АМГТХЭГ-ын Кадастрын албанаас ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз давхардуулан олгож аж ахуйн нэгжүүдийн хооронд маргаан үүсгэж, хууль журам зөрчигдөж байна гэсэн байна.

15. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ /УИХ-2007-52/

1/жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлаг байгуулах;

2/Үйлдвэр, худалдааны яам болон холбогдох бусад төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр ажиллаж байгаа хэлтэс, алба, сан, төслийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэх;

3/жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сангуудыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

* * *

16. ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК БАЙГУУЛЖ, ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ /УИХ-2003-54/

9. Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, хөгжүүлэх үе шат

Үйлдвэрлэл, технологийн паркийг дараах үе шаттайгаар байгуулан хөгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2004-2008 он.

1/ Дархан, Эрдэнэт, Чойр, Сүхбаатар, Ховд хотод үйлдвэрлэл, технологийн парк, Налайх дүүрэгт “Тенант” парк байгуулах ажлыг эхлүүлнэ.

2/ Зуунмод, Чойбалсан, Улиастай хот, Багахангай дүүрэгт парк байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангаж, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, гадаад орнуудад сурталчлах, хөрөнгө оруулагчдад танилцуулах, хөрөнгийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хүрээнд шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат: 2008-2012 он.

1/ Дархан, Эрдэнэт, Чойр, Сүхбаатар, Ховд хот, Налайх дүүргийн парк дахь үйлдвэрлэлийн цогцолборыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулна.

2/ Зуунмод, Чойбалсан, Улиастай хот, Багахангай дүүрэг үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж эхэлнэ.

10. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлэх эдийн засаг, нийгмийн үр дүн

10.1. Монгол улсын ирээдүйн хөгжил, дэвшлийг хангах экспортын чиглэлтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн бүтэц бий болно.

10.2. Экспортын хэмжээ нэмэгдэж, эдийн засаг өөрийгөө тэтгэн хөгжих боломж бүрдэж, Монгол улс даяаршиж байгаа дэлхийн зах зээлд тодорхой нэрийн бүтээгдэхүүнээр өөрийн байр суурийг эзэлнэ.

10.3. Үйлдвэрлэлийн хөгжлийг даган дэд бүтэц, үйлчилгээний тогтолцоо эрс сайжирч, ажил эрхлэлт нэмэгдэн, хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.

10.4. Орчин үеийн технологи, менежмент нэвтэрч, үндэсний боловсон хүчний чадавхи дээшилнэ.

10.5. Үндэсний шинжлэх ухаан, техник, технологийн түвшин дээшилж, эрдэм, шинжилгээ, судалгааны ажил арилжааны тогтолцоонд шилжиж, боловсрол, шинжлэх ухааны үйлчилгээ, үйлдвэрлэл, практикт чиглэгдэх тогтолцоо бий болно.

17. “БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ, УЯЛДУУЛСАН СИСТЕМ”-ИЙН ДАГУУ ГАРГАСАН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТ БҮХИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЗАРИМ СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Гааль болон НӨАТ-с чөлөөлөгдсөн ЖДҮ-ийн зориулалт бүхий тоног төхөөрөмжүүдийн жагсаалт:

Нэг. Хөнгөн үйлдвэрийн салбар:

Оёдол, сүлжмэлийн ҮЙЛДВЭР-15

Ноос, ноолуурын үйлдвэр-14

Арьс ширний үйлдвэр-22

Мод боловсруулах үйлдвэр-10

Хэвлэлийн үйлдвэр-11

Цаасны үйлдвэр-2

Сав, баглаа боодлын үйлдвэр-12

Нано, биотехнологийн шинжлэх ухааны үйлдвэрлэл-34

Хими цэвэрлэгээ-7

Алт, мөнгөн эдлэл бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэл-8

Хоёр. Хүнсний үйлдвэрлэл:

Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр-26

Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр-22

Ундааны үйлдвэр-21

Давсны үйлдвэр-16

Махны үйлдвэр-110

Консервын лаазны үйлдвэр-18

Кетчуп, майонез, ургамлын тосны үйлдвэр-32

Төрөл бүрийн хүнсний ногоо нөөшлөх үйлдвэр-21

Талх, нарийн боовны үйлдвэр-51

Загасны үйлдвэр-8

Шувууны аж ахуй-5

Гурав. Барилгын үйлдвэрлэл:

Барилгын материалын үйлдвэр-46

Цементийн үйлдвэр-25

Төмөрлөг, металл боловсруулах үйлдвэр-12

Эмийн үйлдвэр-66

Тав. Бусад:

Биохийн үйлдвэр-26

Хагас коксын үйлдвэр-16

18. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР АРИЛЖААНЫ БАНКААР ДАМЖУУЛАН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ТӨСЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ /ХХААХҮ-ИЙН САЙДЫН 2010-35/

Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих арга хэмжээг зохион байгуулах, арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комисс /цаашид “дэд комисс” гэх/ -ын үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулна.

1.2. Хөнгөлөлттэй зээлийг Засгийн газрын тусгай сан болох Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид “Сан” гэх/ -гийн хөрөнгөөс олгох ба энэхүү зээл нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг өргөтгөх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.5. Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссын Даргаар аймгийн Засаг дарга, Дэд даргаар ХХААЖДҮГазрын дарга, Нарийн бичгээр ХХААЖДҮГазрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн байх ба гишүүдээр Оролцогч банкны төлөөлөл, Төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

1.9. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох банкыг Жижиг дунд үйлдвэрийн газар, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн саналыг үндэслэн ХХААХҮ-ийн сайд сонгон, гэрээ байгуулна.

1.10. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд банкаар дамжуулан зээл олгуулахаар Сангаас сонгосон банкны салбарт тусгай данс нээж, гэрээнд оролцогч талууд гэрээнд тохиролцсон хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлж ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН САН /цаашид “сан” гэх/ бүрдүүлнэ.

1.11. Дээрх сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

1.11.1 Улсын төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд тусгагдсан хөрөнгө

1.11.2. Аймаг, нийслэлийн орон нутгийн төсвөөс гаргах хөрөнгө

1.11.3. Арилжааны банкнаас гаргах хөрөнгө

1.11.4. Санд зээлийн эргэн төлөлтөөс бүрдсэн хөрөнгө

19. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР /2006-283-2 ДУГААР ХАВСРАЛТ/

Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

3.1.7 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн ангиллаар өсөлт, хөгжлийн онцлог, эрүүл ахуйн стандартад нийцсэн ширээ, сандал, ор, сурах бичиг, тавилгын хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр **үндэсний үйлдвэрлэлийг дэмжих** бодлого явуулах;

* * *

7. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Аймгуудын Хөгжлийн цогц бодлогын баримт бичгүүд /2009 - 2020 хүртэл/
- Strategic Directions on Industrial Policy in Mongolia, United Nations Industrial Development Organization 2011, Vienna, Austria.
- “Өнөөдөр” сонины 2010 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн №149(4012) дугаарт нийтлэгдсэн Ж.Тэгшжаргалын “Бид хэнийг, биднийг хэн тэжээдэг вэ?”
- Хүнсний үйлдвэрүүдийн судалгаа, 2009 оны дүнгээр, ХХААХҮЯам
- Жижиг дунд үйлдвэрийн газрын мэдээлэл, брошюр, 2010
- “2010 онд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан” 2010 оны 3 дугаар улирлын байдлаар, Монгол Улсын Засгийн газар
- Монгол банкны төрөлжсөн статистик мэдээллүүд, 2010
- Статистикийн бюллетень, 2010 оны 12 дугаар сар, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээлэл, 2010
- <http://www.exporthelp.co.za>
- <http://www.austrade.gov.au>
- Монгол улсын Экспортын Баримжаатай Үйлдвэр, Худалдааны Бодлого төслийн захиалгаар хийсэн судалгааны ажлын тайлан, 2004, Нээлттэй нийгэм хүрээлэн
- “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын тогтоол №178, 2009
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны статистик мэдээлэл, 2010-2011



**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ БА АРХИ СОГТУУРУУЛАХ
УНДААНЫ ХУДАЛДАА, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ АСУУДЛААРХИ
СУДАЛГАА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батбаяр, Ц. Батдорж, Г. Билгээ,
Г. Гэрэл, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*

СЭДВИЙН АГУУЛГА

Оршил

Судалгааны дүгнэлт

Нэг. Тэмдэгтийн хураамжийн хууль зүйн агуулга, үндэслэл, тодорхойлолт

Хоёр. Монгол Улсын төсөвт тэмдэгтийн хураамжаас төвлөрүүлсэн орлогын судалгаа

Гурав. Бусад орнуудын Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, тогтоомжийн талаархи харьцуулсан судалгаа

3.1 БНХАУ

3.2 Сингапур улс

3.3 Ирланд улс

Дөрөв. Архидан согтуурахтай тэмцэх талаарх зарим орны туршлага, хэрэгжүүлж буй бодлого

4.1 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Европ дахь салбар

4.2 Ирланд улс

4.3 ДЭМБ-ын Номхон далайн бүс нутгийн салбар

4.4 Шинэ Зеланд

4.5 БНХАУ

Тав. Хатуулаг өндөртэй архины татварыг нэмэх байдлаар өндөр үнэтэй болгох, хатуулаг багатай архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлийг дэмжих талаар авсан бодлогын арга хэмжээ

5.1. Архины татварын өнөөгийн байдал

1.2 Архины татварын талаарх Олон Улсын туршлага

- Франц Улс

- Их Британи

- ХБНГУ

- ОХУ

Зургаа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга болон төрийн байгууллагуудаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалт

Ашигласан материалын жагсаалт

Хавсралт

* * *

ОРШИЛ

Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Д.Ганхуяг нарын захиалгаар 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд холбогдуулан

- “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн хууль зүйн агуулга, тодорхойлолт, бусад орны туршлага, олгож буй тусгай зөвшөөрлийн төрлүүд,
- “Олон Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй архи согтууруулах ундааны худалдааны хэлбэр, архидалттай тэмцэж буй туршлага” сэдвийн хүрээнд судалгааг УИХ-ын ТГ-ын Судалгааны төвийн Макро эдийн засгийн салбарын судлаачид гүйцэтгэлээ.

Судалгааны бүтэц

1-р бүлэгт “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн хууль зүйн агуулга, тодорхойлолт болон зарим орны тэмдэгтийн хураамжийн эрх зүйн зохицуулалт, тэмдэгтийн хураамжийн төрөл, хувь хэмжээний талаархи мэдээллийг харьцуулан судаллаа.

2-р бүлэгт Улсын тэмдэгтийн хураамжаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын талаархи мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар гаргахыг зорьж холбогдох яам, газарт албан бичгийг хүргүүлсэн.

Гэвч Сангийн яам болон Татварын Ерөнхий газраас 1993 онд батлагдсан хуулийн хүрээнд тэмдэгтийн хураамжийн орлогыг үйлчилгээний төрөл тус бүрээр гаргадаггүй байсан ба 2010 онд батлагдсан хуулийн дагуу 2011 оны 3 дугаар улирлаас эхлэн тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний төрөл тус бүрээр гаргах боломжтой болно гэсэн хариу ирүүлсэн. /Тоотыг хавсаргав/

Иймд Улсын төсвийн гүйцэтгэлд тулгуурлан 2002 - 2010 онд тэмдэгтийн хураамжаас Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын динамик судалгаа, өсөлт бууралт, хуулиар тогтоосон тэмдэгтийн хураамжийн төрлүүд, тэмдэгтийн хураамж төлөгч ба тэмдэгтийн хураамж ногдуулах үйлчилгээний төрлүүд зэргийг харьцуулан судалсан болно.

3-р бүлэгт “Тэмдэгтийн хураамж”-ийн талаархи бусад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлав. Судалгаанд БНХАУ, Сингапур улс, Ирланд улсыг тус тус хамруулав.

4-р бүлэгт Улсын хэмжээнд архи согтууруулах ундааны худалдаа, архидалттай хэрхэн тэмцэж байгаа туршлага, хатуулаг өндөртэй архины татварын ногдуулалт, бусад орнуудын туршлагыг харьцуулан судлав. Мөн төгсгөлд нь, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн хүрээнд төрийн захиргааны байгууллага болон аймаг нийслэлийн Засаг даргаас олгож буй тусгай зөвшөөрөл, зөвшөөрлүүдийн жагсаалтийг лавлагаа мэдээлэл хэлбэрээр төрөлжүүлэн хавсаргав.

Эх сурвалж

Судалгаанд 1993 болон 2010 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолууд, холбогдох яам, агентлагийн дүрэм, журам тогтоол, татвар, санхүүгийн эрх зүйтэй холбогдох онол арга зүйн ном, сурах бичиг зэргийг үндсэн эх сурвалж болгон ашиглав. Бусад орнуудын тэмдэгтийн хураамж, архи дан согтуурахтай тэмцэх талаархи материалыг холбогдох албан ёсны цахим хуудаснаас авч ашигласан болно.

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

УИХ-аас 2010 оны 11 сарын 25-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хууль 2011 оны 1 сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлснээр нийгмийн зүгээс шүүмжлэлд өртөн, бизнес эрхлэгчдээс санал гомдол ихээр гарах болсон.

Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын 2011 оны төсвийн төсөлтэй хамт УИХ-д өргөн барьсан ба “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуульд заасны дагуу хуулийн танилцуулга, үзэл баримтлалыг УИХ-д тухайн үед хүргүүлээгүй байна.

УИХ-д албан ёсоор өргөн барьсан хуулийн бүрдэлийг архивийн материалаас авч үзэхэд, уг хуулийн төслийг шинэчлэн боловсруулахдаа эдийн засгийн тооцоо судалгаа хийгээгүй, гарах үр дагаврыг урьдчилан судлаагүй, бусад хууль, тогтоомжид орох нэмэлт, өөрчлөлтүүдийг холбогдох хуульд тусгаагүй зэрэг зөрчлүүд байна.

УИХ-ын нэр бүхий гишүүд захиалга ирүүлэхдээ судлах асуудлуудыг тодорхой зааж өгсөн тул дараахь 2 багц асуудлын хүрээнд судалгааны үр дүнг нэгтгэн гаргахыг зорилоо. Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн талаар:

- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн актууд болон бусад орнуудын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсоноор Тэмдэгтийн хураамж гэдэг бол нэг төрлийн татвар гэж үзэж болохоор байна.
- БНХАУ, Сингапур, Ирланд улсуудад Тэмдэгтийн хураамжийг тодорхой хэдэн төрлийн үйлчилгээнд төлдөг бөгөөд тэмдэгтийн хураамжийг мөнгөн дүнгээр бус үнийн дүнгээс хувь тооцон авдаг байна. Дээрхи улсуудад тэмдэгтийн хураамжийн төрөл, тоо хэмжээ харьцангуй цөөн байна.
- Тэмдэгтийн хураамжийн төрлөөр авч үзвэл, 1993 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар төрийн заиргааны байгууллага, Зааг даргаа нийт 18 төрлийн 84 үйлчилгээнээс хураамж авдаг байсан бол 2010 онд батлагдсан хуулиар 42 төрлийн 564 үйлчилгээнээс төлбөр хураамж авахаар хуульчилсан байна.
- Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоогоор авч үзвэл, 1993 онд батлагдсан хуулиар 5 /“Аж ауйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуульд 91 төрлийн тусгай зөвшөөрөл олгохоор заасан болно./ төрлийн тусгай зөвшөөрөлд тэмдэгтийн хураамж ногдуулж байсан бол 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулиар 151 төрлийн тусгай зөвшөөрөл, 122 төрлийн зөвшөөрөлд тэмдэгтийн хураамж ногдуулахаар хуульчилсан байна. Эдгээрээс 143 төрлийн тусгай зөвшөөрөл, 103 төрлийн зөвшөөрөл нь төрийн захиргааны байгууллагаас, 8 төрлийн тусгай зөвшөөрөл, 19 төрлийн зөвшөөрлийг аймаг, Нийслэлийн Засаг даргаас олгож байна.
- Судалгаанаас үзэхэд, төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй тусгай зөвшөөрөл болон зөвшөөрлийн агуулга, нэр томъёо зөрчилтэй байна. Тухайлбал: Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн 15.7-д боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ гэж заасан бол “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 22.1-т зөвхөн зөвшөөрөл авна гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, “Тусгай зөвшөөрөл”, “Зөвшөөрөл”-ийн алин болох нь ойлгомжгүй байна. Иймд “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Тэмдэгтийн хураамжийн тухай хууль” болон холбогдох салбарын хуулинд тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгох, бүртгэл хураамж, эрх олгох үйл ажиллагааны төрлүүдийг нэг мөр нийцүүлэн тусгах шаардлагатай байна.

- Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоохдоо тухайн хураамж авч байгаа салбарын ач холбогдол болон үйлчилгээний цар хүрээ, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, төрөөс баримталж буй бодлого зэргийг харгалзан тодорхой аргачлалаар тооцох шаардлагатай байна. Тооцоо судалгаагүйгээр тэмдэгтийн хураамжийн хэмжээг хэт их хэлбэлзүүлэх нь зохимжгүй юм.
- 2011 оны 5 сарын 13-ны байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 502 аж ахуйн нэгж зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байна. 2011 оны 5 дугаар сард хугацаа нь дуусах 1968 аж ахуйн нэгж хүлээлтийн байдалд орсон байна./Тоотыг хавсаргав/

2. Архи согтууруулах ундааг худалдаалах, архидалттай тэмцэх талаар:

- Архи, согтууруулах ундааг буруу хэрэглэснээс үүсэх хор уршиг нь эрүүл мэндийн салбарт томоохон асуудал болж байгаагийн зэрэгцээ нийгэм эдийн засагт томоохон асуудал болж, энэ нь дан ганц орон нутаг, үндэсний хэмжээний асуудал бус дэлхийн нийтийг хамарсан асуудал болж байна. 2010 оны 5-р сард ДЭМБ-ын 63 дахь Ассамблейгаас “Архи, согтууруулах ундааны хор уршгийг багасгах тухай” тогтоолыг батлан гаргасан энэхүү зорилгод чиглэсэн болно.
- Архи, согтууруулах ундааны татварыг нэмэх, энэ төрлийн барааг худалдаалах журмыг нарийвчлан хатуу тогтоох нь архины хэрэглээг багасгах нэг чухал арга бөгөөд энэ нь архи, согтууруулах ундааны эсрэг авч хэрэгжүүлж буй бодлогуудаас олон улсын хэмжээнд хамгийн үр дүнтэйд тооцогдож байна.
- Бусад орнуудын туршлагаас үзэхэд, тусгай зөвшөөрөл олгох журамд архины худалдаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ согтууруулах ундааг борлуулах цагийг богиносгох, хэрэглээ, хангамжийг багасгах арга хэмжээ авч байна. Архи согтууруулах ундааны худалдааг хязгаарлах, дэг журам тогтоох чухал арга бол тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн шаардлагыг өндөржүүлэх явдал юм. Бусад орнуудад архи, согтууруулах ундааг зарах цэгийг цөөрүүлэх, тусгай зөвшөөрлийг 1 жилээр олгох, жил тутам тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох зэргээр хяналт тавьдаг байна. Тодорхой тооны цөөхөн газарт архи, согтууруулах ундааг борлуулах, насанд хүрээгүй хүмүүст худалдахыг хориглох, худалдах цагийн хязгаар тогтоох зэрэг арга хэмжээнүүд авч байна. Энэ нь гэмт хэрэг, замбараагүй байдлыг багасгах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалан сайжруулах, эцэст нь архи, согтууруулах ундааны улмаас үүсэх хор уршгаас хүүхдийг хамгаалах зэрэг олон зэрэг үр дагавартай юм.
- Мөн архины зар сурталчилгаанаас хамаарч өсвөр насныхан уруу татагдах боломж нэмэгддэг нь судалгаагаар батлагдсан тул архи согтууруулах ундааны зар сурталчилгааг хуулиар хязгаарлаж байна.
- Бусад орнуудын туршлагаас үзэхэд хатуулаг өндөртэй архи худалдан борлуулахыг хязгаарлах, архины хатуулгаас хамааруулан татварын хэмжээг өсгөх зэрэг арга хэмжээнүүд авч байна. /Эрхэм гишүүд та бүхэн судалгааны тайлангаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу. /

Нэг. Тэмдэгтийн хураамжийн хууль зүйн агуулга, үндэслэл, тодорхойлолт

“Татварын Ерөнхий хууль”-ийн 5дугаар зүйлийн 5.1-т зааснаар “Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ.” Мөн хуулийн 5.3-т “Албан татвар шууд болон шууд бус татвараас бүрдэнэ.” гэсэн байна.

Хууль тогтоомжийн дагуу төрийн ба орон нутгийн байгууллагуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд үзүүлж байгаа үйлчилгээний дийлэнх хэсэг нь төлбөргүйгээр хийгддэг. Төр захиргааны байгууллагын зардлын зарим хэсгийг нөхөх зорилгоор төрийн болон орон нутгийн байгууллагууд хуулиар тогтоосон хэмжээнд багтаан үйлчилгээний төлбөрийг хураан авч төвлөрсөн болон орон нутгийн төсөвт оруулдаг.¹⁸

Монгол Улсын татварт дараахь татвар, хураамж, төлбөр хамаарна. Үүнд:

Хүснэгт 1.1

Албан татвар	<ul style="list-style-type: none"> аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; гаалийн албан татвар; нэмэгдсэн өртгийн албан татвар; онцгой албан татвар; авто бензин, дизелийн түлшний албан татвар;
Төлбөр	<ul style="list-style-type: none"> ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр; ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр. агаарын бохирдлын төлбөр.
Тэмдэгтийн хураамж	<ul style="list-style-type: none"> цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж; цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж; цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж; цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, идэвхийг сулруулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж.

Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараахь татвар орон нутгийн татварт хамаардаг байна. Үүнд:

Хүснэгт 1.2

¹⁸ Санхүүгийн эрх зүй С.Төмөр УБ 2002 он

Албан татвар	<ul style="list-style-type: none"> - хувь хүний орлогын албан татвар; - үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар; - орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар; - автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар - бууны албан татвар; - нийслэл хотын албан татвар; - нохойны албан татвар; - өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар.
Төлбөр	<ul style="list-style-type: none"> - ус, рашааны нөөц ашигласны төлбөр; - байгалийн ургамал ашигласны төлбөр; - түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр; - газрын төлбөр; - ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;
Тэмдэгтийн хураамж	<ul style="list-style-type: none"> - энэ хуулийн 7.3.9-7.3.12-т зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж; - ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж; - агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

- ✓ Татварын ерөнхий хуулийн 5.2-т Хууль тогтоомжийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг **албан татвар** гэнэ.
- ✓ Татварын ерөнхий хуулийн 5.6-т Төрийн зохих байгууллагаас хувь хүн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг **хураамж** гэнэ.
- ✓ Татварын ерөнхий хуулийн 5.7.Төрийн өмчийн газар, түүнчлэн газрын хэвлий, эрдэс баялаг, ой, ургамал, рашаан, усны нөөц ашиглуулсны, агаар, ус, хөрс бохирдуулсны, ан амьтан агнуулсны төлөө хувь хүн, хуулийн этгээдээс авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг **төлбөр** гэнэ.

Төлбөр, хураамж нь эрх зүйн агуулгын хувьд татварын нэг хэлбэр мэт боловч албан татвар нь **хураамж**, төлбөрөөс зарчмын хэд хэдэн ялгаатай.

Нэгд, Иргэн, хуулийн этгээдийн орлогын тодорхой хэсгийн төрийн /нийгмийн/ хэрэгцээнд албан журмаар дайчлах утга санааг албан татвар илэрхийлдэг бол **хураамж**, төлбөр нь үйлчилгээний үнэ, хөлсний шинжтэй байна.

Хоёрт, албан татвар нь өсөн нэмэгдэх, шууд хамааралтай, буурах шинжтэй бөгөөд энэ нь албан татварын хувь, хэмжээгээр тодорхойлогддог бол **хураамж**, төлбөрт ийм шинж байдаггүй.

Гуравт, албан татвар бол эдийн засгийн зохицуулалтын үндсэн хэрэгсэл юм. Нийт эдийн засагт учирсан хүндрэл бэрхшээл, онцлог нөхцөл байдлаас шалтгаалан албан татварын концепцийг боловсруулж, түүнд тулгуурлан албан татварын тогтолцоог бүрдүүлдэг. Харин

хураамж, төлбөр, нийт эдийн засгийн зохицуулалтын үндсэн хэрэгсэл болдоггүй.¹⁹

Улсын тэмдэгтийн хураамжийг ногдуулах, төсөвт төлөх, хураахтай холбогдсон харилцааг 1993 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулж байсан ба 2010 онд УИХ-аас уг хуулийг шинэчлэн найруулан батлаж 2011 оны 1 дгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

* * *

Улсын тэмдэгтийн хураамжийн талаархи тайлбар, тодорхойлолтууд:

- Нэр томъёоны хувьд

2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 3.1 -т “Улсын тэмдэгтийн хураамж” гэдэг нь “...төрийн эрх бүхий байгууллагаас хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ ...”

“Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн 57 дугаар зүйлд Улсын тэмдэгтийн хураамжтай холбогдох харилцааг зохицуулсан бөгөөд уг хуулийн 57.1-т “...Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг **улсын тэмдэгтийн хураамж** гэнэ..”

Академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд “...төрийн зохих байгууллагаас эрх олгох, эрх шилжихтэй холбогдсон баримт бичиг олгох буюу бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлах, гэрчлэх, иргэний бүртгэл хийх, шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ “ гэж тус тус тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд, Улсын тэмдэгтийн хураамж гэдэг нь төрийн эрх бүхий байгууллагаас тодорхой үйлчилгээ үзүүлсэний төлөөх төлбөр гэж ойлгогдож байгаа атал ИХШХШТ хуульд зөвхөн шүүхээс тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээний хураамж гэж ойлгохоор тайлбарлаж үүнийгээ “Улсын тэмдэгтийн хураамж” хэмээн нэрлэсэн байна. Иймд дээрхи хуулиудын нэр томъёоны тодорхойлолтыг нэг мөр болгох шаардлагатай.

Бусад орнуудад “Тэмдэгтийн хураамж “–ийг дараахь байдлаар хууль эрх зүйн актуудад тодорхойлжээ. Үүнд:

Хүснэгт 1.3

Зарим улс орны улсын тэмдэгтийн хураамжийн талаарх тодорхойлолт

№	Улсын нэр	Улсын тэмдэгтийн хураамжийн тодорхойлолт	Улсын тэмдэгтийн хураамжийг тогтоодог субъект
---	-----------	--	---

¹⁹ <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=31655>

1	Сингапур улс	Тэмдэгтийн хураамж нь арилжааны болон хууль ёсны баримт бичгээс хураадаг татвар юм. Баримт бичгээс тэмдэгтийн хураамжийг хураан авснаар, тухайн ажлыг “хүлээн зөвшөөрөгдсөн” гэж тэмдэглэнэ. ¹ Тэмдэгтийн хураамж – эд хөрөнгө, эсхүл эд хөрөнгөөс олох ашиг, хувьцаа, эсхүл хувьцаанаас олох ашиг зэрэгт холбогдох баримт бичгийн үйлчилгээний татвар. Тэмдэгтийн хураамжийн тухай хууль (Stamp Duties Act, Cap 312)-д заасан баримт бичгийн үйлчилгээнд төлнө. ²	Парламент
2	Хятад улс	Тэмдэгтийн хураамж гэдэг нь эдийн засгийн үйл ажиллагаа ба эдийн засгийн арилжааны явцад үүсдэг, хуулийн хүчин төгөлдөр баримт бичгийн үйл ажиллагаанаас хураадаг нэг төрлийн татвар юм. ³	Засгийн газар
3	Англи улс	1.6 Тэмдэгтийн хураамж нь зарим төрлийн хөрөнгийн шилжүүлгийн баримт бичиг болон хууль ёсны баримт бичигт төлөх татвар юм. Хөрөнгө гэдэг нь бүх төрлийн эзэмшиж болох зүйл ба, зөвхөн газар эсвэл байшин биш, гэвч бүх шилжүүлж болох хөрөнгөнд хураамж төлөхгүй. Хөрөнгийг зөвхөн шилжүүлэх үед баримт бичиг үүсдэг зарим хөрөнгө, жишээлбэл байшин, газар, компани хувьцаа зэргийг шилжүүлэхэд хууль ёсны маягтаар шилжүүлнэ. Харин машин, тавилга гэх мэт хөрөнгөнд ямар ч тэмдэгтийн хураамж төлөхгүй учир нь үүнийг гүйцэтгэхэд баримт бичиг үүсэхгүй. ⁴	Засгийн газар
4	Австрали улс	Тэмдэгтийн хураамж нь доорх зарим баримт бичиг болон зарим баримт бичиггүй хөрөнгийн эзэмшилд ноогдуулсан ерөнхий татвар юм. Үүнд: үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, бизнесийн хөрөнгө ба бусад хөрөнгийг худалдаалснаас эзэмших эрх шилжиж байгаа, мөн бэлэг, даатгалын гэрээнүүд ба орон сууцны зээл зэрэг орно. Хураамжийг худалдан авагч эсвэл зээлдэгчээр төлүүлнэ. Хураамжийн орлогыг олон нийтийн үйлчилгээний фондод хэрэглэнэ. Үүнд: боловсрол, эрүүл мэнд, хууль журам, мөн олон нийтийн аюулгүй байдал орно. ⁵	Засгийн газар
5	Аргентин улс	Татварын гарын авлага /Tax Guide 2009/ Аргентинд татвар ногдуулах ба хөрөнгө оруулах акт 2011 /Taxation and Investment in Argentina 2011/ Тэмдэгтийн хураамж нь тухайн улсын нутаг дэвсгэрт хууль ёсны бичиг баримт болон баримт бичиг үүссэнээс үүдэн хуулийн харилцаанд орж буй талуудын хооронд хөрөнгө шилжүүлэхэд оноох татвар юм. Тиймээс тэмдэгтийн хураамж нь үл хөдлөх хөрөнгө ба иргэний, арилжааны эсвэл санхүүгийн үүргүүдийг баримтжуулахад хэрэглэгдэнэ. Тэмдэгтийн хураамж гэдэг нь нь олон нийтийн болон хувийн баримт бичгийн албан ёсны гүйцэтгэлд татвар ноогдуулахыг хэлнэ. Баримт бичигт: бүх төрлийн гэрээ, ногириатын баримт, төлбөр төлөгч этгээдээс баталгаажуулсан падаан, нэхэмжлэл, вексель, хэлэлцээрийн баримт бичиг орно. ⁶	Засгийн газар

6	Энэтхэг улс	Энэтхэгийн тэмдэгтийн хураамж / Stamp Duty India/ Энэтхэгийн тэмдэгтийн хураамж бол “Энэтхэгийн Тэмдэгтийн хураамжийн хуулийн” /Indian Stamp Act, 1899/ зохицуулалтаар баримт бичгийн ажил гүйцэтгэлээс хураамж авах татварын нэг төрөл юм. Энэ нь бусад татвартай ижилхэн, худалдааны татвар эсвэл орлогын татвар зэрэг шиг энэ нь улсын мөнгөн санд орно, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэж буй улсын засгийн газраас тэмдэгтийн хураамжийг хураана.	Засгийн газар
7	Ирланд улс	Тэмдэгтийн хураамж – эд хөрөнгий эрхийг тодорхойлж байгаа баримт бичгийн үйлчилгээний төлбөр. Хураамжийг Тусгай эрхт төлөөлөлөгч ногдуулдаг.	Парламент тогтооно. “Тэмдэгтийн хураамжийг баталгаажуулах тухай хууль” (1999) ⁷

* * *

Дээрхээс үзэхэд, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн актууд болон бусад орнуудын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсоноор Тэмдэгтийн хураамж гэдэг бол нэг төрлийн татвар юм.

Хураамж төлөгч болон хураамж хураах үйлчилгээний төрөл:

Дараахь этгээдүүд хууль тогтоомжид заасны дагуу хураамж төлөгч байна. Үүнд:

- Монгол Улсын иргэн;
- Гадаадын иргэн, харъяалалгүй хүн;
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газар, улс төрийн нам, хөдөлгөөн, сан, шашны байгууллага;
- Гадаад улс дахь Монгол Улсын элчин сайдын яам, консулын газраар дамжуулан үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээд төлбөр төлөгч болно.

1993 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар нийт 18 төрлийн 84 үйлчилгээнээс хураамж авдаг байсан бол 2010 онд батлагдсан хуулиар 42 төрлийн 564 үйлчилгээнээс төлбөр хураамжийг авахаар хуульчилсан байна.

Тэмдэгтийн хураамж ногдуулах хувь хэмжээ нь төрөл тус бүр дээр өөр өөр байх бөгөөд дараахь үйлчилгээний төрлүүдээс тэмдэгтийн хураамжийг авахаар хуульчилсан байна.

1. Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
2. Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
3. Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
4. Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
5. Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
6. Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн
7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамжийн хэмжээ

8. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
9. Галт зэвсэг худалдах, эзэмших, улсын лээр нэвтрүүлэх, тээвэрлэх, бүртгэх, харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
10. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон тэмдэгтийн хураамж

2010 оны хуульд нэмэж орсон тэмдэгтийн хураамжийн төрлүүд

1. Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
3. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
4. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
5. Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ
6. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон тэмдэгтийн хураамж
7. Арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон тэмдэгтийн хураамж
8. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон тэмдэгтийн хураамж зэрэг болно.

Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх:

Дараахь үйлчилгээг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

- Тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;
- Патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;
- Төсвийн байгууллагын нэхэмжлэл;
- Төсөвт төлөх албан татвар, хураамж, төлбөр, торгууль, хүү, алдангийг төлүүлэх талаар гаргасан нэхэмжлэл;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар гаргасан нэхэмжлэл;
- Цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл;
- Хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан шийтгэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл;
- Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан нэхэмжлэл;
- Төлбөрийн чадваргүй болсон банкинд томилогдсон банкны бүрэн эрхт төлөөлөгч, банкны эрх хүлээн авагчаас гаргасан нэхэмжлэл.

Тэмдэгтийн хураамж төлөх журам, түүнд хяналт тавих:

Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн биелэлтэнд Үндэсний татварын алба хяналт тавих ба тэмдэгтийн хураамжийн мөнгөн төлбөрийг хуульд заасан үйлчилгээ үзүүлж байгаа эрх бүхий байгууллага бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хураана. Хураамж авах албан

тушаалтныг байгууллагын эрх баригчийн шийдвэрээр томилон ажиллуулана.

Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.

Тэмдэгтийн хураамжийн талаар гомдол гаргах:

Иргэн, хуулийн этгээд нь тэмдэгтийн хураамжтай холбоотой гомдлоо тэмдэгтийн хураамж төлснөөс хойш 14 хоногийн дотор эрх бүхий байгууллага болон шүүхэд гаргах эрхтэй бөгөөд уг гомдлыг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ. Шүүхээс хураасан тэмдэгтийн хураамжийн талаар гарсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу дээд шатны шүүх нь хянан шийдвэрлэнэ.

* * *


Хоёр. Монгол Улсын төсөвт тэмдэгтийн хураамжаас төвлөрүүлсэн орлогын судалгаа

1993 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 20 дугаар зүйлд Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хураамжийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Улсын татварын албанд гаргаж өгөхөөр заасан байдаг.

Судалгааны явцад Татварын Ерөнхий газраас Улсын тэмдэгтийн хураамжаас төсөвт оруулсан орлогыг үйлчилгээний төрөл тус бүрээр гаргаж өгөхийг албан тоотоор хүссэн боловч Татварын Ерөнхий газар нь өөрийн мэдээллийн санд улсын тэмдэгтийн хураамжийг төрөл тус бүрээр нь ангилан гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй, харин 2010 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулинд заасны дагуу үйлчилгээний төрөл тус бүрээр ангилан татварын тайланг гаргахаар бэлтгэл ажлыг хангаж байна хэмээн тайлбар өгсөн болно. 2011 оны 3 дугаар улирлаас эхлэн ТЕГ-аас үйлчилгээний төрөл тус бүрээр ангилсан мэдээллийг гаргах боломжтой юм байна. /Татварын Ерөнхий газраас ирүүлсэн 2011 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 6/1131 тоот албан бичгийг Хавсралт 1-ээс үзнэ үү/

Иймд захиалгын 1-р асуултанд заасны дагуу шинэ хууль батлагдсанаас хойшхи улсын төсөвт оруулсан улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хуучин хуулийн үйлчлэлийн хүрээнд төсөвт төвлөрүүлсэн тэмдэгтийн хураамжийн орлоготой зүйл тус бүрээр нь харьцуулан судлахад шаардагдах мэдээллийн бааз холбогдох байгууллагад байхгүй байгаа тул эдгээр үзүүлэлтийг тоон утгаар нь харьцуулах боломжгүй байна. Харин Сангийн яамны жил бүрийн төсвийн гүйцэтгэлд тулгуурлан 2002-2011 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого дахь улсын тэмдэгтийн хураамжийн орлогын динамик судалгааг гаргасан болно.

Зураг 2.1 Улсын төсвийн орлогын төлбөр хураамжийн хэсэг дэх улсын тэмдэгтийн хураамжийн орлого /2002-2010 он тэрбум төгрөгөөр/



Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Бусад татвар /төлбөр хураамж/	25,8	30,8	62,1	83,8	107,7	170,8	194,7	200,9	267,9	580,2
Улсын тэмдэгтийн хураамж	5,1	7,3	20,6	31,5	34,0	47,0	17,7	16,6	56,3	64,8
Улсын тэмдэгтийн хураамжийн бусад татвар төлбөр хураамжид эзлэх хувь	19,8%	23,7%	33,2%	37,6%	31,6%	66,4%	9,1%	8,3%	21,0%	11,2%

* * *

Гурав. Бусад орнуудын Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, тогтоомжийн талаархи харьцуулсан судалгаа

3.1 Хятад улс

БНХАУ нь Тэмдэгтийн хураамжийн төрлүүдийг тогтоохдоо ихэвчлэн тухайн улс эсвэл бүс нутгийн нийгмийн хэрэгцээг үндэслэн тогтоодог байна. Тиймээс улс орон, бүс нутгуудын тэмдэгтийн хураамжийн төрлүүдийн хамрагдах хүрээ нь харилцан адилгүй өөр өөр байдаг.

БНХАУ -д тэмдэгтийн хураамжийг Хятад улсын Төрийн зөвлөлийн 1988 оны 6 сарын 24 -ны өдрийн хурлаар хэлэлцэн батлаж, 1988 оны 8 сарын 6 ны өдрийн 11 дэх тогтоолоор зарласан “Хятад улсын тэмдэгтийн хураамжийн түр тогтоол” /Interim Regulations of the people's republic of China on stamp tax/ болон “Хятад улсын тэмдэгтийн хураамжийн түр тогтоолын гүйцэтгэх тодорхой журам”-аар тус тус зохицуулж байна.

БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр иргэн, хувь хүн болон байгууллага, хуулийн этгээд нь дараахь төрлийн бичиг баримт болон бусад үйлчилгээнд тэмдэгтийн хураамж төлөх үүрэгтэй. Үүнд:

- Худалдах худалдан авах, боловсруулалт, барилга байгууламжийн төсөл, эд хөрөнгө түрээслэх, түрээслүүлэх, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, агуулах хадгалалт, зээл, эд хөрөнгийн даатгал, техник технологийн гэрээнүүд эсвэл гэрээний шинж чанартай

бичиг баримтууд;

- Эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх баримт бичиг;
- Бизнесийн нягтлан бүртгэлийн баримт бичиг;
- Лиценз гэрчилгээ;
- Үнэт цаасны арилжаа;
- Санхүүгийн яамнаас тогтоосон тэмдэгтийн хураамж авах бусад бичиг баримтууд орно.

Хүснэгт 3.1 БНХАУ-ын тэмдэгтийн хураамжийн төрөл, хувь хэмжээ

	Тэмдэгтийн хураамжийн төрөл	Хамрагдах хүрээ	Хураамжийн хувь	Хураамж төлөх субъект
1	Худалдах худалдан авах гэрээ	Нийлүүлэх, урьдчилан худалдан авах, худалдан авах, худалдах худалдан авах тохиролцоо, эм найруулах, нөхөн олговор олгох, арилжааны гэрээ багтана	Худалдааны мөнгөн хэмжээний 0,03%	Гэрээ байгуулагч тал
2	Боловсруулалтын гэрээ	Боловсруулах, захиалан хийлгэх, засвар сэлбэх, хэвлэх, реклам сурталчилгаа, кадастрийн зураг, хэмжих зэрэг гэрээ багтана.	Орлогын 0,05%	Гэрээ байгуулагч тал
3	Барилга байгууламжийн төсөл, геологийн ажлын гэрээ	Геологийн ажил, зураг төсөл хийх гэрээ	Зардлын 0,05%	Гэрээ байгуулагч тал
4	Барилга байгууламжийн угсралт, төслийн батлан даах гэрээ	Барилга байгууламж, угсралт, батлан даах гэрээ	Нийт мөнгөн хэмжээний 0,03%	Гэрээ байгуулагч тал
5	Эд хөрөнгийн түрээслэлтийн гэрээ	Байр, усан онгоц, онгоц, машин, механик багаж төхөөрөмж, тоног төхөөрөмж зэрэг	Түрээсний мөнгөн хэмжээний 0,1%	Гэрээ байгуулагч тал
6	Бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гэрээ	Иргэний тээвэрлэлт, төмөр замын, далайн, гол мөрний, замын тээвэрлэлтийн гэрээ орно	Тээврийн зардлын 0,05%	Гэрээ байгуулагч тал
7	Агуулах хадгалалтын гэрээ	Агуулах, хадгалалтын гэрээ	Агуулах хадгалалтын зардлын 0,1%	Гэрээ байгуулагч тал
8	Зээлийн гэрээ	Банк, банк бус санхүүгийн байгууллага, хувь хүнээс зээл авсан гэрээ	Зээлийн мөнгөн хэмжээний 0,005%	Гэрээ байгуулагч тал

9	Эд хөрөнгийн даатгалын гэрээ	Эд хөрөнгө, хариуцлагын, хамгаалах зэрэг даатгалын гэрээ	Даатгуулсан мөнгөн хэмжээний 0,003%	Гэрээ байгуулагч тал
10	Техник технологийн гэрээ	Технологийн нээлт, шилжүүлэх, лавлах, үйлчилгээний гэрээ	Мөнгөн хэмжээний 0,03%	Гэрээ байгуулагч тал
11	Эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх баримт	Эд хөрөнгийн өмчлөх эрх, хэвлэлийн эрх, барааны тэмдэгний тусгай зөвшөөрөл, патентын эрх, тусгай техник технологийн хэрэглэх эрх, зэрэг шилжүүлэх зөвшөөрөл	Мөнгөн хэмжээний 0,05%	Өмчлөгч тал
12	Бизнесийн нягтлан бүртгэл	Бизнесийн үйл ажиллагааны нягтлан бүртгэл	Хуудас бүр нь 5Г	
13	Лиценз гэрчилгээ	Засгийн газрын салбараас тараадаг байрны өмчлөх зөвшөөрөл, аж үйлдвэр эрхлэх зөвшөөрөл, барааны тэмдэг/ патентын зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, газар ашиглах зөвшөөрөл	Хуудас бүр нь 5Г	Хүлээн авагч тал
14	Үнэт цаасны арилжаа		0,04%	

Тэмдэгтийн хураамжаас хөнгөлөх, чөлөөлөх нөхцөл:

Уг тогтоолоор тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх баримт бичгийг тодорхойлон зааж өгсөн байдаг. Үүнд:

- Тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар ба олшруулсан хувь;
- Эд хөрөнгийн өмчлөгч нь өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг Засгийн газар, нийгмийн халамжийн байгууллага, сургуульд бэлэглэж байгаа тохиолдолд холбогдох баримт бичиг
- Тариалан, малын төрлийн даатгалын гэрээ
- Санхүүгийн яамнаас зөвшөөрөгдсөн бусад чөлөөлөгдөх баримт бичиг зэрэг болно. Мөн түүнчлэн “Гүйцэтгэх тодорхой журам”-ийн 13-р зүйлийн 4.3-т дурьдсан дараахь бичиг баримтыг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр заасан байна.
- Улсаас иргэдийн төлөөлөгчдийн хуралтай, эсвэл тариаланчтай байгуулсан газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ;
- Хүүгүй зээлийн гэрээ;
- Гадаадын Засгийн газар эсвэл Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас Хятад улсын Засгийн газар болон улсын банк, санхүүгийн байгууллагад олгож буй хөнгөлөлттэй зээлийн гэрээ зэрэг болно.

Тэмдэгтийн хураамж төлөх журам:

Тэмдэгтийн хураамжийг төлөхдөө хураамж төлөгч этгээд нь тэмдэгтийн хураамжийг тухайн хураамж төлөх бичиг баримтанд нэг удаа төлнө. Тэмдэгтийн хураамж төлөх

ёстой нэг баримт бичгийн хувьд хэрэв хоёр буюу хоёроос дээш талууд гэрээ байгуулсан тохиолдолд гэрээ байгуулсан тал тус бүр тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хэрэв хураамж төлсөн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн гэрээнд өөрчлөхөд нэмэгдсэн хураамжаар нөхөж тэмдэгтийн хураамж төлөх ёстой. Гүйцэтгэх тодорхой журам 18-р зүйлд хэрэв тухайн тэмдэгтийн хураамж төлбөр нь мөнгөөр илэрхийлэгддэггүй гэрээний хувьд тухайн баримт бичгийн бүртгэлийн тоо ширхэг эсхүл Хятад улсын тухайн үеийн үнэ ханшаар тооцож тэмдэгтийн хураамжийг төлнө. Хэрэв үнэ ханш нь тогтоогдоогүй бол тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцох бөгөөд дараа нь тогтоосон хураамжийн хувиар тооцож төлнө. Мөн журмын 19-р зүйлд тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь гадаад валютуар тооцогдсон бол, хураамж төлөгч тухайн өдрийн Хятадын Ардын Банкны валютын ханшаар тооцож тэмдэгтийн хураамжийг төлнө гэж заасан байдаг.

Тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомжид татварын байгууллага хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Хятад улсын Татварын газар /State Taxation Bureau/ тэмдэгтийн хураамжийг хураах ажлыг удирдан зохион байгуулна. Тэмдэгтийн хураамжийн тасалбар нь улсын мөнгөн тэмдэгт болох RMB-ээр илэрхийлэгдэнэ.

Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:

Хураамж төлөгч нь дараахь аль нэг зөрчлийг гаргасан нөхцөлд татварын байгууллагаас тухайн зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан хариуцлага хүлээлгэнэ. 1/ Тэмдэгтийн хураамж төлөх ёстой баримт бичигт тэмдэгтийн хураамжийг төлөөгүй эсвэл дутуу төлсөн бол, татварын байгууллага тэмдэгтийн хураамжийг нөхөж төлүүлэхээс гадна, тэмдэгтийн хураамжийн нөхөн төлөх мөнгөний нийт хэмжээнээс 20 дахин их хүртэлх мөнгөөр торгож болно.

2/ Энэ тогтоолын 6-р зүйлийн 1-д зааснаар, хураамж төлөгч нь хүчингүй болгох ёстой тэмдэгтийг хүчингүй болгоогүй байгаа бол татварын байгууллага нь тэмдэгтийн хураамжийн төлөх мөнгөн дүнгийн хэмжээнээс 10 дахин их хүртэлх мөнгөөр торгож болно.

3/ Энэ тогтоолын 6-р зүйлийн 2-д зааснаар, хураамж төлөгч нь тэмдэгтийн хураамжийн тасалбарыг дахин хэрэглэсэн бол, татварын байгууллага нь тухайн тэмдэгтийн хураамжийн төлөх нийт мөнгөний хэмжээнээс 30 дахин их хүртэлх мөнгөөр торгож болно. Хэрэв хураамж төлөгч нь тэмдэгтийн хураамжийн тасалбарыг хуурамчаар үйлдсэн бол, татварын байгууллагаас шүүхийн байгууллагад гомдол гаргаж хариуцлага хүлээлгэж болно. Мөн үүнээс гадна гүйцэтгэх тодорхой журмын 39-р зүйлд хэрэв тогтоолын 5-р зүйлийн 2-д заасныг зөрчсөн тохиолдолд, татварын байгууллагын тогтоосон тэмдэгтийн хураамж төлөх хугацаа хэтэрвэл, төлөөгүй байгаа хураамж болон дутуу төлсөн хураамжийг татварын байгууллагад нөхөн төлүүлэхээс гадна, хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 5% тэнцэх хэмжээний торгуулийг ногдуулна.

Хэрэв хураамж төлөгч нь тэмдэгтийн хураамжийг илүү төлсөн тохиолдолд буцаан олгох эсвэл нөхөн хэрэглэх талаар өргөдөл гаргах эрхтгүй байдаг. Харин тэмдэгтийн хураамж төлөгч нь хураамжийн төлөх эсэх талаархи бичиг баримтын талаар үүссэн маргааныг дээд шатны нь татварын байгууллагад мэдэгдэж тухайн бичиг баримтыг хянуулна.

Хятад улсын тэмдэгтийн хураамжийн эрх зүйн зохицуулалтын хувьд, Хон Конг, Макао, Тайвань бүс нутгийн тэмдэгтийн хураамжийн төрлүүд нь өөр өөр байх бөгөөд бусад нутаг дэвсгэрийн хувьд хоорондоо маш их ялгаатай байна. Товч дурьдвал:

Макао-ын тэмдэгтийн хураамжийн төрөл:

Макао-ын тэмдэгтийн хураамжийн хуульд зааснаар, зарчмын хувьд худалдаа арилжааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон бүх төрлийн баримтаас тэмдэгтийн хураамжийг хураадаг. Мөн түүнчлэн гэрээнээс үүссэн бичиг баримт, түрээслэх, түрээслүүлэх гэрээний бичиг баримт, даатгалаас тэмдэгтийн хураамжийг тус тус авдаг.

Эдгээр энгийн тэмдэгтийн хураамжийн төрлүүдээс гадна, Макао-д зарим онцгой тэмдэгтийн хураамжууд байна. Тухайлбал, компани байгуулахад хувьцааны тэмдэгтийн хураамж, тоглолт, үзэсгэлэн худалдаа, бусад баяр наадмын арга хэмжээний тасалбарын үнээс авах үзвэр тоглолтын тэмдэгтийн хураамж, усан онгоц эсвэл онгоцонд суух тасалбараас авах замын хөдөлгөөний тэмдэгтийн хураамж, банкны хүү, зээлийн ашгийн хураамж зэрэг болно.

Хон конгийн тэмдэгтийн хураамжийн төрөл:

Хон конгийн тэмдэгтийн хураамж нь дараахь гурван төрлийн эрх зүйн баримт бичгээс зөвхөн тэмдэгтийн хураамж авна:

- Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх баримт бичиг
- Түрээслэх, түрээслүүлэх гэрээний баримт бичиг
- Хон конгийн үнэт цаасны арилжааны баримт бичиг

Тайваний тэмдэгтийн хураамжийн төрөл нь:

Тайван нь мөн дараахь гурван төрлийн баримт бичгээс тэмдэгтийн хураамжийг авах бөгөөд бусад төрлийн хураамжийн үйлчилгээ нь тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны актуудаар тогтоогддог байна.

- Мөнгөний баримт
- Үл хөдлөх хөрөнгийн зарах, авах, хуваах баримт
- Хөрөнгийн худалдаа

3.2 Сингапур улс

Сингапур улс нь 1998 оны 2 сарын 28-ны өдөр батлагдаж, 2006 оны 4 сарын 28-ны өдөр шинэчлэн найруулсан “Тэмдэгтийн хураамжийн Акт”/Stamp duties act/-аар зохицуулах бөгөөд энэхүү актаар дараахь бичиг баримтанд тэмдэгтийн хураамжийг төлдөг байна.

Хүснэгт 3.2 Сингапур улсын Тэмдэгтийн хураамжийн төрөл, хэмжээ

№	Тэмдэгтийн хураамжийн төрөл	Хамрагдах хүрээ	Хураамжийн хувь	Хураамж төлөх субъект
1	Бонд, гэрээ, баримт бичиг	Тавилга, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн түрээс	Түрээстэй ижил	Түрээслэгч
2	Өмч шилжүүлэх, тээвэрлэх	Үл хөдлөх хөрөнгө	Эхний 1800\$-ын 100\$ бүрт –1\$ Дараагийн 1800\$-ын 100\$ бүрт –2\$ Түүний дараагийн 1800\$-ын 100\$ бүрт –3\$	Байгууллага, хувь хүн, шилжүүлэгч, эсвэл түрээслэгч
3	Мэдэгдэл, мэдүүлэг	Үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас хувьцааны худалдах, бэлэглэх, төлбөр тооцооны мэдэгдэл	10\$	

4	Хуулбар, олшруулсан хувь	Бичиг баримтын хуулбар, олшруулсан хувь	2\$ эсвэл эх хувьтай ижил	
5	Солилцох	Үл хөдлөх хөрөнгийг солих эсвэл солихоор тохирсон	Зарах төлбөртэй ижил	Байгууллага, хувь хүн, шилжүүлэгч, эсвэл түрээслэгч
6	Бэлэг		Зарахтай ижил	
7	Түрээс	Тавилга, хөрөнгө, тоног төхөөрөмжийн түрээс	250\$ бүрт: нэг жилд-1\$ хоёроос гурван жилд-2\$ Гурваас дээш –4\$	Түрээслэгч, түрээслүүлэгч
8	Зээл, зээлийн хэлэлцээр, өрийн бичиг \ дебентур\	Үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас хувьцаа	1000\$ бүрт- 4\$ ба 500\$-аас дээшгүй	зээлдэгч
9	Үл хөдлөх хөрөнгө хуваах	Үл хөдлөх хөрөнгийн баримт	Бичиг баримт бүрт 10\$	
10	Үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас эсвэл хувьцааны хэлэлцээр	Хэлэлцээрийн баримт бичиг	Өмч шилжүүлэх, тээвэрлэхтэй ижил	
11	Үл хөдлөх хөрөнгийн түрээс	Үл хөдлөх хөрөнгө	Бичиг баримт бүрт 10\$	

Тэмдэгтийн хураамж төлөх журам:

Тэмдэгтийн хураамжийг төлөх бичиг баримтанд хураамж төлсөн талаарх тамга, тэмдэг дарах эсвэл тусгай зориулалтын наалтыг наасанаар баталгаажуулна. Мөн түүнчлэн тэмдэгтийн хураамж төлөгч иргэн, хуулийн этгээд бүр электрон банкнд данс нээх шаардлагатай бөгөөд электрон тэмдэгтийн системд бүртгүүлэн өөрийн данснаас Комиссарын дансруу мөнгө шилжүүлж болдог.

Бичиг баримтыг нэрлэсэн үнээс хураамжийг ногдуулахдаа:

- Сингапуриас бусад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн тэмдэгт
- Хувьцаа эсвэл гүйлгээнд буй үнэт цаас, эсвэл бусад үнэт цаас бол хураах ёстой хураамжийг тухайн баримт бичгээр тодорхойлогдсон үнэ ханшаас, үнэт цаас бол дундаж үнээр бодох эсхүл тухайн өдрийн Сингапурын валют солих ханшаар тооцно.

Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42-р зүйлд хуульд өөрөөр заагаагүй бол, тэмдэгтийн хураамж төлөгч /иргэн, хуулийн этгээд/ нь хураамж төлөх ёстой бичиг баримтыг Сингапур улсын хил дотор үйлдсэн бол бичиг баримтанд гарын үсэг зурахаас өмнө хураамжийг төлсөн тухай тамга тэмдэгийг даруулсан байх ёстой. Харин хуулийн 43-р зүйлд Сингапур улсын хилээс гадна үйлдсэн бол Сингапур улсад ирснээс хойш 30 хоногийн дотор тэмдэгтийн хураамжийг төлж тамга тэмдэг даруулах ёстой.

Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх нөхцөл:

- Сингапур улсаас гадна байгуулсан түрээс шилжүүлэг, худалдаа, хувьцаа зэрэг
- /Co-operative Societies Act/
- /Monetary Authority of Singapore under the Exchange Control Act/
- Газар ашиглалтын хуулийн Газрын орлогын хураамжийн /Collector of Land Revenue

under the Land Acquisition Act/ дагуу бүрдүүлсэн бичиг баримтуудыг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

Хэрэв комиссар нь энэ хуулийн дагуу төлөх хураамжыг хэн нэгэн илүү мөнгө төлсөн гэдгийг хүлээн зөвшөөрвөл, илүү хураасан мөнгийг буцаан олгохоор баталгаа гаргана.

Тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага:

Тэмдэгтийн хураамж төлөх талаар маргаан гарсан тохиолдолд Комиссарт хүсэлт гаргаж тухайн бичиг баримт хураамж төлөх эсэх талаар болон тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоолгож болно. Хэрэв хураамж төлөгч нь комиссарын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр гарснаас хойш 21 хоногийн дотор дээд шүүхд гомдол гаргаж, давж заалдаж болно.

Хэрэв хураамж төлөгч нь хураамж төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд мөн тэмдэгтийн гэрчилгээтэй холбоотой зөрчил гаргасан тохиолдолд, зөрчлийн нөхцөл байдлаас хамааран 10,000\$-аас хүртэлх хэмжээгээр торгох эсвэл 3 жил хүртлэх хугацаагаар хорих хүртлэх хариуцлага хүлээлгэнэ.

Электрон тэмдэгтийн систем /E-stamping system/:

Комиссар нь дараахь үйлчилгээнд Электрон тэмдэгтийн системийг байгуулан ажиллуулж болно.

- Бичиг баримт дээр тэмдэгтийн хураамжийн үнэлгээ \ болон торгууль \ ;
- Үнэлгээний дагуу бичиг баримтын тэмдэгтийн хураамж, болон торгуулийг электрон хэлбэрээр шилжүүлэх;
- Комиссараас бичиг баримтанд гаргасан зөвшөөрлийн дугаар бүхий тэмдэгтийн гэрчилгээг тухайн бичиг баримттай хасаргах;

Энэхүү Электрон тэмдэгтийн системд бүртгүүлэн ашигласнаар Комиссарт бичиг баримтыг хураалгах эсвэл комиссарын ажлын байранд очин хураамж төлөх шаардлагагүй байдаг.

3.3 Ирланд Улс:

Ирланд улсын тэмдэгтийн хураамжийн тухай эрх зүйн зохицуулалтыг 1990 онд батласан 12 бүлэг, 164 зүйл бүхий “Тэмдэгтийн хураамжийн нэгдсэн хууль”-аар зохицуулдаг байна. Энэ хуулиар үл хөдлөх хөрөнгө, түүний шижүүлэг, үнэт цаас, бонд, лизинг буюу санхүүгийн түрээс, түрээс зэрэг хэдэн төрлийн үйлчилгээнд тэмдэгтийн хураамж ногдуулдаг байна. Тэмдэгтийн хураамж төлөгч нь тухайн төрлийн үйлчилгээний эзэмшигч буюу худалдан авагч байх бөгөөд тэмдэгтийн хураамжийг тусгай эрх бүхий төлөөлөгч хариуцаж гүйцэтгэнэ.

Тэмдэгтийн хураамжийн төрөл, хувь хэмжээ:

Үл хөдлөх хөрөнгө

Үл хөдлөх хөрөнгөнд тэмдэгтийн хураамжийг тухайн үл хөдлөх хөрөнгийн зориулалт / орон сууцны ба орон сууцны бус/, хөрөнгийн үнэ, худалдан авч байгаа хүний статусаас шалтгаалан оногдуулна.

Хүснэгт 3.3 Үл хөдлөх хөрөнгө болон газрын шилжүүлэг ба бусад
/Орон сууцны бус зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хураамж/

Хөрөнгийн хэмжээ	Хэмжээ хувь
₮10,000 доош	Хөнгөлөнө
₮10,001 - ₮20,000	1%
₮20,001 - ₮30,000	2%
₮30,001 - ₮40,000	3%
₮40,001 - ₮70,000	4%
₮70,001 - ₮80,000	5%
₮80,000 дээш	6%

* * *

Орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хураамж

Хөрөнгийн үнэ(₮)	Анх удаа худалдан авч байгаа хүн	Хоёрдогч эзэмшигч
125,000 хүртэлх	Хөнгөлөлт	Хөнгөлөлт
₮125,001 - ₮1,000,000	Хөнгөлөлт	7%
Balance over ₮1,000,000	Хөнгөлөлт	9%

Тухайн орон сууц нь 125м²-аас илүүгүй тохиолдолд анх удаа худалдан авч байгаа эзэмшигч нь хөнгөлөлтийг эдлэх бөгөөд хөнгөлөлт эдэлнэ. Хэрэв тухайн үл хөдлөх хөрөнгө бэлэг хэлбэрээр бусдад шилжсэн тохиолдолд тухайн үеийн зах зээлийн ханшын дагуу тооцож тэмдэгтийн хураамжийг авна.

Үнэт цаасны шилжүүлэг, үнэт цаас

Үнэт цаасны төлбөрийн 1% байна. Тухайн үнэт цаасны хураамж нь Ү1-с доошоо унасан тохиолдолд доод хэмжээ нь хамгийн багадаа Ү1 төлнө. Мөн түүнчлэн моргажийн зээлийн хувьд хураамжийг үнэт цаасны нэгэн адил хэмжээгээр тооцдог. Лизингийн хураамжийг түрээс болон нэрлэсэн үнэ хоёрт оногдуулна.

Түрээс	Түрээсийн хураамж
Амины сууц ба орон сууцны лизингийн нөхцөл нь тодорхой бус эсвэл 35 жилээс ихгүй ба түрээс нь жилийн Ү19,050 илүүгүй	Хөнгөлнө
Бусад тохиолдолд:	
Тодорхой нөхцөлтэй 35 жил хүртэлх	Түрээсийн жилийн дундажын 1%
35 жил их ба 100 жил ихгүй	Түрээсийн жилийн дундажын 6%
100 жилээс их	Түрээсийн жилийн дундажын 12%

Санхүүгийн карт: Кредит карт, төлбөрийн карт, АТМ карт болон лазер карт дээр хураамж ногдуулна.

- Кредит карт - 30᠖
- Төлбөрийн карт - 30᠖

Тухайн хүн өөрийн дансандаа нэмэлт карт эзэмшиж болох бөгөөд нэмэлт хураамж төлөхгүй харин аж ахуй нэгж нь нэг дансанд олон карттай байж болох бөгөөд карт бүрт нэмэлт хураамж төлнө.

- АТМ карт - 2.50᠖
- Дебит /лазер/ карт - 2.50᠖
- АТМ ба лазер холимог карт - 5᠖

Хөнгөлөлтүүд:

- Хэрвээ тухайн карт эзэмшигч нь нэг жилийн хугацаанд ашиглаагүй бол тэмдэгтийн хураамж төлөхгүй.
- Тухайн санхүүгийн хугацаанд карт эзэмшигч нь нас барсан тохиолдолд тэмдэгтийн хураамж ногдуулахгүй
- Төлбөрийн хаяг тухайн улсаас гадна бол хураамж ногдуулахгүй

Бусад хэрэгслүүд дээрх тэмдэгтийн хураамжийн хөнгөлөлтүүд:

- Концерни доторхи үл хөдлөх хөрөнгийн шилжилт нь хөнгөлөлтөнд хамрагдах бөгөөд лизинг нь үүнд хамаарахгүй болно.
- Тодорхой компаниудын сэргээн босголт болон нэгдэх.
- Компани нь хувьцаат компани болох.
- Залуу фермерийн хөнгөлөлт – энэ нь фермерийн зориулалтын үл хөдлөх хөрөнгө, газар эзэмшигч бөгөөд тухайн хөнгөлөлтөнд хамрагдах үед 35 нас хүрээгүй хүн хамрагдана.
- Фермерийн нэгдэлийн хөнгөлөлт
- Буяны зориулалтаар газар шилжүүлэх, түүний лизинг хөнгөлөх
- Хандив – сургууль болон 3 дугаар зэрэглэлийн коллежд
- Спортын зориулалтаар газар шилжүүлэх болон лизинг хөнгөлөх бөгөөд Татварын ерөнхий хуулийн 235-д заасан заасан этгээдэд
- Тодорхой гэр бүлийн шилжүүлэг–фермерийн газрын тодорхой шилжүүлгүүд хамрагдана.
- Арилжааны зориулалтын ой – тухайн газар ургаж байгаа модны өртөгт оногдуулахгүй
- Эхнэр нөхөр хоёрын хооронд үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх
- Ирландын шүүхийн дагуу гэр бүл салгуулсан тохиолдолд чөлөөлөгдөнө.
- Оюуны хөрөнгө – патент, барааны таних тэмдэг /trade mark/, зохиогчийн эрх, зохион бүтээл, домайн нэр гэх мэт зүйлс хамаарана.
- Европын холбооны нэгж фермерийн төлбөрийн баримтын дагуу худалдаа, шилжүүлэг зэрэг нь хөнгөлөгдөнө.
- Орон сууцны байгууллага ба Боломжит орон сууцны нөхөрлөл
- Oireachtas сан буюу Ирландын Парламентын сангууд

Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:

Тэмдэгтийн хурааж төлөөгүй этгээдэд тавих торгууль болон хариуцлагыг уг хуулийн 10 дугаар бүлэгт тусгаж өгсөн байна. Уг хуулийн 129-д зааснаар хувь хүн нь зохих ёсоор тэмдэгтийн хураамж төлөөгүй нь нотлогдсон тохиолдолд 500 фунт стерлинг торгууль төлнө гэж заасан байна. Тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх үйл ажиллагаа нь тухайн харъяа дүүргийн шүүхийн журмаар шийдэгдэх бөгөөд тэмдэгтийн хураамжтай холбоотой бусад торгуулыг Татваруудын ерөнхий хууль /1997/-ийн 987.4, 1061, 1062, 1063, 1064, 1065, 1066 ба 1068 заасан заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Архидан согтуурахтай тэмцэх талаарх бусад орны туршлага, хэрэгжүүлж буй бодлого

4.1 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Европ дахь салбар


Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (Worth Health Organization)-ын Европ дахь салбар 2002 онд байгуулагдсан бөгөөд түүний гишүүн улсаар одоогийн байдлаар нийт 53 орон хамрагддаг байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) эдгээр орнуудын архи, согтууруулах ундаатай холбогдолтой үйл ажиллагааны нэгдсэн тайланг 2010 онд гаргажээ. Уг тайланд улс орнуудын архи, согтууруулах ундаатай холбоотой харилцааг зохицуулсан нийтлэг зохицуулалтыг дараахь байдлаар тоймолсон байна.

- Гишүүн орнуудын 60 хувь нь архи, согтууруулах ундааны талаархи үндэсний хэмжээний бичмэл бодлогын баримт бичигтэй аж. Бусад орнуудын бодлогын баримт бичиг нь төсөл хэлбэрээр байгаа, эсвэл бодлогын баримт бичиг огт байхгүй байна.
- Үндэсний хэмжээний бодлогын баримт бичигтэй улс орнуудын ихэнхи нь орон нутгийн хэмжээнд үйлчлэх бодлогын баримт бичгийг зэрэгцүүлэн хэрэгжүүлж байна.
- Жолоочийн цусан дахь архины хэмжээг 8 орон “тэг” гэж заасан бол 9 орон 0.2-0.4 гр/л, 25 оронд 0.5 гр/л, 3 оронд 0.8 гр/л гэж тус тус заажээ.
- Нийт орнуудын 2/3 нь пиво, вино худалдан авах, 3/4 нь спиртын төрлийн ундааг худалдан авах насны доод хязгаарыг 18 нас гэж заасан байна.
- Улс орнуудын 40 хувь нь архи, согтууруулах ундааг худалдаалах цагийн хязгаарыг тогтоосон бол 67 хувь нь худалдаалах газрыг хязгаарласан байна.

ДЭМБ-ын Европ дахь салбарын үзүүлэлтээр дэлхийн бусад орнуудаас Европт архины улмаас өвчлөлт болон нас баралт хамгийн өндөр хувьтай байна. (Зураг 1.) 2010 оны байдлаар Европт 2007 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын дараах хор уршиг үргэлжилсээр байгаа нь архины хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Европын холбоонд ажилгүйдлийн түвшин гурван хувиар нэмэгдэхийн зэрэгцээ архины улмаас нас баралтын хувь хэмжээ ч нэмэгдсэн байна.

Зураг 4.1. Дэлхийн улс орнуудын архи, согтууруулах ундаанаас үүдсэн өвчлөлт, нас баралтын түвшин

Бүс нутгаар, хүйсээр



Эх сурвалж: ДЭМБ, 2004 он.

Бодлогын үндсэн зорилт бол эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ нийгмийн сайн сайхан аж байдлыг сайжруулах явдал юм. Дээрхи тайланд архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээтэй тэмцэх үр дүнтэй бодлогын зохицуулалтыг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

- Архи, согтууруулах ундаанд ногдуулах татварыг нэмэгдүүлэх,
- Архи, согтууруулах ундааны эсрэг сургалт, сурталчилгаа явуулах,
- Цусан дахь архины хэмжээг бууруулан тогтоох,
- Архи, согтууруулах ундааны зар сурталчилгааг хязгаарлах,
- Архи, согтууруулах ундааны худалдаалах харилцааг хуулиар зохицуулах,
- Европын орнуудаас Ирланд улс нь архи, согтууруулах ундааны хэрэглээ дээгүүрт ордог тул судлагаанд тусгайлан авч үзсэн юм.

4.2 Ирланд улс

Тус улсад архи, согтууруулах ундаатай холбоотой харилцааг зохицуулдаг гол зохицуулалт бол 2008 онд батлагдсан **Архи, согтууруулах ундааны тухай хууль** бөгөөд мөн **Архи, согтууруулах ундааны үндэсний хөтөлбөрийг** хэрэгжүүлдэг байна. Тус улсын иргэдийн архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ 1989-2001 оны үед Европын холбооны орнуудын дунд хамгийн өндөр байсан. Тус улс нь 1995 онд Европын архи, согтууруулах ундааны тухай чартерыг зөвшөөрөн баталсан байна.

Архи, согтууруулах ундааны худалдаа

Ирландад сонтууруулах ундааг зарах тусгай зөвшөөрөл авсан газарт зарахаас гадна тусгай зөвшөөрөл аваагүй газарт зарж болно. 2003 оны 8-р сараас Ирландад эхлэн аливаа согтууруулах ундааг хямдруулсан үнээр зарахыг хориглосон байна. Өмнө нь “азтай цаг” гээд тодорхой цагуудад согтууруулах ундааг хямралтай үнээр зардаг байжээ.

Тусгай зөвшөөрөлтэй газар. Архи, согтууруулах ундааны тухай хуулиар 18 нас хүрээгүй этгээдэд согтууруулах ундаа зарахыг хориглох бөгөөд хэрэв хууль зөрчвөл шүүх худалдсан этгээдийн анхны үйлдэлд нь 3.000 еврогоос ихгүй, дараа дараагийн үйлдэлд 5.000 еврогийн торгууль ногдуулна. 18 нас хүрээгүй этгээд согтууруулах ундаа худалдан авах эрхгүй нь дээр эцэг эхийг зөвшөөрөлгүйгээр хувийн эзэмшилээс өөр газар уухыг хориглоно.

Тусгай зөвшөөрөлтэй газарт согтуу хүнд согтууруулах ундаагаар үйлчлэх, эсвэл согтуу хүнийг оруулахыг хуриглоно. Согтуу гэдгийг өөртөө болон бусдад аюул учруулахуйц хүртэл түвшинд согтууруулах ундаа уусаныг хэлнэ. Хэрэв хууль зөрчсөн бол тухайн газрын эзэмшигчийн анхны үйлдэлд нь 3.000 евро, дараа дараагийн үйлдэлд 5.000 еврогийн

торгууль ногдуулна. Мөн 18 нас хүрээгүй этгээд согтууруулах ундаа зарах зөвшөөрөлтэй газар удаан хугацаагаар байхыг зөвшөөрөхгүй бөгөөд хэрэв ийм тохиолдолд гарвал тухайн газрын зөвшөөрлийг хураах хүртэл арга хэмжээ авна.

Тусгай зөвшөөрөлгүй газар. Тусгай зөвшөөрөл аваагүй бол тухай газар нь согтууруулах ундааг Даваа-Баасан гаригуудад 10.30-22.00, амралтын өдрүүдэд 12.30-22.00 цагийн хооронд зарна.

Тусгай зөвшөөрөл аваагүй газарт 18 нас хүрээгүй этгээд эцэг, эх, халамжлан хүмүүжүүлэгчгүйгээр байхыг хориглох бөгөөд эдгээр газарт үүнийг хориглосон тухай тэмдэгийг үргэлж, ил харагдахуйц газар заавал тавьсан байх ёстой. 18 нас хүрээгүй этгээд хууль зөрчвөл анхны үйлдэлд 25.40 евро, дараа дараагийн үйлдэлд 63.50 еврогийн торгууль ногдуулна. Хэрэв тухайн газрын эзэмшигч нь буруутай бол 381 евро, дараа дараагийн үйлдэлд 635 еврогийн торгууль төлнө.

Тойргийн шүүх дээрхи зөрчлийг гаргасан байгууллагыг түр хугацаагаар хаах хүртэл арга хэмжээг авна. Энэ арга хэмжээг торгуулиас гадна авч болно. Түр хугацаагаар хаах арга хэмжээ нь анхны үйлдэлд нь 2 хоногоос багагүй, 7 хоногоос ихгүйгээр тогтоох бол дараа дараагийн үйлдэлд нь 30 хоногоос ихгүй тогтооно.

Архидалтай тэмцэх арга хэмжээ

Ирландад **Архины эсрэг үйл ажиллагаа** гэсэн үндэсний хэмжээний тусламжийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг байна. Тус байгууллага нь иргэдэд архи, согтууруулах ундаатай холбоотой мэдээ, мээдээлэлээр хангах, түүний хор уршгийг танин мэдүүлэх болон шийдвэр гаргачидад бодлогын баримт бичиг, зөвлөмж гаргахад нь туслалцаа үзүүлдэг байна. Архи, согтууруулах ундааны хор уршиг нь тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлж байгаа бөгөөд дараах байдлаар илэрч байна гэж үзжээ:

- өвчлөлт бий болох, нэмэгдэх,
- аваар осол гарах,
- ашиг орлого буурах,
- ядуурлын үзүүлэлт болон ажлын байран дахь бүтээмж буурах,
- архи, согтууруулах ундаанаас болж ажилдаа ирэхгүй байх,

Архи, согтууруулах ундаанаас үүдэх хор уршгийг арилгах нийгэм, эрүүл мэндийн зардал үлэмж их болж байгаа бөгөөд 2003 оны байдлаар 2.6 тэрбум еврод хүрсэн, архи, согтууруулах ундаанаас болж ажилдаа ирээгүйгээс болж 1 тэрбумаас дээш еврогийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл тасарсан байна. Үүнээс гадна айл өрхөд учирсан хохирлыг тооцоох аргагүй юм.

Ирландад **Архи, согтууруулах ундааг буруу хэрэглэхтэй тэмцэх үндэсний стратеги бодлогыг** 2009-2016 оны хооронд хэрэгжүүлэхээр баталсан байна. Судалгааны үндсэн дээр боловсруулсан бүх талыг хамарсан бодлогыг хэрэгжүүлэх нь үр дүнтэй бөгөөд үүнд дараах гол бодлогыг хамруулсан:

- 1) Архи, согтууруулах ундааг худалдаалах бодлого,
- 2) Архи, согтууруулах ундааг уухыг багасгах бодлого,
- 3) Богино зөвлөгөө болон архинд донтох эмгэгийг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулах.

Мөн архи, согтууруулах ундааны худалдаа, зар сурталчилгаанаас хамаарч өсвөр насныхан үүнд ууруу татагдах боломж нь нэмэгддэг гэдгийг судалгаагаар батлагдсан тул хуулиар хязгаарлаж зохицуулсан байна.

4.3. ДЭМБ-ын Номхон далайн бүс нутгийн салбар

ДЭМБ-ын Номхон далайн орнуудын баруун бүсийн архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэх хор уршгийг бууруулах стратегийг 2006 оны 9-р сард боловсруулан баталсан байна. Уг стратегийн үндсэн зорилго нь архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах явдал бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн байна:

- Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэх эрсдэлийг бууруулах,
- Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний нөлөөг багасгах,
- Архи, согтууруулах ундааны хэрэглээг хууль эрх зүйн орчиноор зохицуулах,
- Стратегийн хэрэгжилтийг дэмжих, тогтвортой байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх.

4.4 Шинэ Зеланд

Шинэ Зеланд нь “Согтууруулах ундаа худалдах тухай хууль”-ийг 1989 оны 8-р сарын 17-нд батлан 1990 оны 4-р сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Архи, согтууруулах ундааны худалдаа

Согтууруулах ундааг олон нийтэд худалдах буюу нийлүүлэхэд шаардлагатай согтууруулах ундааны зөвшөөрлийг энэхүү хуульд заасны дагуу олгох бөгөөд согтууруулах ундааны 4 төрлийн зөвшөөрөл байдаг. Үүнд:

1. **Согтууруулах ундааг зарах зөвшөөрөл** (off licence) - согтууруулах ундаа худалдах, гэхдээ үйлчлэхгүй. Жишээ нь: архи виноны дэлгүүр, супермаркет.
2. **Согтууруулах ундаагаар шууд үйлчлэх, худалдах патент** (on licence) - согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл. Жишээ нь: зочид буудал, ресторан, шөнийн клуб.
3. **Клуб Зөвшөөрөл** (club licence) - Клубд хамрагдах. Жишээ нь: нийгмийн клуб, спорт клуб гэх мэт.
4. **Тусгай зөвшөөрөл** (special licence) - Үйл ажиллагаа явуулах ба арга хэмжээ зохион байгуулах газарт согтууруулах ундаа зарах. Жишээ нь: үзэсгэлэн, үзүүлбэр, хандивийн тоглолт гэх мэт.

Согтууруулах ундаа зарах зөвшөөрлийн хугацаа:

Бүх согтууруулах ундааг зарах зөвшөөрлийн хугацаа нь зөвшөөрөл гарснаасаа хойш 1 жил хүчинтэй байх ба хэрэв согтууруулах ундааг зарах зөвшөөрлийн хугацааг сунгах өргөдлийг зохих ёсоор гаргасан бол, өргөдөлд тогтоосон хугацаа хүртэл хүчинтэй байна.

Auckland хотод согтууруулах ундааны зөвшөөрлийг олгохдоо: Согтууруулах ундааны зөвшөөрлийг Веллингтоны согтууруулах ундааны зөвшөөрлийн захиргааны байгууллага (Liquor Licensing Authority in Wellington)-аас олгоно. Auckland хотын зөвлөл нь захиргааны байгууллагын агент юм.

Хүснэгт 4.1 Auckland хотын согтууруулах ундааны зөвшөөрлийн төрөл, хувь хэмжээ

Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн төлбөр	Зөвшөөрлийг сунгах төлбөр	Хүчинтэй хугацаа	Төлбөрийн нөхцөл
-------------------	--------------------	---------------------------	------------------	------------------

Согтууруулах ундааг зарах зөвшөөрөл	\$793.24	\$793.24 Сунгахад эхлээд 1 жилийн дараа сунгах ба үүний дараа 3 жил тутам	1 жил	Өргөдөл гаргах үед төлбөрийг төлөх ба төлсөн төлбөрийг буцаан олгохгүй.
Согтууруулах ундаагаар шууд үйлчлэх, худалдах патент	\$793.24	\$793.24 Сунгахад эхлээд 1 жилийн дараа сунгах ба үүний дараа 3 жил тутам	1 жил	Өргөдөл гаргах үед төлбөрийг төлөх ба төлсөн төлбөрийг буцаан олгохгүй.
Клуб Зөвшөөрөл	\$793.24	\$793.24 Сунгахад эхлээд 1 жилийн дараа сунгах ба үүний дараа 3 жил тутам	1 жил	Өргөдөл гаргах үед төлбөрийг төлөх ба төлсөн төлбөрийг буцаан олгохгүй
Тусгай зөвшөөрөл	\$64.40	Тухайн үйл ажиллагаа ба арга хэмжээний хугацаанд газарт согтууруулах ундаа зарах.		Өргөдөл гаргах үед төлбөрийг төлөх ба төлсөн төлбөрийг буцаан олгохгүй

Мөн тус улс нь 1976 онд Архины зөвлөлийн байгуулсан. Тус зөвлөлийн жилийн төсөв нь 12.7 сая шинэ зеланд доллар бөгөөд санхүүгийн эх үүсвэр нь архины онцгой албан татвар юм. Архины онцгой албан татвар нь 1 л тутамд 1.37-44.74 цент байдаг. Сүүлийн жилүүдэд дараах үндсэн ажлыг хэрэгжүүлсэн байна:

- Архи худалдаалах насыг 18 нас байсныг 20 болгосон (2002),
- Согтууруулах ундааны эрэгтэй, эмэгтэй хүний зохистой хэрэглээний хэмжээг боловсруулсан (2002),
- Олон нийтийн газар архины хэрэглээг зохицуулах бодлого боловсруулсан (2004),
- Архинд донтох эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх бодлого (2004).

1.5 БНХАУ

Хятад улс нь согтууруулах ундааны зөвшөөрлийг “БНХАУ-ын захиргааны зөвшөөрлийн тухай хууль”-аар зохицуулах бөгөөд энэ хууль нь 2003 оны 8-р сарын 27-ны өдөр БНХАУ-ын 10 дахь удаагийн Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны 4 дэх чуулганаар баталж, 2004 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

Согтууруулах ундааны зөвшөөрлийг олгохдоо тухайн шатны Захиргааны байгууллага нь хууль, захиргааны тогтоосон журмын дагуу, хуульд заасан төрөл, стандартын хэмжээгээр төлбөрийг төлнө.

Хүснэгт 4.2 **Хятад Улсын согтууруулах ундааны зөвшөөрлийн төрөл, хувь хэмжээ**

Хот, муж Хууль, эрх зүйн зохицуулалт	Зөвшөөрлийн төрөл	Төлбөр RMB Г	Тавигдах шаардлага
--	-------------------	-----------------	--------------------

Guang dong муж “Guang dong мужын эдийн засаг худалдааны байнгын хорооны согтууруулах ундааны үйлдвэрлэх зөвшөөрлийн тогтоол”	Согтууруулах ундааны үйлдвэрлэх зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 1000000–аас дээш	Үйлвэрийн талбайн хэмжээ 500 метр кв-аас багагүй
	Согтууруулах ундааны бөөний худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 500000–аас дээш	Агуулахын талбайн хэмжээ 80 метр кв-аас багагүй, үйлчилгээ явуулах талбайн хэмжээ 50 метр кв-аас их
	Согтууруулах ундааны жижиглэнгийн худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 100,000–аас дээш	Үйлчилгээ явуулах талбайн хэмжээ 20 метр кв-аас их
Si chuan муж “Si chuan мужын согтууруулах ундаа удирдах тогтоол”	Согтууруулах ундааны бөөний худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 300,000-аас доошгүй	Үйлчилгээ явуулах талбайн хэмжээ 40 метр кв-аас их, Агуулахын талбайн хэмжээ 100 метр кв-аас багагүй,
	Импортын Согтууруулах ундааны бөөний худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 1000,000-аас доошгүй	
	Импортын Согтууруулах ундааны жижиглэнгийн худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 500,000-аас доошгүй	
Shang hai хот “Shang hai хотын согтууруулах ундааны үйлдвэрлэх, худалдах тогтоол”	Согтууруулах ундааны бөөний ба жижиглэнгийн худалдааны зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 500,000-аас доошгүй	Үйлчилгээ явуулах талбайн хэмжээ 50 метр кв-аас их, Агуулахын талбайн хэмжээ 80 метр кв-аас багагүй,
	Импортын Согтууруулах ундааны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 500,000 –аас дээш	
Guang zhou муж “Guang zhou мужын согтууруулах үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл”	Guang zhou мужын Согтууруулах үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл	Бүртгэлийн хураамж 100,000 –аас дээш	Үйлчилгээ явуулах талбайн хэмжээ 20 метр кв-аас их

* * *

Тав. Хатуулаг өндөртэй архины татварыг нэмэх байдлаар өндөр үнэтэй болгох, хатуулаг багатай архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлийг дэмжих талаар авсан бодлогын арга хэмжээ

5.1. Архины татварын өнөөгийн байдал

Манай улс архи, тамхины хэрэглээг хязгаарлах тодорхой арга хэмжээ авсаар ирсэн ба 1923 оноос эхлэн архи, тамхи, шүдэнз зэрэг бараанд онцгой албан татварыг ногдуулж ирсэн. Энэ нь согтууруулах ундаа болон тамхины борлуулалтын орлогод 4 хувиар ногдуулж байжээ. 1992 оноос эхлэн татварын багц хуулийг батлан мөрдүүлэх явцад зах зээлийн нөхцөлд нийцсэн Онцгой албан татварын хуулийг 1993 оноос батлан мөрдүүлж эхэлсэн билээ. Төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгын зэрэгцээгээр согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах, зарим төрлийн үйлдвэрлэлийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор онцгой албан татварыг хэрэглэж байна.

Монгол Улсын Их Хурлаас Онцгой албан татварын тухай хуулийг 2006 оны 06 сарын 29-ны өдөр шинэчилсэн найруулга хийн 2007 оны 01 сарын 01 өдрөөс дагаж мөрдөхөөр

баталсан юм. Шинээр батлагдсан Онцгой албан татварын хууль нь согтууруулах ундаанд ногдох албан татварыг тухайн бүтээгдэхүүний үнэнд ногдуулдаг байсныг биет хэмжээнд ногдуулдаг болгон өөрчлөөд байна.

Татварын албанд хийгддэг судалгаанаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд 2010 оны байдлаар бүх төрлийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 103 аж ахуйн нэгжийн 128 үйлдвэр нийт 250 нэр төрлийн согтууруулах ундаа үйлдвэрлэн борлуулж байна. Харин үүн дотор архи, спиртийн үйлдвэр нь 80 гаруй хувийг эзэлж байгаа юм. 2010 оны арваннэгдүгээр сарын байдлаар Монгол Улсад 18,5 сая литр архи, 40,5 сая литр шар айраг үйлдвэрлэсэн нь 2009 оны мөн үетэй харьцуулахад архи 19.4, шар айраг 65,6 хувиар өссөн байна.

Энэхүү үйлдвэрлэсэн архи, шар айргийг манай орны эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулж үзвэл нэг хүнд архи 15.4 литр, шар айраг 33.6 литр болж байна. Энэ тоонд импортоор оруулж ирж байгаа согтууруулах ундааны тоог хамааруулаагүй болно.

Татварын албаны зүгээс согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулалтанд тавих хяналтыг сайжруулах үүднээс дэлхийн олон оронд хэрэглэгддэг “Үйлдвэрлэлийн шугамуудыг үндэсний хэмжээнд ил тод болгох” шийдлийг хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна. нууцлалтай будгийн тусламжтайгаар тэмдэглэгээ хийж түүнийгээ мэдээллийн санд нэгтгэн, улмаар онцгой татварт ногдох бүтээгдэхүүнийг бүртгэснээр тухайн бүтээгдэхүүний хөдөлгөөний бүрэн мэдээллийг бий болгох нь тус шийдлийн үндсэн зарчим юм. Нөгөө талаас хатуулаг багатай согтууруулах ундааны үйлдвэрлэлийг дэмжих үүднээс хатуулаг багатай согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын хэмжээг багасгах, хатуулаг ихтэй согтууруулах ундаанд ногдуулж буй онцгой албан татварын хэмжээг ихэсгэх бодлого баримталж болох юм.

5.2. Олон улсын туршлага

Хүн төрөлхтөн олон зуун жилийн тэртэйгээс цангаа тайлах үүднээс дарс болон шар айргийг хэрэглэж иржээ. Учир нь түүхий усыг олон төрлийн өвчин дамжуулах аюултай гэж үздэг байв. Түүнчлэн бага хэмжээнд иссэн шингэн хүний бие организмд байх ёстой усны балансыг хангаж байхаас гадна хэрэгцээт амин дэмийг бас нөхөж чаддаг байжээ. Харин манай эриний 12 дугаар зуунаас иссэн бүтээгдэхүүнээс этанолыг нэрэх замаар гаргаж авдаг Дорно зүгээс гаралтай технологи дэлхий дахинд нэвтэрснээр согтууруулах ундааны хатуулаг хэд дахин нэмэгдэж архийг хэтрүүлэн хэрэглэх процесс анх эхэлсэн гэж үздэг байна.

Архины зохисгүй хэрэглээтэй тэмцэх олон төрлийн хяналтын аргуудыг дэлхийн улс орнууд хөгжлийнхөө туршид авч хэрэгжүүлж ирснийг үндсэнд нь эдийн засгийн, албан болон албан бус хяналт гэж гурав ангилж болохоор байна.

Эдийн засгийн хяналт гэж архины үнээр дамжуулан хяналт тогтоохыг, албан ёсны хяналт гэж тухайн улсад тусгайлан баталсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд тавих хяналтыг, албан бус хяналт гэж тухайн нийгэмд архитай холбогдолтой тогтсон зан заншил, уламжлал, уух архины хэмжээний дээд хязгаарыг тогтоох, архи уух насны доод ангилалыг тогтоосон дэг журам, зүйр цэцэн үгс зэргийг хамруулан ойлгож болох юм.

Дэлхийн зарим орнуудад архидан согтуурахтай эдийн засгийн аргаар хэрхэн тэмцдэг тухай зарим товч дурдвал:

Франц

19 дүгээр зууны эхэнд Франц улс нэг хүнд жилд 20 гаруй литр цэвэр спирттэй тэнцэх хэмжээний согтууруулах ундаа хэрэглэдэг байв. Гэхдээ францчуудын хувьд хөнгөн төрлийн дарс хэрэглэдэг байсан учир согтууруулах ундаанаас болж нас барагсадын тоо харьцангуй цөөн байжээ. Тухайлбал жилд 11 хүн архианаас болон нас бардаг байсан бол нэг хүнд ногдох цэвэр спиртийн хэмжээгээрээ тус улсаас 7 дахин бага цэвэр спиртийн хэмжээтэй тэнцэх архи, согтууруулдаг ундаа хэрэглэдэг Хаант Орос улсад жилд 55 хүн дээрхи шалтгаанаас болж нас барж байв.

1960 онд Франц улсын нэг хүнд жилд ногдох цэвэр спиртны хэмжээ 20 литр болох үед тус улсын ерөнхийлөгч Шарль Де Голь хэд хэдэн эрх зүйн актуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал, архи тамхины үнийг байнга нэмэх бодлого, Луи Эвины “Согтууруулах ундааны сурталчилгааг хориглох тухай хууль” зэргийг дурдаж болно. Үүнээс хойш сүүлийн 40 гаруй жилд францчуудын согтууруулах ундааны хэрэглээ тогтмол буурсаар байна. Тухайлбал, 1960 онд 20 литрийг хэрэглэдэг байсан бол 2001 онд 15,1 литр цэвэр спирттэй тэнцэх хэмжээнд хүрч 38 хувиар буурсан байна. 2009 онд Францын Засгийн газар согтууруулах ундаа худалдах насны доод хэмжээг 16 байсныг 18 болгон өсгөсөн байна.

• ИБУИНВУ /Их Британи/

Их британид согтууруулах ундааны зах зээлийг Засгийн газар монопольчлоггүй учир тус улсын томоохон компаниуд зоогийн газар, согтууруулах ундааны үйлдвэрүүд, усан үзмийн тариалан эзэмшдэг байна. Засгийн газрын зүгээс тэдэнд нөлөөлөх ганц арга нь лиценз юм. Тухайлбал, 2005 оноос Их британид лиценз олгох журамд согтууруулах ундаа хэрэглэсний улмаас нийгмийн хэм журмын зөрчил их гаргадаг уушийн газруудын удирдлагад эхлээд сануулах арга хэмжээ аван, дутагдал дахин гарсан тохиолдолд цагдаагийн эргүүлийн зардлыг нөхөн төлүүлэх нэмэлт орсон байна. Одоо Их британийн Засгийн газар насанд хүрээгүйчүүдэд согтууруулах ундаа худалдах явдалд тавих хяналтыг чангатгах тухай хуулийн төслийг хэлэлцэж байна.

ХБНГУ

ХБНГУ-д согтууруулах ундааны борлуулалт, үйлдвэрлэлтийг Засгийн газар монопольчлоогүй, харин согтууруулах ундааны хэрэглээг бууруулах бүхий л санаачлагыг Засгийн газар бус улс төрийн намууд гаргадаг байна. Германы уламжлалын нам болон ногоон намын төлөөлөгчид насанд хүрээгүйчүүдэд согтууруулах ундаа худалдаалахгүй байх талаар санаачлага гаргаж байна. Тус улсад архидан согтуурахтай тэмцэх олон аргуудаас нэгэн сонирхолтой байж болох аргыг дурдвал, хэрэв герман ажилчин хүн нэг байгууллагад 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаад архинд донтох өвчтэй болсон нь тогтоогдвол тус байгууллага түүний эмчилгээний зардлыг бүрэн хариуцдаг байна.

ОХУ

2009 оны байдлаар ОХУ-д 2,7 сая бүртгэлтэй архинд донтох өвчтэй хүмүүс байна гэсэн судалгаа гарчээ. Архинд донтох өвчтэй хүмүүсийн ихэнх нь хөдөлмөр эрхлэх насны эрэгтэй хүмүүс байгаа нь түгшүүр зарлахад хүргээд байна. Тус улсад “АНУ-д 1949 оноос хойш хэрэглэгдэж үр дүнгээ өгч байгаа архинд донтох өвчтэй хүнийг албан байгууллага дээрээ илрүүлэн эмчлэх аргыг нэвтрүүлэх нь зүйтэй” гэж ОХУ-ын Эрүүл мэнд нийгмийн хөгжлийн яамны ерөнхий наркологч Евгений Брюн үзэж байна. Түүнчлэн түүний үзэж байгаагаар Засгийн газар согтууруулах ундааны нэгж хатуулгын үнийг тогтоох явдал маш чухал бөгөөд ингэснээр согтууруулах ундаа хэдий чинээ өндөр хатуулагтай байна төдий чинээ өндөр үнэтэй байх юм.

Эдийн засгийн онолд бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах мэдрэмж үнийн өсөлт, бууралтаас шууд хамаардаг гэж үздэг байна. Ихэнх бараа, бүтээгдэхүүний мэдрэмж сөрөг утгатай байдаг. Өөрөөр хэлбэл үнэ бага байх тусам худалдан авах тоо хэмжээ их байна.

Харин Пенсильваний Их Сургуулийн судлаач Жон Нельсоны судалгааг үндэслэн үзэхэд АНУ-д 1978 оноос согтууруулах ундааны үнэ тогтмол буурсаар ирсэн байна. Энэ нь дээр дурьдсан онолыг үгүйсгэж байгаа мэт харагдаж байгаа боловч нөгөө талаар хүний амьдрах орчин, хэдийн чинээ баталгаатай байна тэр хирээр согтууруулах ундааны хэрэглээ буурч байгаа нь эдийн засагчдын судалгаагаар нотлогдсон байна.

Москва хотын дарга Юрий Лужков Оросын нийслэлд согтоох чадвар ихтэй архийг худалдаалах журмыг чангатгах тухай захирамжид гарын үсэг зуржээ. Уг захирамжаар 15 градусаас дээш этилийн спиртийн агууламж бүхий архи, коньяк болон бусад төрлийн согтууруулах ундааг 2010 оны 9-р сарын 1-нээс эхлэн үдшийн 20.00 цагаас өглөөний 10.00 цаг хүртэл худалдахгүй юм байна. Захирамжийг зөрчсөн тохиолдолд дэлгүүрүүдийн лицензийг хураах ажээ. Уг хориг ресторан, нийтийн хоолны бусад газар болон шар айргийн худалдаа, алкоголь багатай коктейлийн худалдаанд хамаарахгүй юм байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч Дмитрий Медведев 2010 оны 8-р сард Сочи дэх өргөөндөө Орос улсад согтууруулах ундааны хэрэглээг багасгах арга хэмжээний талаар зөвлөлгөөн хийжээ. Тэрбээр мөн өнгөрсөн зургадугаар сарын сүүлчээр Эрүүлийг хамгаалах, нийгмийн хөгжлийн сайд Татьяна Голиковатай уулзахдаа архидан согтуурах хийгээд бусад хортой зуршлын эсрэг тэмцэх хөтөлбөр боловсруулахын чухлыг онцлон тэмдэглэж байжээ. Левадын төвөөс 2010 онд явуулсан санал асуулгаас үзвэл Оросын иргэдийн дөрөвний гурав нь архи шөнийн цагаар худалдаалахыг хориглосон шийдвэрийг дэмжсэн байна. Түүнийг эсэргүүцэгчид архи байнга юм уу нэлээд ихээр уудаг хүмүүс байжээ.

Оросын ерөнхий наркологич Евгений Брюн 2010 оны 7-р сард хэвлэлийн хурал хийлгэж, “Хүмүүсийг өглөөнөөс эхлэн согтууруулахгүйн тулд” өдрийн 14.00 цагаас үдшийн 21.00 цаг хүртэл хатуулаг ихтэй архи худалдаалахыг хязгаарлахыг уриалжээ. Москва орчимд нийслэлийнхээс илүү хатуу хязгаарлалт тогтоод буй ажээ. Тухайлбал 2010 оны тавдугаар сарын 10-аас эхэлж дэлгүүрт үдшийн 21.00-с өглөөний 11.00 цаг хүртэл архи худалдаалахыг зогсоосон байна. СанктПетербург, Ульяновск, Нижегород, Ростов муж болон БН Коми улс, Байгалийн чанадад цагийн зөрүүтэйгээр мөн ийм арга хэмжээ аваад байна. Чеченьд өдөрт хоёр удаа, өглөөний наймаас өдрийн арван цагийн хооронд л согтууруулах ундаа худалдаалахыг зөвшөөрсөн бол Дагестаны хүн ам оршин суудаг зарим газарт орон нутгийн жамаат (өөрийн удирдлагын албан бус байгууллага) согтууруулах ундаа худалдаалахыг бүрмөсөн хоригложээ.

ОХУ-ын Эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн яамны мэдээнээс үзвэл тус улсын дунд зэргийн амьдралтай нэг иргэн жилдээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон дээд хэмжээнээс дөрөв дахин их буюу 18 литр цэвэр спирт хэрэглэдэг байна. Орос улс энэ үзүүлэлтээрээ дэлхийд 18 дугаарт ордог байна. Архи гээч угтаа Оросын бүтээл биш юм. Түүхийн баримтаас үзвэл архийг XIV зуунд Германд бодож олж, түүнээс хойш ойролцоогоор зуун жилийн дараа Орост орж иржээ. Хаант засгийн үед, дараа нь императорын Засгийн газар зан суртахуун хийгээд улсын төсөв, санхүү хоёрыг тэнцвэржүүлэх үүднээс архийг үйлдвэрлэж, худалдаалахыг заримдаа хязгаарлаж, бас хөхиүлэн дэмжиж байжээ. XIX зууны үед тус улсад эрүүлжихийн төлөө олон нийтийн хүчтэй хөдөлгөөн хүртэл гарч байсан байна.

1914 онд Хоёрдугаар Ни колай хаан дэлхийн дайн дуустал Орост архийг бүрмөсөн хориглож байжээ. Большевик үүд засгийн эрхэнд орсныхоо дараа уг арга хэмжээний хугацааг сунгаж байжээ. 1923 оны наймдугаар сарын 26 -нд Төсвийн гүйцэтгэх хороо, Ардын комиссариудын газар ЗСБНХУ-д архины үйлдвэрлэл, спиртийн ундаа худалдаалахыг дахин сэргээх тогтоол гаргаж, дэлгүүрүүдэд тухайн Засгийн газрын тэргүүн Алексей Рыковын нэрээр нэрлэсэн “Рыковк” нэртэй хямд үнэтэй архи гарч эхэлсэн байна. Иосиф Сталин архины орлогогүйгээр хүнд үйлдвэрийг хөл дээр нь босгох арга байхгүй, тиймээс ичих хэрэггүй гэж нэг бус удаа цохон тэмдэглэж байжээ.

Орост 1958-1972 онд спиртийн худалдааг хязгаарлах үүднээс согтууралтай тэмцэх тухай тогтоол хоёр ч удаа гаргажээ. 1985 оны тавдугаар сард ЗСБНХУ-ын түүхэнд хамгийн өргөн цар хүрээтэй архидан согтуурахын эсрэг кампани эхэлсэн боловч хоёр жилийн үйл ажиллагаа нь суларсан байна.

Зургаа. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга болон төрийн байгууллагуудаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалт

2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн хүрээнд төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас үзүүлэх үйлчилгээнд дараахь төрлийн тэмдэгтийн хураамжийг авахаар заасан байна. Үүнд:

- Төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас зүгээс **үйлчилгээ үзүүлэхэд** хураах хураамж;
- Улсын бүртгэлийн бүртгэлд **бүртгэлийн үйлчилгээ** үзүүлэхд хураах хураамжийн хэмжээ;
- Төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас зүгээс **зөвшөөрөл олгоход** хураах хураамж;
- Төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас **тусгай зөвшөөрөл олгоход** хураах хураамжийн хэмжээ;
- Төрийн захиргааны байгууллагаас **эрх олгоход** хураах хураамж;
- Төрийн захиргааны байгууллагаас хураах **төлбөрийн хэмжээ** зэрэг байна.

- 1993 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар 5 тусгай зөвшөөрөл / Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-аар 91 төрлийн тусгай зөвшөөрлийг олгож байсан бол 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн хірээнд нийт 151 төрлийн тусгай зөвшөөрөл, 122 төрлийн зөвшөөрөл олгохоор хуульчилсан байна.
- Эдгээрээс 143 төрлийн тусгай зөвшөөрөл, 103 төрлийн зөвшөөрөл нь төрийн захиргааны байгууллагаас, 8 төрлийн тусгай зөвшөөрөл, 19 төрлийн зөвшөөрлийг аймаг, Нийслэлийн Засаг даргаас олгож байна.

Энэхүү хуулийн хүрээнд зөвхөн тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөл олгож байгаа байдлыг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр гаргалаа.

Хүснэгт 6.1

Төрийн захиргааны байгууллага болон Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалт

1/ Банкны үйл ажиллагааны чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ ⁸ Төгрөгөөр
1	банк байгуулах тусгай зөвшөөрөл	1 200 000
2	мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000

3	зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	750 000
4	төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	45 000
5	өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах тусгай зөвшөөрөл	185 000
6	гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл	175 000
7	үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл	250 000
8	үнэт зүйл хадгалах тусгай зөвшөөрөл	250 000
9	гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл	450 000
10	үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл	120 000
11	санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	450 000
12	зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл	120 000
13	хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	130 000

2/ Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ ⁹ Төгрөгөөр
1	арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1 000 000
2	давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1 000 000
3	даатгагчид өөрийн салбар төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	280 000
4	даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл	45 000
5	даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл	65 000
6	даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл	85 000
7	зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	300 000
8	факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	250 000
9	хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	200 000
10	төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	1 000 000
11	төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000

12	цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
13	гадаад валютын үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	2 000 000
14	итгэлцлийн үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
15	богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
16	үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
17	үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тусгай зөвшөөрөл	100 000
18	үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл	150 000
19	андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл	145 000
20	хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	280 000
21	банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
22	компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл	олгоход 100 000
23	хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл	олгоход 100 000
24	барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	олгоход 100 000
25	хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	олгоход 100 000

3/ Санхүү, эдийн засгийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	5 000 000
2	аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
3	үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	5 500 000
4	эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл	600 000

5	хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл	240 000
6	гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	850 000
7	гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	4 500 000

4/ Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	50 000
2	өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	100 000
3	нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	10 000
4	Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /"Төрийн мэдээлэл"-ээс бусад/ хэвлэх тусгай зөвшөөрөл олгоход хэвлэх эх материалын	хуудас тутамд 400
5	төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	2 150 000
6	тамга, тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	2 200 000

5/ Байгаль орчны чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ
1	байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	8 000 000
2	стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах тусгай зөвшөөрөл	26 000 000
3	химийн хортой болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах тусгай зөвшөөрөл	75 000 000
4	тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	50 000 000
5	байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл	500 000
6	озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл	5 000 000

6/ Түлш эрчим хүчний чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл:

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих этгээдэд эрчим хүчний барилга, байгууламж барих зөвшөөрөл	1кВт тутамд 3 000
2	сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	300 000
3	бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл	75 000
4	бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл	60 000

7/ Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000

8/ Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл	3 250 000
2	тамхи импортлох тусгай зөвшөөрлийг олгох,	олгох болон сунгах 14 000 000
3	а.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл	50 000 000
4	б.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	100 000 000
5	в.газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	5 000 000

9/ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	7 500 000
2	тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн	хугацаа сунгахад 4 500 000

3	спирт үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	200 000 000
4	спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн	хугацаа сунгахад 100 000 000
5	спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад	50 000 000
6	малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл	600 000
7	малын өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
8	ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл	20 000
9	шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан мал, амьтны эм, үр, үр хөврөлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах, энэ хуулийн 26.2-т зааснаас бусад үржлийн мал, амьтныг гадаадад гаргах тусгай зөвшөөрөл	500 000
10	улсын болон бүс нутгийн хэмжээнд мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	2 000 000
11	ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	20 000

10/ Эрүүл мэндийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез, ортопед үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл	110 000
2	мансууруулах үйлчилгээ бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис тэдгээрийн угтвар бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	12 000 000
3	мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх	тусгай зөвшөөрөл 6 600 000 хугацааг сунгахад 1 500 000
4	гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эмчилгээний гоо заслын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	10 000 000

5	Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	50 000
---	--	--------

11/ Барилга, хот байгуулалтын чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл	500 000
2	барилгын ажил гүйцэтгэх, барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	2 500 000
3	барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл	100 000
4	өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл	350 000
5	цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	2 000 000
6	нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	1 000 000

12/ Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	төмөр замын суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл	5 000 000
2	төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах засварлах тусгай зөвшөөрөл	5 000 000
3	төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	16 000 000
4	авто зам, авто замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл	3 000 000
5	автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл	280 000
6	улс хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	4 000 000
7	хот хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	100 000
8	иргэний агаарын хөлгийг Монгол Улсад бүтээх, түүнд өөрчлөлт, сайжруулалт хийх тусгай зөвшөөрөл	2 578 000
9	усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000

10	усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	700 000
11	дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	4 000 000
12	тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	1 450 000

13/ Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	мэдээлэл холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
2	мэдээлэл холбооны бүсийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
3	мэдээлэл холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
4	мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	2 250 000
5	үүрэн холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	2 250 000
6	радио, телевизийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
7	шуудан холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
8	шуудан холбооны бүсийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
9	шуудан холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад	1 250 000
10	улс хоорондын шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад;	1 250 000
11	радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход	125 000
12	улс хоорондын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	1 500 000
13	бүсийн телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	1 000 000
14	хотын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	800 000
15	хот хоорондын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	600 000
16	үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	2 200 000
17	утасгүй телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд /WLL8 PHS гэх мэт/	2 100 000
18	телевизийн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэхэд	1 500 000
19	кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэхэд /CATV MMDS гэх мэт/	2 000 000
20	радио өргөн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэхэд	100 000
21	интернет телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд	1 250 000

22	улс хоорондын суваг, шугам түрээслүүлэх үйлчилгээ эрхлэхэд	2 500 000
23	улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд	120 000
24	шуудангийн үндсэн үйлчилгээ эрхлэхэд	80 000
25	шуудангийн нэмэлт үйлчилгээ эрхлэхэд	70 000
26	улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээг чиглэсэн маршрутаар эрхлэхэд	75 000
27	сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэхэд	180 000
28	улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд;	120 000
29	интернетийн үйлчилгээг дахин дамжуулан хүргэхэд	250 000
30	дотоод хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэхэд	250 000
31	Интернетийн үйлчилгээ эрхлэхэд	300 000

* * *

13/ Цацраг идэвхит ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр олгох тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах тусгай зөвшөөрөл олгоход	25 000 000
2	цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл олгоход	80 000 000
3	цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл олгоход	8 500 000
4	цацраг идэвхт ашигт малтмал экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх тусгай зөвшөөрөл олгоход	250 000 000
5	цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход	5 000 000
6	цацраг идэвхт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход	15 000 000
7	цацраг идэвхт ашигт малтмал ашиглах, ашигт малтмалын боловсруулалтын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход	20 000 000
8	цацраг идэвхт ашигт малтмалыг импортлохтой холбоотой тусгай зөвшөөрөл олгоход	25 000 000г

9	Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:
---	--

Цацрагын үүсгүүр	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Суманд
Ангилал 1-ийн үүсгүүр	350 000	550 000	650 000
Ангилал 2-ын үүсгүүр	300 000	500 000	600 000
Ангилал 3-ын үүсгүүр	250 000	450 000	550 000
Ангилал 4-ийн үүсгүүр	200 000	400 000	500 000
Ангилал 5-ын үүсгүүр	150 000	350 000	450 000
Рентген тоног төхөөрөмж	100 000	300 000	400 000

14/ Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга	250 000
2	гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс бусад этгээдэд эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга	500 000
3	агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл	500 000
4	суманд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	20 000
5	тамхи худалдах тусгай зөвшөөрөл	250 000

6	спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл	10 000 000
7	спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл	300 000
8	согтууруулах ундаагаар шөнийн 00 цаг хүртэл үйлчлэх тусгай зөвшөөрөл	20 000 000
9	Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл Хувийн хамгаалалтын тухай хуулийн 6.1-т заасан дагуу Аймаг, Нийслэлийн Цагдаагийн газар /хэлтэс/	Зөвшөөрөл олгоход 75000, Зөвшөөрлийн хугацааг сунгах бүрд 75000
10	Галт зэвсэг болон сумыг улсын хилээр оруулах, нийтэд худалдаалах тусгай зөвшөөрөл Галт зэвсгийн тухай хуулийн 12.1, 15 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулах комиссын шийдвэрээр Цагдаагийн төв байгууллага	<ul style="list-style-type: none"> - галт зэвсэг үйлдвэрлэх, нийтэд худалдах эрхийн тусгай зөвшөөрөл олгоход 750 000 төгрөг; - галт зэвсэг худалдах төв салбараас орон нутагт салбар байгуулах тусгай зөвшөөрөл олгоход салбар бүрт 240 000 төгрөг; - хуулийн этгээдэд нийтэд худалдах зориулалтаар галт зэвсэг болон сумыг улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгарсан этгээдэд олгоход 500 000 төгрөг.

6.2 “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулиар төрийн захиргааны болон аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй зөвшөөрлийн жагсаалт

1/ Банкны үйл ажиллагааны чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл	3 200 000
2	гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл	1 200 000

2/ Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд олгох зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	4 500 000
2	банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл	10 000
3	банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл	60 000

4	үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл	33 000
5	үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл	120 000

3/ Байгаль орчны чиглэлээр олгох зөвшөөрөл:

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	нэн ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл	кг тутамд 45 000
2	ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл	кг тутамд 25 000
3	ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл	кг тутамд 800
4	эрх бүхий байгууллагаас импортоор оруулах, экспортлохыг зөвшөөрсөн ургамалд үзлэг шалгалт хийж хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл	кг тутамд 150
5	ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тусгай хэрэгцээний мэдээллээр хангах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	30 000
6	100 шоометрээс дээш ус ашиглах зөвшөөрөл олгох, зөвшөөрөл	хугацааг сунгахад 200 000
7	аюултай хог хаягдлыг ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	3 785 000
8	аюултай хог хаягдлыг экспортлох зөвшөөрөл	1 500 000
9	иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай конвенцийн хавсралтад орсон ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, рэкспортлох буюу далай, тэнгисээс олборлон оруулах зөвшөөрөл, гэрчилгээ	ААН, байгууллагаас 1 850 000, иргэнээс 650 000
10	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын Амьтны аймгийн тухай хуулийн ¹⁰ 17.3-т заасан амьтны цуглуулгыг гадаадад гаргах зөвшөөрөл	750 000
11	хувиргасан амьд организм экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл	3 000 000

4/ Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр олгох зөвшөөрөл:

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах зөвшөөрөл	370 000

2	мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт эрхлэх зөвшөөрөл	400 000
3	магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрөл	200 000
4	дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах зөвшөөрөл	150 000
5	мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах зөвшөөрөл	400 000
6	мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах зөвшөөрөл	150 000
7	уран бүтээл, цуглуулгын зүйлс ба түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл	400 000
8	дээрхи зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад	200 000
9	Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл	465 000
10	улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл	65 000
11	түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагаа, судалгаа хийх зөвшөөрөл	460 000
12	хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл	85 000
13	төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, шаардлагатай бол хугацааг сунгахад	640 000
14	хувийн өмчид байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөгч өөрөө язгуур ахуйн хэрэглээний зориулалтаар улсын хил нэвтрүүлэх зөвшөөрөл	240 000
15	түүх, соёлын дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар гадаадад гаргах зөвшөөрөл	600 000

5/Түлш эрчим хүчний чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах зөвшөөрөл	1МВт тутамд 300 000

2	эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд	1 000 000
3	туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ хийх зөвшөөрөл	150 000
4	115 градусын температуртай 0.7-35.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	100 000
5	116 градусын температуртай 35.0-70.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	200 000
6	117 градусын температуртай 70.0-100.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	500 000
7	118 градусын температуртай 100.0 кгх/см кв-аас дээш даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	1 000 000
8	115-250 градусын температуртай 0.7-16.0 кг/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	100 000
9	250-350 градусын температуртай 16.0-40.0 кгх/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	200 000
10	350-450 градусын температуртай 80.0 кгх/см кв-аас дээш даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	500 000
11	450 градусаас дээш температуртай 40.0-80.0 кгх/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл	1 000 000
12	0.4/10 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл	100 000
13	15/35 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл	200 000
14	110 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл	1 000 000
15	220 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл	2 000 000
16	400 кВ-оос дээш тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамын зөвшөөрөл	5 000 000

6/ Нийгмийн халамжийн чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	зуучлах зөвшөөрлийг сунгахад	200 000
2	гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад зуучлах зөвшөөрөл	8 000 000
3	Засгийн газраас гадаадын иргэнд улсын онц чухал объект гэж тогтоосон газар ажиллах зөвшөөрөл	850 000

7/ Үйлдвэр, худалдааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	одон, медаль үйлдвэрлэх зөвшөөрөл	500 000
2	аж ахуйн нэгж, байгууллага хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдах зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас	50 000
6	тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас	тухай бүр 250 00
7	төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл	500 000
8	үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	200 000
9	үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл	2 000 000
10	таримал ургамлын үр үйлдвэрлэх зөвшөөрөл	125 000

8/ Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	5 000 000
2	эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	400 000
6	энэ хуулийн 27.1.6-д заасан тусгай зөвшөөрлийн	хугацааг сунгахад 125 000
7	энэ хуулийн 27.1.6-д заасан тусгай зөвшөөрлийг	дахин олгоход 200 000
8	эрүүл мэндийн магадлан итгэмжлэл олгоход	250 000
9	биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	100 000
10	өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга турших, нэвтрүүлэх зөвшөөрөл	20 000
11	ургамлын хорио цээрийн гэрчилгээ	тонн тутамд 25 000

12	импортын лиценз олгоход	12 500
13	экспортын лиценз олгоход	12 500
14	анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид хоёр жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	10 000
15	мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон дээр (14) заасан зөвшөөрлөөр хоёр жил ажилласан эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	5 000
16	анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эмчлэх, эм барих, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар	400 000

9/Барилга хот байгуулалтын чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх зөвшөөрөл	2 400 000
2	кадастрын зураглал хийх зөвшөөрөл олгоход	450 000
3	цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалттай байгууламж, 16-гаас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, тухайн барилга байгууламжид зөвшөөрөл	2 400 000
4	геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	500 000
5	газрын кадастрын судалгаа хийх зөвшөөрөл	1 500 000
6	хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөв, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслийг боловсруулах мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл	900 000

10/ Зам тээвэр аялал жуулчлалын чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	авто зам засварлах, арчлах зөвшөөрөл	300 000
2	аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	752 000

Судалгааны эмхтгэл, IX боть

3	агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	14 000 000
4	агаарын хөлгийн засвар, үйлчилгээ хийх зөвшөөрөл	4 580 000
5	иргэний нисэхийн багц дүрмээр аюулгүйн бүсийн нутаг дэвсгэрт барилга байгууламж барих, мал, гэрийн тэжээвэр ан амьтдыг байрлуулах зэрэг аливаа ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл	2 400 000
6	нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоход ашиглалтын хугацааны жил тутамд	200 000
7	захиалгат нислэг үйлдэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг агаарын хөлгийн жингээс хамааруулж, нислэг үйлдэх тухай бүрт	хүнд жингийн хөлөг онгоцонд 2 000 000 төгрөг, дунд жингийн хөлөг онгоцонд 1 000 000 төгрөг, нисдэг тэрэг /хөнгөн/-т 500 000 төгрөг;
8	Монгол Улсын болон гадаад улсын агаарын хөлөгт олон улсын тогтмол нислэг үйлдэх зөвшөөрөл	200 000

11/ Мэдээлэл харилцаа холбоо технологийн чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	дотоод холбооны сүлжээний суурилуулалт, засварын үйлчилгээ эрхлэхэд	800 000
2	холбооны кабель шугамын суурилуулалт, засвар, угсралтын ажил үйлчилгээ эрхлэхэд	900 000
3	барилгын дотор холбооны монтаж, угсралтын үйлчилгээ эрхлэхэд	1 100 000
4	цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсрах суурилуулах үйлчилгээ эрхлэхэд	1 500 000
5	Мэдээлэл, лавлагааны зориулалттай тусгай дугаарын менежментийн үйлчилгээ эрхлэхэд	850 000
6	Дотоодын хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход	550 000

7	Тусгай зөвшөөрлийн хугацаа болон нэгдсэн бүртгэл сунгахад жил тутамд	500 000
---	--	---------

12/ Цацраг идэвхт ашигт малтмал цөмийн энергийн чиглэлээр олгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	цөмийн төхөөрөмж ашиглах тусгай зөвшөөрөл олгоход	15 000 000

13/ Аймаг нийслэл сум дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаасолгож буй зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга	1 000 000
2	ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга	Улаанбаатар хотод 250 000 төгрөг, аймагт 150 000 төгрөг
3	ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл	240 000
4	ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс доош ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд	80 000 төгрөг, гэрээг сунгахад 50 000
5	усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад	100 000
6	иргэн, хуулийн этгээдэд ан амьтныг эзэмших зөвшөөрөл	120 000
7	нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг ашиглахдаа түүнийг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл	100 000
8	хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг	20 000
9	ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль орчны улсын байцаагч гарал үүслийн гэрчилгээ	50 000

10	үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад	1 000 000
11	мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход	малын толгой тутмаас 50
12	иргэн, хуулийн этгээдэд ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл	кг тутамд 20 000
13	иргэн, хуулийн этгээдэд элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл	1 000
14	элбэг ургамлыг гадаадын иргэн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд	килограмм тутмаас 10 000
15	иргэн, хуулийн этгээдэд ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход	ашиглахаар тооцсон хэмжээний килограмм тутамд 50 төгрөг;
16	мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга	Улаанбаатар хотод хуулийн этгээдэд 500 000 төгрөг, иргэнд 250 000 төгрөг, аймагт хуулийн этгээдэд 400 000 төгрөг, иргэнд 200 000 төгрөг;
17	мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга	200 000
18	мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ	5 000
19	рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход	320 000

* * *

15/ Шинэ бүтээл зохиогчийн эрхийн чиглэлээр олгох зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр	Хураамжийн хэмжээ Төгрөгөөр
1	зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөл	345 000

2	тодорхой бүтээлийн зохиогчийн эрхийг өөрийн болон гадаад оронд төлөөлөн хамгаалах зөвшөөрөл	150 000
3	нийтийн эзэмшлийн барилга, байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл	100 000

* * *

Ашигласан материал, эх сурвалж:

- Татварын тогтолцоо Б.Ганхүлэг /I-II дэвтэр/УБ 2002 он
- Санхүүгийн эрх зүй С.Төмөр УБ 2002 он
- Монгол Улсын Татварын эрх зүй УБ 2009 он <http://www.cnlyjd.com/tax/shuiwudawen/yinhuaahui/200911/5509412.html>
- http://www.law-lib.com/law/law_view.asp?id=5175
- <http://www.chinaacc.com/new/63/67/102/1991/1/ad8109010111119911360.htm>
- http://www.gov.cn/banshi/2005-08/19/content_24836.htm
- http://statutes.agc.gov.sg/non_version/cgi-bin/cgi_retrieve.pl?actno=REVED-312
- <http://baike.baidu.com/view/2459574.html?fromTaglist>
- <http://www.hqswj.gov.cn/info/Print.asp?ArticleID=183>
- http://www.law-lib.com/law/law_view.asp?id=79264
- <http://www.gz.gov.cn/publicfiles/business/htmlfiles/gzgov/zcfgk/201009/612352.html>
- <http://www.zhuze668.com/article/NZ/info-1127.html>
- <http://yasw.0835.com/info/ShowArticle.asp?ArticleID=800>
- http://www.paat.com.cn/tips2011/tips_11041201.html
- <http://www.aucklandcity.govt.nz/council/services/liquor/offlicence.asp>
- <http://www.legislation.govt.nz/act/public/1989/0063/latest/DLM165116.html>

(Footnotes)

1. <http://baike.esnai.com/view.aspx?w=%D3%A1%BB%A8%CB%B0>
2. <http://www.iras.gov.sg/irasHome/page01.aspx?id=724>
3. <http://www.hmrc.gov.uk/so/manual.pdf> <http://www.stampdutyrates.co.uk/>
4. <http://www.moneybuddy.com.au/home-loans/guide-stamp-duty.html>
5. http://www.jpof.com.ar/esp/publicaciones/pdfs/publicaciones_02.pdf
6. http://www.deloitte.com/assets/Dcom-Global/Local%20Assets/Documents/Tax/Intl%20Tax%20and%20Business%20Guides/2011/dtt_tax_guide_2011_Argentina.pdf
7. <http://www.realestatezing.com/india/stamp-duty-india.html>
8. <http://www.revenue.ie/>
9. 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулиар тогтоосон хураамжийн хэмжээ
10. Амьтны аймгийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



**МОНГОЛ УЛСАД ИМПОРТООР ОРЖ ИРЖ БУЙ ГОЛ НЭРИЙН БАРАА
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ /2005 - 2011/**

Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

Оршил

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Шинэбаярын ирүүлсэн захиалгын дагуу “Монгол Улсын импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний талаархи лавлагаа мэдээлэл” -ийг 2005-2011 оны эхний хагас жилийн байдлаар УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн макро эдийн засгийн багийн судлаач Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа нар хийж гүйцэтгэлээ.

Судалгааны бүтэц

Монгол Улсын импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний талаарх лавлагаа мэдээллийг дараахь бүтэцтэйгээр хийж гүйцэтгэлээ. Нэгдүгээр хэсэгт, Монгол Улсын гадаад худалдааны импортын өнөөгийн байдал болон импортын бараа бүтээгдэхүүнд голлох байр суурь эзэлж буй бүтээгдэхүүнийг сонгон сүүлийн 5 жилийн хугацаан дахь динамик үзүүлэлтийг гаргалаа. Дараагийн хэсэгт, Гадаад худалдааны статистик үзүүлэлтээс импортын бараа бүтээгдэхүүнд хамаарах ойлголтууд, импортоор орж ирж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүний сонголт болон тэдгээрээс гол нэрийн 50 бараа бүтээгдэхүүний жагсаалтыг 2005-2011 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан болно. Мөн түүнчлэн гадаад худалдааны өнөөгийн байдлын мэдээллийг тоймлон хүргүүлж байна.

1. Монгол Улсын гадаад худалдааны импортын өнөөгийн байдал болон импортын бараа бүтээгдэхүүнд голлох байр суурь эзэлж буй бүтээгдэхүүний талаарх мэдээлэл

Манай улс 2011 оны эхний эхний 7 сарын байдлаар нийт 3442.4 сая ам.долларын импорт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 дахин буюу 1773.2 сая ам.доллараар өссөн байна. Энэхүү өсөлтөд: хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт 114.3%-иар өсч 627.0 сая ам.долларт, нефтийн импорт 71.8%-иар өсч 581.1 сая ам.долларт, тээврийн хэрэгслийн импорт 3.1 дахин өсч, 578.5 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна.

Манай улсын гадаад худалдааны импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүнд согтууруулах ундаа, тамхи гол хувийн жинг эзэлдэг бөгөөд эдгээр нэр төрлийн бүтээгдэхүүнийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзлээ. Бусад бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дэлгэрэнгүй хүснэгтээр судалгааны хоёр дахь хэсэгт харууллаа.

Импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн дотроос онцгой албан татвар ногдуулах бараанд:

- Бүх төрлийн согтууруулах ундаа
- Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи
- Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи
- Автобензин, дизелийн түлш
- Суудлын автомашин хамаардаг.

Онцгой албан татвартай барааны импортыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 63.1%-иар буюу 284.7 тэрбум төгрөгөөр, ногдуулсан татвараар 53.5% -иар буюу 74.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1.1

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар.

Взүүлэлт		Хэмжих нэгж	2010.06 сарын гүйцэтгэл		2011.06 сарын гүйцэтгэл		Хувь		Зөрүү -,+	
			Тоо	Үнэ мян. төг	Тоо	Үнэ мян. төг	тоо	Үнэ	Тоо	Үнэ мян. төг
Үнийн дүн			xxx	451362843	xxx	736127906		163.1	xxx	284765063
Согтууруулах ундаа		л	9024954	10083776	10903564	11110024	120.8	110.2	1878610	1026248
Үүнээс	Шар айраг	л	8320323	7365732	9910712	7378448	119.1	100.2	1590389	12716
	Дарс	л	664085	1948506	909997	2620476	137.0	134.5	245912	671970
	Архи, Виски	л	40546	769538	82855	1111100	204.3	144.4	42309	341563
Тамхины дүн			xxx	15035481	xxx	26538120		176.5		11502640
Үүнээс	Янжуур тамхи	мян.ш	430052	11937251	807839	23574488	187.8	197.5	377787	11637237
	Дүнсэн тамхи	кг	594520	3098229	571330	2963632	96.1	95.7	-23190	-134597

Нефть бүтээгдэхүүн		тн	316656	347917476	400735	481586957	126.6	138.4	84079.8	133669481
Үүнээс	Бензин 90 хүртэл окт.	тн	55505	58754369	58775	64731604	105.9	110.2	3269.7	5977235
	Бензин 90 дээш окт.	тн	67896	76813119	90432	100302829	133.2	130.6	22536.1	23489710
	Дизелийн түлш	тн	193254	212349988	251528	316552524	130.2	149.1	58273.9	104202536
Автомашин		ш	9092	78326110	20413	216892805	224.5	276.9	11321.0	138566695


2011 оны эхний 6 сарын байдлаар импортын гаалийн албан татвар өнгөрсөн оны мөн үеэс 71106.6 сая төгрөгөөр, архи тамхины онцгой албан татвар 5118.2 сая төгрөгөөр, автобензин дизелийн түлшний онцгой албан татвар 6131.3 сая төгрөгөөр, суудлын автомашины онцгой албан татвар 22268.2 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 157005.7 сая төгрөгөөр, автобензин дизелийн түлшний албан татвар 764.9 сая төгрөгөөр, импортын шар айрагны онцгой албан татвар 141.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.²⁰

Онцгой албан татвартай бараа. Онцгой албан татвартай барааны импортын тоо хэмжээг 2011 оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж авч үзвэл:

- **Согтууруулах ундаа** 20.8%-иар буюу 1878.6 мянган литрээр өссөн байна. Үүний дотор шар айраг 19.1%-иар буюу 1590.4 мянган литрээр, дарс 37.0%-иар буюу 245.9 мянган литрээр, архи виски 104.3%-иар буюу 42.3 мянган литрээр тус тус өссөн байна.

Зураг 1.1


Согтууруулах ундааны импортын хэмжээ
/сүүлийн 5 жилийн байдлаар мянган литрээр/




- ✓ **Янжуур тамхи** 87.8%-иар буюу 377787 мянган ширхэгээр өсч, дүнсэн болон задгай тамхи 3.9%-иар буюу 23.2 тонноор буурчээ.

²⁰ Гаалийн Ерөнхий газар, 2011/7 сарын статистик

Зураг 1.2 Янжуур тамхины импортын хэмжээ




Зураг 1.3 Дүнсэн тамхины импортын тоо хэмжээ, үнийн дүн



- ✓ **Нефть бүтээгдэхүүн** 2011 оны эхний хагас жилд тоо хэмжээгээрээ өнгөрсөн оны мөн үеэс 26.6 %-иар буюу 84079.8 тонноор өссөн байна. Үүнээс 90 хүртэл октантай автобензиний импорт 3269.7 тонноор, 90-ээс дээш октантай автобензин 22536.1 тонноор, дизелийн түлш 58273.9 тонноор тус тус өссөн.

Автобензин, дизелийн түлшний хэрэглээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа бөгөөд уул уурхайн томоохон төслийн бүтээн байгуулалт эхэлсэн, барилгын салбарын сэргэлт, хүн амын автомашины хэрэглээний өсөлт зэргээс шалтгаалан нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ өссөөр байна.

Зураг 1.4 Нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ (мян.тонн)



- ✓ **Суудлын автомашины** импорт 124.5%-иар буюу 11321 ширхэгээр өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

Монгол Улсад сүүлийн үед импортоор орж ирж буй суудлын авто машины тоо эрс өссөн бөгөөд нийт автомашины 50 хувь нь нийслэл хотод ашиглагдаж байна. Мөн сүүлийн 10 жилд нийслэл хотын автомашины тоо 1.7 дахин, үүний дотор суудлын автомашины тоо хоёр дахин өссөн байна. 2009 оны байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн 306.3 мянган автотээврийн хэрэгслийн 252.5 мянга нь автомашин бөгөөд үүний 69.9 хувь нь суудлынх, 21.3 хувь нь ачааных, 5.6 хувь нь автобус, 3.5 хувь нь тусгай зориулалтын автомашин байна гэсэн тоо баримт байна.

Импортын гол нэрийн бараа, түүхий эд 2011 оны эхний 7 сарын байдлаар

Хүснэгт 1.2

д/д	Нэр төрөл	2010 оны 7 сар	2011 оны 7 сар	Өөрчлөлт / хувиар/
1	Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	292,6	627,0	114,3%
2	Нефтийн бүтээгдэхүүн	338,3	581,1	71,8%
3	Тээврийн хэрэгсэл	186,2	578,5	210,7%
4	Хүнсний бүтээгдэхүүн	93,2	105,4	13,1%
5	Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	52,1	100,3	92,5%
6	Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	31,9	46,5	45,8%
7	Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	13,3	34,3	157,3%
8	Төрөл бүрийн даавуу	1,0	1,1	10%
9	Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	64,1	109,3	70,4%

10	Бусад	596,5	1258,9	111,1%
	Нийт импорт	1669,2	3442,4	106,2%

Эх сурвалж:

Монголбанк. Монгол Улсын гадаад секторын талаарх мэдээлэл, 2011/7/28

Монгол улсад хэрэгжиж буй уул уурхайн төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулалтаар орж ирж буй хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн импортын тоо хэмжээ өсч, цаашид ч өсөх хандлагатай байна. Үүнд уул уурхайн зориулалттай машин техник, автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл болон газрын тосны бүтээгдэхүүний импортын дундаж үнэ нэмэгдсэнээс хамаарч импортын өсөлт экспортынхоос 48.7 пунктээр өндөр байна.

2011 оны эхний хагас жилийн мэдээгээр нийт импортын 80.3% буюу 2764.5 сая ам.долларыг валютын төлбөртэйгээр, 17.6% буюу 605.4 сая ам.долларыг хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа эзэлж байна гэж Гаалийн ерөнхий газраас мэдээлэл хийгдсэн. Мөн эхний 7 сарын байдлаар Монгол Улсын нефтийн импорт огцом өслөө. Нийт 581.1 сая ам.долларын нефтийн бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 71.8%-иар өссөн байна.

Хоёр. Гадаад худалдааны импортын бараа бүтээгдэхүүнд хамаарах ойлголтууд,

Гадаад худалдааны статистик мэдээллийг ҮСХ-ны дарга, Сангийн сайд болон ГЕГ-ын даргын 2009 оны 2 сарын 17-ны өдрийн 01/17/42/069 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу боловсруулдаг байна.

Энэхүү аргачлалд дурьдсанаар “импортын бараа бүтээгдэхүүн” гэдэгт худалдааны бүртгэлийн ерөнхий системийн дагуу дараахь урсгалыг хамааруулдаг байна. Үүнд:

- гадаадын барааг хилийн чанадаас дотоодын хэрэглээнд оруулах;
- гадаадын барааг хилийн чанадаас оруулж, дахин боловсруулан дотоодын хэрэглээнд оруулах;
- хилийн чанадаас гадаадын барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулах;
- гадаадын барааг хилийн чанадаас гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн газар, барилгын талбай, тусгай бүсэд оруулах;
- гадаадын барааг гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар болон татваргүй барааны дэлгүүрээс гаалийн нутаг дэвсгэрт оруулах;
- гадаадын барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах;
- хилийн чанадад боловсруулахаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах;
- хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах.

“Гадаад худалдааны экспорт, импортод оруулж тооцвол зохих бараа” гэдэгт

- мөнгөжөөгүй алт;
- гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаас;
- Засгийн газрын худалдааны хэлэлцээр, гадаад тусламжийн хөтөлбөр болон дайны нөхөн төлбөрийн дагуу эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж, түүнээс гаргаж байгаа иргэний болон цэргийн зориулалттай бараа /төлбөр, хандив, зээл,

- солилцооны бараа хамаарна/;
- хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;
- хөрөнгө оруулалтын бараа;
- цэргийн зориулалттай бараа;
- зорчигчийн арилжааны шинж чанартай бараа;
- консигнацийн бараа /улсын хил нэвтрэх үед өмчлөлийн эрх шилжээгүй, арилжих зорилго бүхий бараа, тухайлбал үзэсгэлэн, яармагт тавигдаж буй бараа/;
- арилжааны зориулалттай програм хангамж, бичлэг хийгдсэн аудио, видео хальс;
- толгой компани болон түүний шууд хөрөнгө оруулалтаар бий болсон охин компаний хооронд шилжүүлж буй бараа;
- цахилгаан эрчим хүч, хий, ус;
- улс хоорондын шуудан илгээмжийн арилжааны шинж чанартай бараа;
- шилжин суурьшигчдын үнэ бүхий эд хогшил;
- нэг ба түүнээс дээш жилээр түрээслэх бараа;
- хоосон лонх, сав, баглаа, боодол;
- тодорхой үнэ өртөг бүхий үйлдвэрлэлийн хаягдал, үлдэгдэл /тухайлбал, хаягдал лааз, хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл, хаягдал зэрэг/, аюултай хог хаягдал;
- усан онгоц, агаарын болон бусад тээврийн хэрэгсэл;
- Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
- Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс, бусад эд зүйл болон гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх буудалд буулгасан бараа.

“Гадаад худалдааны экспорт, импортын тооцоонд оруулахгүй бараа” гэдэгт:

- мөнгөжсөн алт;
- гүйлгээнд оруулсан мөнгөн дэвсгэрт, зоос, үнэт цаас /үүнд гадаад валютын зузаатгал орно/;
- хилийн чанадад 1 жилээс дээшгүй хугацаагаар гаргасан, гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулсан бараа;
- улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа;
- захиалгын сонин, тогтмол хэвлэл;
- захиалгын дагуу хийгдсэн програм хангамж, түүнийг агуулж байгаа диск, эх бичлэг хийгдсэн аудио болон видео хальс; захиалгаар хийгдсэн зураг төсөл;
- нэг жилээс дээшгүй хугацаагаар түрээслэх бараа;
- устгах бараа;
- дахин ашиглагдах эргэлтийн хоосон лонх, сав, баглаа, боодол;

“Барааны экспорт, импортод тооцогдохгүй, тусгайлан бүртгэх бараа” гэдэгт:

- давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан хохирлыг арилгах, барилга байгууламж барих зэрэг тодорхой зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар нэвтрүүлсэн машин механизмыг дотоодын хэрэглээнд оруулах эсхүл хилийн чанадад гаргах тохиолдолд;

- засварын зориулалттай бараа;
- улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа зэрэг болно.

Манай улсын импортын бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг нефть, өргөн хэрэглээний бараа, машин тоног, төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, эд анги, агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Дэлхийн бусад орнуудын жишгээс харахад импортоос хэт хараат байгаа байдал нь худалдааны өсөлтөнд сөргөөр нөлөөлж байгаагаас гадна тухайн импортын барааны нэр төрөл хэт олон байна. Мөн өсөлтөд нөлөөлж байгаа гол зүйл бол өөрийн оронд үйлдвэрлэж болох бүтээгдэхүүнийг гаднаас авч байна. Жишээлбэл нефть, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн юм. Нефтийн хувьд авч үзвэл нэг орноос хэт хамааралтай байгаа нь импортод нөлөөллөх бас нэгэн хүчин зүйл юм.

Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 оны эхний 7 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 80.3%-иар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 48.4%-иар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 70.0%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.

Судалгааны Хүснэгт 2.1-т Үндэсний Статистикийн Хороо болон Гаалийн Ерөнхий Газраас гаргасан гадаад худалдааны статистик мэдээлэлд тулгуурлан импортын бараа бүтээгдэхүүнд хамгийн өндөр хувийн жин эзэлж байгаа 50 бараа бүтээгдэхүүнийг сонгон 2005-2011 оны эхний хагас жилийн байдлаар мэдээллийг бэлтгэсэн болно.

Хүснэгт 2.1

Монгол Улсад импортоор орж ирж буй гол нэрийн бүтээгдэхүүний 2005-2011 оны эхний хагас жилийн жагсаалт²¹

(мян.ам.долл)

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Статистик мэдээлэл										2011 он ¹ /эхний хагас жилийн байдлаар/	
			2005 он		2006 он		2007 он		2008 он		2009 он		2010 он	
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
1	Өндөг	мян.ш	15136.6	637.5	23303.0	979.4	41278.6	1973.0	36800.3	2011.3	34778.5	2417.8	47582.8	3214.0
2	Төмс	т	40985.7	3078.2	35609.5	3633.6	30170.2	3629.8	35445.8	5086.2	23215.2	3183.4	8505.0	1846.2
3	Сонгино, сармис	т	5497.2	607.6	4272.8	619.6	1936.8	364.7	14358.8	2039.4	11230.4	2186.7	1494.5	2982.9
4	Алим, лийр	т	16278.3	3539.4	9437.4	2162.4	9962.6	2230.5	6473.8	1770.8	10049.2	2579.5	8338.4	2385.3
													3788.6	1267.1

²¹ 2005-2010 оны ЁСХ-ноос гаргасан статистикийн эмтхгэл

5	Ногоон цай	т		1478.9	578.6	2026.6	813.5	2504.2	1071.2	2659.7	1597.5	2522.8	1768.1	2268.9	1665.5	1322.6	1066.5
6	Цагаан будaa	т		13777.4	3672.0	19063.2	5223.8	28362.6	8147.9	27947.0	11103.8	19025.7	6424.4	25938.4	14695.6	5085.8	2420.7
7	Шар будaa	т		8353.6	1647.5	7160.6	1455.9	5654.9	1208.1	3844.4	1211.7	1898.8	673.0	1334.2	601.7	819.4	398.1
8	Улаан буудай	мян.т		97.5	15788.5	102.2	20051.7	92.8	21360.5	171.3	60391.1	114.7	30770.5	66.2	12049.4	0.0	0.8
9	Гурил	мян.т		103.9	20023.9	105.6	21326.0	112.3	29048.2	132.9	54684.7	105.7	30430.8	65.2	15642.9	40.1	15566.9
10	Ургамалын тос	т		223.5	177.6	118.7	94.5	3589.9	3780.1	1273.8	2122.4	6719.6	7164.0	8709.1	10729.1	2621.8	4445.9
11	Маргарин	т		4557.3	3597.7	5102.1	3980.1	5155.4	5463.3	4741.9	7661.9	3212.0	3939.7	5101.0	6531.1	2063.6	3037.2
12	Элсэн чихэр	т		26834.7	7008.9	26339.7	8769.9	36749.1	13258.6	42850.4	16800.9	26330.7	10683.8	37999.1	18653.1	20888.7	12467.8
13	Хатуу чихэр	т		6016.9	5846.4	5447.2	5785.0	7057.5	8562.0	7262.4	11411.7	6737.9	10072.9	7105.9	11765.1	2753.3	5111.3
14	Амтлаг гурлин зүйлс	т		6113.6	7142.8	6675.1	8380.9	9182.8	12559.3	11210.6	21184.7	9210.1	16060.6	11863.0	20417.2	7105.4	13182.2
15	Лаазалсан жимс, самар	т		61.4	40.0	35.7	22.8	34.1	20.6	230.7	114.6	10.3	12.6	21.0	28.8	16.0	20.6
16	Согтууруулах биш ундаа	мян.л		4189.7	1849.3	5492.7	2852.1	6551.0	3844.3	9938.6	7176.8	7165.4	5586.3	12464.3	9989.0	9095.3	7161.9
17	Согтууруулах ундаа	мян.л		9383.9	7360.6	12025.5	9743.9	19875.5	18347.2	22968.3	22743.3	11900.5	11295.9	2110.7	19047.9	9506.8	8066.9
18	Үүнээс: Шар айраг	мян.л		7781.0	4470.1	10814.1	6742.7	17041.0	10777.8	20469.1	13621.3	0629.8	7254.1	1847.8	12166.3	8779.8	5105.0
19	Янжуур	сая.ш		629.3	579.2	761.4	11857.6	1512.4	24839.7	1867.2	35076.7	1549.4	29585.6	1320.9	30209.1	833.8	21442.6
20	Дүнсэн тамхи	т		1383.3	2787.3	1178.7	2620.0	1405.5	3251.9	1532.2	4376.5	1316.6	4523.3	459.9	1854.1	182.7	816.9
21	Автобензин	мян.т		254.8	122870.9	280.4	175043.8	346.2	239085.1	366.0	361522.6	323.0	223035.8	284.7	228783.0	146.7	131456.2

22	Дизель түлш	МЯН.Т	270.9	156926.7	310.0	204335.5	387.6	270702.6	428.3	467960.6	416.2	273888.1	499.4	39 678.2	249.0	251733.8
23	Онгоцны түлш	МЯН.Т	18.9	11197.3	41.4	28707.3	39.2	29059.6	31.6	34496.6	14.7	11174.4	16.2	13 650.5	10.9	11636.1
24	Түлшний мазут	МЯН.Т	4.9	1369.4	5.5	1974.0	7.6	2733.2	6.8	3783.2	4.6	1971.8	5.3	2 414.1	3141.3	1814.2
25	Цахилгаан эрчим хүч	САЯ. КВТ.Ц	175.5	5564.8	241.8	6584.4	207.6	6366.9	197.6	7994.8	156.5	6398.8	262.9	13 527.1	68.3	5168.9
26	Азотын бордоо	Т	13306.4	2777.8	20345.7	4333.8	18691.0	4266.0	27263.0	11950.4	23142.8	7726.3	31 54.1	9 367.4	17175.1	5718.6
27	Саван	Т	6261.5	4405.4	6745.9	4960.1	6791.0	6500.6	6953.1	8314.0	5945.8	7224.4	5 586.8	8 365.5	3042.5	5169.0
28	Угаалгын нунтаг	Т	2751.1	2384.9	3184.3	3161.7	4459.2	5113.7	5052.1	6976.3	5241.7	7087.8	5 496.3	7 648.7	2941.9	4353.5
29	Тунгаар савлагдсан эм	Т	790.7	7874.8	813.2	10475.3	1068.6	16199.8	1217.7	23385.3	997.8	23004.6	1 192.0	30 788.4	2230.5	21182.5
30	Шинэ дугуй	МЯН.Ш	121.2	8484.3	124.8	11431.3	186.6	18018.7	163.8	21899.0	111.2	21949.3	191.5	38 047.1	98.3	36885.0
31	Нийлэг мяндсан даавуу	МЯН. М²	10653.7	8545.7	8250.3	5808.7	4827.2	2991.3	3603.4	1766.5	1597.0	700.9	1 084.7	726.2	374.8	450.6
32	Хөвөн цаасан даавуу	МЯН. М²	8672.0	9851.9	9286.6	10916.8	3466.6	3752.9	1308.9	1241.2	332.9	153.2	434.6	180.6	109.2	126.8
33	Цонхны шил	МЯН. М²	818.5	1267.1	803.8	1350.8	936.3	1853.5	1436.6	4091.1	963.2	2405.0	923.4	2 318.7	309.4	880.4
34	Өрөөний агаар тохируулах техөөрөмж	Ш	9650	855.6	14727	997.3	22172	1620.9	25957	2579.3	3109	1257.9	13 853	3 083.7	5955	2548.4
35	Хэвлэгч машин механизм тэдгээрийн туслах эд анги	Ш	1463	349.5	1120	430.0	48329	5181.4	98255	8176.0	62998	4108.8	76 225	10 252.3	54820	6735.7
36	Хөргөх, хөлдөөх техөөрөмж	Ш	29941	3174.9	29192	3156.1	54975	7639.6	75592	11896.1	41363	7470.2	69 105	14 649.3	49475	10509.7
37	Бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор	Ш	358	35128.1	2134	16583.1	1249	55945.2	1402	86083.4	456	68279.2	771	101369.8	1111	159247.3

Судалгааны эмхтгэл, IX боть

38	Өргөгч, ачигч буулгагч зэргийн эд анги	МЯН.Ш	178.3	17326.5	221.8	21753.9	444.7	31715.5	285.8	42402.3	241.9	22556.7	234.3	45 157.4	2297.2	43750.9
39	Шороо, чулуу ялгах, холих машин	МЯН.Ш	145.8	24702.1	22.6	24149.4	20.6	23439.8	32192.0	40850.3	24686.0	25420.5	41.9	64 499.7	92.3	84293.6
40	Ахуйн цахилгаан хэрэгсэл	МЯН.Ш	93.5	2383.0	124.8	3985.0	162.2	5878.8	256.6	11296.8	143.0	6928.1	209.2	10 980.0	108.6	7650.3
41	Тоос сорогч	Е	25970	482.1	21860	423.3	1808	77.2	5457	223.3	3123	169.0	4 851	211.8	1445	88.7
42	Мэдээлэл боловсруулах машин түүний бүрдэл хэсэг	МЯН.Ш	114.0	13339.5	224.7	27809.7	89.7	12179.3	105.7	21941.6	57.1	14355.0	102.4	23 575.3	66.5	20418.2
43	Телефон цахилгаан шуудан холбооны аппарат	МЯН.Ш	34.3	19551.2	37.6	26578.1	151.2	39246.7	357.7	47839.7	231.3	45087.2	243.3	46 409.2	136.4	21659.1
44	Телевизор, видео монитор ба видео проектор	Е	41397	3415.6	43811	3890.6	67667	10024.5	91062	16265.7	49847	10564.5	113 475	22 197.7	115384	25101.7
45	Нийтийн тээврийн хэрэгсэл	Е	1639	7458.2	2341	8060.1	2791	13602.7	3172	16826.9	1178	30151.4	1 634	13 623.9	1274	13726.8
46	Хөнгөн тэрэг	Е	14366	51789.5	21784	81055.1	22150	100806.2	38526	189829.5	11658	71305.7	26 378	164396.7	22328	182313.0
47	Ачааны тэрэг	Е	6237	22617.8	7481	25327.1	13116	54198.4	18073	119213.0	4559	59236.1	12 221	208354.6	11331	260779.1
48	Тээврийн хэрэгслийн салбарт эд анги	МЯН.Ш	305.1	6226.6	313.2	6541.6	501.0	9620.5	511.8	10866.8	449.6	8144.0	621.3	16 343.8	301.2	12007.6



УИ.МН
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2011 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОЙМ СУДАЛГАА

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа


1. УЛСЫН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны эхний хагас жилд 1966.7 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1868.2 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 98.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Өмнөх оны мөн үед улсын нэгдсэн төсөв 167.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол энэ оны эхний хагас жилд улсын нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай гарахад өмнөх оны мөн үеийнхээс орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 25.8 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Төсвийн урсгал орлого 1918.1 тэрбум төг, урсгал зардал 1523.1 тэрбум төг болж, урсгал тэнцэл 395.0 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн нийт орлого, зарлага, нийт тэнцэл болон урсгал тэнцлийг 2007-2011 оны эхний хагас жилийн байдлаар доорх зургаар харууллаа.


Зураг 1.1 Төсвийн нийт орлого, зарлага, нийт тэнцэл болон урсгал тэнцэл (тэрбум төг/)



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн

2011 оны эхний хагас жилийн байдлаар 1 966.7 тэрбум төг, урсгал орлого 1 918.0 тэрбум төгрөг болж өссөн дүнтэй гарчээ. Урсгал орлого өссөхөд татварын орлогын бүлгийн дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого, бусад татварын орлого, гадаад худалдааны татварын орлого, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, орлогын албан татвар өссөн ба татварын бус орлогын бүлгийн төсөвт газрын өөрийн орлого, хувьцааны ногдол ашгийн орлого, навигацийн орлого, торгуулийн орлого зэрэг орлогууд голлон нөлөөлсөн байна.


Зураг 1.2 Нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлтүүд



Татварын орлого

Татварын орлого сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй гарсаар ирсэн ба 2009 оны хямралтай холбоотойгоор буурсанч 2010 оноос эргэж сэргэн дахин өссөх хандлагатай байна.

Зураг 1.3 Татварын орлогын үзүүлэлтүүд



Өмнөх оны мөн үеийнхээс татварын нийт орлого 617.8 тэрбум төг буюу 57.5 хувиар нэмэгдэхэд дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 257.9 тэрбум төг буюу 71.3 хувь, бусад татварын орлого 208.4 тэрбум төг буюу 2.6 дахин, гадаад худалдааны татварын орлого 71.1 тэрбум төг буюу 90.7 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 64.4 тэрбум төг буюу 44.3 хувь, орлогын албан татвар 14.1 тэрбум буюу 4.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. /Зураг 1.3-аас харна уу/


Татварын бус орлого

Өмнөх оны мөн үеийнхээс 94.6 тэрбум төг буюу 71.7 хувиар өсөхөд төсөвт газрын өөрийн орлого 43.9 тэрбум төг буюу 77.7 хувь, хувьцааны ногдол ашгийн орлого 28.7 тэрбум төг буюу 7.7 дахин, навигацийн орлого 6.8 тэрбум төг буюу 48.4 хувь, хүү, торгуулийн орлого 6.1 тэрбум төг буюу 32.5 хувь, бусад нэр заагдаагүй орлого 5.9 тэрбум төг буюу 30.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ

2011 оны эхний хагас жилд 1868.2 тэрбум төг болж өмнөх оны мөн үеийнхээс 461.1 тэрбум төг буюу 32.8 хувиар нэмэгдсэн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 69.5 тэрбум төг буюу 52.0 хувь, зээлийн үйлчилгээний төлбөр 7.7 тэрбум төг буюу 27.1 хувиар буурсан хэдий ч, татаас ба шилжүүлэг 279.1 тэрбум төг буюу 51.3 хувь, бараа, үйлчилгээний зардал 150.7 тэрбум төг буюу 28.5 хувь, хөрөнгийн зардал 108.5 тэрбум төг буюу 62.9 хувиар өссөнөөс шалтгаалжээ.


Зураг 1.4 Нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлтүүд /тэрбум төг/



Урсгал зардал

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардал 81.5 хувь эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.3 функтээр өссөн байна. Урсгал зардал өсөхөд татаас ба шилжүүлэг 51.3 хувиар, бараа үйлчилгээний зардал 28.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Урсгал зардлын бүлгийн зардал болох зээлийн үйлчилгээний төлбөр 27.1 хувиар буурсан нь банкы зээл болон бондын хүү буурсан нь нөлөөлсөн байна.

Зураг 1.5 Урсгал зардлын үзүүлэлтүүд /тэрбум төг/



Хөрөнгийн зардалд

2011 оны эхний хагас жилд 281.0 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 108.5 тэрбум төг буюу 62.9 хувиар нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 105.2 тэрбум төг буюу 61.5 хувь, гадаад эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 3.2 тэрбум төг буюу 3.6 дахин өссөнөөс шалтгаалжээ. Монгол улсын төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 58.6 хувиар өсч гарсан бөгөөд энэхүү өсөлтөд орлогын бүх төрлүүд өссөн байгаагаас зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, дотоодын

тамхины онцгой албан татвар, агнуурын нөөц ашигласны төлбөр зэрэг буурсан дүнтэй гарч орлогын үзүүлэлтүүд сүүлийн үед сайжирсаар байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн нийт зарлаг ба цэвэр зээлийн дүн өмнөх оны мөн үеийхээс 232.8 хувиар нэмэгдсэн ашигт малтмалын өсөлтийн жилүүдэд төсөв уул уурхайгаас хэт хамааралтай болсон ба тэрхүү хуримтлалын ихэнх хэсгийг цалин хөлс, нийгмийн халамжийн зардал, хөрөнгө оруулалтын зардалуудад зарцуулжээ.


Монгол банкнаас бодлогын хүүг эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагад нийцүүлэн тогтоодог. Бодлогын хүү хөдлөхөд түүнийг дагаад арилжааны банкуудын хадгаламжийн хүү болон зээлийн хүүнд өөрчлөлт ордог. Монголбанкны бодлогын хүүний өсөлт нь инфляцийн хөөрөгдлийг бууруулах, мөнгө зээлийн агрегатуудын хурдацтай өсөлтийг сааруулж зохистой түвшинд байлгах, эдийн засгийн хэт халалтаас зайлсхийхэд чиглэгддэг байна. Харин эдийн засгийн өсөлт саарах шинж тэмдэг ажиглагдвал Төв банк бодлогын хүүгээ бууруулж мөнгөний үнэ цэнийг хямдруулдаг.

2. МӨНГӨНИЙ БОДЛОГО

Бодлогын хүү

Монголбанкнаас 2010 оны 5 дугаар сард бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 11 хувьд хүргээд байсан бол 2011 он гарсаар 4-р сард инфляцийн өсөлт, илүүдэл мөнгөний нийлүүлэлт зэрэг эдийн засгийн хэт халалтын шинж тэмдгүүд илэрч эхэлсэнтэй холбогдуулан бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 11.5% болгосон гэж мэдээлж байна.²² Зураг 1-т 2007 оны 11 сараас хойшхи Төвбанкны бодлогын хүүний өөрчлөлтийг харууллаа.

Зураг 2.1: Төвбанкны бодлогын хүүний өөрчлөлт



Эх сурвалж: www.mongolbank.mn

Инфляци

Энэ жил түлш шатахууны үнийн өсөлтөөс хамаарч нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, өргөн хэрэглээний хүнс болон зарим барааны үнэ өссөн. Энэ оны эхний хагас жилийн байдлаар Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны эцэстэй харьцуулахад 4.7 хувь, өмнөх оны мөн үеийнтэй харьцуулахад 6.2 хувиар өссөн гэж ҮСХ-оос тооцжээ. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд тээврийн бүлгийн дүн 8.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 0.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн гэж үзэж

²² www.mongolbank.mn


байна. Суурь инфляци өмнөх сараас 2.3 хувь, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын инфляцид хүнсний ногооны үнэ 22.1 хувь, нийтийн тээврийн билетийн үнэ 16.7 - 25.0 хувь, бензин, дизелийн түлшний үнэ 5.0-17.4 хувиар тус тус өссөн нь голчлон нөлөөлсөн байна.

ҮСХ-ноос мэдээлснээр жилийн инфляцид хувцас, бөс бараа, гутал болон орон сууц, ус цахилгаан, түлшний бүлгийн бараа, үйлчилгээний үнийн өсөлт буюу хүнснээс бусад барааны үнийн өсөлт инфляцийн гол өдөөгч хүчин зүйл болж байна. Тухайлбал: 6 дугаар сард ОХУ-аас нийлүүлж буй түлшний хэмжээ буурсны улмаас дизель болон АИ-92 бензиний түр зуурын хомсдол үүсч 1 литр дизель түлш өнгөрсөн оны мөн үеийнхээс 34.6 хувь, АИ-92 бензиний үнэ 9.5 хувиар тус тус өссөн нь инфляцид нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт, түүний бүтэц

2011 оны эхний хагас жилийн байдлаар мөнгөний нийлүүлэлт буюу М2 5772,6 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 63,8 хувиар өсчээ. Энэ тоог 2009 оны эцэстэй харьцуулахад 2 дахин өссөн байна. (2009 оны эцэст мөнгөний нийлүүлэлт 2880,0 тэрбум төгрөг байсан байна.)

Зураг 2.2 Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Эх сурвалж: www.mongolbank.mn 2011/06 сарын бюллетень

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 63,8 хувиар өссөн нь төгрөгийн хадгаламж 74,2%, гадаад валютын хадгаламж 41,1%, гадаад валютын харилцах 32,6%, төгрөгийн харилцах 118,5 хувиар тус тус нэмэгдсэн тэй холбоотой байна. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 44,3 хувийг төгрөгийн хадгаламж, 14,7 хувийг валютын хадгаламж, 14,1 хувийг валютын харилцах, 18,6 хувийг төгрөгийн харилцах, 8,3 хувийг банкнаас гадуурхи мөнгө тус тус эзэлж байна.

Аж ахуйн нэгж, иргэд байгууллагад олгосон зээлийн өрийн үлдэгдэл

Зураг 2.3: Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин



Нийт зээлийн багцад чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувийн жин оны эхний хагас жилийн байдлаар 10,1 хувьтай гарчээ. Банкны салбарын хэмжээнд 2009 онд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн багцийн 22,0 хувийг эзэлж ихээхэн анхаарал татсан асуудлуудын нэг байсан бол 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр энэ тоо буурч 14,2 хувь, 2011 оны эхний хагас жилийн байдлаар 10,1 хувь болж 2009 онтой харьцуулахад 2 дахин буураад байна. Чанаргүй зээл дангаараа нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8,6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.

- Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл /Өмнөх оны эцэстэй харьцуулсан байдлаар/

	2006	2007	2008	2009	2010	2011-6
Нийт зээл	1223.3	2056.1	2635.5	2655.0	3264,8	4552,8
өсөлтийн хувь	42.3%	68.1%	28.2%	0.7%	17,2%	39,4%
Хэвийн зээл	1129.9	1947.7	2353.6	2071.3	2799,9	4092,4
өсөлтийн хувь	43.1%	72.4%	20.8%	-12.0%	28,0%	46,2%
Хугацаа хэтэрсэн зээл	33.3	40.3	93.3	121.7	90,6	69,9
өсөлтийн хувь	59.3%	21.0%	131.5%	30.4%	-25,9	-22,8%
Чанаргүй зээл	60.0	68.1	188.7	462.0	374,4	390,5
өсөлтийн хувь	21.2%	13.5%	177.1%	144.8%	-19,7	4,3%
Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзэлж буй хувь	7.6%	5.3%	10.7%	22.0%	14,2%	10,1%


Эх сурвалж: Монголбанк. 2011/06 сарын бюллетень

Нийт хадгаламжийн хэмжээ

Банкуудын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд 2009 онд өмнөх оноос 35.1 хувиар, 2010 онд 48,5 хувиар өсч байсан бол 2011 оны эхний 6 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 64,5 хувиар өсч, нийт хадгаламжийн хэмжээ 3406,0 тэрбум төгрөгт хүрээд байна. 2011

оны эхний хагас жилийн байдлаар ДНБ оны үнээрээ 4762,5 тэрбум төгрөг болж, нийт хадгаламжийн хэмжээ ДНБ-ний 71,5 хувийг эзэлж байна.

Зураг 2.4 Нийт хадгаламжийн хэмжээ, ДНБ-нд эзлэх хувиар




Иргэдийн төгрөгийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 65.8 хувь буюу 905.6 тэрбум төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж 3 дахин буюу 182.7 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 41.1 хувь буюу 247.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Монголбанкнаас нийт хадгаламжийн 75 хувь нь төгрөгийн, 25 хувь нь валютын хадгаламж бөгөөд төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.0 нэгж хувиар нэмэгдсэн нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш өнгөрсөн оны мөн үеэс 8 хувиар чангарсантай холбон тайлбарлаж байна.

Гадаад валютын нөөцийн талаар

Манай орны гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны эхний 6 сарын байдлаар 2544,8 сая ам доллар болж энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1109,7 сая ам доллараар нэмэгдэж импортын 22,2 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна

Арилжааны банкуудын актив

Зураг 2.5. Арилжааны банкуудын активын хэмжээ

**Эх сурвалж:**

Монголбанк. 2010/12 барын бюллетень, 2011/06 сарын бюллетень


2011 оны эхний хагас жилийн байдлаар арилжааны банкуудын активын хэмжээ 7169,7 тэрбум төгрөгт хүрч, энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 55,0 хувиар нэмэгдэж санхүүгийн зуучлалын цар хүрээ улам нэмэгдэж байна.

3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Дотоодын нийт бүтээгдэхүүн

2011 он гарсаар ДНБ оны үнээр 1 дүгээр улиралд 1748.3 тэр бум төгрөг, 2 дугаар улиралд 3014.2 тэрбум төгрөг болж 2011 оны эхний хагас жилд 4762.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 29.1 хувь буюу 1073.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Зураг 3.1 Улирлын ДНБ-ний бодит өсөлт, хувиар

**Эх сурвалж:** ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар авч үзвэл:

ДНБ-ний энэхүү өсөлтөнд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 1453.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 27.1 хувь /үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 31.1 хувь өссөн нь аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 26.3 хувь, дотоод худалдааны нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үеийнхээс 36.3 хувь, тээврийн орлого 34.8 хувь өссөн нь үйлчилгээний салбар 25.5 хувь өсөхөд нөлөөлжээ. Мөн түүнчлэн бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлтөд НӨАТ болон гадаад худалдааны татварын орлого өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 3.2

ДНБ -ний бодит өсөлтийг хангаж буй салбарууд /тэрбум төг/**4. ГАДААД ХУДАЛДАА****Нийт бараа эргэлт**

Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийг улсаар нь авч үзвэл 2011 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн 113 оронтой худалдаа хийснээс 55.1 хувь нь БНХАУ-д, 20.4 хувь нь ОХУ-д үлдсэн 24.5 хувь нь бусад улсуудад ногдож байна. Нийт бараа эргэлтээс 1992.8 сая.ам.долларын бараа бүтээгдэхүүнийг 51 оронд экспортлон, 2725.6 сая.ам.долларын бараа бүтээгдэхүүнийг 110 оронтой импортын худалдаа хийсэн байна.

Эдийн засагт гарсан гадаад болон дотоод эерэг өөрчлөлтийн нөлөөгөөр манай улсын гадаад худалдаа эрчимтэй нэмэгдэж гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 оны эхний хагас жилийн байдлаар 4718.3 сая ам.доллар болж энэ нь өмнөх оны мөн үеэс 2053.4 сая ам.долл буюу 77.1 хувиар өссөн байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт ийнхүү нэмэгдсэн нь уул уурхайн салбарын хөгжил, түүнд түшиглэсэн гадаадны хөрөнгө оруулалт импортын хэмжээ нэмэгдэж байгаа голчлон нөлөөлсөн байна.

Зураг 4.1.


Гадаад худалдааны нийт бараа эргэлт (2010 -2011 оны I-VI сар, сая ам. долл)**Эх сурвалж:** ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга**Экспорт**

Манай улс 2011 оны эхний хагас жилийн байдлаар 51 оронд бараа бүтээгдэхүүн экспортлосноос 90.8 хувийг БНХАУ-тай, 2.2 хувийг Канад улстай, 1.9 хувийг ОХУ-д, 5.1 хувийг БНСУ, Итали, Их Британи, ХБНГУ зэрэг бусад улс оронтой хийжээ.

2011 оны эхний хагас жилийн байдлаар нийт экспортын хэмжээ 1992.8 сая ам.долл болж өмнөх оны мөн үеийнхээс 684.1 сая ам.долл буюу 52.3 хувиар өссөн байна.

Зураг 4.2.

Гадаад худалдааны экспортийн хэмжээ, 2010 -2011 оны I-VI сар, сая ам.долл




Эх сурвалж: ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

Энэхүү өсөлтөнд эрдэс бүтээгдэхүүний экспорт 712.5 сая ам.долл, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн 23.6 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл 7.2 сая ам.долл тус тус өссөн байна. Харин экспортын барааны бүлгийн дүнгээр авч үзвэл үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс 2010 оны мөн үетэй харьцуулахад 41947.1 мян.ам.долл буюу 38.9 хувиар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч тэдгээрийн сэлбэг анги 7456.5 мян ам.долл буюу 50.5 хувиар тус тус огцом буурсан байна.

Импорт.

Зураг 4.3. **Гадаад худалдааны импортын хэмжээ (2009 -2011 оны I-VI сар, сая ам.долл)**



Эх сурвалж: ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

Манай улс 2011 оны эхний хагас жилд нийт 110 оронтой худалдаа хийж, импортын хэмжээ 2725,6 сая ам.доллар болж энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1369,3 сая ам.доллар буюу 2,0 дахин өссчээ.

Энэхүү импортын хэмжээний огцом өсөлт нь манай улсын уул уурхайг түшиглэсэн эдийн


засаг, гадаадын шууд хөрөнгө оруулалт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Учир нь ҮСХ-ны гадаад худалдааны статистикт импортын барааны бүлгийн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр хувийн жин эзлэж буй бараа бүтээгдэхүүнд: машин, техник төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт тэдгээрийн сэлбэг хэрэгсэлийн бүлгийн импортын хэмжээ 449.1 сая.ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийн импорт 426.7 сая.ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүний имдорт 175.3 сая.ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 162.9 сая.ам.долл болсон байна.

Гадаад худалдааны тэнцэл

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний хагас жилийн байдлаар 732.8 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 685.1 сая ам.долл буюу 15.4 дахин өссөн дүн гарсан байна.

Үүнд уул уурхайн зориулалттай машин техник, автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл болон газрын тосны бүтээгдэхүүний импортын дундаж үнэ нэмэгдсэнээс хамаарч импортын өсөлт экспортынхоос 48.7 пунктээр өндөр байгаа нь голлон нөлөөлсөн байна. 2011 онд гадаад худалдааны тэнцэл хамгийн их алдагдлыг хүлээсэн байна

Зураг 4.4. Гадаад худалдааны тэнцэл, 2009 - 2011 оны I - VI сар, сая ам.долл



Эх сурвалж: ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

5. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ


Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2011 оны эхний хагас жилд /оны үнээр/ 2228.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 175.2 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеийнхээс 475.3 тэрбум төгрөг буюу 27.1 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 366.6 тэрбум буюу 23.7 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбар 86.8 тэрбум буюу 18.3 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж 22.6 тэрбум буюу 10.8 хувиар тус тус өссөн байна.

Манай улс 2010 оноос нүүрс экспортлож эхэлсэнээс хойш уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд үүн дотор нүүрсний олборлолтын хэмжээ жил ирэх тутам нэмэгдэж байна. 2011 оны эхний хагас жилийн байдлаар 491.3 тэрбум төгрөгийн нүүрс олборлосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 184.6 тэр бум төг буюу 37.5 хувиар, газрын тос олборлолт 132.1 тэр бум төг буюу өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 19.9 тэр бум төг буюу 15.0 хувиар тус тус өссөн байна


Зураг 5.1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Салбараар, тэрбум.төг.



Эх сурвалж: ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулсан бүтээгдэхүүн 2011 оны эхний хагас жилд оны үнээр 2391.3 тэрбум төгрөг болж, үүний 1525.9 тэрбум төгрөг буюу 63.8 хувийг гадаад зах зээл дээр борлуулжээ. Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулсан бүтээгдэхүүний 69.5 хувийг уул уурхай, олборлох салбарын аж үйлдвэрт, 21.8 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 8.7 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл усан хангамжийн салбарт ногдож байна.

Зураг 5.2 Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт, /оны үнээр.тэрбум.төг/



Эх сурвалж: ҮСХ-ны 2011 оны 6 сарын танилцуулга

Цаашид нүүрс, газрын тос, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний олборлолт ихээхэн өсөх төлөвтэй байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбар, түүн дотроо хүнсний үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өсөх төлөвтэй байна. Мөн түүнчлэн Оюутолгой болон бусад уул уурхайн томоохон орд газруудын дэд бүтэц, барилгын бүтээн байгуулалтын ажил идэвхижиж байгаа нь барилгын салбарын өсөлтийг нэмэгдүүлж, цахилгаан дулааны хэрэглээг өсгөхөөр байна.

Хөдөө аж ахуй

Манай улсын эдийн засгийн томоохон салбарын нэг болох хөдөө аж ахуй нь цаг уурын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд оршдог. Оны эхэнд тоологдсон нийт малын 1.5 хувь буюу 506.1 мян.толгой мал 2011 оны эхний хагас жилд зүй бусаар хорогдов. Нийт зүй бусаар хорогдсон малын 20.6 мян буюу 4.1 хувь нь адуу, 41.2 мян.буюу

8.1 хувь нь үхэр, 1.2 мян буюу 0.2 хувь нь тэмээ, 211.8 мян буюу 41.9 хувь нь хонь, 231.2 мян буюу 45.7 хувь нь ямаа байна.

Малын зүй бус хорогдол өндөр байгаатай холбоотойгоор мал аж ахуйн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, сүү, ноос, ноолуурын гарц буурахад голлон нөлөө үзүүлсэн байна. “Атрын III аян” хэрэгжиж эхэлсэнээс хойш манай улсын газар тариалангын салбарт эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд 2011 оны 7 дугаар сарын байдлаар нийт 340.4 га талбай тариалалт хийсэнээс үр тариа 298.9 мян.га, төмс 14.9 мян.га, хүнсний ногоо 7.6 мян.га, тэжээлийн ургамал 8.5 мян.га, техникийн ургамал 10.5 мян.га-г тус тус тариалсан байна.



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ӨСӨЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

АГУУЛГА

“Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба эдийн засгийн хөгжлийн хамаарал” сэдэвт бодлогын судалгааны төгсгөлийн хэсэг...

...

3. Монгол Улсын хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарлын судалгаа, дүн шинжилгээ

3.1. Хүн амын өсөлтийн прогноз /2050 он хүртэл/

3.2. Хүн амын өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээ

3.3. Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн харилцан хамаарал /бодит байдал, прогноз/

* * *

Оршил

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг “Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба хөгжлийн асуудал” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Хүн ам зүйн бодлого нь хүн амын өсөлт, бүтцийг хадгалах буюу өөрчлөх, хүн амын нөхөн үржихүйн хүрээний үйл явцыг зохицуулахад чиглэгдсэн төрийн байгууллага, нийгмийн институцүүдийн зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, энэхүү бодлого нь хүн амын тоо, өсөлт, өөрчлөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлүүд болох төрөлт, гэрлэлт, гэр бүл салалт, нас баралт, хүн амын насжилтын бүтцийн өөрчлөлт, бүхэлдээ хүний хөгжил, амьдралын чанар, нөхцлийг сайжруулах үйл явцад нөлөөлдөг бөгөөд нийгэм, эдийн засгийн бодлоготой нягт уялдаа холбоотой хэдий ч бас өөрийн гэсэн онцлогтой.

Энэ удаад бид дурдсан нэр бүхий судалгааны төгсгөлийн буюу 3 дугаар хэсгийг үүгээр уншигчиддаа хүргэж байна. Судалгааны тайлангийн өмнөх хэсгийг бид өнгөрсөн онд “Бодлогын судалгаа шинжилгээ” эмхтгэлдээ нийтэлсэн болно.

Хүн ам зүйн бодлого нь эдийн засгийн, захиргаа-эрх зүйн, хүмүүжлийн болон ухуулга, сурталчилгааны цогц арга хэмжээний үндсэн дээр хэрэгждэг. Тухайлбал, хүн амын өсөлтийг дэмжсэн эдийн засгийн арга хэмжээнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж, гэр бүл, хүүхдийг дэмжсэн тэтгэмж, хүүхдийн мөнгө, татварын, орон сууцны хөнгөлт эдлүүлэх зэрэг арга хэмжээ багтдаг бол захиргаа-эрх зүйн хүрээнд гэрлэлт, гэр бүл салалт, гэр бүл дэх хүүхдийн байдал, эх, хүүхдийг хамгаалах, үр хөндөлт, хөдөлмөр эрхэлж буй эхчүүдийн хөдөлмөрийн нөхцөл зэрэг асуудлууд хамаарах ба үүнийг холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулж байна.

Хүн ам зүйн бодлогын үндсэн асуудлууд нь хүүхэдтэй гэр бүлийг дэмжих, эцэг, эхчүүд идэвхтэй хөдөлмөр эрхлэх нөхцлийг хангах, хүн амын өвчлөлт, нас баралтыг бууруулах, наслалтыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг хангах, шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд үзүүлэх нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд юм.

Өнөөдөр олонх өндөр хөгжилтэй орнуудад, ялангуяа Европт хүн ам зүйн хямралын үе гэж нэрлэгддэг төрөлт харьцангуй буурч, хүн амын жам ёсны өсөлт саарч, насны бүтцэд ахмад настны эзлэх хувь нэмэгдсэн үе тохиож байгаа бол харин манай улсад хүн амын насны бүтэц идэршиж, хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их байгаа “**хүн амын цонх**” хэмээн нэрлэгддэг хүн амын насны бүтцийн хамгийн тааламжтай үе ирж байгаа тухай судлаачид мэдээлж байна. Хүн амын насны бүтцийн тааламжтай үеийг зөв зохистой ашиглаж чадсан улс орнууд хурдацтай хөгжиж, ашиглаж чадаагүй нь нийгмийн олон асуудалтай тулгарч, хөгжил нь саардгийг гадаад улс орнуудын туршлага харуулж байна.

Судалгааны зорилго:

Төрөөс баримталж буй хүн ам зүйн бодлогын хэрэгжилтийн явцад буй болсон тулгамдсан асуудлыг тодруулж, холбогдох мэдээлэл, дүгнэлт гарган тодорхой санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Монгол Улсын хүн ам зүйн болон хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн динамик судалгаа,
- Монгол улсын хүн ам зүйн бодлогын тулгамдсан асуудлыг тодорхойлох
- Монгол Улсын хүн ам зүйн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх
- Хүн ам зүйн талаар гадаадын зарим орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрх зүйн орчин, туршлагыг харьцуулан судлах,
- Монгол Улсын иргэн, харьяатын асуудалтай холбоотой эрх зүйн орчин, тулгамдсан асуудлыг судлах,
- Монгол улсын хүн амын өсөлтийн коэффициент түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ, 2009-2050 оны хүн амын өсөлтийн прогноз болон хүн амын өсөлт

ба эдийн засгийн хөгжлийн хамаарал зэрэг асуудлуудыг судалсан болно.

Судалгааны үр дүн:

- Хүн амын хөгжлийг хангах чиглэлээр бодлого, хөтөлбөрүүд цөөнгүй байгаа ч зарим заалтуудын хувьд тунхаглалын шинж чанартай, хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд илэрхий алдаа дутагдлууд гарч байгаа бөгөөд үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн чадвар дутмагаас болж хэрэгжилтэнд ахиц гарахгүй байгаа нь харагдаж байна.
- Төрөөс хүн ам зүйн талаар баримтлах тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй, тууштай, цаг үеийн шаардлагад нийцсэн бодлого үгүйлэгдэж байгаагийн зэрэгцээ хүн ам, гэр бүлийн хөгжлийн асуудлыг хариуцсан тогтолцоог боловсронгуй болгох, эдгээрийг үндэсний хэмжээнд төлөвлөлт, зохицуулалтаар хангах механизм бий болгох шаардлагатай байна.
- Ажлын байрны хомсдлоос шалтгаалан хүн амын хөдөөгөөс хот руу, эх орноосоо гадаад улс руу чиглэсэн албан болон албан бус шилжих хөдөлгөөн буурахгүй байна. Хөдөлмөрийн болон нөхөн үржихүйн насны олон мянган залуус гадаад, дотоодод нүүдлийн байдаар ажиллаж, амьдарч байгаагийн цаана эд материал, хөрөнгө мөнгөөр илэрхийлэх боломжгүй хүйсийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөх, гэр бүл салж сарних зэрэг олон тулгамдсан асуудал бий болсныг анхаарах шаардлагатай байна.
- Цаашид хүн амын өсөлт, төрөлтийг дэмжсэн бодлогыг илүү үр дүнтэй, нийгмийн тэгш хөгжлийг дэмжих зорилттой уялдуулан авч хэрэгжүүлэх нь оновчтой байна. Ялангуяа тоон өсөлтөөс илүү хүн амыг боловсролтой, бие бялдрын хувьд эрүүл чийрэг, ажил мэргэжлийн чадамжтай болгон хөгжүүлэх асуудал чухал юм.
- Судалгаанаас үзэхэд ихэнхи хүмүүсийн гадаад, дотоод шилжилтэнд оролцож байгаа шалтгаан нь ажлын байр байхгүй, байсан ч цалин, хөлс бага зэрэг манай улсын хөдөлмөрийн зах зээлийн тулгамдсан асуудал байгаа нь "хүн амын урамшууллын үе"-ийг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломж болгон ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.
- Уул уурхай, боловсруулах салбарыг хөгжүүлсэнээр хүн амын суурьшил, гэр бүлийн хөгжилд хэрхэн нөлөөлөх, шинээр хөгжиж буй салбарт шаардлагатай өндөр ур чадвартай мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дэвшилтэт техник, технологийг эзэмших, нутагшуулах тал дээр гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдтэйгээ хэрхэн хамтарч ажиллах тал дээр ч нухацтай хандах нь зүйтэй байна.
- Судалгаанд хамрагдсан ОХУ, Швед, Франц, Итали, Бельги гэх мэт орнуудын хүн ам зүйн бодлоготой холбоотойгоор хэрэгжүүлдэг арга хэмжээг нэгтгэн үзвэл гэр бүлийн болон хүүхдийн тэтгэвэр, тэтгэмж олгох, шинэ залуу гэр бүлд орон байрны хөнгөлөлт үзүүлэх, хүн амын өсөлт нь бүх нийтийн зорилго байх ба үүнд хүрэхийн тулд дарамтыг бүгдэд тэгш хуваарилах. Өөрөөр хэлбэл, Хүүхэдгүй болон хүүхэдтэй болохыг хүсдэггүй /хүүхэд үрчлэхийг оруулаад/ хүмүүс хүн амын нөхөн үржихүйн үндсэн ачааллыг үүрч байгаа хэсэгт санхүүгийн тусламж үзүүлэх, /хүүхэдгүйн татвар төлөх, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх гэх мэт эдийн засгийн арга хэмжээнүүд хүн амын өсөлтөд тодорхой нөлөө үзүүлж байна.
 - Иргэний харьяаллын асуудлаар Монгол улсын харьяаллаас гаралгүйгээр өөр улсын харьяат болсон иргэдийн асуудал нэлээн анхаарал татаж байгаа асуудал болж байна. Тухайлбал, өнөөгийн байдлаар манай улсаас БНКаз.У-д шилжин суурьшисан иргэдээс **26644** иргэн хоёрдмол харьяалал үүсгээд байсны **17042** иргэнийг хялбаршуулсан журмаар харьяатаас гаргах асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьж Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлүүлсэн байна.

- Судалгаанаас үзэхэд гадаадын иргэд Монгол улс харьяат болох нь тооны хувьд харьцангуй буурсан, харин Монгол улсын иргэд өөрийн иргэний харьяаллаас гарах нь нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна. Тухайлбал, 2004 онд гадаадын 23²³ иргэн манай улсын харьяат болсон бол 2009 онд 12 иргэн Монгол улсын харьяат болжээ. 2004 онд Монгол улсын 70 иргэн иргэний харьяаллаасаа гарсан бол 2009 онд 276²³ иргэн тус улсын иргэний харьяаллаас гарчээ.
- Монголчууд урт хугацаагаар гадаадад амьдрах болсноор тэдний үр хүүхдүүд тухайн орныхоо иргэн болох нь цөөнгүй байгаа болон Монгол улсын харьяатаас гарсан иргэдийн тоо нэмэгдэж байгааг анхааран давхар иргэншлийг хуульчилах боломжийг судлах, хэрэгжүүлэх. Давхар иргэншлийн асуудал нь хоёр чиглэлтэй юм. Эхнийх нь аль ч орны иргэн манай улсын иргэнээр давхар байж болох нөхцөл. Удаах нь зөвхөн Монгол Улсын иргэн өөр аль нэг орны иргэн давхар байж болно гэсэн чиглэл юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн монгол хүнд л хамаатай асуудал, ялангуяа гадаадад аж төрж, тухайн орныхоо иргэншлийг нэгэнт авчихсан болон авах гэж буй монголчуудад хамаатай болно. Олон улсын туршлагаас үзэхэд ийм практик цөөнгүй бий. Тухайлбал, манай хойд хөрш ОХУ гэхэд 2002 оноос зөвхөн ОХУ-ын иргэдийн хувьд иргэний давхар харьяалалтай байж болохыг хуульчилжээ²⁴.
- Дотоодод ажилгүйдэл их байгаа нөхцөлд гадаадаас ажиллах хүчин олноор оруулахдаа компаний ашиг сонирхолд хөтлөгдөхгүй байх, гагцхүү шаардлагатай нөхцөлд гадаадаас тодорхой мэргэжил, мэргэшлийн ажиллах хүчин оруулахыг зөвшөөрч байх, өөрийн үндэсний мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэх ажлыг улам эрчимжүүлэхэд анхаарах зэрэг олон асуудлыг анхаарах шаардлагатай байгаа нь бидний хийсэн судалгаанаас харагдсан болно.

* * *

3. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ӨСӨЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хүн амын өсөлт

- Английн эдийн засагч Роберт Мальтусыг хүн ам судлалын “Загалмайлсан эцэг” хэмээдэг. Тэрээр хүн амын өсөлт геометр хуулиар өсч байхад үйлдвэрлэлийн өсөлт арифметик хуулиар өсөх учир хүн амыг өсөлтийг хязгаарлах хэрэгтэй гэсэн санааг гаргаж ирж байсан. Энэ нь хүн амын экспонциал загварын үндэс нь байхгүй.
- Мальтусын хүн ам үргэлж тогтмол хувиар өсдөг гэсэн хуулийг 1883 онд Верхолст (Verhulst) хүн амын өсөлт эхэндээ өсөөд хүн амын тоо ихсэхийн хэрээр, нийгмийн хөгжилтэй уялдан буурдаг гэж үзэн хүн амын логистик загварыг боловсруулсан. Өөрөөр хэлбэл хүн амын өсөлт нь шугаман функцээр илэрхийлэгдэж байсныг квадрат хэлбэртэй болгосон.

3.1 Хүн амын өсөлтийн прогноз /2050 он хүртэл/:

Ямар ч улс хүн ам зүй, насжилттай холбоотойгоор эдийн засаг, нийгмийн олон бэрхшээлтэй тулгарч байдаг. Ялангуяа манай улс сүүлийн жилүүдэд хүүхдийн мөнгө, Хүний хөгжил сангаас олгох мөнгө зэрэг халамжийн мөнгүүдийг олгож байгаа нь хүн амын өсөлтөд нөлөөлж байгаа бөгөөд төр засаг болон бодлого боловсруулагчид хүн ам зүй, түүний бүтцийн талаар оновчтой бодлого баримтлах нь чухал юм.

²³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэдээлэл

²⁴ Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаархи үндэсний дээд хэмжээний уулзалт. УБ., 2005 он, 51 дэх тал

Монгол Улсын хүн амын өсөлтөд гарч байгаа бодитой нөхцөл байдлуудыг харгалзан хүн амын өсөлтийн 2050 он хүртэлх урьдчилсан таамаглал, тооцооллыг 1995-2009 оны суурин хүн амын тоонд тулгуурлан тооцлоо.

Энэхүү таамаглал, тооцооллыг гаргахдаа:

1. Монгол Улсын хүн амын өсөлтийн экспоненциал загварыг ашиглан, эконометрик аргаар 2050 он хүртлэх хүн амын тоог тооцоолсон бөгөөд хүн амын өсөлтийн хэтийн тооцооны чанар нь тооллого явагдсан суурь оны хүн амын тоо, мэдээллийн чанар, хүн ам зүйн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн талаарх төсөөллийн бодит байдлаар хамаарна.

Хүн амын тооны өсөлтийн экспоненциал загвар:

Уг загварт хүн амын тоо экспоненциал хуулиар өсөх ба төрөлтөөр нэмэгдэж, нас баралтаар буурдаг гэж үздэг. Тус загвар нь дискрет байдлаар дараах хэлбэртэй байна.

$$P_{t+1} = P_t + T_t - N_t$$

Энд: $(t+1)$ -р үеийн хүн амын тоо
 P_t - t дүгээр үеийн хүн амын тоо
 N_t - t дүгээр үеийн нас барсан хүмүүсийн тоо

Дээрх загварт хүн амын цэвэр шилжих хөдөлгөөнийг оруулан тооцох ёстой бөгөөд энэ нь монгол улсын харьяатаас гарсан болон монгол улсын харьяат болон шилжиж ирсэн хүмүүсийн зөрүү юм. Энэ тоо нь манайд төдийлөн их байдаггүй тул ихэнхдээ шилжилт хөдөлгөөнийг " $M_t=0$ " байна гэж үздэг. Дээрх загварт шилжих хөдөлгөөнийг тооцоогүй бөгөөд төрөлт ба нас баралт нь хүн амын тоотой пропорциональ байдаг. Өөрөөр хэлбэл:

$$\begin{cases} T_t = \alpha * P_t \\ N_t = \beta * P_t \\ \alpha = \alpha - \beta \end{cases}$$

Энд: α – төрөлтийн коэффициент
 β – нас баралтын коэффициент
 α – цэвэр өсөлтийн коэффициент

Дээрх 2 тэгшитгэлийг оруулбал дискрет загвар нь дараах байдалтай болно.

$$P_{t+1} = (1 + \alpha)P_t$$

2000 - 2009 оны хүн амын төрөлт болон нас баралтын тоо болон тэдгээрийн зөрүү болох цэвэр өсөлтийн өөрчлөлтийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүн амын төрөлт, нас баралтын тоо болон цэвэр өсөлтийн өөрчлөлт /2000 - 2009 он/

Хүснэгт 1

Он	Хүн амын тоо /сая хүн/	Өөрчлөлт-ийн хувь	Төрөлт мян. хүн	Өөрчлөлт-ийн хувь	Нас баралт	Өөрчлөлт-ийн хувь	Цэвэр өсөлт	Өөрчлөлт-ийн хувь
2000	2407,5	1,43%	48721	-1,50%	15472	-3,93%	33249	-0,32%
2001	2442,5	1,45%	49658	1,92%	15999	3,41%	33659	1,23%
2002	2475,4	1,35%	46922	-5,51%	15857	-0,89%	31065	-7,71%
2003	2504,0	1,16%	45723	-2,56%	16006	0,94%	29717	-4,34%
2004	2533,1	1,16%	45501	-0,49%	16404	2,49%	29097	-2,09%

2005	2562,4	1,16%	45326	-0,38%	16480	0,46%	28846	-0,86%
2006	2594,8	1,26%	49092	8,31%	16682	1,23%	32410	12,36%
2007	2635,2	1,56%	56636	15,37%	16259	-2,54%	40377	24,58%
2008	2683,5	1,83%	63768	12,59%	15413	-5,20%	48355	19,76%
2009	2735,8	1,95%	69167	8,47%	16911	9,72%	52256	8,07%

Хүн амын тооны өсөлтийн прогнозыг хийхдээ төрөлтийн болон нас баралтын коэффициентийг тооцож, улмаар цэвэр өсөлтийн коэффициентийг тооцох шаардлагатай болдог.

Хүн амын төрөлт, нас баралтын цэвэр өсөлтийн коэффициент /2000-2009 он/

Хүснэгт 2

Он	Хүн амын тоо	Төрөлт	Төрөлтийн коэффициент	Нас баралт	Нас баралтын коэффициент	Цэвэр өсөлтийн хувь	1000 хүнд ногдох цэвэр өсөлтийн хувь
2000	2407,5	48,72	0,0202	15,47	0,0064	0,01381	1,381
2001	2442,5	49,66	0,0203	16,00	0,0066	0,01378	1,378
2002	2475,4	46,92	0,0190	15,86	0,0064	0,01255	1,255
2003	2504,0	45,72	0,0183	16,01	0,0064	0,01187	1,187
2004	2533,1	45,50	0,0180	16,40	0,0065	0,01149	1,149
2005	2562,4	45,33	0,0177	16,48	0,0064	0,01126	1,126
2006	2594,8	49,09	0,0189	16,68	0,0064	0,01249	1,249
2007	2635,2	56,64	0,0215	16,26	0,0062	0,01532	1,532
2008	2683,5	63,77	0,0238	15,41	0,0057	0,01802	1,802
2009	2735,8	69,17	0,0253	16,91	0,0062	0,01910	1,910
Дундаж хувь						0,01397	1,397

2. Таамаглалыг 3 хувилбараар дэвшүүлж тооцооллыг хийсэн бөгөөд хувилбар тус бүрийг ойлгомжтой байх үүднээс доорхи байдлаар ангилав.

✓ **Хувилбар 1:**

Он	Хүн амын тоо /мянган хүн/	Өсөлтийн хувь
1995	2251,3	2,01
1996	2283,1	1,41
1997	2315,6	1,42
1998	2349,1	1,45
1999	2373,5	1,04
2000	2407,5	1,43
2001	2442,5	1,45
2002	2475,4	1,35
2003	2504,0	1,16
2004	2533,1	1,16
2005	2562,4	1,16
2006	2594,8	1,26
2007	2635,2	1,56
2008	2683,5	1,83
2009	2735,8	1,95
дундаж өсөлтийн хувь		1,44

Суурин хүн амын тоо төрөлт, нас баралтын 1995-2009 оны жилийн эцсийн мэдээллүүдийг ашиглан тус бүр дээр нь таамаглалыг дэвшүүлсэн.

Хугацааны түүхэн өгөгдөл ашигласан загвараас харахад Монгол Улсын хүн ам 1995 оноос хойш жилд дундажаар 1.44 хувиар өссөн бөгөөд цаашид хүн амын цэвэр өсөлтийн коэффициентийг 1.40 хувиар өснө гэж таамаглалаа.

- ✓ **Хувилбар 2:** Хүн амын өсөлтийг 3 түвшинд тооцсон. 2009-2015 онд хүн амын дундаж өсөлт 1.7 хувь, цаашид эдийн засгийн өсөлт нэмэгдэхийн хэрээр хүн амын дундаж өсөлтийн коэффициентийг 2016 - 2030 онуудад 2.0 хувь, харин 2031-2050 онд хүн амын өсөлт харьцангуй буурч дундаж өсөлтийн коэффициентийг 1.3 хувь байхаар тус тус тооцсон болно.
- ✓ **Хувилбар 3:** Хүн амын өсөлтийг цаашид тогтвортойгоор нэмэгдэнэ гэж тооцож хүн амын өсөлтийн коэффициентийг 1.70 хувиар тооцсон.

Эдгээр хувилбар тус бүрийг 2009-2050 он тус бүрээр дэлгэрэнгүйгээр тооцвол

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 3 Монгол Улсын хүн амын өсөлтийн таамаглал 2050 он хүртэл 3 хувилбараар

Хувилбар 1

он	хүн амын тоо	өсөлтийн хувь
2009	2735,80	1,4%
2010	2774,02	
2011	2812,77	
2012	2852,07	
2013	2891,91	
2014	2932,31	
2015	2973,27	
2016	3014,81	
2017	3056,93	
2018	3099,63	
2019	3142,94	
2020	3186,84	
2021	3231,36	
2022	3276,50	
2023	3322,28	
2024	3368,69	
2025	3415,75	
2026	3463,47	
2027	3511,85	
2028	3560,91	
2029	3610,66	
2030	3661,10	
2031	3712,25	
2032	3764,11	
2033	3816,69	
2034	3870,01	
2035	3924,07	
2036	3978,89	
2037	4034,48	
2038	4090,84	
2039	4147,99	
2040	4205,94	
2041	4264,69	
2042	4324,27	
2043	4384,68	
2044	4445,93	
2045	4508,04	
2046	4571,02	
2047	4634,88	
2048	4699,63	
2049	4765,28	
2050	4831,85	


Хувилбар 2

он	хүн амын тоо	өсөлтийн хувь
2009	2735,80	1,7%
2010	2782,31	
2011	2829,61	
2012	2877,71	
2013	2926,63	
2014	2976,39	2,0%
2015	3026,98	
2016	3087,52	
2017	3149,27	
2018	3212,26	
2019	3276,50	
2020	3342,03	
2021	3408,88	
2022	3477,05	
2023	3546,59	
2024	3617,53	
2025	3689,88	
2026	3763,67	1,3%
2027	3838,95	
2028	3915,73	
2029	3994,04	
2030	4073,92	
2031	4126,88	
2032	4180,53	
2033	4234,88	
2034	4289,93	
2035	4345,70	
2036	4402,20	
2037	4459,42	
2038	4517,40	
2039	4576,12	
2040	4635,61	
2041	4695,88	
2042	4756,92	
2043	4818,76	
2044	4881,41	
2045	4944,86	
2046	5009,15	
2047	5074,27	
2048	5140,23	
2049	5207,05	
2050	5274,75	

Хувилбар 3

он	хүн амын тоо	өсөлтийн хувь
2009	2735,80	1,7%
2010	2782,31	
2011	2829,61	
2012	2877,71	
2013	2926,63	
2014	2976,39	
2015	3026,98	
2016	3078,44	
2017	3130,78	
2018	3184,00	
2019	3238,13	
2020	3293,18	
2021	3349,16	
2022	3406,09	
2023	3464,00	
2024	3522,89	
2025	3582,78	
2026	3643,68	
2027	3705,63	
2028	3768,62	
2029	3832,69	
2030	3897,84	
2031	3964,11	
2032	4031,50	
2033	4100,03	
2034	4169,73	
2035	4240,62	
2036	4312,71	
2037	4386,02	
2038	4460,59	
2039	4536,42	
2040	4613,54	
2041	4691,97	
2042	4771,73	
2043	4852,85	
2044	4935,35	
2045	5019,25	
2046	5104,58	
2047	5191,35	
2048	5279,61	
2049	5369,36	
2050	5460,64	

График 1



Прогнозын үр дүн:

- Хувилбар 1-н** хувьд 2050 он хүртэлх хүн амын цэвэр өсөлтийг өнгөрсөн 15 жилийн дунджаар цаашид 1.40 хувиар тогтвортой өснө гэж тооцсон бөгөөд 2050 онд манай улсын хүн ам **4 831 850** болно гэсэн таамаглал гарсан болно. Энэ таамаглалд төрөлт болон нас баралтыг огцом өөрчлөлтгүйгээр тооцсон болно.
- Хувилбар 2-н** хувьд таамаглалыг арай өөдрөг байдлаар буюу 2050 он хүртэлх хүн амын цэвэр өсөлтийг 3 байдлаар тооцсон. Үүнд: хүн амын амьжиргааны түвшин нэмэгдэхийн хэрээр төрөлт ихсэж, нас баралтыг харьцангуй буурна гэж тооцож 2009-2015 он хүртэл хүн амын цэвэр өсөлтийн коэффициентийг 1.7 хувиар өсгөвөл 3 026 980 хүн;
 - 2016 оноос уул уурхайн салбар хөгжиж Оюутолгой, Тавантолгойн олборлолтоос эдийн засаг харьцангуй өснө гэж тооцож 2016-2030 он хүртэл хүн амын цэвэр өсөлтийн коэффициентийг 2.0 хувиар тооцвол 4 073 920 хүн;
 - 2031 оноос хүн амын хурдацтай өсөлт харьцангуй буурна гэж тооцож 2031-2050 оны хүн амын цэвэр өсөлтийн коэффициентийг 1.3 хувиар өсгөвөл **2050 онд манай улсын хүн ам 5 274 750** болно гэсэн таамаглалыг гаргалаа.
- Хувилбар 3-н** хувьд хүн амын өсөлтийг цаашид тогтвортойгоор 1.7 хувиар өсгөн тооцоход 2050 онд манай улсын хүн ам **5 460 640** болно гэсэн таамаглал гарч байна.

1.2 Хүн амын өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ:

Дээрх хүн амын өсөлтийн таамаглал, прогнозыг хэр бодитойгоор таамагласныг шалгахын тулд “70-ийн дүрмээр” шалгаж үзье. 70-ийн дүрэм гэдэг нь хэдэн жилийн дараа хүн ам 2 дахин өсөхийг тооцоолж болдог. 2009 онд суурин хүн амын тоо 2735,8 мянга байсан бол 70-ийн дүрмийг ашиглан хэдэн онд манай хүн ам 5,4 сая болохыг тооцъё. Ингэхийн тулд:

$$\text{Хүн ам 2 дахин өсөхөд шаардагдах жил} = \frac{70}{1.397} = 50.1$$

Тооцооллоос харахад манай улсын хүн ам 50 жилийн дараа буюу 2060 онд 2 дахин өсч 5,5 сая хүн болохоор байна.

Нэг хүнд ногдох ДНБ болон төрөлт:

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг. Хүн амын өсөлт нь тухайн улсын эдийн засгийн өсөлтөөс хамаарах бөгөөд эдийн засгийн өсөлтийг нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, үйлдвэрлэлийн бүтээмж дээшлэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх, нас баралтын түвшин буурах, хүүхдийн эндэгдэл багасч байгаагаар тайлбарладаг. Эдийн засгийн хямралд өртсөн аливаа улс орны хувьд инфляцийн түвшин өндөр байдаг бөгөөд хоол хүнсний болон боловсрол эрүүл мэндийн үйлчилгээний өртөг үргэлж нэмэгдэж

байдаг. Үнийн өсөлт нь эргээд төрөлтийн түвшинд ч нөлөөлж байдаг байна. Өөрөөр хэлбэл хүмүүс өмнөх үеийнхтэй харьцуулахад хүүхэд өсгөх зардал өндөр болсноос төрөлтийн түвшин маш хурдацтай буурдаг байна. Улс орны эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох орлого болон төрөлтийн коэффициентын хоорондын хамаарлын шинжилгээнд 1995-2009 оны статистик мэдээллийг ашиглалаа.

Төрөлтийн коэффициент /2000-2009 он/


График 2



Манайх шиг бага буурай хөгжилтэй оронд нэг хүнд ногдох орлого хүн амын өсөлтөд нөлөөлдөг гэж үздэг. Хүн амын амжиргааны түвшин, орлогын түвшин сайжрахын хирээр хүн амын өсөлт нэмэгдэж байна.

Нас баралтын коэффициент


График 3



Хүн амын өсөлтөд төрөлтөөс гадна нас баралтын түвшинг оруулан тооцоолдог бөгөөд сүүлийн хэдэн жилийн тоон үзүүлэлтээс харахад нас баралтын коэффициент бараг тогтмол буюу 0,0062 хувьтай байна. /Хүснэгт 2/

Нэг хүнд ногдох ДНБ /2000-2009 он/

График 4




Мөн манай орны хувьд сүүлийн жилүүдэд төрөөс иргэдэд хүртээсэн халамжийн мөнгөнөөс

шалтгаалсан хүн амын өсөлт явагдсан гэж дүгнэж болохоор байгаа юм.

Хүн амын төрөлт болон нэг хүнд ногдох ДНБ –ний хоорондын харьцаа /2000-2009 он/

График 5



Гэр бүл, хүүхдэд хандсан төрийн бодлого:

Хүн амын өсөлтөнд нөлөөлөх бас нэг хүчин зүйл нь гэр бүл, хүүхэд рүү хандсан төрийн бодлого юм. Манай улсын хувьд 2006 оны 5 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулийн үйлчлэлийн хүрээнд /2009 оны 11 сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсон/ буюу 2005-2009 оны хооронд хүн амын төрөлт 45.3-69.2 мянган төрөлтөөр нэмэгдсэн гэж хэлж болохоор байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийг олгосон байдал 2000-2009 оны

Хүснэгт 4


	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Төрөлт /мян.хүн/	48721	49658	46922	45723	45501	45326	49092	56636	63768	69167
Төрөөс олгосон нийгмийн халамжийн мөнгө /мян.төг/	Жирэмсэний болон амаржсны*	2269.4	3563.6	4254.1	4189.6	4294.4	4134.9	2956.1	-	-
	Хүүхэд асарсанийн*	2866.7	3297.6	4343.7	4807.4	5705.8	5736.9	5645.5	1484.6	-
	Нярай хүүхдийн арчилгааны *	89.2	62.3	112.0	146.0	186.3	166.0	82.6	-	-
	Шинэ гэр бүлд**			-	-	-	-	11814.0	29724.0	17447.0
	Шинэ төрсөн хүүхдэд олгосон**			-	-	-	-	4111.0	5769.3	6381.5
	Хүүхдийн мөнгөн тэтгэмж***					18087.0	26249.4	33223.0	32761.2	32176.5
	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж								15753.6	16184.9
	Монгол улсын хөгжүүлэх сангаас 18 нас хүртэлх хүүхэд бүрт олгосон мөнгөн тэтгэмж								89958.1	89739.8

* - Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаарх холбогдох хуульд орсон өөрчлөлтийн дагуу 2006.07.01-ний өдрөөс олгогдохгүй болсон.

** - Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн хүрээнд 2006.01.01 өдрөөс эхлэн олгогдож эхэлсэн.

***-Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хүрээнд олгож эхэлсэн.

График 6



3.3 Хүн амын өсөлт ба эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарал /бодит байдал, прогноз/:

Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжил харилцан уялдаатай, нэг нэгэндээ нөлөөлөх зүй тогтолтой үйл явц юм. Эдийн засгийн хөгжил хүн амын өсөлтөд нөлөөлөхийн зэрэгцээ эргээд хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжилд нөлөөлдөг гэж үздэг. Энэ нь эдийн засгийн өсөлттэй уялдан хүн амын өсөлтөнд чухал өөрчлөлтүүд илэрч байхад, хүн амын өсөлт нь эдийн засгийн өсөлтөнд янз бүрээр нөлөөлж байдаг.

Зарим эрдэмтэн судлаачид юуны өмнө хөгжиж буй орнуудын хувьд нэн тэргүүнд хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хоорондын харилцан хамаарал байгааг авч үзэх буюу хүн амын өсөлт нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах уу, удаашруулах уу, эдийн засгийн хөгжилтэй хамааралгүй байна уу гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж үздэг. Эдийн засгийн өсөлтийн үр дүнд эрүүл мэндийн үйлчилгээ чанаржиж улмаар нас баралт буурч, дундаж наслалт нэмэгддэг.

Эдийн засгийн сонгодог, шинэ сонгодог хийгээд дотоод өсөлтийн онолоор эдийн засгийн өсөлтөнд:

- Капиталын өсөлт /хөрөнгө оруулалт/;
- Хөдөлмөрийн өсөлт /ажлын байрны өсөлт/;
- Хүмүүн капиталын өсөлт /мэдлэг, дадлага туршлага, ур чадвар гэх мэт/;
- Институцын хөгжил /засаглал, хууль тогтоомж, дүрэм журам, татвар гэх мэт/

зэрэг үзүүлэлтүүд нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг.

Манай улсын хувьд эдийн засгийн өсөлтөнд ямар ямар хүчин зүйлс, ямар хэмжээгээр нөлөөлдгийг тодорхойлох зорилгоор Кобба-Дугласын үйлдвэрлэлийн функцийг сонгон ашиглалаа.

Хүн амын өсөлт ба эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг харуулахын тулд:

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Y_t — t дүгээр жилийн бодит ДНБ (зэрэгцүүлэх үнээр)

K_t — t дүгээр жилийн капиталын хэмжээ, үндсэн хөрөнгө

L_t — t дүгээр жилийн ажиллах хүч, ажиллагсад

Сонгодог онолоор тухайн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ нь капиталын болон хөдөлмөрийн хэмжээнээс хамаардаг гэж үздэг. Түүнийг:

$$Y_t = A \times K_t^\alpha \times L_t^\beta \times E^{at} \quad (1) \text{—Кобба Дугласын үйлдвэрлэлийн функцээр илэрхийлдэг.}$$

Энд:

$$\begin{cases} Y_{2009}=3564,3 \\ K_{2009}=20668,5 \\ L_{2009}=1006,3 \end{cases}$$

Хэрвээ дээрх хамаарал оршин байвал тэдгээрийн өсөлтийн хувиуд болох

$$\begin{cases} g_{Yt} \text{— бодит ДНБ-ний өсөлтийн хувь, эдийн засгийн өсөлт} \\ g_{Kt} \text{— капиталын өсөлтийн хувь} \\ g_{Lt} \text{— ажиллагсадын тооны өсөлтийн хувийн хооронд} \end{cases}$$

$$g_{Yt} = A + \alpha * g_{Kt} + \beta * g_{Lt} \quad (2) \text{—ийм хамаарал байдаг.}$$

$$\begin{cases} \alpha \text{— капиталаас хамаарсан бүтээгдэхүүний мэдрэмж;} \\ \beta \text{— хөдөлмөрөөс хамаарсан бүтээгдэхүүний мэдрэмж;} \\ a \text{— бие даасан шинэслэх ухаан технологийн дэвшлийн коэффициент;} \end{cases}$$

α , β , a — нь Кобба Дугласын үйлдвэрлэлийн функцийн параметрууд бөгөөд тухайн хүчин зүйлсийн үйлдвэрлэлийн хэмжээнд нөлөөлөгч үзүүлэлтэд үзүүлэх мэдрэмжийн коэффициент байна. Үнэлгээнд ашигласан үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 5

Он	2005 оны зэрэгцүүлэх үнээр бодит ДНБ /сая төг/	2005 оны зэрэгцүүлэх үнээр капиталын хэмжээ /сая.төг/	Нийт хүн амын тоо /мян.хүн/	Ажилчидын тоо /мян.хүн/
2000	2103.9	11963.7	2407.5	809,0
2001	2125.5	10500.5	2442.5	832,2
2002	2211.5	11967.5	2475.4	870,7
2003	2342.7	12163.5	2504.0	926,5
2004	2591.6	15335.8	2533.1	950,5
2005	2779.6	12346.7	2562.4	968,3
2006	3017.4	16781.4	2594.8	1009,9
2007	3316.5	15954.7	2635.2	1024,1

Судалгааны эмхтгэл, IX боть

2008	3620.5	21787.7	2683.5	1047,1
2009*	3564.3	20668.5	2735.8	1006,3

*-Урьдчилсан гүйцэтгэлээр авсан болно.

Хүн амын дотор эзлэх ажиллагсадын эзлэх хувийг γ гэе. Тэгвэл $L_t = \gamma * P_t$ болно.Эндээс $g_{Lt} = g_{Pt}$ гэж үзвэл (2) тэгшитгэлийг

$$g_{t\gamma} = A + \alpha \times g_{Kt} + \beta \times g_{Pt}$$

(3) хэлбэрээр бичиж болно.

Эндээс 2000-2009 оны тоон өгөгдлүүд дээр үнэлгээ хийхэд $\lambda = 0.016337$ болно.

$$G_{1999} = 1.6 + 0.223672 * (-14.81) + 0.817254 * 2.65 = -0.863$$

$$G_{2008} = 1.6 + 0.223672 * 36.56 + 0.817254 * 2.25 = 7.008 \text{ гэх мэтээр тооцоолж болно.}$$

Шинжилгээнд ашигласан статистик мэдээллүүд /1995-2009 он/

Хүснэгт 6

Он	Бодит ДНБ	Капиталын хэмжээ	капиталын өсөлтийн хувь	ажиллах хүч	ажиллагсадын тооны өсөлтийн хувь	хүн амын тоо	хүн амын өсөлтийн хувь	ажиллагсадын хүн амын дотор эзлэх хувь	өөрчлөлтийн хувь	ДНБ-ний өсөлтийн хувь
	GDP	K	g_{Kt}	g_{Lt}		pop		gamma		
1995	1830,3	9147,1		767,6	1,03	2251,3		0,34097		
1996	1873,3	10886,8	19,02	769,6	0,26	2283,1	1,41	0,33708	-1,14	7,008
1997	1948,2	10803,2	-0,77	765,1	-0,58	2315,6	1,42	0,33041	-1,98	2,592
1998	2017,1	10319,6	-4,48	792,6	3,59	2349,1	1,45	0,33740	2,12	1,781
1999	2081,9	8791,6	-14,81	813,6	2,65	2373,5	1,04	0,34278	1,59	-0,863
2000	2103,9	11963,7	36,08	809,0	-0,57	2407,5	1,43	0,33603	-1,97	10,841

2001	2125,5	10500,5	-12,23	832,2	2,87	2442,5	1,45	0,34075	1,40	0,053
2002	2211,5	11967,5	13,97	870,7	4,63	2475,4	1,35	0,35178	3,24	5,826
2003	2342,7	12163,5	1,64	926,5	6,41	2504,0	1,16	0,37001	5,18	2,911
2004	2591,6	15335,8	26,08	950,5	2,59	2533,1	1,16	0,37523	1,41	8,383
2005	2779,6	12346,7	-19,49	968,29	1,87	2562,4	1,16	0,37788	0,71	-1,814
2006	3017,4	16781,4	35,92	1009,9	4,30	2594,8	1,26	0,38920	3,00	10,667
2007	3316,5	15954,7	-4,93	1024,1	1,41	2635,2	1,56	0,38862	-0,15	1,771
2008	3620,5	21787,7	36,56	1047,1	2,25	2683,5	1,83	0,39019	0,40	11,275
2009	3564,3	22657,6	3,99	1006,3	-3,90	2735,8	1,95	0,41025	5,14	4,086

Дээрх мэдээлэл дээр үндэслэн статистик шинжилгээний судалгааны багц программ Eviews 3.1 дээр регрессийн шинжилгээг хийхэд үр дүн нь дараахь байдалтай гарч байна.

Dependent Variable: LOG(GDP)				
Method: Least Squares				
Date: 09/28/10 Time: 16:50				
Sample: 1995 2008				
Included observations: 14				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
LOG(K)	0.223672	0.108309	2.065132	0.0633
LOG(L)	0.817254	0.148905	5.488418	0.0002
@TREND+1	0.016337	0.003676	4.444131	0.0010
R-squared	0.958379	Mean dependent var		7.767848
Adjusted R-squared	0.950812	S.D. dependent var		0.218091

S.E. of regression	0.048369	Akaike info criterion	-3.032502
Sum squared resid	0.025735	Schwarz criterion	-2.895562
Log likelihood	24.22752	Hannan-Quinn criter.	-3.045179
Durbin-Watson stat	0.983427		

Үүнээс (3) тэгшитгэлийг сэргээн бичвэл:

$$gt_y = A + \alpha \times g_{Kt} + \beta \times g_{Pt}$$

Дээрх тэгшитгэл дээр γ – г хугацаанаас хамааран өөрчлөгдөхгүй гэж тооцсон бол одоо хугацаанаас хамааран өөрчлөгдөнө гэж үзвэл ажиллагсадын тооны өөрчлөлт нь:

$$g_{Lt} = g_{Yt} + g_{Pt} \text{ болно.}$$

$$g_{Yt} = A + \alpha * g_{Kt} + \beta_1 * g_{Yt} + \beta_2 * g_{Pt} \quad (4) \text{ болно.}$$

Үүнээс $G_{Yt} = 1.6 + 0.223672 * 36.56 + 0.817254 * 2.25 + 1.004 * 0.39019 = 12.008$ (хүн амын бүтцийг оруулан тооцоолсноор) γ нь хүн амын насны бүтэцтэй холбоотой. Цаашид манай улсын хувьд γ нь 2030-2040 оны хооронд өсөх хандлагатай байгаа бөгөөд харин 2040 оноос хойш 1990 оны дараахь төрөлтийн бууралтаас шалтгаалан буурах хандлагатай байна.

Энэхүү томъёогоор эдийн засгийн өсөлт болон хүн амын 2009-2050 оны хоорондын өсөлтийн хоорондын хамаарлын таамаглалыг энэ бүлгийн 3.1-т хэсгийн хувилбараар авч үзсэн **прогнозын үр дүн:**

- Хувилбар 1-н хувьд:** Хүн амын өсөлтийн хувийг дунджаар **1.4 хувь** цаашид тогтвортойгоор 2010-2050 он хүртэл өсөж, капиталаас хамаарсан бүтээгдэхүүний мэдрэмж буюу хөрөнгө оруулалтыг
 - 10 хувь гэвэл манай улсын эдийн засгийн өсөлт 5.7 хувиар;
 - 15 хувь гэвэл 6.8 хувь;
 - 20 хувь гэвэл 8.0 хувиар өсөх дүн гарч байна.
- Хувилбар 2 -н хувьд:** Хүн амын өсөлтийг энэхүү бүлгийн 3.1-т дурьдсанаар **1.7, 2.0, 1.6 хувь** гэсэн хувилбар тус бүр дээр хөрөнгө оруулалтыг 10-20 хувиар тооцвол манай улсын эдийн засаг дараахь хувиар өсөх таамаглал гарч байна.

		Хүн амын өсөлтийн коэффициент		
Капиталаас хамаарсан бүтээгдэхүүний мэдрэмж		2010-2015 1.7%	2016-2030 2.0 %	2031-2050 1.3 %
	10%	6.0	6.2	5.6
	15%	7.1	7.3	6.8
	20%	8.2	8.5	7.9

- Хувилбар 3-н хувьд:** Хүн амын өсөлтийн хувийг дунджаар **1.7 хувь** тогтвортойгоор 2010-2050 он хүртэл өсөж, капиталаас хамаарсан бүтээгдэхүүний мэдрэмж буюу хөрөнгө оруулалтыг доорх хувиар тооцвол манай улсын эдийн засгийн өсөлтийн хувь
 - 10 хувь 5.6 хувиар;

- 15 хувь гэвэл 6.8хувиар;
- 20 хувь гэвэл 7.9 хувиар тус тус өсөх дүн гарч байна.

Үүнээс харахад эдийн засгийн өсөлтөнд капиталын нөлөө болон хүн амын өсөлтийн коэффициентын нөлөө хамгийн их байх бөгөөд харин хөдөлмөрөөс хамаарсан бүтээмжийн мэдрэмж болон эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх бусад хүчин зүйлс болох хүмүүн капитал, институцын хөгжлийг дээрх Eviews 3.1 дээр регрессийн шинжилгээний үр дүнгээс тооцсон тогтмол тоогоор авсан болно.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2

БҮЛЭГ

НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУЮУ МЭРГЭШЛИЙН
ХОЛБООДЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХИ
ХБНГУ-ЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Захиалагч: Д-р Д. Энхбат, УИХ-ын гишүүн
Судлаач: Д-р Г. Алтан-Оч, ахлах референт
Судалгааны хугацаа: 2011.05.05 - 06.14
Судалсан байдал: Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол доорхи эх сурвалж буюу сайтын мэдээллийг ашигласан. Үүнд:

1. Мэргэшлийн холбоо/Berufsverband (Wikipedia) <http://de.wikipedia.org/wiki/Berufsverband>
2. Биет эвлэл/Kürperschaft (Wikipedia) <http://de.wikipedia.org/wiki/K%C3%B6rperschaft>
3. Мэргэшлийн эрхийн биет эвлэл/Berufsständische Kürperschaft (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Berufsst%C3%A4ndische_K%C3%B6rperschaft
4. Эрхийн төлөөллийн байгууллага/ Standesvertretung (Wikipedia) <http://de.wikipedia.org/wiki/Standesvertretung>
5. Мэргэшлийн эрхийн эрхзүй/Standesrecht (Wikipedia) <http://de.wikipedia.org/wiki/Standesrecht>
6. Өөрийн удирдлага/Selbstverwaltung (Wikipedia) <http://de.wikipedia.org/wiki/Selbstverwaltung>

Мэргэшлийн холбоо гэдэг нь тодорхой мэргэшлийг эрхлэхэд тавигдах шаардлага, нөхцлийг тогтоох, хөгжүүлэх зорилго бүхий хувийн эрхт биет эвлэлийг хэлнэ. Мэргэжлийн холбоо нь сонирхлын холбооны нэг төрөл юм.[1]

ХУУЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Биет эвлэл-Хүний гишүүнчлэлтэй, тухайн үеийн гишүүдийн бүрэлдэхүүнээс үл хамааран оршдог холбоо буюу улстөрийн намыг хэлнэ. Ерөнхийдөө хуулийн этгээд байх ба өөрийн дээд төвшний хуулийн этгээдийн хэсэг ("бие даасан бус биет эвлэл") байж болно. "Бие" нь бодит хүн, эсвэл хуулийн этгээдээс бүрдэнэ. Тодорхой гишүүн солигдохоос үл хамааран оршдог. Дотор нь доорхи байдлаар ангилна:

Хувийн эрхт биет эвлэл (Үндсэн хэлбэр: олон тооны эдийн засгийн холбооны төрөл бүхий бүртгэлтэй холбоо, Жишээ нь: Хувьцаат компани/нийгэмлэг, Хязгаарлагдмал хариуцлагатай компани/нийгэмлэг, эсвэл Хоршоо)

Нийтийн эрхт биет эвлэл (Жишээ нь: Холбооны улс, Муж улсууд, Аймаг, Сумд (орон нутгийн байгууллага); Их сургуулиуд, Их эмч нарын, Апотекчдийн, Шүдний эмч нарын г.м. танхимууд; хоршмол (корпорацилагдсан) христийн сүмүүд, бусад шашны болон ертөнцийг үзэх үзлийн нийгэмлэгүүд)

Доорхи хязгаарлалтуудтай:

Холбоо (эрхзүйн)-нийтийн эрхт биет эвлэлээс бусад бодит хүн буюу хуулийн этгээдийн сонирхлын бүлгийн дээд ойлголт.

Нийгэмлэг-гишүүнгүй, харин хувь нийлүүлэгчтэй. Хувь нийлүүлэгчийн байгаа эсэхээс оршин тогдох нь хамаардаг.

Төрийн байгууллага-гишүүнгүй, харин хэрэглэгчтэй. Жишээ нь: Боловсролын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хэрэгцээний байгууллага г.м.

Сан-хүнээс хамааралгүй.

Мөн түүхэн уламжлалаар нэгдэл, корпораци нь биет эвлэлийн нэг хэлбэр юм.[2]

МЭРГЭШЛИЙН ХОЛБООНЫ ҮҮРЭГ ЗОРИЛГО[1]

Мэргэшлийн холбоодын ажил нь гадагшаага ижил мэргэшлийн аль болох олон хүний сонирхлыг нэгтгэн багцалж, энэхүү ашиг сонирхлыг ерөнхийдөө гэрээт талууд (жишээлбэл, ажил олгогч, ажил гэрээлэгч, олон нийтийн/төрийн байгууллага, хууль тогтоогч) болон олон нийтийн дунд хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Дотоод ажил нь ихэвчлэн тулгамдаад байгаа мэргэшлийн аливаа асуудлыг дэвшүүлж, хэлэлцэж, тэгээд шийдвэрлэх байдлаар явагдана. Мэргэшлийн холбоод нь татвараа төлсөн гишүүддээ хариуд нь ихэвчлэн мэргэшилтэй холбоотой мэдээлэл давуу эрхтэйгээр өгөх, мэргэжил эзэмших болон мэргэшил дээшлүүлэх боломжоор хангах, болон бусад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг.

МЭРГЭШЛИЙН ЭРХИЙН БИЕТ ЭВЛЭЛ (ТАНХИМ) БУЮУ ЭРХИЙН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГА

Мэргэшлийн эрхийн биет эвлэл (танхим) гэж ихэвчлэн нийтийн эрхт, тодорхой академи мэргэшлийг төлөөлсөн, улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан, мэргэшлийн өөрийн удирдлагад чиглэсэн үүрэг зорилго бүхий биет эвлэлийг хэлнэ.[3]

Танхимууд нь Ажил олгогчдын холбоо болон Үйлдвэрчний эвлэл мэтийн хувийн эрхт эвслээс ялгаатай.[3]

Эдгээр танхимуудыг мөн Эрхийн төлөөллийн байгууллага буюу Эрхийн хэв журам ч гэж хэлдэг. Тэдний хамаарах хүрээ нь харгалзах Танхимын муж юм.[3]

Эрхийн төлөөллийн байгууллагууд нь мэргэшлийн эрхийг томъёолох (тодорхойлох), төрийн хуулийг гаргахад баримтлах чиг шугамыг тодорхойлох замаар хууль тогтоох үүрэгтэй.[4]

Өөрт ногдох төрийн үүргээс гадна эдгээр танхимууд нь гишүүдийнхээ ашиг сонирхлыг төлөөлдөг. Мөн үндсэн дүрэм хүчин төгөлдөр үйлчилнэ. Тэр нь хувь хүний хувьд гишүүдээрээ, ажил хэргийн хувьд үүрэг хариуцлагын тойргоор хязгаарлагдана. Ихэнх тохиолдолд, албадан гишүүнчлэлтэй.[3]

Төр танхимыг хянах (Төрийн хянан шалгах байгууллага/"Төрийн аудитын ерөнхий газар" [ГА]) үүрэг гүйцэтгэнэ. [3]

Танхимуудын жишээ дурьдвал:[3]

- Чөлөөт мэргэжлийн
 - Эмч нарын танхим (Холбооны эмч нарын танхим орохгүй, энэ нь хувийн эрхт эвлэл юм)
 - Шүдний эмч нарын танхим
 - Малын эмч нарын танхим
 - Сэтгэл, мэдрэлийн эмч нарын танхим
 - Апотекдийн танхим
 - Өмгөөлөгчдийн танхим, Холбооны өмгөөлөгчдийн танхим (Германы

- өмгөөлөгчдийн холбоо (DAV) нь үүний эсрэг орон нутгийн өмгөөлөгчдийн холбоог нэгтгэсэн хувийн эрхт нэгдэл)
- Нотаратчдийн танхим
 - Татварын зөвлөхийн танхим
 - Эдийн засгийн шалгагчдын танхим
 - Патентын өмгөөлөгчдийн танхим
 - Архитекторчдын танхим
 - Инженерүүдийн танхим
 - Үйлдвэрлэл, үйлчилгээний
 - Аж үйлдвэр, Худалдааны танхим
 - Гар урчуудын танхим
 - Эдийн засгийн танхим (Австри улс)
 - Хөдөө аж ахуйн
 - Хөдөө аж ахуйн танхим
 - Ажилчдын
 - Бремен улсын ажилчдын танхим
 - Заарланд улсын хөдөлмөрийн танхим
 - Ажилчид болон албан хаагчдын танхим (Австри улс)

Дээрх чөлөөт мэргэжлийн ажил эрхлэлтийг эрхийн төлөөллийн байгууллагын хяналтаар зохицуулдаг. [4]

Танхимуудын үүрэг гэвэл: Танхимууд мэргэшлийн зөвшөөрөл олгох ба хэрэв зөрчил гаргавал зөвшөөрлийг татаж авах (хүчингүй болгох) болон торгууль хүлээлгэнэ. Мэргэжлийн сургалтанд нөлөөлнө, шалгалтанд баримтлах шугамыг тодорхойлно. Цаашилбал, тодорхой албан тушаал хаших болзол, нөхцлийг тогтооно (жишээлбэл, нарийн мэргэжил эзэмших мэргэшил дээшлүүлэх сургалтын төрөл). [3]

Танхимууд нь хураамж төлөлтийг журамлаж болно. Ихэвчлэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр энэхүү журмыг тогтоодог. Эцсийн тайлан тавихад дур зоргоор аашилахаас сэргийлэх зорилгоор ингэж зохицуулдаг. [4]

МЭРГЭШЛИЙН ЭРХИЙН ЭРХЗҮЙ [5]

Мэргэшлийн эрхийн эрхзүй гэж төрийн зүгээс хариуцлагаа хүлээн өөрийн удирдлагыг шилжүүлсэн эрхзүйг хэлнэ. Энэ нь эхний ээлжинд чөлөөт мэргэжлийн (уламжлалын дагуу эмч болон өмгөөлөгчдийн) мэргэшлийн эрхэд хамаарна. Мэргэшлийн эрхийн эрхзүй нь -зарим тохиолдолд өнөөдрийг хүртэл- эхлэл төдий хуульчлагдан зохицуулагдсан бөгөөд ихэвчлэн уламжлалт зан үйлийн эрхзүйд суурилсан байдаг.

Мэргэшлийн эрхийн эрхзүйд холбогдох эрхийн байгууллагын бүтцэд байх орон тооны бус (хүндэт/honorary [ГА]) шүүх хяналт тавьдаг. Бүх мэргэжлийн хувьд ингэж зохицуулсан байдаг. Эрхзүйн талаас нь авч үзвэл, төрийн дээд тогтоомж (хууль)-ийн дагуу шилжүүлсэн өөрийн удирдлага гэсэн үг юм.

Холбооны үндсэн хуулийн цэцийн 1987.07.14-ний өдрийн “1 BvR 537/81” тоот шийдвэрээр

төрийн хяналтыг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэхийн тулд Шийдвэрлэх онолыг баталсан. Үүний дагуу удаан хугацаагаар хүлээсний эцэст, 1997 онд Өмгөөлөгчдийн мэргэжлийн журмыг хуульчлан баталсан юм. Ингэснээр илүү либералчлагдсан бөгөөд тухайлбал, үйл ажиллагаагаа рекламдан сурталчилахыг зөвшөөрдөг болсон.

Энэхүү онол нь шийдвэрлэх буюу хамгийн чухал, амин чухал шийдвэрийг л парламент өөрөө гаргаж байх тухай юм. Шийдвэрлэх онолын хүрээнд, шийдвэрлэх асуудал гэвэл эрх чөлөөтэй байх эрх, тэгш байх эрхийн тодорхой асуудал байсан ч хамаагүй, хүний үндсэн эрхийг баталгаажуулахад амин чухал бүх асуудлыг багтаана. Ялангуяа, үндсэн эрхэд хамаарах оролцох эрх, хамгаалах үүргийг нарийвчлан зохицуулсан асуудал орно.²⁵

ӨӨРИЙН УДИРДЛАГА[6]

Эрхзүйн шинжлэх ухааны хүрээнд өөрийн удирдлага гэж хувийн хариуцлагаа хүлээсэн, эрхзүйн хувьд бие даасан байгууллага (хуулийн этгээд)-д захиргааны үүргийг шилжүүлэхийг хэлнэ. Тодорхойлолтын дагуу, түүний эсрэг талд нь төрийн захиргааны ойлголт байдаг. Өөрийн удирдлагын нийтлэг зохион байгуулалтын хэв маяг бол нийтийн эрхт биет эвлэл юм. Эдгээр нь өөрийн тогтоосон нормын дагуу байгуулагдах ба бие даасан (автоном) үндсэн дүрэмтэй байдаг. Мөн ихэвчлэн гишүүдээсээ татвар хураадаг.

Өөрийн удирдлагын байгууллагуудыг дотор нь 4 хувааж ангилдаг: Орон нутгийн өөрийн удирдлага (жишээлбэл, аймаг, сум), **мэргэшлийн эрхийн болон иргэний өөрийн удирдлага** (жишээлбэл, танхимууд, анчдын холбоо, гал сөнөөгчдийн холбоо), соёлын өөрийн удирдлага (жишээлбэл, их-дээд сургуулиуд, нийтийн эрхт радио өргөн нэвтрүүлгийн байгууллага) болон нийгмийн өөрийн удирдлага (нийгмийн даатгалын байгууллага).

Германд шашны нийгэмлэгүүдийн эрхзүйг Сүмийн өөрийгөө тодорхойлох эрхзүй гэж нэрлэдэг. Шашны нийгэмлэгүүд нь төрийн ямар ч оролцоогүйгээр өөрөө өөрийгөө зохицуулдаг бөгөөд төрөөс шашныг тусгаарлах үндсэн хуулийн заалтын дагуу сүм нь төрийн хэсэг биш учир “захиргаа” гэсэн ойлголт байхгүй. Иймээс төрийн хэвийн ажиллагааг хангах зорилго бүхий эрхзүйн хяналт байхгүй. Сүмийн төрийн хяналт бий болговол тэр нь үндсэн хууль зөрчих болно.

Түүнээс гадна иргэний эрхт холбооны автоном нь мөн зөв хуулийн ойлголтын дагуу өөрийн удирдлагад хамаарахгүй.

Хэдийгээр төр өөрийн удирдлагын байгууллагуудад тодорхой тоглолтын орон зай өгч байгаа боловч эдгээр нь нөгөө талаасаа эрхзүй болон хуулийн зарчмуудыг хангах ёстой. Энэ нь эрхзүйн хяналтаар хэрэгжинэ. Өөрийн удирдлагын байгууллагуудад өөрийнх нь захиргаа гадуур нэмэлт үүрэг даалгавар шилжүүлэн өгсөн бол (төрийн үүрэг) Мэргэжлийн хяналтын байгууллагыг ажиллуулдаг.



ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

²⁵ Шийдвэрлэх онол/Wesentlichkeitstheorie <http://de.wikipedia.org/wiki/Wesentlichkeitstheorie>

**ЦЭРГИЙН ТЭТГЭВЭР БОЛОН НЭГ УДААГИЙН ТЭТГЭМЖ АВСАН
ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ТАЛААРХ СУДАЛГАА**
(Лавалгаа, мэдээлэл)

Б. Мөнхцэцэг, А. Пагма

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн дагуу цэргийн алба хаасан тэтгэвэр болон нэг удаагийн тэтгэмж авсан цэргийн албан хаагчдын тухай мэдээлэл

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль нь 1994 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш 1999, 2000, 2002, 2003, 2004, 2005, 2008, 2009, 2010 онуудад уг хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ. 2010 оны 7 дугаар сарын 02-ны өдөр тус хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийн дагуу Засгийн газраас 2011 оны 2 дугаар сарын 09-ний өдөр 38 дугаар тогтоолын хавсралтаар /Тогтоолыг хавсаргав/ “Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох Журмыг” баталсан байна.

Энэхүү судалгаанд Монгол улсын Зэвсэгт хүчин болон Хил хамгаалах Ерөнхий газрын хэмжээнд “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн дагуу цэргийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж авсан хүний тоо, түүний дотор 2000 оноос өмнө уг тэтгэмжийг авсан хүний тоог нэгтгэн гаргасан болно.

Зэвсэгт хүчний Жанжин штабын хүний нөөцийн газраас гарган ирүүлсэн судалгаанаас үзэхэд нийт Зэвсэгт хүчний хэмжээнд 1994 оноос 2011 оны эхний хагас хүртэлх байдлаар цэргийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийг нийт **2103** цэргийн албан хаагчид олгосон бөгөөд үүнээс 2000 оноос өмнө тэтгэвэрт гарсан цэргийн албан хаагч **820** цэргийн албан хаагч байна.

Хил хамгаалах Ерөнхий газрын хэмжээнд 1994 оноос 2010 оныг дуустал хугацаанд цэргийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийг нийт **1418** цэргийн албан хаагчид олгосон бөгөөд үүнээс 2000 оноос өмнө тэтгэвэрт гарсан цэргийн албан хаагч **350** цэргийн албан хаагч байна.

Цэргийн алба хаасан тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тухай мэдээллийг улсын хэмжээнд Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн судалгааны дагуу гаргав. Цэргийн алба хаасны тэтгэвэрт 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт **14009** хүн хамрагдаж Нийгмийн даатгалын сангаас **7 435,8 сая** төгрөгийн тэтгэвэр олгогдсон байна. Үүнээс 2000 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нь **5165** хүн **3 095,7** сая төгрөгийн тэтгэвэр авчээ. Түүнчлэн Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийт **9390** хүн мөнхүү тэтгэвэрт хамрагдсан ба 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар тэдэнд **5 120.9 сая** төгрөгийн тэтгэвэр олгогдсон байна. Үүнээс 2000 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нь **3844** хүн **2 357,0** сая төгрөгийн тэтгэвэр авчээ²⁶.

Нийгмийн даатгалын сангаас олгогддог бусад тэтгэвэр, тэтгэмжүүдэд цэргийн хүмүүс хамрагддаггүй бөгөөд тусдаа “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуулиар зохицуулагддаг. Цэргийн алба хаасны тэтгэвэр авагчдын тоо ба авч байгаа

²⁶ УНДЕГ -аас ирүүлсэн тайлангаас

Судалгааны эмхтгэл, IX боть

тэтгэврийн хэмжээг / 2000 оноос өмнө ба нийт тэтгэвэр авагчид/ аймаг, нийслэл, дүүргээр гаргаж Хавсралт №1-д үзүүлэв.

* * *

ЦЭРГИЙН АЛБА ХААСНЫ ТЭТГЭВЭР АВАГЧДЫН СУДАЛГАА

Хавсралт №1

2011 оны 1 улирлын байдлаар /сая төгрөгөөр/

		Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоолгосон		Үүнээс 2000 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон	
		Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
1	Архангай	124	54.4	26	13.2
2	Баян-Өлгий	219	109.9	29	16.8
3	Баянхонгор	82	37.5	18	8.8
4	Булган	138	69.5	23	12.4
5	Говь-Алтай	105	50.9	14	6.8
6	Дорноговь	276	144.9	94	53.4
7	Дорнод	399	195.1	98	53.6
8	Дундговь	87	43.9	22	13.1
9	Завхан	117	54.7	23	12.3
10	Өвөрхангай	210	103.5	52	29.1
11	Өмнөговь	216	115.6	68	37.2
12	Сүхбаатар	221	102.8	60	32.9
13	Сэлэнгэ	461	235.2	172	95.2
14	Төв	306	149.4	88	49.4
15	Увс	146	68.7	27	15.3
16	Ховд	175	89.7	45	23.8
17	Хөвсгөл	272	132.8	68	36.5
18	Хэнтий	132	63.4	40	21.7
19	Дархан-Уул	411	213.9	161	91.4
20	Орхон	464	249.2	178	106.9
21	Говьсүмбэр	58	29.9	15	9.1
22	Нийслэл	9,390	5 120.9	3,844	2 357.0
	Чингэлтэй	1,176	617.9	457	276.5
	Сонгинохайрхан	1,916	996.1	697	413.2

	Баянгол	1,215	676.2	530	334.3
	Хан-Уул	831	460.5	371	231.7
	Баянзүрх	2,693	1,516.0	1132	697.9
	Сүхбаатар	1,025	578.2	473	296.8
	Багануур	192	99.6	61	35.0
	Налайх	311	161.7	116	67.8
	Багахангай	31	14.7	7	3.7
Нийт		14,009	7,436	5,165	3,096



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“АЛСЛАГДСАН БҮС” НУТГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДЭНД ОЛГОДОГ ХӨНГӨЛӨЛТ, НЭМЭГДЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА

Захиалагч: УИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга Ж. Сүхбаатар
Судлаач: Ахлах референт Д-р Г. Алтан-Оч
Судалгааны хугацаа: 2011.06.02 - 10
Судалсан байдал: Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол доорхи эх сурвалж буюу сайтын мэдээллийг ашигласан. Үүнд:

1. Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орнуудын туршлага-Бодлогын шинжилгээ, УИХТГ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв, 2009, file://МУ-ын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарагдах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орнуудын туршлага.doc

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зах зээлийн тогтолцоотой улс орнуудад бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлохдоо доорхи 9 шалгуур үзүүлэлтийг ашигладаг. Үүнд:

- Хүн амын амьжиргааны төвшин /нэг хүнд ноогдох бодит орлого, ажилгүйдлийн төвшин/ г.м.;
- Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ;
- Аж үйлдвэрийн бүтэц;
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын байдал;
- Хүн ам зүйн үзүүлэлтүүд;
- Эдийн засгийн голлох үзүүлэлт;
- Нийгмийн хөгжлийн ерөнхий төвшин;
- Байгалийн нөхцөл, нөөц баялаг;
- Газарзүйн байрлал.

Улс орнууд өөрийн онцлогийг харгалзан дээрх шалгуур үзүүлэлтүүдээс сонгон аль нэгийг буюу хэсэг бүлгийг авч ашигласан байдаг. Жишээ нь: Скандинавын орнууд байгалийн нөхцөл, нөөц баялаг, газарзүйн байрлалыг, Франц хотжилтын төвшинг, Англи хүн амын нягтаршил, тухайн бүс нутгийн төвөөс алслагдсан байдлыг онцгойлон сонгон авч бүсийн хөгжлийн бодлогоо тодорхойлоход анхаарсан байна.

“Алслагдсан бүс”-ийг улсын нийслэл, эсвэл бүсийн төвөөс алслагдсан зайгаар тодорхойлдог. Судалгаанаас үзэхэд, нийслэлээс алслагдсан аймгуудад амьжиргааны өртөг төвийн бүс буюу Төв, Сэлэнгэ аймгаас даруй 1.5-аас 2.5 дахин өндөр болж, хот хөдөөгийн ялгаа эрс ихэсч, хөдөөд ядуурал газар авах хандлагатай болсоныг тогтоосон байна.

Алслагдсан бүсийг нийслэлээс алслагдсан зайнаас хамааруулж доорхи байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

- 800 км хүртэл;
- 801-1200 км;

- 1201 км-ээс дээш.

Мөн бүсийн төв (аймгийн төв)-өөс алслагдсан байдлаар нь тодорхойлбол:

- 100 км хүртэл;
- 101-300 км;
- 301 км -ээс дээш.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь арга хэрэгслийг ашигладаг. Үүнд:

- Санхүүгийн дэмжлэг;
- Бизнесийн орчныг сайжруулах;
- Төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох.

Санхүүгийн дэмжлэгт хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх, тээврийн хөнгөлөлт үзүүлэх, бүсийн нэмэгдэл олгох (бүсийн, хилийн, хүйтний, алслалтын г.м.), ажлын байр шинээр бий болгосны шагнал олгох зэрэг багтдаг.

Бизнесийн таатай орчныг дэмжих нь орчин үеийн бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл бөгөөд нийгмийн ба үйлдвэрлэл, үйлчилгээ, банк санхүүгийн тогтолцоо, дэд бүтэц, төрөл бүрийн бирж байгуулах, мэдээллийн сүлжээ зэргийг боловсронгуй болгон сайжруулахад чиглэгддэг байна.

Төлөвлөлт, удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгох нь улсын болон бүс нутгийн ашиг сонирхол, эдийн засаг, нийгмийн салбарын хүрээний бодлогыг уялдуулан зохицуулахад чухал үүрэгтэй юм.

БҮСИЙН НЭМЭГДЭЛ

Бүсийн аливаа нэмэгдэл олгох нь бүсчилсэн хөгжлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэлд хамаардаг. Монгол улсын хувьд, бүсийн аливаа хэлбэрийн нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь дараахь зорилтуудыг шийдвэрлэх хүрээнд хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

1. Эдийн засгийн байгуулалтын хүрээнд:
 - **Алслагдсан**, говийн болон сул хөгжилтэй бүс нутгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
2. Нийгэм соёлын хүрээнд:
 - Хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих сум дундын зориулалтын санхүүгийн механизм бий болгох, алслагдсан болон говийн бүс нутагт ажлын байр бий болгосон хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор урамшуулах.
 - Хүн амын амьжиргааны доод түвшин, нийгмийн даатгалын шимтгэлийг бүс нутгийн ялгарвартай тогтоох хэлбэрийг сонгох
 - **Алслагдсан** болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох замаар тогтвор суурьшилтай ажиллуулахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх.
3. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:
 - ОХУ -тай хил залгаа Алтанбулаг (Сэлэнгэ аймаг) Цагаан нуур (Баян-Өлгий

аймаг), БНХАУ-тай хил залгаа Замын үүд (Дорноговь аймаг) боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай хамтран ажиллах бизнесийн орчинг бүрдүүлэн ашиглах замаар хөгжлийг дэмжих.

БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

Бүсийн төлөв байдлыг тодорхойлж буй судалгааны үзүүлэлтийн чиглэл, ангилал, бусад орны туршлага, зарим судлаачдын бүтээл зэргийг харгалзан бүсийн нэмэгдэл олгох үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

1. Хөгжлийн өнөөгийн түвшинг харгалзах үндэслэл.
 - Макро эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн харьцуулсан судалгаагаар тогтоосон төвшин.
2. Газар нутгийн тогтоц, дэд бүтцийн хөгжлийн онцлогийн үндэслэл.
 - Газар нутгийн тогтоц, **алслагдсан байдал**;
 - Нутаг дэвсгэрийн хэмжээ, ашигт малтмалын нөөц;
 - Дэд бүтцийн хөгжлийн үзүүлэлт (Шатахуун, тээвэр, эрчим хүч, ус дулааны үнэ тариф).
3. Байгаль цаг уурын онцлог, хүний эрүүл мэнд сэтгэл зүйд таагүй нөлөөлөх хүчин зүйлийн үндэслэл.
 - а/ Байгаль цаг уурын онцлогийг харгалзан:
 - Уур амьсгалын эрс тэс, хатуу ширүүн байдал /Бодманы индексээр/ (Увс аймгийн Зүүнговь сум...)
 - Говийн (Говь-Алтай аймгийн Алтай сум...)
 - Цөлийн (Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Эхийн гол баг...)
 - Өндөр уулын (Баян-Өлгий аймгийн Алтай сум...)
 - Тагийн (Хөвсгөл аймгийн Ринченлхүмбэ сум...)
 - Халууны (Ховд аймгийн Манхан, Зэрэг сум, Увс аймгийн Зүүнговь сум...)
 - Хүйтний (Завхан аймгийн Тосонцэнгэл, Увс аймгийн Зүүнговь сум...)
 - Далайн (Увс аймгийн Давст, Хөвсгөл аймгийн Ханх сум...)
 - б/ Бүс нутгийн онцлогийг харгалзан:
 - Экологийн гамшгийн (цөлжилт, бэлчээр талхлалт)
 - Цаг агаарын хүнд нөхцлийн (цас, бороо, салхи)
 - Цацраг идэвхжилийн нөлөөлөл (Дорнодын Мардай гэх мэт)

АЛСЛАЛТЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ХЭЛБЭРҮҮД

Алслалтын нэмэгдлийг тухайн бүс нутагт оршин суугчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, ашиг орлогын /ажилгүйчүүдэд цалингийн баталгаажих төвшний/ тодорхой хувиар тооцож олгоно. Мөн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ерөнхий төвшинг харгалзан олгодог доорхи хөнгөлөлт, нэмэгдлийг давхардуулан олгох боломжтой. Үүнд:

- Тухайн бүсэд байгуулсан үйлдвэр үйлчилгээний газруудад гааль, НӨАТ, орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
- Бүс нутагт ажиллагсад хөнгөлөлттэй урт хугацааны зээл олгох нөхцөл бүрдүүлэх, зээлийн баталгааг төрөөс даах;

- Албан хаагчдад ажлын цагийг багасгасан 7 хоног бий болгох;
- Ээлжийн амралт дээр нь нэмэгдэл хоног олгох;
- Тухайн бүс нутагт шилжин суурьших зардал олгох.

ГАДААД ОРНУУДАД БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОЖ БҮЙ ТУРШЛАГА

Өндөр хөгжилд хүрсэн улс орнуудын туршлагаас үзэхэд, бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо доорхи хоёр үндсэн чиглэлийг барьж, төсөл хөтөлбөр боловсруулдаг байна. Үүнд:

1. Улс орноо бүхэлд нь хамарсан бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
2. Улс орныхоо тодорхой бүс нутгийг онцгойлон анхаарч хөтөлбөр хэрэгжүүлэх.

Дээрхи чиглэлээр хөгжиж байгаа улс орнууд аль аль нь бүс нутгийн эдийн засгийн хөгжил, амьжиргааны үзүүлэлт, **төв (нийслэл) -өөс алслагдсан байдал**, тухайн бүс нутгийн байгаль цаг уур, хөгжлийн судалгааг үндэслэн бүс нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжих “санхүүгийн дэмжлэг” хэлбэрээр бүсийн нэмэгдэл олгодог байна. Зарим улс орнуудад бүсийн нэмэгдэл олгодог туршлагыг авч үзвэл:

Оросын Холбооны Улс

Оросын умард хязгаар түүнтэй адилтгах бүс нутагт оршин суугчдад /ажилчин, албан хаагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчид, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуульд суралцагсад/тухайн газар нутгийн байгаль цаг уурын онцлог, **төвөөс алслагдсан байдал** зэргийг харгалзан тэдгээрийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлгийг тодорхой коэффициентээр /районный коэффициент/ нэмэгдүүлэн олгодог. Жишээлбэл, хамгийн алслагдсан Хойд мөсөн далайн арлууд, Саха /Якут/, Чукотка, Курилийн арлууд, Камчатка, Сахалин мужийн тодорхой нутагт оршин суугчдын бүсийн нэмэгдлийн коэффициент 2.0 байхад, Красноярск, Мурманск, Хабаровск, Тюмень, Томск, Эрхүү муж, Алс Дорнодод 1.40-1.80 байдаг байна.

Мөн манай Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Дорнод аймгуудтай хил залгаа оршдог, байгаль цаг уурын ижил төстэй нөхцөлтэй Алтайн хязгаарт 1.40, Тувад 1.50-1.40, Буриадад 1.30-1.20, Чита мужад 1.30 коэффициентийн бүсийн нэмэгдэл олгодог.

Канад Улс

Канад алслагдсан бүс нутгийн оршин суугчид, ажил олгогч нартаа тухайн **газар нутгийн алслалт**, байгаль цаг уурын байдал зэрэг нөхцлүүдийг харгалзан тэдгээрийн цалин, орлогод ногдох орлогын албан татвараас тодорхой шалгуурыг үндэслэн татварын хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөлт олгох хэлбэрээр бүс нутгийн иргэдээ дэмждэг байна.

Ийм хөнгөлөлтийг 1987 оноос олгож эхэлсэн бөгөөд дараахь хоёр үндэслэлээр олгодог. Үүнд:

1. Цаг агаарын хүнд, бараа, үйлчилгээний хязгаарлагдмал нөхцөл;
2. Гол зах зээлээс алслагдсан тул амьдралын өртөг өндөр.



ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), Б. Буяндэлгэр,
Т. Мягмаржав, О. Нарантуяа, Н. Түвшинтөгс*

УИХ -ын гишүүн С. Эрдэнийн 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 10/1851 тоотоор ирүүлсэн захиалгын дагуу УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн ахлах судлаач Р. Хатанбаатараар ахлуулсан баг ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаархи АНУ (судлаач Р.Хатанбаатар), ХБНГУ (Г.Алтан-Оч), ОХУ (Н.Түвшинтөгс), БНСУ (О.Нарантуяа), Япон (Т.Мягмаржав) улсын эрх зүйн зохицуулалтын судалгааг хийж гүйцэтгэв.

Ялтныг засан хүмүүжүүлэх, тэднийг ял эдлээд гарсны дараах чөлөөт амьдралд бэлтгэхэд ялтны хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол олгох болон чөлөөт цагийг зохистой ашиглах зэрэг ажлыг зөв зохион байгуулах явдал чухал. Албан хүчээр бий болсон хэт их чөлөөт цагийг өнгөрөөх нь ялтнуудын хувьд болон ял эдлүүлэх байгууллагын хувьд маш хүнд асуудал юм. Ял эдлэх хугацаа, ялтны цагийг үр ашигтай ашиглахад дараах гурван хүчин зүйл гол үүрэгтэй:

- ялтныг үр ашигтай хөдөлмөрөөр хангах,
- хорих байгууллагын дэргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол олгох боломжийг бүрдүүлж, боловсрол олохыг хүссэн ялтнуудыг сургах
- ялтнуудын чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх ажлыг зохион байгуулах, олон нийт, шашин, урлагийн зэрэг үйл ажиллагаанд оролцох нөхцлийг бүрдүүлэх зэрэг болно.

Эдгээрээс хамгийн гол нь ялтны хөдөлмөр эрхлэлт юм. Ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаар улс бүр ялгаатай ханддаг байна. Жишээлбэл, ОХУ-ын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хуулиар (Уголовно-исполнительный кодекс) бүх ялтан албадан хөдөлмөр хийх ёстой байдаг бол Европын орнууд, АНУ, Япон зэрэг улсуудад хоригдлын хөдөлмөр бол албадан хөдөлмөр гэсэн логикоор ханддаг байна.

Олон улсын эрх зүйн нормоор ялтны албадан хөдөлмөрийг тодорхой нөхцөлтэйгээр байж болохыг үгүйсгэдэггүй. Тухайлбал, ялтны эрхлэх хөдөлмөр нь түүний мэргэжил, чадварыг тооцсон байх ёстой, хэрэв ингэх бололцоогүй бол уг хөдөлмөр нь ашигтай бөгөөд нийгмийн ач холбогдолтой байх ёстой гэх мэт төрөл бүрийн нөхцөл байна. Харин улсуудын хуулийн практикт бол ихээхэн ялгаатай байна. Зарим улсад албадан хөдөлмөрийг хуулиараа зөвшөөрдөг бол зарим улсад тэдний хөдөлмөрийг хөдөлмөрийн эрх чөлөөний зарчимд нийцэх ёстой гэж үздэг.

Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн шийтгэл нь албадан хөдөлмөрлүүлэх ба шоронд хориод албадан хөдөлмөр эрхлүүлэх гэж хоёр хуваагдана. Мөн хөдөлмөр эрхлүүлэхээр эрүүгийн шийтгэл оноогоод шоронг аюулгүй хөдөлмөрлөхөд ашиглах болон ялтныг ялын хугацаандаа ямарваа нэгэн зүйл эрхэлсэн байлгахын тулд хөдөлмөрлүүлэх (албадан хөдөлмөр биш) гэж ангилах ч бий. Энэ ангилалыг тодруулбал:

1. Шоронгийн албадан хөдөлмөр. Энэ нь чөлөөт бус хөдөлмөрийн нэг хэлбэр бөгөөд шоронд хорих ял дээр нэмэлт шийтгэл маягаар эртнээс хэрэглэж ирсэн, одоо ч ОХУ гэх мэт зарим оронд хэрэглэсээр байгаа шийтгэл юм. Ийм албадан

хөдөлмөр нь тодорхой үр дүн бүхий үйлдвэрлэлийн чанартай хөдөлмөрөөс эхлээд ялтныг примитив хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, биеийн хувьд тамлах зэрэг утга учиргүй зорилгоор хөдөлмөр хийлгэх хүртэл өргөн хүрээтэй байна. Зарим үед төрийн байгууллагын зүгээс ялтны хөдөлмөрийг үйлдвэрлэл (prison farm) болгон хувиргасан улсууд байна.

2. Шоронгийн албадан бус хөдөлмөр. Олон орны эрүүгийн эрх зүйд ялтан ажил хөдөлмөр эрхлэх боломж байдаг. Энэ нь хэд хэдэн гол зорилготой.
 - Юуны өмнө ялтан үр ашигтай хөдөлмөр эрхэлж, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болох нь эргэн нийгэмшихэд нь чухал үүрэгтэй. Ялтан чөлөөлөгдсөнийхөө дараа ажил олоход нь тус болох чадвар эзэмших боломжтой.
 - Мөн засан хүмүүжүүлэх маш чухал ач холбогдолтой. Шоронгийн ялтны амьдралын харгис хатуу нэгэн төрлийн уйтгартай байдлыг нь зөөллөнө. Ажил хөдөлмөр эрхлэн завгүй байснаар ялтан ямарваа нэгэн хүчирхийллийн юмуу нийгмийн эсрэг үйл ажиллагаанд татагдан орохгүй байх талтай. Суугаа амьдралаар байнга байхгүй нь тэдний эрүүл мэндэд ч зохих нөлөөтэй.

Бид энэ судалгаандаа ялтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг юуны өмнө ялтныг нийгэмшүүлэх зорилго бүхий албадан бус хөдөлмөр гэсэн талаас нь авч үзэж, гадаадын хэд хэдэн орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзлээ. Дашрамд дурдахад манай улсад ялтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг нилээн нарийн зохицуулсан байдаг. Монгол Улсад ялтны эрх зүйн байдлыг дараах эрх зүйн актуудаар зохицуулж байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол (2009.01.28, №23)
- Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээ тогтоох түр журам (ШШГЕГ-ын даргын 2008 оны тушаал)

1. Америкийн Нэгдсэн Улс

Нэг. АНУ-д бүхэлдээ болон муж улсуудад хорих ял эдлүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд маш олон янзын дүр зураг байна. Эрүүгийн ба засан хүмүүжүүлэх байгууллагуудын хууль тогтоомжууд нь АНУ-ын хуулийн системийн онцлогийг тусгасан байна, өөрөөр хэлбэл, холбооны хуулиуд болон муж улс бүрийн хуулиуд хамтран үйлчилнэ.

Хорихоос бусад төрлийн шийтгэлийн шийдвэр гүйцэтгэлийг эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх төрлийн актуудаар зохицуулдаг бол хорихтой холбоотой шийтгэлийг пенитенциар нормоор зохицуулна. Хорих ялыг засан хүмүүжүүлэх байгууллагуудад эдлүүлэх бөгөөд системд нь холбооны шоронгууд, штатуудын шоронгууд болон орон нутгийн шоронгууд багтана.

Холбооны пенитенциар систем нь аюулгүйн төвшинөөр ангилсан дараах дөрвөн төрлийн байгууллагаас бүрдэнэ: минимал аюултай, дунд зэргийн аюултай, максимал аюултай, онцгой аюултай шоронгууд.

Минимал аюултай шорон нь нээлттэй хэлбэрийн байгууллага бөгөөд зэвсэгт хамгаалалт байхгүй. Эдгээр шоронд хөнгөрүүлсэн дэглэм тогтоогдох ба ялтнууд нь шоронгоос гадуур ажиллах боломжтой байна.

Дунд зэргийн аюултай шорон нь хаалттай хэлбэрийн байгууллага бөгөөд зэвсэгт

хамгаалалттай байна. Ялтнуудыг нь шоронгоос гадуур ажил хийлгэхээр гаргаж болно. Манай жирийн дэглэмтэй хорих ангитай ойролцоо.

Максимал аюултай болон онцгой аюултай шоронгуудад аюултай гэмт хэрэгтнүүдийг хорих ба ялтныг хатуу дэглэмээр хорино. Ялтан нь шоронгийн нутаг дэвсгэрээс гарч болохгүй, хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрөхгүй. Орон нутгийн шорон нь нийгмийн хэв журам зөрчсөн, жижиг хэмжээний хулгай хийсэн зэрэг хамгийн аюул багатай хэрэгтнүүдэд зориулагдсан ба маш олон төрлийн байх учир ангилах боломжгүй.

Хоёр. АНУ-д ялтны хөдөлмөр эрхлэх асуудлыг 1973 оны 11755 (1987 онд 12608 дугаар хуулийн дэд актаар нэмэлт оруулсан), 1994 оны 12943 дугаар хуулийн дэд актуудаар (Executive Order) зохицуулсан байдаг. Эдгээр актанд “Ялтнуудын мэргэжлийн болон боловсролын чадварыг хөгжүүлэх нь тэдний засран хүмүүжих болон эргээд чөлөөт нийгэмд очиж амьдрахад нь зайлшгүй чухал шаардлагатай.

Учир утгатай хөдөлмөр эрхлэлт тэдний эдгээр чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой. Гэхдээ хоригдлуудын хөдөлмөрийг мөлжих болон бараа таваар үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэгт хоригдлуудын хөдөлмөр ба чөлөөт хөдөлмөрийн хооронд эрүүл бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэн болгоомжтойгоор зохион байгуулах ёстой” гэж заасан байна. Энэ хуулийн дэд актаар ажил олгогч доор дурдсан этгээдүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоогүй. Үүнд:

1. хугацаанаас өмнө суллагдсан болон туршилтын хугацаанд байгаа этгээд,
2. өршөөгдсөн болон хугацаат ялаа эдлээд гарсан этгээд,
3. холбооны шоронд ял эдлэгч
4. холбооны биш шоронд ял эдлэгч зэрэг хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг Хуулийн дэд актанд заасан дор дурдсан хууль эрхийн орчинд зөвшөөрнө. Үүнд:
 - ажиллагч хөдөлмөрийн хөлс авдаг юмуу батлагдсан хөдөлмөрийн сургалтанд сайн дурын үндсэн дээр хамрагдах
 - үйлдвэрчний төв байгууллагын тухайн нутаг дахь төлөөлөгч юмуу адил төстэй үйлдвэрчний байгууллагатай зөвшилцсөн
 - хөдөлмөрийн хөлс төлөх ажил нь а) хөлсний ажилчдыг өөр газар руу аваачихгүй байх, б) тухайн нутагт илүүдэлтэй байгаа үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд оролцохгүй байх болон, в) үйлчилгээний ажлын гэрээг дордуулахгүй байх
 - хөдөлмөрийн хөлс болон хөдөлмөрийн бусад нөхцөл нь тухайн орон нутаг дахь адил төстэй хөдөлмөрийнхөөс доошгүй байх
 - ажил эрхлэхтэй холбоотой хуулиуд болон бусад зохицуулах дүрэм журам нь 11755 дугаар Хуулийн дэд акт ба түүнд оруулсан нэмэлтүүдийн шаардлагад нийцсэн байна гэдгийг АНУ-ын Ерөнхий прокурор баталсан байх.

Гурав. Federal Prison Industries, Inc., буюу UNICOR нэрээр нийтэд танигдсан байгууллага нь 1934 онд холбогдох хууль тогтоомж болон Executive Order-ийн дагуу байгуулагдсан төрийн өмчит корпораци бөгөөд Холбооны Шоронгийн товчооны (United States Federal Bureau of Prisons) ялтнуудын хөдөлмөрийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг юм.

Уг корпорацийн гол зорилго нь ялтнуудад ажил олгох, мэргэжилийн дадлага олгон бэлтгэх, ялтнуудыг ажилтай байлгаснаар засан хүмүүжүүлэх байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, зах зээлийн үнээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бие даан ажиллах юм. UNICOR нь ялтныг хөдөлмөр хийлгэхээр албадаж болохгүй бөгөөд хөдөлмөр эрхлэх

эсэх нь зөвхөн сайн дурын үндсэн дээр байна. Мэргэжлийн бэлтгэл хийлгэхэд ч мөн адил. Ажлын сайн чадвар эзэмшсэн, сайн ажилласан ялтанд шоронгоос гарахад нь UNICOR-ийн зүгээс дэмжлэг үзүүлдэг.

UNICOR нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зөвхөн холбооны засгийн газрын байгууллагуудад зарах бөгөөд шууд зах зээлд гарах эрхгүй. UNICOR нь 2008 оны байдлаар холбооны шоронгуудад 109 үйлдвэртэй, 175 орчим төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг байсан байна. UNICOR нь эдийн засгийн хувьд бүрэн бие даасан байгууллага бөгөөд улсаас ямар нэгэн санхүүжилт авдаггүй.

Ялтнуудын хөдөлмөрөөр бүтсэн бүтээгдэхүүнийг Холбооны засгийн газрын байгууллагууд худалдан авахдаа Холбооны худалдан авалтыг зохицуулах системийн (Federal Acquisition Regulation) журмыг баримтлана.

Дөрөв. Executive Order гэдэг нь АНУ-ын ерөнхийлөгч холбооны гүйцэтгэх засгийн тэргүүний хувьд гаргадаг зарлиг юм. Executive Order нь гүйцэтгэх засгийн албан хаагчдын хэрэгжүүлэн ажиллах журмыг тогтоох бөгөөд иргэдэд ямар нэг үүрэг оноохгүй. АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн нэгдүгээр хэсэгт “Төлөөлөгчдийн танхим ба Сенатаас бүрдэх Нэгдсэн улсын Конгресс энд тогтоосон хууль тогтоох бүрэн эрхийг эдэлнэ” гэж заасан байдаг. Конгрессоос гаргасан хуулийн актаар ерөнхийлөгчид шилжүүлсэн бүрэн эрхийн (delegated legislation) хүрээнд тодорхой хуулийг хэрэгжүүлэхийн тулд гаргасан Executive Order нь хуулийн бүрэн чадамжтай байна. Жич: Executive Order 11755-ийг хавсралтад хавсаргав.

2. ОХУ

Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг ОХУ-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль (Уголовно-исполнительный кодекс Российской Федерации), Хөдөлмөрийн хууль, Тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулагддаг байна.

ОХУ-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 14-р бүлэгт Хорих ял эдэлж буй ялтнуудыг хөдөлмөр, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтанд хамруулах талаар дараах зохицуулалтуудыг заасан байна.

103 дугаар зүйл. Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх

1. Бүх ялтнууд хоригдож байх хугацаандаа засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаанаас тодорхойлсон ажлын байранд хөдөлмөр эрхлэх үүрэгтэй.

Засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаа нь: ялтнуудын нас, хүйс, хөдөлмөр эрхлэх чадвар, эрүүл мэндийн байдал, ажлын байрнаас хамаарч тэднийг хөдөлмөр эрхлүүлэх үүрэгтэй.

2. 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй мөн тахир дутуугийн 1, 2 дугаар групптэй ялтнуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлүүлнэ. (Хөдөлмөрийн хууль, тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай)

Насанд хүрээгүй ялтнуудыг мөн ОХУ-ын хөдөлмөрийн хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлүүлнэ.

3. Шоронд хорих ял эдэлж буй ялтнуудыг энэ хуулийн 74-р зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шоронгийн газар нутаг дээр хөдөлмөрлүүлнэ.
4. Хоригдлуудын ажиллахыг хориглох ажлын жагсаалтыг засан хүмүүжүүлэх

байгууллагын дотоод журмаар тогтооно.

5. Хоригдлуудын хөдөлмөрлөх цаг нь засан хүмүүжүүлэх байгууллагын үндсэн зорилт болох засан хүмүүжүүлэх үйл ажиллагаатай давхцаж болохгүй.
6. Ажлаас татгалзах, эсвэл ажлыг зогсоовол тогтоосон журмыг санаатай зөрчсөн гэж үзэж шийтгэлийн арга хэмжээ, хариуцлага хүлээлгэнэ.

104 дүгээр зүйл. Ялтнуудын хөдөлмөрийн нөхцөл

1. Ялтны ажиллах хугацаанд хөдөлмөр хамгааллын, техникийн аюулгүй байдал болон ариун цэвэрт холбогдох дүрмийг ОХУ-ын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжинд нийцүүлэн тогтооно. Ажлын эхлэх болон дуусах цаг нь ээлжийн графикаар тодорхойлогдоно.
2. Засан хүмүүжүүлэх болон шоронд ял эдэлж буй хоригдлуудын гүйцэтгэж байгаа ажлууд нь ажлын цагийг уртгасан хэлбэрт ордог. (өдөр болгон тогтмол цагаар ажилладаггүй. нэг өнжөөд 24 цаг ч юм уу ажилладаг гэсэн утгатай)
3. Ялтнуудын цалинтай ажил хийлгэхэд цаг нь нийт ажлын цагаар тооцогдоно. Засан хүмүүжүүлэх байрны захиргаа нь ажлын цагийг тооцож гаргана. Хэрэв ажил гүйцэтгэхээс байнга зайлсхийвэл, засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны шийдвэрээр ялтны нийт ажлын цагаас хасна. Засан хүмүүжүүлэх байгууллагын шийдвэр нь шүүхэд гомдол болон очиж болно.
4. Ажил хийдэг хоригдлууд жил бүр төлбөртэй амралт авна. Хүмүүжүүлэх колонд хорих ял эдэлж буй ялтан ажлын 18 өдөр, засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож буй ялтан 12 ажлын өдрийн амралт (төлбөртэй) авах эрхтэй.

108 дугаар зүйл

1. Мэргэжилгүй ялтнуудад анхан шатны мэргэжлийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох ажлыг засан хүмүүжүүлэх газар зохион байгуулна. Мэргэжил эзэмшсэн ялтнууд засан хүмүүжүүлэх байранд болон суллагдсанахаа дараа ч тэндээ ажиллаж болно.
2. Тахир дутуугийн 1, 2-р группт байдаг ялтнууд, 60-аас дээш насны эрэгтэй мөн 55-аас дээш насны эмэгтэй ялтнуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох мэргэжлийн сургалтанд хамрагдаж болно.
3. Ялтнуудыг анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтанд хамруулахдаа тэдний хүмүүжиж буй зэргийг харгалзан үзнэ.
4. Анхан шатны мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу явуулна.
5. Засан хүмүүжүүлэх байгууллага нь ялтнуудын дээд мэргэжлийн боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
6. Бүх насаараа хоригдож буй ялтнууд шууд үйлдвэр дээр мэргэжил эзэмшинэ.

3. ХБНГУ

Дээр үед хоригдлын хөдөлмөр нь зөвхөн хүнд биеийн хүчний ажил байсан бөгөөд энэ нь нэг талаас ял шийтгэл мэт ойлгогддог, доромжлол, гутамшигтай, дарлуулсан байдалтай байсан. Харин үйлдвэржсэн энэ эрин үед, ялтны хямдхан ажлын хөлсийн улмаас шорон маш сайн үйл ажиллагаатай, ашигтай гар үйлдвэрлэл (мануфактур) болж хувирсан. Гэвч хөдөлмөр хувийн аз жаргал, баян чинээлэг амьдрал, нийгэмд байр суурь эзлэхэд хүргэнэ гэсэн бодрол хоригдлын хувьд онол хэвээр үлдсэн. Бага цалин хөлс, албадан ажиллах, маш муу ажлын нөхцөл шоронгийн гар үйлдвэрлэлийн өдөр тутмын дүр төрх юм.

Ялтны хөдөлмөр эрхлэлт эргэн нийгэмшүүлэх зорилготой

ХБНГУ-д 2-р зүйлийн 1 дэх хэсэгтээ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зорилго нь эргэн нийгэмшүүлэхэд оршино” гэж тусгасан **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль** (ШШГХ) (дэлгэрэнгүйгээр: “Эрх чөлөөний шийтгэлийг гүйцэтгэх болон эрх чөлөөг хасаж сайжруулах, бататгах үндсэн журмын тухай хууль”) 1977.01.01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дан ганц зорилго нь ялтныг эргэн нийгэмшүүлэхэд оршино. Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг зохион байгуулахад ерөнхийд нь болон нэг бүрчлэн баримтлах эрхэм дээд чиг шугам юм. Хоригдлуудад эргэн нийгэмших арга хэмжээнд үл хамруулж болохгүй, түүнд үүнийг албадан тулгаж болохгүй. [Feest 1990]

Уг хуулийн хэллэг нь нилээн оновчтой, нарийн ойлголтыг илэрхийлдэг. Шийтгэгдсэн хоригдол хамгийн оройтсондоо гэхэд шоронгоос суллагдах өдөр хүртлээ нийгмийн хариуцлага хүлээж, шийтгэлгүй амьдрахад бэлтгэгдсэн байх ёстой. Ингэснээр, уг хуулийн 2-р зүйл нь зорилгоос гадна үүргийг давхар зохицуулж байгаа юм.

Шоронгийн өдөр тутмын амьдралын цөм нь хөдөлмөр юм. Энэ нь эргэн нийгэмшүүлэхэд шийдвэрлэх биш юмаа гэхэд нэгэн чухал хэрэгсэл. Хөдөлмөр амьдралыг амьдрах утга учиртай болгодог. Ихэнх судлаачид ингэж үздэг.

Хөдөлмөрийн болон мэргэжлийн сурган хүмүүжүүлэх арга хэмжээнүүд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Уг хуулийн 37-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан хөдөлмөрийн эмчилгээний ажил, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалт, мэргэшүүлэх сургалт нь ялангуяа суллагдсаны дараа хөдөлмөр эрхлэхэд зуучлах, дэмжих, чадавхитай болгох зорилготой. Хоригдол хөдөлмөр эрхлэх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд засан хүмүүжүүлэх чухал арга хэмжээ юм. Уг хуулийн 41-р зүйл, Үндсэн хуулийн 12-р зүйлд шийтгэгдсэн хоригдол хөдөлмөр эрхлэх үүрэгтэйг зааж өгсөн. Үүгээр мөрдөн байцаагдаж байгаа хоригдлоос ялгаатай. Хөдөлмөрийн хувьд эдийн засгийн үр ашигтай ажил байх ёстой.

Үндсэн хуулийн 12-р зүйлд тусгагдсан текстийг үзэхэд, хөдөлмөр эрхлэх үүрэг нь албадан хөдөлмөр эрхлэлт гэж харагдах талтай. Гэвч судлаачид дээрх хуулийн 41-р зүйлд тусгагдсан хөдөлмөр эрхлэх үүргийг засан хүмүүжүүлэх арга хэмжээ гэж тайлбарладаг. Хууль нь ч мөн ийм юм. Шоронгийн хөдөлмөр эрхлэлтийн дүнд хоригдол нь тогтмол ажил хийх, суралцах, хөдөлмөрт дуртай болоход дасан зохицох ёстой. Гэхдээ энэ нь дургүй ч гэсэн ямар ч ажлыг хамаагүй хий гэсэн үг биш ээ. Ялтны чадавхи, сурц, хүслийг харгалзан үзэх нь зүй. Энэ талаас нь үзвэл шоронгийн хөдөлмөр олон талтай, сонголт өргөнтэй байх шаардлага гарч ирнэ. Цаашилбал, нэгэн хэмийн (монотон) үйлдвэрийн ажил хөдөлмөрийн баяр бахдал төрүүлдэггүй гэдгийг анхааран үзэх шаардлагатай.

Хоригдлын хөдөлмөрийн хөлс

Хоригдлын хөдөлмөрийн хөлсийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 43-р зүйлээр зохицуулдаг. Энэ журам нь ШШГХ тогтоогч шоронгийн хөдөлмөрийг чөлөөт эдийн засгийн хөдөлмөртэй аль болох ойртуулахаар зорьсон болон Үндсэн хуулиар тогтоосон хоригдлын хөдөлмөрийг эргэн нийгэмшүүлэх арга хэмжээ гэдгээр нь бүтэц, зохион байгуулалтаар хангахад шийдвэрлэх үүрэгтэй.

Хууль тогтоогч хөдөлмөр эрхлэх үүргийг хангахдаа шоронгийн гаднах шиг ажилдаа тохирсон цалин хөлс авч байхаар зохицуулсан. Ингэснээр ШШГХ-ийн 43-р зүйл нь хоригдлын хөдөлмөрийн хөлс авах эрхийг бататгаж өгсөн. Гэхдээ тарифаар цалинжих,

нийгмийн даатгалд хамрагдах эрхгүй. Хөдөлмөрийн хөлсийг бүх хүний дундаж хөдөлмөрийн хөлсний 5%-тай тэнцүү байхаар тогтоосон. Сүүлд өсгөн тогтоохоор анх батлагдсан ч Үндсэн хуулийн цэц (1998) эргэн нийгэмшүүлэх зарчмын талаасаа үндсэн хууль зөрчиж байна гэж үзэх хүртэл нэмэгдээгүй юм. Ингээд хууль тогтоогч уг хэмжээг **9%** байхаар шинэчлэн тогтоосон.

Хоригдлын хөдөлмөрийн мэргэжлийн сургалт

Мэргэжилгүй хоригдол шоронд мэргэжил эзэмших боломжтой. Энэ нь ихэвчлэн хүүхдийн засан хүмүүжүүлэх хориход байдаг. Мэргэжлийн сургалтыг мэргэжлийн ангиллын “боловсролгүй туслах хүч” гэдэгт хамаардаг хоригдлуудад явуулдаг. Мэргэжилтэй хоригдлуудын хувьд, олж авсан мэргэжлийн мэдлэгийг нь өргөжүүлэх, хадгалах зориулалттай мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Эдгээр мэргэжлийн сургалтуудад хоригдлуудын дунд боловсролын төвшин хангалтгүй байдаг учраас тодорхой хязгаарлалтыг оруулсан байдаг.

Германы шоронгуудад сургадаг үндсэн мэргэжлүүд гэвэл: **цэцэрлэгч, төмрийн дархан, мужаан, будагчин/лакчин, тогооч, үйлдвэрийн механикч, барилгачин**. Үргэжлэх хугацаа нь 2 жил. Мэргэжилтэй ажилчны гэрчилгээ олгодог. Зарим тохиолдолд, ял эдлэх хугацаандаа багтаан мастерын курсэд хамрагдаж, шалгалтыг нь өгөх бололцоо байдаг.

ШШГХ-ийн 44-р зүйлд зааснаар, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтыг адилтган үздэг. Ингэснээр сургалтанд хамрагдах хугацаандаа ялтан хөдөлмөрлөх үүргээс чөлөөлөгддөг. Сургалтын стипенд нь хөдөлмөрийн хөлстэй ижил хэмжээтэй байдаг. Ингэж мэргэжлийн сургалтыг хөдөлмөртэй адилтган тохирсон мөнгө төлдөг.

Хорихын хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн явцын зохион байгуулалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ажиллах хүсэл эрмэлзэл бүхий ялтан бүрт эдийн засгийн үр ашигтай хөдөлмөр эрхлэх нөхцөл бололцоог хангасан зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэгтэй. Эдийн засгийн үр ашгийн талаар хуулинд тодорхой заагаагүй. Ажлын байр бий болгох хорихын үүрэг нь үнэндээ байгаа нөөц бололцоондоо тааруулан хэрэгжих боломжтой. Эдийн засгийн уналтын үе (хямрал)-д жишээ нь, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас “бүрэн ажилд хамруулахыг” шаардах хэцүү юм.

Саксон муж улсын хувьд, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байдал, түүний үнэ цэнэ нь бараа, үйлчилгээ худалдан авах эрхэд тусгалаа олсон байдаг. Энэ улсад төрийн байгууллага хорихоос ажил үйлчилгээ авахаар бол төндэр зарлах үүргээс чөлөөлөгдөх эрхтэй. Эсрэгээрээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бизнесийн байгууллагатай уралдаант шалгаруулалтанд оролцож болохгүй.

Хоригдлын хөдөлмөрийн функциональ төвшингүүд

Хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн явцын зохион байгуулалтыг хөдөлмөрийн зорилгоос хамааруулан доорхи функциональ төвшингүүдэд хувааж үзнэ:

- Хоригдлуудыг өөрийн цехэд ажиллуулах

Хорихын өөрийн хангамж болох хувцас, хэрэглээний зүйл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех. Мөн угаалга, цэвэрлэгээ болон засварын ажил байж болно. ШШГХ-ийн 41-р зүйлд заасны дагуу ялтан иймэрхүү туслах ажлыг 3 сар хүртлэх хугацаагаар хийх үүрэгтэй, өөрийн зөвшөөрснөөр үүнээс хэтэрч болно. Өөрийн цехүүд орлого олохгүй боловч зардал хэмнэдэг. Зардал нь хөдөлмөрийн захиргаанд хамаардаггүй, харин эдийн засгийн захиргаанд хамаардаг. Хоригдлын хөлсийг ямар газарт ажилласнаас үл хамааран зөвхөн хөдөлмөрийн захиргаанаас олгодог.

- Хоригдлуудыг өөрийн үйлдвэрт ажиллуулах

Өөрийн үйлдвэр гэж хорихын захиргаанаас байгуулан удирддаг, хорихын хашаан дотор байрладаг гар үйлдвэрлэл, юмуу аж үйлдвэрийг хэлдэг. Үйлдвэр нь бусад яам, төрийн байгууллагыг оролцуулан зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээг хангаад зогсохгүй чөлөөт зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулахаар оролддог үйлдвэр юм. Өөрийн үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд ихэнхдээ хуучирсан байдгаас бүтээмж нь хязгаарлагдмал, ажиллах хүч нь байнга солигдож байдаг, мэргэжлийн биш ажлын байранд томилогддог, хязгаарлагдмал ачаалалтай байдаг. Өөрийн үйлдвэр нь хорих шигээ дотоод албадлагын шинжтэй зохион байгуулагдсан. ШШГХ-ийн 149-р зүйлд заасны дагуу, хорихууд ийм төрлийн аж ахуйнуудаа аль болох өргөтгөхийг эрмэлздэг. Нэг давуу тал гэвэл, өөрийн үйлдвэрийн хөдөлмөрийг компанитай харьцуулахад илүү олон талт, сонирхолтой зохион байгуулах боломжтой. Мөн сургалт явуулахад ч илүү тохиромжтой. Өөрийн үйлдвэр дэх ажлыг тухайн салбараас ирсэн мэргэжлийн мастерууд хянадаг.

Хойд-райн-Баруун-хүрхрээ (Нордрайн-Вестфаллен) муж улсын хувьд, хорихын өөрийн үйлдвэрт **модон эдлэл, төмөр эдлэл, хэвлэх, ном хавтаслах үйлдвэрүүд** ажиллуулдаг.²⁷

- Хоригдлуудыг хувийн үйлдвэрт ажиллуулах

Хоригдлууд харгалзагчийн хяналт дор хувийн үйлдвэрүүдэд ажилладаг. Энд хоригдол ажиллуулж байгаа компаний эзэн эдийн засгийн эрсдлээ үүрдэг, харин хорихын захиргаа биш. Хорихын захиргаанаас хоригдол ажиллуулах зөвшөөрөл авсан компаний эзэн болон тухайн үйлдвэрт ажиллах зөвшөөрөл авсан хоригдол аль аль нь ажлын журмыг мөрдөх үүрэгтэй. Ийм төрлийн хөдөлмөр эрхлэлт өмнөхтэйгээ харьцуулахад одоо гэмт хэрэгтнийг сурган хүмүүжүүлэх ажиллагаанд маш их эрэлттэй байгаа. Хөдөлмөрийн хувьд, түргэн сурах боломжтой, амархан хянаж болох, тооны хувьд яг таг тоолох боломжтой ажил байдаг. Энэ нь хөдөлмөрийн чанарт төдийлэн анхаардаггүй ажил гэсэн үг. Ийм төрлийн хөдөлмөр эрхлэлтийн дутагдалтай тал нь гэвэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэл сургалтанд голлон анхаарсан байх шаардлага орхигддог.

- Хоригдлуудыг өөрийн үйлдвэрт хувийн аж ахуйн хэлбэрээр ажиллуулах

Ийм үйлдвэр нь голцуу хязгаарлагдмал хариуцлагатай компаний хэлбэртэй байдаг. Төр тодорхой хувийг нь эзэмшинэ. Энд чөлөөт эдийн засгийн ертөнцтэй ижил шахуу хөдөлмөрлөх боломж олгодог. Ингэснээр хоригдлуудыг нийгэмшүүлэхэд илүү дөхөмтэй, гэхдээ харуул-хамгаалалтын нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай.

²⁷ Хоригдлын хөдөлмөр эрхлэлт (www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/Justizvollzug/Gefangenenarbeit_1/index.php)

- Хоригдлуудыг чөлөөт хөдөлмөрийн харилцаанд ажиллуулах
ШШГХ-ийн 39-р зүйлд заасны дагуу, хоригдол хорихын гадуур хөдөлмөр эрхэлнэ. Урьдчилсан нөхцөл нь ялтан чөлөөт явагч байх ёстой. Тэр шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой багахан хэмжээгээр хорогдуулсан тухайн ажлын байрны тарифт цалинг ажлын хөлсөнд авдаг. Хоригдол ердийн нийгмийн даатгалын үүрэг хүлээнэ. Гэхдээ олсон орлогоо бүрэн захиран зарцуулах эрхгүй, суллагдах хүртэл нь түүнийг хорих мэдэлдээ байлгадаг.
Энэхүү чөлөөт хөдөлмөрийн харилцаанаас гадна “жинхэнэ бус чөлөөт явагч” гэж бас байна. Ийм хоригдол хорихын гадуур хөдөлмөр эрхлэх боловч нийгмийн даатгалын харилцаанд ордоггүй. Үр дагавар нь, ажил олгогч хөдөлмөрийн хөлсийг бүтнээр нь хориход шилжүүлнэ, харин хорих нь хоригдолд оногдох хөлсийг олгодог. Энэ тохиолдолд хорих хоригдлыг газар дээр нь харгалзах ёстой.

Мекленбург-Форпоммерн муж улсын Хуульзүйн яамны мэдээгээр, 2006 онд нээлттэй шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 33 хоригдлыг хорихоос гадуур ажиллуулж, улсын санд 363 000 еврогийн орлого оруулжээ. 2007 оны эхний хагас жилд 126 хоригдлын хувьд энэ үзүүлэлт 206 000 евро байсан байна.²⁸ Тус муж улс нь 2006 онд хоригдлуудын **хөдөлмөрийн хөлс, сургалтын стипенд, ажилгүйдлийн даатгал болон халаасны мөнгө** (хүндэтгэх шалтгаанаар ажиллаагүй хоригдолд олгодог)-нд нийтдээ **3.2 сая евро** зарцуулсан байна.²⁹

- Хөдөлмөрийн эмчилгээний арга хэмжээнүүд
Эдийн засгийн үр ашигтай хөдөлмөр эрхлэх чадамжгүй, мэргэжлийн сургалт, эсвэл дунд боловсрол эзэмшүүлэх боломжгүй хоригдлуудад эмчилгээ-засан хүмүүжүүлэх хөшүүрэг чухал байдаг. Хөдөлмөрийн эмчилгээний арга хэмжээнүүд болох хоригдлыг дэгийн дагуу өдрийг өнгөрөөхөд дасгах, тодорхой амжилтын амтыг мэдрүүлэх, гараар ажиллахыг зааж сургах, өөрийн ухамсрыг бэхжүүлэх, хүндэтгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол өгдөг. Байнгын хөдөлмөр эрхлэлтэд хүргэхийг оролдох нь хүүхдийн хориход шаардлагатай бөгөөд олон талт хандалт хэрэгтэй. Хойд-райн-Баруун-хүрхрээ (Нордрайн-Вестфаллен) муж улсын хувьд, хөдөлмөрийн эмчилгээний чиглэлд голцуу бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэдэг.³⁰

4. БНСУ

БНСУ -ын хорихын байгууллагуудыг Хууль зүйн яам мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилладаг. БНСУ-ын Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлэгт ял шийтгэлийн талаар хуульчилсан байдаг. Хуулийн 41 дүгээр зүйлд дараах ял шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан байна. Үүнд:

1. Цаазаар авах
2. Хорих
3. Ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих

²⁸ “Хоригдлын хөдөлмөр эрхлэлт: Шорон дахь үйлдвэрлэл” нийтлэл (http://www.focus.de/finanzen/karriere/berufsleben/gefangenenarbeit_aid_69175.html)

²⁹ “Хоригдлын хөдөлмөр эрхлэлт: Шорон дахь үйлдвэрлэл” нийтлэл (http://www.focus.de/finanzen/karriere/berufsleben/gefangenenarbeit_aid_69175.html)

³⁰ Хоригдлын хөдөлмөр эрхлэлт (http://www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/Justizvollzug/Gefangenenarbeit_1/index.php)

4. Зэрэг дэв хасах
5. Мэргэжлийн зэрэг хасах
6. Торгууль
7. Албадан саатуулах буюу баривчлах
8. Бага хэмжээний торгууль ногдуулах
9. Анз төлөх

Хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, бүх насаар нь хорих, тодорхой хугацаагаар хорих зэрэг ял нь 1 жилээс 30 жил хүртэл байдаг. БНСУ-ын ялтны эрх зүйн байдал болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг эрүүгийн хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиараа нарийвчлан зохицуулаагүй байна. Хууль зүйн яамнаас баталсан дүрэм, журмуудаар нарийвчлан зохицуулсан байдаг. Ерөнхийдөө хорих байгууллага болон хоригдлуудын эрх зүйн байдлыг дараахь хууль тогтоомжуудаар зохицуулдаг байна. Үүнд:

1. Хууль зүйн яамны тухай хууль
2. Цагдаагийн байгууллагын тухай хууль
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль
4. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хууль /2010-12-30/
5. Хорих байгууламжийн тухай журам
6. Харгалзагчийн үзлэг шалгалт хийх журам
7. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хүчин төгөлдөр болгох зарлиг /2010-12-30/
8. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хэрэглэх журам /2010-05-31/

Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд ялтан гэж “хорих, цагдан хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, урьдчилан хорих шүүхийн шийдвэр авсан тэрхүү ял нь батлагдсан хүн болон мөнгөн торгуулиа төлж дуусгаагүй ажлын байранд ажиллах шийдвэр хүлээн авсан этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Шүүгдэж буй этгээд гэж гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон шүүгдэгчээр баривчлагдсан эсвэл цагдан хорих шүүхийн шийдвэр хүлээн авсан этгээдийн хэлнэ гэжээ. Тус хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд зааснаар ялтнуудыг дараахь төрлийн хорих байгууламжид хорих ял эдлүүлнэ.

1. 19-өөс дээш насны ялтан: Шорон
2. 19 нас хүрээгүй ялтан: Хүүхдийн хорих
3. Шийдэгдээгүй хоригдол: Саатуулах төвд
4. Цаазаар авах ял авсан этгээд: Шорон болон саатуулах төвд. Энэ тохиолдолд тодорхой ангиллын стандартыг хууль зүйн яамны дүрэм, журмаар зохицуулна.

Ялтны хөдөлмөр эрхлэлт

Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийн 4 дүгээр бүлэгт ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан байдаг. Ялтанд ногдуулах ажил нь эрүүл чийрэг амьдралд эргэж очиход туслах зорилгоор ур чадварыг сайжруулах, ажиллах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Хорихын дарга ялтанд хийх ажлыг оноохдоо нас, ялын хугацаа, эрүүл мэндийн байдал, ур чадвар, зан ааш, сонирхол, ажил байдлын намтар, ирээдүйн амжиргаа, болон ялтны нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой.

Ялтан нь өөрт ногдох ажил, үүргийг гүйцэтгэх үүрэгтэй. Хорихын дарга нь ажил хөдөлмөр

хийлгэхгүйгээр хорих болон урьдчилан хорих шүүхийн шийдвэртэй этгээдэд өргөдөл заасан ажлыг ногдуулж болно. Хорихын дарга нь ялтны эрүүл амьдралд эргэж ороход, ур чадвараа сайжруулахыг хөхиүлэн дэмжих зорилгоор шаардлагатай гэвэл гадны үйлдвэрт ажиллуулах эсвэл хорих байгууламжийн дотор зохион байгуулж гадны үйлдвэрийн ажлыг хийж болно.

Энэхүү гадны үйлдвэрийг сонгон авах стандартад холбогдох шаардлагатай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ. Мөн хорихын дарга ялтны ур чадварыг сайжруулах, дээшлүүлэх үүднээс хөдөлмөрийн мэргэжлийн сургуулийг байгуулж болно. Хорихын дарга ялтаны мэргэжлийн сургуульд шаардлагатай гэж үзвэл гадны байгууллага, үйлдвэрт мэргэжлийн сургалтыг хийлгэж болно. Мэргэжлийн сургуульд холбогдох шаардлагатай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ.

Ялтан нь амралтын өдөр, хагас сайн өдөр болон олон нийтийн амралтын өдөр ажиллахгүй. Ялтаныг дараах тохиолдолд ажлаас чөлөөлнө.

- Гэр бүл болон хань ижлийн хамаатан, ойр дотны хүн нас барвал 2 хоног
- Аав ээж болон хань ижлийн нас барсан өдөр 1 өдөр /Хэрэв ялтан ажлаа хийхийг хүсвэл ажиллуулж болно/
- Гэмтэл бэртэл, өвчин, ажлаа хийхэд саад болохүйц нөхцөл байдал үүсвэл түүнийг арилах хүртэл ажлаас чөлөөлж болно.

Ялтны хийсэн ажлын хөдөлмөрийн хөлс нь улсад орно. Хорихын дарга ялтны ажиллах хүсэл сонирхлыг хөгжүүлэх, эрүүл амьдралд эргүүлэн оруулах зорилгоор хууль зүйн яамны сайдын тогтоосны дагуу ажлыг дуусгах, ажлын үр дүн, хүмүүжлийн үзүүлэлт болон бусад нөхцөл байдлыг харгалзан ялтанд ажлын шагнал урамшуулалыг олгож болно. Ажлын шагнал урамшууллыг нь суллахад нь өгч болно. Ялтан өөрөө гэр бүлийн амьдралаа туслаж дэмжих, соён гэгээрэх, эрүүл амьдралд эргэн орох зорилгоор шаардлагатай гэвэл суллахын өмнө бүгдийг болон зарим хэсгийг авч болно. Хэрэв ялтан нь ажлын байр болон мэргэжлийн сургалтын явцад болон түүний улмаас нас барвал ялтны хөдөлмөрийн шагнал урамшуулалаар авсан мөнгийг өв залгамжлагчид өгнө.

5. Япон улс

Япон улсын 1882 онд батлагдсан Эрүүгийн хуулийн агуулгын үндсэн үзэл санаанд Францын адил төсөөтэй хуулийн үзэл санаа тусгагдсан байна. Харин одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулинд 20-р зууны эхэн үед Герман улсад хэрэглэгдэж байсан зохих хуулийн агуулгыг тусган баталжээ. Дэлхийн 2-р дайны дараа Япон улс өөрийн орны эрүүгийн хууль тогтоомжиндоо үндэсний онцлогоо тусгасан дорвитой өөрчлөлтүүдийг удаа дараа хийсэн байна.

Япон улсын шоронгийн тухай хууль 1908 онд батлагдан зохих нэмэлт өөрчлөлт орсоор шинэ зуунтай золгож байгаа ажээ. Мөн 1950 онд “Суллагдасдад тусламж үзүүлэх тухай”, 1958 онд “Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай” хуулиуд батлагдан үйлчлэх болов. Түүнчлэн “Шоронгийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн зарчим”, “Ялтныг ангилах тухай товч удирдамж” нэртэйгээр зохих дээд байгууллагын баталсан эрхийн актууд нь ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтанд хамаарагддаг байна.

Япон улсын эрүүгийн ял нь:

1. Бага хэмжээний торгууль
2. Торгууль
3. Эрүүгийн баривчилгаа
4. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих

5. Цаазаар авах гэсэн төрлүүдтэй байдаг

Торгууль бол хамгийн өргөн хэрэглэгддэг ялын төрөл юм. Нийт шийтгүүлэгчдийн 90 хувь нь торгуулийн ялд хамаарагддаг байна. Энэ нь нэгд: авто замын осол зөрчилтэй холбогдсон гэмт хэрэг их гардаг, хоёрт: богино хугацааны хорих ялыг аль болох цөөн оногдуулах эрмэлзлэлтэй байдаг зэргээр тайлбарлагдана.

Эрүүгийн баривчилгаа бол хор хохирлоор бага гэмт хэрэг үйлдэгчдэд 1-30 хоногийн хугацаагаар оногдуулна. Албадан буюу албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих ялыг 1 сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорихоор оногдуулдаг. Бүх насаар нь хорихоор ял оногдуулдаг гэх боловч тэр нь харьцангуй ойлголт юм. Хэрэв бүх насаараа хорих ялаар шийтгүүлэгчид 10 жил хорих ял эдлэх ба хүмүүжиж чадсанаа харуулсан тохиолдолд тэднийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болдог байна.

Япон улсын ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих, баривчлах байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийг хорих байгууллага багтана. Японы ял эдлүүлэх байгууллага нилээд төвлөрсөн байдалтай боловч нарийвчилсан ангилалтай байдаг. Хорих ялаар шийтгэгдсэн бүх хоригдол эхлээд ангилан хуваарилах төвд ирдэг. Дараа нь тэднийг доорхи байдлаар хуваарилан ялыг нь эдлүүлдэг байна. Үүнд:

1. Бага, багавтар хэмжээний гэмт хэрэг үйлдэгсэд
2. Гадаадын иргэд
3. 8-аас дээш жил ял эдлэх хүмүүс
4. 20 хүртэлх насны залуучууд
5. Сэтгэл мэдрэлийн болон бусад өвчнөөр өвчлөгсөд, биеийн эрүүл мэндээр сул дорой хүмүүсийг тус тусд нь байлгаж ял эдлүүлдэг.

Японд хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулах эрх зүйн үндэс нь хөдөлмөрийн хууль тогтоомж бөгөөд “Шоронгийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн зарчим”, “Албадлагын журам” гэх мэт дэгүүдээр зохицуулагдана. Хоригдлууд нь доор дурьдсан хоёр төрөлд хуваагдан ажиллана.

- 1-рт. Аж үйлдвэрийн салбар, ял эдлүүлэх байгууллага хоорондын хамтарсан холбооны гэрээний дагуу гутал, цүнхний гэх мэт үйлдвэрт 25 хувь нь ажилладаг
- 2-рт. Улсын гэрээтэй хувийн компанид худалдааны бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрт 75 хувь нь ажилладаг байна. Хоригдлууд өдөрт 8, долоо хоногт 40 цаг ажилладаг. Өглөө, өдөр 15 минутын амралттай бөгөөд өдрийн хоол 40 минутын амралттай

Хөдөлмөр эрхлэлтээс олсон орлого үндэсний сан руу ордог. Цалингүй ажиллана гэсэн үг. Гэхдээ ажлын төрлөөс хамаарч бага зэргийн тэтгэмж хуримтлагдана. Энэ нь ойролцоогоор 3500 иен байна цаашид нэмэгдэнэ. /1994 оны хувьд 35 доллар байсан/ Энэ мөнгийг суллагдахад нь өгөх ба зарим хэсгийг өөрсдийнх хэрэгцээнд зарцуулдаг. Мөн хоригдлуудыг аваар осолд орох, бэртэж гэмтэх, амь насаа алдсан тохиолдолд засгийн газраас 1,4 сая иений нөхөн төлбөр олгодог байна.

Хоригдлууд нь маш хатуу чанга дэглэмтэй ажилладаг. Ажил хийж байхдаа хоорондоо ярих, харгалзагч болон өөр хоорондоо нүдээрээ харьцахыг ч хатуу хориглодог. Мөн таван зарчим баримталж ажиллана. Үүнд:

1. Шударга
2. Зарчимтай
3. Найрсаг

4. Тусархаг
5. Талархалтай байх ёстой

Хоригдлуудын дунд хүмүүжлийн ажил зохиохдоо аль болохоор олныг хамарч хавтгайруулахгүй байхыг хичээдэг онцлогтой.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Барилгын салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол (2009.01.28, №23)
4. Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээ тогтоох түр журам (ШШГЕГ-ын даргын 2008 оны тушаал)
5. МУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй., А.Лхагва, 2004., УБ

Цахим хаягууд:

- ХБНГУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль (JuraForum.de)
- Хоригдлын хөдөлмөр эрхлэлт (Krimpedia) (<http://www.kriminologie.uni-hamburg.de/wiki/index.php/Gefangenenarbeit>)
- “Хоригдлын хөдөлмөр эрхлэлт: Шорон дахь үйлдвэрлэл” нийтлэл (http://www.focus.de/finanzen/karriere/berufsleben/gefangenenarbeit_aid_69175.html)
- Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн түүх <http://www.justiz.sachsen.de/content/900.htm>)
- Хоригдлын хөдөлмөр эрхлэлт (http://www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/Justizvollzug/Gefangenenarbeit_1/index.php)
- БНСУ-ын хуулийн лавлах цахим хуудас- <http://law.go.kr/main.html>
- Prison labour in Japan- www.jca.apc.org/cpr/kaido.html
- U.S. Department of Justice
- Federal Bureau of Prisons- www.bop.gov
- General Services Administration, Acquisition Systems Division-www.acquisition.gov
- UNICOR, Federal Prison Industries- www.unicor.gov
- Дерюга Николай Николаевич. Организационно-правовые проблемы занятости осужденных, содержащихся в местах лишения свободы : Дис. ... д-ра юрид. наук : 12.00.08 : Хабаровск, 2003 476 с. РГБ ОД, 71:05-12/17
- <http://www.uikodeks.ru/vkodeks/uikodeksru/ugolovno-glava14.html>
- Уголовно-исполнительный кодекс Российской Федерации (25-12-1996)

* * *

Хавсралт 1

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002-01-10

... 8 дугаар зүйл. Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэг

...8.2. Баривчлах, хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

...8.2.4. ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох;

...120 дугаар зүйл. Ялтны хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл

120.1.Ялтны хөдөлмөрийг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна.

120.2.Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

120.3.Ялтнаар ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах боловч мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

120.4.Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно.

120.5.Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих байрны аж ахуйн үйлчилгээнд ажиллуулж болно.

120.6.Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.

120.7.Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.

120.8.Төрийн нууц, цэрэг стратегийн холбогдолтой зэрэг тусгай дэглэм бүхий онцгой объектод ялтан ажиллуулахыг хориглоно.

121 дүгээр зүйл.Ялтны хөдөлмөрийн хөлс

121.1.Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.

121.2.Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ.

121.3.Хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон энэ хуулийн 121.2-т заасны дагуу шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ.

121.4.Энэ хуулийн 121.3-т заасны дагуу төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгоно.

121.5.Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар тогтооно.

121.6.Хорих анги, эсхүл ажил олгогч нь ялтны хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн үнэлгээ, ханшаар тооцно.

122 дугаар зүйл. Ялтныг харуул хамгаалалтгүй ажиллуулах

122.1.Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн, ялын гуравны нэг хувийг эдэлсэн ялтныг засрал, хүмүүжил, хувийн байдал, ажлын онцлогийг нь харгалзан хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн харуул хамгаалалтгүй ажиллуулах тухай шийдвэр гаргаж болно.

123 дугаар зүйл Хүмүүжлийн ажил

123.1.Гэмт хэрэг, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, хорих ялын зорилгыг хангахын тулд ялтны дунд хүмүүжлийн ажил явуулна.

123.2.Хүмүүжлийн ажлыг ялтны үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх дэглэмийг харгалзан ялгамжтай явуулна.

124 дүгээр зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт

124.1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна.

125 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт

....125.3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.

....125.4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.

126 дугаар зүйл. Ялтныг урамшуулах

126.1.Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна.

126.1.1.хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх;

126.1.2.урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах;

126.1.3.энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.

126¹дугаар зүйл. Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах, гянданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорих ялаар солих тухай санал гаргах

...126¹.2.Хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж урамшуулагдаж байсан ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах тухай саналыг хорих ангийн дарга прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

* * *

Хавсралт 2**ЯЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН НОРМ, ХӨЛСНИЙ ҮНЭЛГЭЭ ТОГТООХ ТҮР ЖУРАМ**

(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны А08 дугаар тушаалын хавсралт)

1. Ялтны ажлын хөлсний нэгдсэн жишиг тогтоож цалинжуулах, шаардлагатай зардлын эх үүсвэр бүрдүүлэх, улс болон иргэдэд учруулсан хорирлыг төлүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэхэд энэхүү журмын зорилго нь оршино.

2. Ялтны хөдөлмөрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, норм, норматив, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулах

3. Байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хорих ангиас ялтан ажиллуулахаар байгуулсан гэрээгээр ажиллах ялтны нэг өдрийн ажлын хөлсний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан

а / Хот суурин газарт 4000 төгрөг,

б / Хөдөө орон нутагт 3500 төгрөгөөс доошгүй байхаар тус тус тогтоож, цагийн үнэлгээнд шилжүүлэн олгоно.

4. Гуравдугаар зүйлд заасан ялтны нэг өдрийн ажлын хөлсний үнэлгээг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний үнэлгээ ханшаар тооцох ба тухай бүр түр журамд дагаж өөрчлөлт оруулна.

5. Хорих ангид ял эдэлж байгаа ялтны ахуйн үйлчилгээ, аж ахуй, үндсэн үйлдвэрлэлийн туслах чанарын бусад ажилд нийт ялтны 8-10 хувь байхаар тогтоож, тэдгээрийн хөдөлмөрийн хөлсөнд хуулийн дагуу ногдох шагналын хоног олгож байх.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон баривчлах ял эдлүүлэх, цагдан хорих байрны үйлчилгээнд ажиллаж байгаа ялтныг энэ журмын 5 дугаар зүйлд нэгэн адил хамааруулна.

7. Хорих анги, байгууллагын өөрийн үйлдвэрлэл, байгууллагын хувь нийлүүлсэн болон хамтарсан аж ахуйн нэгж дээр ажиллаж байгаа ялтны хөдөлмөрийн хөлсийг энэ журмын 3 дугаар зүйлд заасан жишгээр тогтооно.

8. Ажил олгогчоос шилжиж ирсэн ажлын хөлсний 30 хүртэлх хувийг ялтанд цалин хөлс болгон тооцон дараах тохиолдолд суутгал хийсний дараа үлдэх цалинг нэрийн дансанд бичилт хийнэ. Үүнд:

- шүүхийн шийтгэх тогтоолд даасан хохирол,
- ял эдэлж байхдаа анги, байгууллагад учруулсан эд хөрөнгийн хохирол

9. Ажлын хөлсний үлдэх хувийг хорих анги ялтныг ажлын байраар хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, үйлдвэрлэлийг өргөтгөх, бүтээн байгуулалтын ажил, ялтантай холбогдон нэмэгдэж гарах шаардлагатай зардал болох / гэрэл цахилгаан, хоол хүнс, хувцас, дулаан, ус, ялтны эрүүл мэндийн даатгал, эм гэх мэт / шууд зардал зарцуулна.

10. Ялтны нэрийн дансанд төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг нь суллагдах үед өөрт нь олгоно.

11. Ялтны хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөрийн даамал болон хөдөлмөр цалин хөлсний нягтлан бодогчийн бүртгэл дээр үндэслэн бодож холбогдох тооцоог хийсний дараа ерөнхий /ахлах/ нягтлан бодогч хянан баталж нягтлан бодох бүртгэлд тусгана.

12. Ялтны хөдөлмөр хангалтын мэдээ болон ялтны бодогдсон цалин хөлсний тайланг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тогтоосон маягтын дагуу хорих ангийн хөдөлмөр, цалин хөлс хариуцсан мэргэжилтэн гаргаж сар бүрийн 25-ны дотор Санхүү, үйлдвэр, төлөвлөлт бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

* * *

Хавсралт 3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

БАРИЛГЫН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧИН БЭЛТГЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2009 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр, Дугаар 23, Улаанбаатар хот,

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

...6. Ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төвлөрсөн

хорих ангиудын дэргэд мэргэжлийн түр сургалт зохион байгуулж ажиллуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд С.БАЯР

Зам,тээвэр,барилга,хот байгуулалтын сайд Х.БАТТУЛГА

* * *

Хавсралт 4

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛ

Улаанбаатар хот, дүүрэг Баянзүрх:

407 дугаар анги- Төрөл бүрийн оёдолын үйлдвэрлэл

409 дүгээр анги- Тоосгоны үйлдвэрлэл

421 дүгээр анги- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, тахианы аж ахуй

431 дүгээр анги- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл

Дарь эхийн 441 дүгээр анги- Барилга угсралтын ажил, ханын материалын үйлдвэрлэл.

Хан-Уул дүүрэг:

401 дүгээр анги- Уран дархан, мужаан, барилгын материалын үйлдвэрлэл

Багануур:

427 дугаар анги- Төмс, хүнсний ногоо тариалалт, барилгын материалын үйлдвэрлэл, гутлын үйлдвэр, мод бэлтгэл.

Орон нутаг:

Төв аймаг:

403 дугаар анги - Ногоон боржин чулуу олборлолт, боловсруулалт

415 дугаар анги - Шохой чулуу олборлолт, шохойн үйлдвэрлэл

417 дугаар анги - Ойжуулалт, мод үржүүлэг, ойн цэвэрлэгээ, мод, модон эдлэлийн үйлдвэр.

Сэлэнгэ аймаг:

413 дугаар анги- Төмс, хүнсний ногоо тариалалт, мод бэлтгэл болон боловсруулах үйлдвэрлэл, үр тариа, гурилын үйлдвэр.

433 дугаар анги - Төмс, хүнсний ногоо тариалалт, мод бэлтгэл болон боловсруулах үйлдвэрлэл, үр тариа, гурилын үйлдвэр.

Хэнтий аймаг дахь 419 дүгээр анги - Тоосгоны үйлдвэрлэл

Говьсүмбэр аймаг дахь 425 дугаар анги - Эсгий, эсгий гутлын үйлдвэрлэл, жоншны үйлдвэрлэл

Өвөрхангай аймаг Хар хорин сум дахь 423 дугаар анги - Үр тарианы үйлдвэрлэл, гурилын үйлдвэр, ойн цэвэрлэгээ

Хөвсгөл аймаг дахь 443 дугаар анги - Чулуун нүүрсний үйлдвэрлэл, мод бэлтгэл

Булган аймаг дахь 439 дүгээр анги - Шохойн чулуу олборлолт, шохой үйлдвэрлэл

Дархан 435 дугаар анги - Барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хадлан бэлтгэл

Ховд аймаг дахь 457 дугаар анги - Төмс, хүнсний ногоо тариалалт, барилга, барилгын материалын үйлдвэрлэл

* * *

Хавсралт 5

Executive Order 11755--Relating to prison labor

Source: The provisions of Executive Order 11755 of Dec. 29, 1973, appear at 39 FR 779, 3 CFR, 1971-1975 Comp., p. 837, unless otherwise noted.

The development of the occupational and educational skills of prison inmates is essential to their rehabilitation and to their ability to make an effective return to free society. Meaningful employment serves to develop those skills. It is also true, however, that care must be exercised to avoid either the exploitation of convict labor or any unfair competition between convict labor and free labor in the production of goods and services.

Under section 4082 of title 18 of the United States Code, the Attorney General is empowered to authorize Federal prisoners to work at paid employment in the community during their terms of imprisonment under conditions that protect against both the exploitation of convict labor and unfair competition with free labor.

Several states and other jurisdictions have similar laws or regulations under which individuals confined for violations of the laws of those places may be authorized to work at paid employment in the community.

Executive Order No. 325A, which was originally issued by President Theodore Roosevelt in 1905, prohibits the employment, in the performance of Federal contracts, of any person who is serving a sentence of imprisonment at hard labor imposed by a court of a State, territory, or municipality.

I have now determined that Executive Order No. 325A should be replaced with a new Executive order which would permit the employment of non-Federal prison inmates in the performance of Federal contracts under terms and conditions that are comparable to those now applicable to inmates of Federal prisons.

NOW, THEREFORE, pursuant to the authority vested in me as President of the United States, it is hereby ordered as follows:

Section 1. (a) All contracts involving the use of appropriated funds which shall hereafter be entered into by any department or agency of the executive branch for performance in any State, the District of Columbia, the Commonwealth of Puerto Rico, the Virgin Islands, Guam, American Samoa, the Commonwealth of the Mariana Islands, or the Trust Territory of the Pacific Islands shall, unless otherwise provided by law, contain a stipulation forbidding in the performance of such contracts, the employment of persons undergoing sentences of imprisonment which have been imposed by any court of a State, the District of Columbia, the Commonwealth of Puerto Rico, the Virgin Islands, Guam, American Samoa, the Commonwealth of the Mariana Islands, or the Trust Territory of the Pacific Islands.

This limitation, however, shall not prohibit the employment by a contractor in the performance of such contracts of persons on parole or probation to work at paid employment during the term of their sentence or persons who have been pardoned or who have served their terms. Nor shall it prohibit the employment by a contractor in the performance of such contracts of persons confined for violation of the laws of any of the States, the District of Columbia, the

Commonwealth of Puerto Rico, the Virgin Islands, Guam, American Samoa, the Commonwealth of the Mariana Islands, or the Trust Territory of the Pacific Islands who are authorized to work at paid employment in the community under the laws of such jurisdiction, if

(1)(A) The worker is paid or is in an approved work training program on a voluntary basis;

(B) Representatives of local union central bodies or similar labor union organizations have been consulted;

(C) Such paid employment will not result in the displacement of employed workers, or be applied in skills, crafts, or trades in which there is a surplus of available gainful labor in the locality, or impair existing contracts for services; and

(D) The rates of pay and other conditions of employment will not be less than those paid or provided for work of a similar nature in the locality in which the work is being performed; and

(2) The Attorney General has certified that the work-release laws or regulations of the jurisdiction involved are in conformity with the requirements of this order.

(b) After notice and opportunity for hearing, the Attorney General shall revoke any such certification under section 1(a)(2) if he finds that the work-release program of the jurisdiction involved is not being conducted in conformity with the requirements of this order or with its intent or purposes.

[Sec. 1 amended by Executive Order 12608 of Sept. 9, 1987, 52 FR 34617, 3 CFR, 1987 Comp., p. 245]

Sec. 2. The Federal Procurement Regulations, the Armed Services Procurement Regulations, and to the extent necessary, any supplemental or comparable regulations issued by any agency of the executive branch shall be revised to reflect the policy prescribed by this order.

Sec. 3. Executive Order No. 325A is hereby superseded.

Sec. 4. This order shall be effective as of January 1, 1974.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ
ТОГТОЛЦОО, СТАНДАРТ, ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ, БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ
ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО** (Лавлагаа - Мэдээлэл)

*Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, А. Пагма, Ч. Базар (Ph.D),
Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг*

ГАРЧИГ

1. Оюун ухааны хомсдлын тухай ерөнхий ойлголт
2. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлын эрх зүйн зохицуулалт
3. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, түүний шатлал
4. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, боловсролд баримтлаж байгаа стандарт
5. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин, төрөөс баримтлаж байгаа бодлого
6. Хөдөө орон нутагт амьдардаг оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагддаг эсэх
7. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суррч боловсроход улсаас зарцуулж буй төсөв
8. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, орлого

**ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, СТАНДАРТ,
ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ, БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО**

1. Оюун ухааны хомсдлын тухай ерөнхий ойлголт

Оюун ухааны хомсдол (mental retardation-англи, олигофрения-грекээр oligos- бага, phereni-ухаан) нь “сэтгэхүйн, юуны түрүүнд сэтгэн бодох үйл ажиллагааны түвшний эргэшгүй, тогтонги дутуу хөгжил бөгөөд төрөлхийн буюу тархины эд эсийн сэргэшгүй согог бүхий олдмол чанартай байж болно. Оюун ухааны хувьд бүрэн бус байхаас гадна сэтгэл хөдлөл, хүсэл зориг, хэл яриа, хөдөлгөөний эх үүсвэрүүдийн хүрээний эмгэгүүд хамаардаг.

17-18-р зуунд оюуны хомсдолтой хүүхдийн сурган, сэтгэл судлалын шинжлэх ухааны үүссэн нь сэтгэц гэм судлалын шинжлэх ухаанд, оюуны хомсдолыг сэтгэл мэдрэлийн өвчнөөс ангид үзэхээр болсонтой холбоотой.

Германы эрдэмтэн Эмиль Крепелин анх олигофрени гэсэн нэр томъёог санал болгохдоо сэтгэхүйн согогийн төрмөл хам шинж (синдром) гээд энэ нь ухаан санааны олдмол доройтлоос ялгаатай гэжээ.

Францын материалистуудын үзэл баримтлалын (1789-1793) нөлөөгөөр оюуны хомсдолтой хүмүүст хандах нийгмийн хандлага ихээхэн өөрчлөгдөж эхэлсэн. Ядуу зүдүү, ухаан хомс, ядарсан хүмүүсээ халамжлах нь улсын үүрэг гэж Францын хөрөнгөтний хувьсгалаар тунхагласан ч амьдралд хэрэгжүүлэх боломж олдоогүй. Гэвч энэ үзэл санаа дээрхи хүмүүст хандах нийгмийн шинэ хандлага бүрэлдэн тогтож цаашид хөгжихөд их үүрэг гүйцэтгэсэн байна.

Оюуны хомсдолтой хүнийг сургах талаар анх удаа сурган хүмүүжүүлэгчдээс Ян Амос Коменский/1592-1670/, клиник талаас Филипп Пинель (1745-1826), Жан Эскироль (1772-1840) нар судалж ангилал тогтоожээ. Эскироль оюун ухааны хомсдолыг төрөлхийн, олдмол гэж ялгаад, оюуны хомсдолын хүндэвтэр зэрэглэлийг тэмдэглэсэн “имбецилизм”-гэдэг нэр томъёог гаргасан.

18-р зууны сүүл, 19-р зууны эхээр эмч, багш нар, нийгмийн дунд оюуны хомсдолтой хүнд тусламж арчилгаа үзүүлэх, сургаж хүмүүжүүлэх тусгай байгууллага буй болгох санал дэвшүүлж эхэлсэн боловч, сургаж хүмүүжүүлэх асуудал маш их эргэлзээг төрүүлж, багш нар хүртэл утгагүй, үр дүнгүй зүйл гэж үзэж эсэргүүцэж байжээ.

Швейцарын нэрт сурган хүмүүжүүлэгч Песталоцци (1746-1827), оюуны хөнгөн хэлбэрийн хомсдолтой хүнийг зайлшгүй сургаж хүмүүжүүлэх шаардлагатай гэж үзээд, оюуны хомсдолтой хүүхдэд тохирсон сургалт, сурганы талын дидактикийн материал хэрэглэх, оюуны хөдөлмөрийг биеийн хөдөлмөртэй хослуулах, сургалтыг амьдралтай холбох гэх мэт тусгай сургалтын зарчмуудыг дэвшүүлсэн. Песталоццийн энэхүү үзэл санаа дэмжлэг аваагүй ба хэрэгжих нийгэм эдийн засгийн нөхцөл нь ч бүрэлдээгүй байв. Францын эрдэмтэн Эдуард Сеген (1812 - 1880) оюуны хомсдолтой хүүхдийн тусгай байгууллагыг нээж, 1846 онд хүнд хэлбэрийн оюуны хомсдолтой хүүхэдтэй ажиллах системийг боловсруулж энэ талаар ном гаргажээ.

19-р зууны 2-р хагаст ерөнхий боловсролын сургуулийн дэргэд тусгай анги бүлгүүд нээгдэж багш нарын үүрэг нэмэгдсэн байна. Орос улсад оюуны хомсдолтой хүүхдэд зориулсан тусгай сургууль 1908 онд байгуулагдсан. Манай улсад оюуны хомсдолтой хүүхдэд зориулсан тусгай анги бүлгийг анх 1967 онд 24-р сургуулийн дэргэд байгуулсан ба хожим 25-р тусгай сургууль болон өргөжсөн.

Оюуны хомсдол үүсэх шалтгаан

Оюуны хомсдолыг үүсгэх маш олон янзын хүчин зүйлүүд байдгийг ерөнхийд нь дотоод

буюу төрөлхийн биологийн шалтгаанууд, гадаад буюу бие организм, мэдрэлийн системд хортой нөлөөлсөн шалтгаанууд гэж хуваадаг.

Дотоод шалтгаанд удамшлын нөлөө, хромосомын төрөлхийн гажгууд (Дауны өвчин, "муурын дууны" хам шинж, Клайнфельтер, Тернерын хам шинжүүд гэх мэт), бодисын солилцооны төрөлхийн гажгууд (фенилкетонурия), үр хөврөл бүрэлдэн тогтох үед эхийн талаас нөлөөлсөн хорт хүчин зүйлүүд орно. Үүнд: Эх жирэмсэн байх үедээ янз бүрийн хортой халдварт өвчнөөр жишээ нь, тэмбүү, цусан хордлого, улаанууд зэрэг өвчнөөр өвчлөх, мөн хортой болон эмийн бодис, архи, хар тамхи хэтрүүлэн хэрэглэх нь урагт хортой нөлөө үзүүлж ургийн хэвийн хөгжлийг гажуудуулдаг байна.

Оюуны хомсдолыг үүсгэх гадаад хүчин зүйлүүдэд эхийн хэвлийд байгаа үр, хөврөл, ураг, төрөх үе болон төрсний дараах 4 хүртэлх насанд хүүхдэд гадна орчноос нөлөөлсөн төрөл бүрийн хурц архаг тархины халдварууд, эх хүүхдийн бие организмын дотоод болон гаднаас авсан хордлогууд, мэдрэлийн систем уураг тархины бэртэл гэмтлүүд, хүрээлэн буй орчны бохирдол, туяаны хордлого орно.

Эцэг эхэд өндөр тун бүхий цацраг идэвхит туяа, хар тугалга, мөнгөн ус зэрэг хортой бодис удаан хугацаагаар нөлөөлж үйлчлэх нь ургийн хөгжилд хортойгоор нөлөөлнө.

Илүү тээлтийн үед уураг тархины хүчилтөрөгчийн дутагдал тархинд цус харвалт үүсгэн улмаар төв мэдрэлийн систем, уураг тархины мэдрэлийн эд эсийг гэмтээнэ. Харин дутуу төрсөн хүүхэд маш эмзэг оюуны хөгжлийн хоцрогдол үүсэх магадлал өндөртэй байна.

Хоол тэжээлийн дутагдлыг ч оюуны хөгжлийн бэрхшээл үүсэхтэй холбон үзэх болсон. Буурай хөгжилтэй орнуудын ард түмэн хоол хүнсний хангамж байнга дутагдалтай байдаг. Судлаачид хоол хүнсний дутагдал, мэдрэлийн систем, уураг тархины дутуу хөгжилд шууд холбоотой байгааг тогтоосон байна.

Хүүхдийн онтогенез (нэгэн биеийн хөгжил буюу төрөхөөс эхлээд өөд болох үе) хөгжлийн ямар үе шат, цаг хугацаанд дээр дурьдсан хортой хүчин зүйлүүд яаж нөлөөлөв гэдэгтэй холбоотойгоор оюуны хомсдлын үүсэх шалтгаан, илрэл янз бүр байдаг. Ийм учраас эдгээр хортой шалтгаанууд нөлөөлсөн цаг хугацаанаас нь хамааруулж гурван бүлэгт хувааж үздэг. Үүнд:

1. Төрөхийн өмнөх үе. Үр хөврөл дөнгөж бүрэлдэн тогтож байгаа жирэмслэлтийн эхний 3 долоо хоногт нөлөөлж буй хорт хүчин зүйлүүд. Жишээ нь согтуу үед үр тогтох, жирэмслэлтээс сэргийлэх эм гэх мэт. Жирэмсний 3-12 дахь долоо хоногт үр хөврөлийн эрхтэн системийн эх үүсвэр тавигдаж байгаа үед буюу цаашид жирэмсний 4 сар хүртэлх хугацааны үр хөврөлийн хөгжих үед нөлөөлсөн хортой хүчин зүйлүүд. Жишээ нь эх жирэмсэн байх үедээ улаанууд өвчнөөр өвдөх Мөн жирэмсэн эх янз бүрийн архаг хүнд өвчин, хордлогоор өвдөх, хүчтэй сэтгэл санааны цохилтонд орох зэрэг орно.
2. Төрөх үе. Энд төрөхтэй холбоотой хүүхдийн тархины гэмтэл, бэртлүүд, цус алдалт, хавчуурга тавьж төрүүлэх гэх мэт
3. Төрсний дараах үе. Төрсний дараа хүүхэд янз бүрийн хурц архаг халдварт өвчнөөр өвдөх, хордлого, тархины гэмтлүүд зэрэг орно.

Ийнхүү дээрхи дурьдсан шалтгаануудаас үүдэлтэй оюуны хомсдолын үед уураг тархи, мэдрэлийн системд бүтэц зохион байгуулалтын мэдэгдэхүйц согог өөрчлөлтүүд гардаг. Жишээ нь, тархины тодорхой хэсэг үгүй болох, эсвэл тархи бүхэлдээ дутуу хөгжих, тархи жижигрэн бичилтэх, нугалаанууд нь хатингаршин багасах, тархи хэт томрох, усан тархитах гэх мэт.

Оюуны хомсдолын ангилал, онцлог

Оюуны хомсдлыг, ДЭМБ-аас боловсруулан, дэлхийн болон манай улсын сэтгэцийн эмгэгийн оношлогооны өнөөгийн практикт мөрдөж байгаа өвчний олон улсын 10-р ангиллаар дараах хэлбэрт хувааж ангилсан байна. Оюуны хомсдлын ангиллыг хүснэгтээр үзүүлбэл

Хүснэгт 1.

F70-F79 Оюуны хомсдлын ангилал
умственная отсталость, mental retardation (13.132)

Шифр	Монгол хэлээр	Орос хэлээр	Англи хэлээр
F70	Оюуны хөнгөн хомсдол / IQ50-69 /	Легкая умственная отсталость	Mild mental retardation
F71	Оюуны хүндэвтэр хомсдол/IQ 35-49/	Умеренная умственная отсталость	Moderate mental retardation
F72	Оюуны хүнд хомсдол/ IQ 20-34/	Тяжёлая умственная отсталость	Severe mental retardation
F73	Оюуны маш гүнзгий хомсдол /IQ 20-оос бага	Глубокая умственная отсталость	Profound mental retardation
F78	Оюуны хөгжлийн бусад хомсдол	Другой тип умственной отсталости	Other mental retardation
F79	Тодорхойлогдоогүй оюуны хомсдол	Неуточненная умственная отсталость	Unspecified mental retardation

1. Хөнгөн хэлбэр – (IQ түвшин нь 50 - 55 буюу 70 - ын хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолтой хүүхдүүд нь аливаа юмс үзэгдлийн талаар тодорхой хэмжээгээр ойлголттой, эрэгцүүлэн бодох чадвартай, хийсвэр сэтгэхүй сул хөгжсөн, механик цээжлэх ой сайтай, энгийн хийсвэрлэн сэтгэх чадвартай, юмны учир зүйн холбоо агуулга чанарыг дутуу ойлгодог. Мөн аливаа далд утгатай үг, тооны болон шинжлэх ухааны мэргэжлийн нэр томъёо, хийсвэр ухагдахууныг сул эзэмшдэг. Харин өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгддэг үг, ойлголт, үзэгдэл юмсын холбоог ойлгоно. Нийгмийн дасан зохицолт харьцангуй сайн байна. Энэ бүлгийн оюуны хомсдолтой хүмүүс тохирсон тусламж авбал бие даан амьдрах чадвартай төдийгүй, орчноос үзүүлэх тодорхой хяналтын дор ажиллаж хөдөлмөрлөх бололцоотой. Ерөнхий боловсролын сургуулийн 4-р ангийн ерөнхий эрдмийн мэдлэгийг эзэмших бүрэн чадвартай. Энэ түвшний оюуны хомсдолтой хүүхдүүд манай улсад хөнгөвчилсөн сургалттай тусгай сургуульд (25,55,63,70) болон тусгай сургууль төгсөгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд сурч ажил хөдөлмөрийн дадал олж авч, улмаар энгийн хөнгөн мэргэжил /мужаан, оёдол, нарийн боов, / эзэмшиж бие даан амьдрах чадвартай болж байна.

2. Дунд хэлбэр- (IQ түвшин нь 35-40, 40-50-ын хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолын үед үгийн нөөц маш хязгаарлагдмал, амьдралын шаардлагын дагуу үүссэн хамгийн энгийн ойр зуурын ярианы хэлтэй, бие даах болон өөртөө үйлчлэх чадвар сул. Ойр зуурын хэрэгцээний механик ойтой, юмыг зөвхөн мэдэрч танин мэдэх чадвартай, анхаарч танин мэдэх чадвараар сул, сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй зэрэг шинжтэй. Хүрээлэн буй орчин юмс үзэгдлийн ойлголт, харьцуулалт, хангалтгүй. Танин мэдэхүйн үйл сул хөгжсөн. Энгийн ойлголт ухагдахууныг л эзэмшинэ. Энэ түвшний хүүхдүүд хүнийг дуурайх замаар хамгийн энгийн үйлдэл хөдөлгөөн, зарим механик ажлыг гүйцэтгэж чадах боловч сурах үйл хүндрэлтэй явагдах ба багшийн болон

насанд хүрэгчдийн байнгын хяналт, тусламжийг шаарддаг.

3. Хүнд хэлбэр –(IQ түвшин нь 20-25, 35-40-ийн хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолтой хүнтэй үгээр харилцаанд орох боломжгүй. Хүний хандсан яриа, түүнд өгч байгаа зааврыг ойлгохгүй. Хүмүүсийн байнгын асаргаа халамжинд байна. Өөрийн хэрэгцээгээ дохио зангаа, тэмдгээр илэрхийлнэ. Оюуны хомсдлын энэ хэлбэр өөр бэрхшээлтэй хавсарсан "Давхар согог"-ийн байдалтай байдгаас гадна гол төлөв хэвтрийн өвчтэй, асрамж сувиллын газарт байдаг. Ийм хүүхдүүд бие эрхтний мэдэгдэхүйц согогтой, аливаа өвчинд амархан өртөмтгий тул амьдрах хугацаа богино.

4. Гүнзгий хэлбэр –(IQ түвшин нь 20-25-ийн хооронд)

Оюуны хомсдлын энэ хэлбэр оюуны хомсдолтой иргэдийн 1-2% ийг эзэлнэ. Нялх байх үедээ 5 мэдэрхүйн үйл ажиллагаа нь маш хангалтгүй хөгжинө. Америкийн сэтгэцийн эмгэг судлалын нийгэмлэг (AAMR)-ийн тодорхойлж байгаагаар оюуны хомсдлыг хөнгөн, хүндэвтэр, хүнд, гүнзгий гэж ангилдаг хэлбэрүүдийн нэршлийг хэрэглэхгүй гэж үзэж байгаа юм байна. Харин " түр зуурын", "тодорхой хугацааны", "урт хугацааны", "бүх талын" гэх мэтээр яг тухайн цаг үед л хэрэгтэй байгаа дэмжлэг туслалцааны нөхцөл байдлаар тухайн эмгэгийн нэршлийг илэрхийлье гэсэн санааг дэвшүүлсэн байна. Оюуны хомсдол, дэмжлэг туслалцаа гэсэн ойлголтууд зайлшгүй харилцан холбоотой асуудал гэдгийг ойлгох хэрэгтэй.

Дээрхи тодорхойлолт, ангиллаас үзэхэд оюуны хомсдолын ерөнхий шинж тэмдэг, оюун ухааны дутуу хөгжил буюу сэтгэцийн хөгжлийн саатал, нийгэмдээ дасан зохицох чадварын алдагдал гэж ойлгож болох юм.

2. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлын эрх зүйн зохицуулалт

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомж нь нилээн олон хуулийг хамран зохицуулагдаж байна.

Олон улсын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх тусгагдсан байдал

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1989он

Энэхүү баримт бичигт эсэн мэнд амьдрах эрх, сурч боловсрох, хөгжих эрх, хамгаалуулах эрх, нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл хүртэх эрх зэрэг хүүхдийн эдлэх ёстой суурь эрхүүдийг тунхагласан. Тус Конвенцийн 23 дугаар зүйлд тэдэнд тусгай халамж болон тэгш хандах зарчмыг эрхэмлэх тухай тусгасан.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох тухай Стандарт дүрэм, 1993он

Нийгмийн, улс төрийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш оролцох нөхцөл

боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн засгийн газруудын үйл ажиллагааны хэрэгжилтийг үр дүнтэй болгоход чиглэгдсэн зөвлөмж юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурал

1994 онд Саламанкад болсон ЮНЕСКО-ийн зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг улс орнуудад хандан уриалж үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан гаргасан.

Монгол улсын хууль, эрх зүйн баримт бичигт оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших талаар тусгагдсан байдал

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

Үндсэн хуульд хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх, халдашгүй чөлөөтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх болон бусад эрхүүдийг баталгаажуулан хуульчилсан билээ.

Боловсролын тухай хууль, 2002он³¹

Тус хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь бие бялдрын зохих чадавхитай, ..., бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршиж байгаа” бөгөөд “хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх” хэмээн хуульчилсан байна³². Мөн Боловсролын тухай хуульд иргэнийг сурч боловсроход хөгжлийн онцлог, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах нөхцөл бололцоог бүрдүүлэх үүргийг төр хүлээхээр хуульчилсан.

Боловсролын тухай хуульд “**хөгжлийн бэрхшээлтэй суралцагч**” гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ гэдгийг тодорхойлсон байна³³. Түүнчлэн тус хуульд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахыг хуульчилсан.

Бага дунд боловсролын тухай хууль, 2002 он³²

Тус хуульд ЕБС-ийн захирлын нийтлэг үүргийг тодорхойлохдоо “...хамран сургах тойргийн хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх, иргэдэд нийтийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах үүрэгтэй” гэж заажээ³³.

Мөн тус хуулийн 3 дугаар бүлгийн 13 дугаар зүйлд Ерөнхий боловсролын тусгай сургуулийн зорилго, чиг үүргийг хуульчижээ³⁴. Үүнд: .

³¹ Тус Конвенцид Монгол Улс 1990 онд нэгдсэн

³² Боловсролын тухай хуульд 2002 онд батлагдсанаас нь хойш нийт 10 удаа нэмэлт өөрчлөлт орсон ба хамгийн сүүлд 2011 оны 1 сард нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

³³ Боловсролын тухай хууль, 2002 он, 4 дүгээр зүйл

³⁴ Мөн тэнд, 3.1.9.

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.
- Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь ерөнхий боловсролын бусад сургууль, багш, иргэн, гэр бүл, олон нийтэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- Тусгай сургуульд орон тооны арга зүйч, нийгмийн болон эрдэм шинжилгээний ажилтан тус тус ажиллаж болно.
- Ерөнхий боловсролын тусгай сургуульд энэ хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна эмч ажиллана.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сургалт-үйлдвэрлэлийн дадлагын газартай байж болно.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он

Тус хуульд “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд оршино” хэмээн заажээ.³⁵ Мөн “тусгай цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг хэлнэ гэж заасан байна³⁶. Түүнчлэн хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болохыг хуульчилсан³⁷.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 2002он

Тус хуулиар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах явдлыг төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх ёстой тухай заагаад хүүхдийг үндэс угсаа, нийгмийн гарал, байдал, боловсрол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах тухай зарчмыг заасан байна. Түүнчлэн бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүнд нөхцөлд байгаа хүүхдэд дараахь халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлнэ. Үүнд:

- боловсрол, мэргэжил эзэмшихэд туслалцаа үзүүлэх;
- эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох;
- хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох;

³⁵ Бага дунд боловсролын тухай хуульд 2003, 2006, 2008 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

³⁶ Бага дунд боловсролын тухай хууль, 2002он, 20.2.8.

³⁷ Мөн тэнд, 3.13.

- хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр”, 2003 он

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд 2003 онд тус хөтөлбөрийг БСШУ-ны, ЭМ-ийн, НХХын сайдуудын хамтарсан тушаалаар батлан гаргасан байна. Уг хөтөлбөрт дараах асуудлыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах арга зүйг боловсронгуй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан сургах нөхцлийг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багшийн ур чадварыг нэмэгдүүлэх.

Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 42 дугаар заалтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг 2006 онд батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийг 2006-2012 оны хугацаанд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангахад тулгарч байгаа хүндрэлтэй асуудлыг төрийн ба иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”, 2005 он³⁸

2005 онд УИХ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг батлаж, 2008 онд тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд төрөөс үзүүлж буй үйлчилгээнд хамрагдах боломж, үйлчилгээний цар хүрээнд тодорхой өөрчлөлт оруулсан. Тус хуулинд тусгагдсан үндсэн өөрчлөлтүүдийг дурьдвал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох нэр томъёо;
- Нийгмийн халамжийн сангаас үзүүлэх тусламж, хөнгөлөлт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжих талаар тусгайлсан заалт;
- Олон нийтийн хэрэгцээний газруудын дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх талаарх зохицуулалт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах зохицуулалт.

Тус хуулийн долдугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, боловсрол эзэмших эрхийг тодруулан зохицуулсан. Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших талаарх заалтуудыг тодруулбал:

- 7.1. Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч,

³⁸ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он, 3.1

боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд тэдгээрийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

7.2. Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтанд оруулахаас татгалзахыг хориглоно.

7.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүүхэд энэ хуулийн 7.1-д заасан шалтгаангүй бол сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад эрүүл хүүхэдтэй хамт хүмүүжих эрхтэй.

7.5. Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс тодорхойлно.

7.6. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу боловсрол эзэмшүүлнэ.

7.7. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллагаар батлуулна.

7.8. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно³⁹.

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй.

“Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002-2010)”, 2002 он

Тус хөтөлбөрт нь хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, хөгжил, боловсрол, нийгмийн оролцоо, эрхийн хамгаалал, амьдралын орчин зэрэг олон талт асуудлыг хамарсан, нийгмийн суурь үйлчилгээг оновчтой хүргэх бодлого, үйл ажиллагааны чухал баримт бичиг хэмээн тодорхойлсон байна. Энэхүү хөтөлбөрийн нэг заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эцэг эх, хамт олон гэр бүлд түшиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх тухай дурьджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх боломжийг өргөжүүлэх, насанд хүрсний дараа тэдний амьдралын баталгааг хангах асуудлыг судалж шийдвэрлэх талаар мөн заасан байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”, 2006 он

Тус дэд хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хувь хүн, нийгмийн гишүүний хувьд өөрийн сонголт, үзэл бодол, үнэт зүйлстэй байх, бие даасан аливаа үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх тэдгээрийн чадамж, чадварыг хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөхиүлэн дэмжих орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална. Үүнд:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд амьдрах, эсэн мэнд хөгжих, эрхээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай мэдээлэл хүртээмжтэй байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд санаа бодлоо илэрхийлэх боломжтой байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ялгаваргүйгээр гэр бүл, сургууль, хамт олны дунд шийдвэр гаргахад оролцохыг хүлээн зөвшөөрдөг байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн болон нийгмийн сайн сайхан хөгжлийн

³⁹ Мөн тэнд

төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагад эвлэлдэн нэгдэх, үүсгэн байгуулахад насанд хүрэгчдийн туслалцаа, дэмжлэгийг авдаг байх зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах олон нийтийн түншлэл, хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор олон үйл ажиллагааг тодорхойлсоны дотор боловсролын салбарын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэгийн талаар дараах арга хэмжээнүүдийг тусгажээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтад ногдох хувьсах зардлын норматив хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэг, сургуулийн багшийн ажлын үнэлгээний хэлбэрийг өөрчлөх, урамшууллыг боловсронгуй болгож шинэчлэх;
- Ердийн сургуулиас тусгай сургуульд шилжүүлдэг тогтолцоог тусгай сургуульд 3 хүртэл жил суралцаж зохих чадамж, чадварын боломжид хүрсэн сурагч ерөнхий боловсролын сургуульд шилждэг болгон өөрчлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулан сургах бодлогыг хэрэгжүүлж, тэдгээрийн сургууль завсардалтыг бууруулах;
- “Сурагчийн өдрийн цай” хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн витаминжуулалтын зардлыг нэмж тусгах асуудлыг судлах;
- Хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан танхимын болон гэрийн сургалт хосолсон хөтөлбөр боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн сурагчдыг гадаад хэл, компьютерийн сургалтад хамруулж, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боловсролын байгууллагад суралцахад нь бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд зориулсан брайл, аудио, видео ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын онцлогт зориулсан бялдаржуулах буюу “Сэргээн засалт”-ын танхимыг орон нутагт байгуулах зэрэг болно.

Ийнхүү дээр авч үзсэн хууль эрх зүйн зохицуулалтын дагуу Монгол Улсын боловсролын тогтолцоо нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндсэн хоёр чиглэлээр:

- Ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд бусад хүүхдүүдийн хамт;
- Тусгай сургалттай ерөнхий боловсролын сургуульд боловсрол эзэмших боломжийг олгодог.

Мөн Боловсролын тухай хуулиудад Ерөнхий боловсролын тусгай сургуулийн зорилго, зарчим, чиг үүргийг хуульчилж, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, оролцоог дэмжих талаархи Хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх халамж, хөнгөлөлт, тусламжийг тодорхойлж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй суралцах, тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгохыг хуульчилжээ.

3. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, түүний шатлал

Монгол улсын албан боловсролын тогтолцоо нь оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндсэн 2 чиглэлээр буюу ердийн сургалттай цэцэрлэг, ерөнхий боловсролын

сургуульд бусад хүүхдүүдийн хамт, тусгай сургалттай цэцэрлэг, сургуульд сургуулийн өмнөх болон бага, дунд шатны боловсрол эзэмших боломжийг олгодог.

1990 оноос өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдээс тусгаарлан тусгай сургалттай сургуульд боловсрол эзэмшүүлэх бодлого голчилж байсан бөгөөд тус бодлогын хүрээнд 1964 онд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан анхны тусгай сургалттай 29 дүгээр сургууль байгуулагдсан нь тусгай хэрэгцээт боловсролын эхлэл байсан.

Одоо 29 дүгээр дунд сургууль нь 21 аймаг, нийслэлийн 6 дүүргээс ирсэн 360 орчим суралцагч, 60 гаруй багштай, дотуур байртай үйл ажиллагаа явуулж байна. Энэ сургуульд одоо хэл сонсголын бэрхшээлтэй цэцэрлэгийн 2 бүлэгт 22 хүүхэд, бага ангийн 17 бүлэгт 168 хүүхэд, дунд ангийн 15 бүлэгт 158 хүүхэд, ахлах ангийн 1 бүлэгт 11 хүүхэд, цэцэрлэгийн 2 бүлэгт 22 хүүхэд боловсрол эзэмшиж байна. 2011-2012 оны хичээлийн жилд 100 хүүхдийн цэцэрлэг ашиглалтанд орно. Энэ сургуульд мэргэжлийн согог зүйч багш 16 ажиллаж байгаагаас 1 нь Унгарт, 15 нь ОХУ-ын Эрхүү, Ленинград, Москва хотуудад 1977- 2003 онд суралцаж төгссөн байна.

1967 онд тусгай сургалттай 25 дугаар сургууль байгуулагдсанаар оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэдэнд зориулагдсан хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээнд хамруулах эхлэл тавигдсан.

Цэцэрлэг, ЕБС-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх статистикийн мэдээллийг “СӨБ-2, БДБ-1” маягтаар БСШУЯ авдаг байна. Энэхүү мэдээллийг харах, сонсох, хэл яриа, оюун ухаан, бие эрхтний гэсэн ерөнхий үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн тоог анги, хүйсээр авч байгаа юм. Мөн энэ үзүүлэлтийг гаргах нэгдсэн аргачлал байхгүй байгаагаас харилцан зөрүүтэй мэдээлэл байгааг үгүйсгэх аргагүй юм.

Бага дунд боловсролын тухайд 2010-2011 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд 6-22 насны 18298 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байгаагаас оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 1523 суралцагч ерөнхий боловсролын 4 тусгай сургууль болох СБД-ийн 25 дугаар дунд сургууль, БЗД-ийн 55 дугаар дунд сургууль, БГД-ийн 70 дугаар дунд сургууль, болон хөдөө орон нутгийн ердийн сургалттай ЕБС-д цөөхөн тооны сурагч суралцаж байна. Үүнээс бага ангид 952, дунд ангид 553, ахлах ангид 18 сурагч суралцаж байна.⁴⁰ Нийт (1523) оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1205 нь хотын 4 тусгай сургуульд сурч байгаа ба хөдөө орон нутаг болон бусад ердийн сургалттай ЕБС-д 318 сурагч байна.

Улаанбаатар хотын 4 дүүрэгт тус бүр нэг нэг оюун ухааны болон тархины саажилт бусад хэлбэрийн оюуны хөгжлийн бэрхшээл хавсарсан хүүхдүүдэд бага болон дунд боловсрол олгохоор дараах 4 ЕБДС үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургуульд 2010-2011 оны хичээлийн жилд суралцаж байгаа сурагч болон одоо багшилж байгаа багшлах боловсон хүчний тоог сургууль тус бүрээр илэрхийлье ⁴¹.

- СБД-ийн 25 дугаар дунд сургууль. 20 бүлэгт 252 сурагч сурч байгаагаас бага ангийн 12 бүлэгт 140, дунд ангийн 8 бүлэгт 112 сурагч сурч байна. Нийт 38 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 10 байгаагийн 1 нь Унгар улсад, 9 нь Эрхүүгийн БДС-ийг 1980-1995 онд төгссөн байна. Нэг бүлэг дунджаар 10 - 15 сурагчтай.
- БГД-ийн 70 дугаар дунд сургууль. 18 бүлэгт 249 сурагч сурч байгаагаас бага

⁴⁰ Мөн тэнд

⁴¹ Сургууль тус бүрийн захирал, сургалтын менежерээс утсаар авсан

ангийн 10 бүлэгт 129, дунд ангийн 8 бүлэгт 120 сурагч сурч байна. Нийт 32 багштайгаас 8 нь мэргэжлийн согог зүйч багш бүгд Эрхүүгийн БДС-ийг 1984-1994 онд төгсжээ. Нэг бүлэгт дунджаар 12-15 сурагчтай.

- БЗД-ийн 55 дугаар дунд сургууль. 35 бүлэгт 469 сурагч сурч байгаагаас бага ангийн 20 бүлэгт 318, дунд ангийн 15 бүлэгт 151 сурагч сурч байна. Нийт 53 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 4, бүгд ОХУ-ын Ленинград болон Эрхүүгийн БДС-ийг 1984-1994 онд төгссөн. Нэг бүлэг дунджаар 15 - 16 сурагчтай.
- ХУД-ийн 63 дугаар дунд сургууль. 17 бүлэгт 235 сурагч сурч байгаагаас бага ангийн 9 бүлэгт 115, дунд ангийн 8 бүлэгт 120 сурагч сурч байна. Нийт 27 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 6, бүгд Эрхүүгийн БДС-ийг 1985-1990 онд төгссөн. Нэг бүлэг дунджаар 11 - 15 сурагчтай.

Сургуулийн өмнөх боловсролын тухайд: Одоогийн байдлаар оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай цэцэрлэг байхгүй байгаа бөгөөд тархины саажилттай хүүхдийн БЗД-ийн 10 дугаар тусгай цэцэрлэгт хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамрагдаж байна. Энэ цэцэрлэгийн 11 бүлэгт 1-5 насны нийт 136 хүүхэд, үүнээс бага ангийн 6 бүлэгт 46, дундын 2 бүлэгт 25, ахлах 1 бүлэгт 20, бэлтгэлийн 2 бүлэгт 45 хүүхдийг 9 багш, 2 туслах багш удирдан сургалт хүмүүжлийн ажил явуулж байна.

Хот хөдөөгийн зарим ердийн сургалттай цэцэрлэг, сувилалын яслийн жирийн ангид 1-5 хүртэл тооны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг. Ер нь сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах талаар Дэлхийн зөн, Японы хүүхдийг ивээх сан, БНСУ-ын Paradise, Италийн IPO зэрэг олон улсын байгууллууд ердийн цэцэрлэгийн дотор янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр холимог 1 анги нээж төсөл хэрэгжүүлэх замаар сургалтанд хамруулах болсон.

Хүснэгт 2

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт⁴²

Хичээлийн жил	Нийт суралцагчдын тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Нийт суралцагчдад эзлэх хувь
2006-2007	122536	1058	8.6
2007-2008	130758	1031	7.8
2008-2009	130710	988	7.5
2009-2010	142065	1156	8.1

Энэ статистик мэдээнээс харахад сургуулийн өмнөх боловсролд хамрагсдын маш бага буюу 8% -ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзлэж байна. Оюун ухааны хөгжлийн бэрхшээл нь ихэвчлэн 5-аас дээш насанд илэрдэг тул хэдэн хүүхэд байгаа нь тодорхой бус юм.

4. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, боловсролд баримтлаж байгаа стандарт

БСШУ-ы сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын стандартыг “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр” нэртэйгээр баталж, 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулиудад

⁴² БСШУЯ-ны статистик мэдээ

мөрдөж байна.

Энэ хөтөлбөрөөр оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад бага боловсрол олгох тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө нь нөхөн сэргээх сургалт ба ерөнхий эрдмийн 10 хичээл- монгол хэл, математик, амьдрах ухаан, хүн орчин, дуу хөгжим, зураг, технологи, биеийн тамир, англи хэл, мэдээлэл зүй хичээлээр нийт 748-850 цагийн хичээлийг 34 долоо хоног хичээллэхээр төлөвлөсөн байна. Долоо хоногт ноогдох цаг I-III ангид 22 цаг, IV ангид 23 цаг, V ангид 25 цаг. Нэг өдрийн ачаалал I-III ангид 4,4 цаг байна, IV ангид 4,6 цаг, V ангид 5 цаг, нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна. Нөхөн сэргээх сургалт буюу хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн заслын ганцаарчилсан сургалтын хичээлийг мэргэжлийн багш заах бөгөөд нөхөн сэргээх сургалт шаардлагатай суралцагч бүрт 20 минутаар I, II ангид долоо хоногт 3-4 удаа, III-V ангид долоо хоногт 2-3 удаа тус тус хичээллэнэ.

Сэтгэл заслын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчид анги удирдсан багш ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах бөгөөд 1 цагийн хичээлд 2 хүүхэд хамрагдана. Нэг суралцагч 7 хоногт 2 удаа сэтгэл заслын хичээлд хамрагдах ба сургалтын хөтөлбөрийг улирал бүрээр гаргаж, сургалтын менежер баталгаажуулсан байна. Амьдрах ухааны хичээлийг тухайн ангийн суралцагчийн нас, сэтгэл зүй, хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэлбэрийг харгалзан тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. (Хүснэгт №1)

Дунд боловсрол олгох тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр нь нөхөн сэргээх сургалт ба ерөнхий эрдмийн 14 хичээл - монгол хэл, математик, технологи, англи хэл, нийгмийн ухааны баримжаа, байгалийн шинжлэл, газарзүй, эрүүл мэнд, биеийн тамир, мэдээлэл зүй, иргэний боловсрол, биеийн тамир, дуу хөгжмийн хичээлээр нийт 945-1085 цагийн хичээлийг 35 долоо хоног хичээллэхээр төлөвлөжээ. Долоо хоногт ноогдох цаг VI ангид 27 цаг, VII ангид 28 цаг, VIII ангид 29 цаг, IX ангид 31цаг. Нэг өдрийн ачаалал VI ангид 5,4 цаг, VII ангид 5,6 цаг, VIII ангид 5,8 цаг, IX ангид 6,2 цаг байна. Нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.

Нөхөн сэргээх сургалт буюу хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн заслын ганцаарчилсан сургалтын хичээлийг мэргэжлийн багш заах бөгөөд нөхөн сэргээх сургалт шаардлагатай суралцагч бүрт 20 минутаар VI-IX ангид долоо хоногт 2 удаа хичээллэнэ. Сэтгэл заслын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчид анги удирдсан багш ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах бөгөөд 1 цагийн хичээлд 2 хүүхэд хамрагдана. Нэг суралцагч 7 хоногт 2 удаа сэтгэл заслын хичээлд хамрагдах ба сургалтын хөтөлбөрийг улирал бүрээр гаргаж, сургалтын менежер баталгаажуулсан байна.

Сургуулийн материаллаг бааз, боловсон хүчний нөөцөд тулгуурлан технологийн хичээлийг VIII-IX ангид суралцагчдийн сонирхол, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохируулан бүлгээр зохион байгуулна./ Хүснэгт №2/

Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд зориулсан тусгай стандарт байхгүй бөгөөд Бага насны хүүхдийн хөгжлийн стандартад суурилсан агууллагын сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.

Хүснэгт 3.1

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн бага боловсролын сургалтын төлөвлөгөө

Бага боловсрол

Хэлбэр	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг					Нийт цаг
		I	II	III	IV	V	

Хичээл	Монгол хэл	272	272	272	272	272	1360
	Математик	136	136	136	136	136	680
	Мэдээлэл зүй					34	34
	Англи хэл					34	34
	Амьдрах ухаан	68	68	68	68	68	340
	Хүн орчин	Хүн байгаль					408
		68	68	68	68	68	
		Эрүүл мэнд					
						34 34	
	Хөгжим	68	68	68	68	68	340
	Биеийн тамир	68	68	68	68	68	340
	Дүрслэх урлаг, технологи	68	68	68	68	68	340
Нөхөн сэргээх сургалт		Хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн засал, сэтгэл заслын ганцаарчилсан сургалт хүүхэд нэг бүрт 20 мин					
Долоо хоногт ногдох цаг		22	22	22	23	25	
Хичээлийн жилийн нийт цаг		748	748	748	782	850	3876
1 өдрийн ачаалал		4.4	4.4	4.4	4.6	5	

Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн суурь боловсролын сургалтын төлөвлөгөө

Суурь боловсрол

Хүснэгт 3.2

Хэлбэр	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг				Нийт цаг
		VII-шилжил-тийн	VII	VIII	IX	

Хичээл	Монгол хэл	175	175	175	175	700
	Англи хэл	70	70	70	70	280
	Математик	105	105	105	105	420
	Иргэншил	35	35	35	35	140
	Түүх	35	35	35	35	140
	Байгалийн шинжлэл	70				70
	Газарзүй		70	70	70	210
	Эрүүл мэнд	35	35	35	35	140
	Биеийн тамир	70	70	70	70	280
	Хөгжим	35	35	35	35	140
	Технологи	140	175	210	280	805
	Мэдээлэл зүй	70	70	70	70	280
	Нийгэм ахуйн баримжаа	70	70	70	70	280
	Иргэний боловсрол	35	35	35	35	140
Нөхөн сэргээх сургалт		Хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн засал,сэтгэл заслын ганцаарчилсан сургалт хүүхэд нэг бүрт 20 мин				
Жилийн нийт ачаалал		945	980	1015	1085	4025
Долоо хоногт ногдох цаг		27	28	29	31	
1 өдрийн ачаалал		5.4	5.6	5.8	6.2	

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, бэрхшээлийг тогтоох нэгдсэн аргачлал байхгүй тул “Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.2 дахь” заалтыг үндэслэн БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 7 дугаар сарын 5-ний өдрийн 325 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй, аргачлал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж одоо АДРА-Монгол олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нийгмийн цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй болон Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх арга турших ажлыг Баянхонгор, Завхан, Улаанбаатар хотын 2 дүүрэгт зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна⁴³. Мөн манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний систем өнөө хүртэл төлөвшөөгүй нь ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад зарим талаар бэрхшээл учруулж байгаа юм.

Энэ нь бага, дунд боловсролын сурлагын амжилтыг үнэлэх бүхий л төрлийн шалгалт /анги дэвших болон сургууль төгсөх, Улсын мэргэжлийн хяналтын газар, аймаг нийслэлийн Боловсрол, соёлын газраас авч буй түвшин тогтоох шалгалт гэх мэт/-д хөгжлийн

⁴³ БСШУЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол хариуцсан мэргэжилтний мэдээллээс

бэрхшээлтэй хүүхдийн амжилтаас шалтгаалан сургууль, ангийн сурлагын амжилт нь доогуур үнэлэгдэх тохиолдол гарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, багш нар авч сургахаас зарим талаар татгалзахад хүргэж, улмаар тэд боловсролд тэгш хамрагдан сурах эрхээ алдахад ч хүрч байгааг үгүйсгэх аргагүй.

Эл байдалд дүгнэлт хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхдийн нэгэн адил арга зүйгээр үнэлж буй үнэлгээний өнөөгийн арга хэлбэрийг өөрчилж, тэдний онцлог, ялгаатай байдлыг харгалзан хөгжлийн ахицаар нь үнэлэх үнэлгээний оновчтой системийг бүрдүүлэх зорилгоор дээрхи ажлын хэсгээс “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг судлах, үнэлэх журам”-ын төслийг боловсруулан 2010 оны 3, 7 - 8 дугаар сард Ховд, Сэлэнгэ, Улаанбаатар хотод нийт 4 хэлэлцүүлэг зохион байгуулж, 120 гаруй багш, эцэг эх, захирал, эмч, олон нийтийн байгууллагын төлөөллийн саналыг авч тусган журмын төслийг эцэслэн боловсруулж дуусгажээ.

5. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин, төрөөс баримтлаж байгаа бодлого

Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын 4 сургууль, 29 дүгээр сургуульд нийт 210 багш ажиллаж байгаагаас мэргэжлийн согог зүйч 45 (21,4%) багш ажиллаж байна. Эдгээр багш нар бүгд 1984-1995 онд гадаадад, тухайлбал Унгар улс болон ОХУ-ын Ленинград, Москва, Эрхүүгийн их, дээд сургуулиудад согог зүйч багшийн мэргэжлээр төгсжээ. Эндээс 1980-1990 онд жил бүр 2-3 хүнийг гадаадын их дээд сургуулиудад явуулж согог зүйч багш бэлддэг байснаа 1990 оноос хойш тасарсан нь ажиглагдаж байна.

Одоо БСШУЯ Монгол улсын Боловсролын их сургууль, АДРА олон улсын байгууллагатай хамтран МУБИС-ийн ерөнхий эрдмийн болон сэтгэл судлалын мэргэжлийн ангиудын сургалтын хөтөлбөрт тусгай хэрэгцээт боловсролын агуулгыг тусгаж, 60 цагийн хичээлийг тус сургуульд суралцаж буй бүх багшийн мэргэжлийн ангийн оюутнууд судалж байна. Өнөөдрийн байдлаар Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Багшийн сургуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог”-ийн талаарх бие даасан хичээлийг дээрх сургуулийн оюутнууд судалж байна.

Багш бэлтгэдэг сургуулийн багш, оюутнуудад зориулсан гарын авлага, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Аутизмтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” зэрэг 10 гаруй ном, гарын авлагыг боловсруулан хэвлүүлж сургуулиудын номын сангуудад хүргэн оюутнууд ашиглаж байна. Монгол улсын Боловсролын Их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн дэргэд “Тэгш хамруулан сургах боловсролын төв”-ийг АДРА-Монгол олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулан ажиллуулж байна. Тус төв нь багш бэлтгэдэг сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхол бүхий оюутнуудад зориулсан сургалт, төрөл бүрийн мэдээллээр хангах үйл ажиллагааг явуулдаг байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах дур сонирхолтой багшийг бакалаврын дараах сургалтаар бэлтгэх нь оновчтой гэж үзэж байна.

БСШУ-ны сайдын 2010 оны тушаалаар батлагдсан Мэргэжил дээшлүүлэх кредитийн сургалтаар багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах эрх олгогдож дээрх сургалтуудад хот, хөдөөгийн 1500 гаруй багш хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ дээшлүүлсэн байна.

6. Хөдөө орон нутагт амьдардаг оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагддаг эсэх

Хөдөө орон нутагт оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн цэцэрлэг,

сургуульд хамрагдаж байгаа. БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 6-22 насны оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 1523 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байна. Эдгээр хүүхдээс Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 25, 55, 63, 70 дугаар дунд сургуульд 1205 хүүхэд байгаа нь хөдөө орон нутгийн ердийн сургалттай ЕБС-д цөөхөн тооны буюу ердөө 318 сурагч суралцаж байна.

Энэ нь Улаанбаатар хотод сурч байгаа хүүхдийн тоотой харьцуулахад ихээхэн цөөхөн байгаа нь энэ төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутагт сургуульд маш бага хамрагдаж байгааг харуулж байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт хангалтгүй, тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг дан юм уу хавсарсан юмуу гэдгийг тогтоох нэгдсэн стандарт байхгүй, орон нутагт төрөлжсөн тусгай сургууль, тэр хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн багш боловсон хүчин байхгүй, ном сурах бичиг, анги танхим хангалтгүй зэрэг болно.

Тус яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, тэднийг ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллүүлэн хөгжлийн ахицаар үнэлэх үнэлгээний журам боловсруулан хэлэлцүүлж байгаа нь хүүхэд, эцэг эхэд ямар нэг хүндрэл дарамт учруулахгүй хүний эрхийг хүндэтгэн дээдэлсэн байхаар сайн бодож хиих, бусад салбаруудтайгаа уялдуулах хэрэгтэй байгаа юмаа.

7. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсроход улсаас зарцуулж буй төсөв

Улаанбаатар хотод улсын төсвөөс санхүүжиж буй Оюуны хөгжлийн бэрхшээлтэй тусгай цэцэрлэг байхгүй бөгөөд хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4 цэцэрлэг, ясли (ХУД-ийн 4, СХД-ийн 41, БЗД-ийн 40, БЗД-ийн 10), 5 сургууль (ХУД-ийн 63, БГД-ийн 70, СБД-ийн 25, БЗД-ийн 55, СБД-ийн 116) үйл ажиллагаа явуулж оюуны хөгжлийн бэрхшээлтэй 19454 сурагч суралцаж байна. (мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн боловсролын газраас)

Хүснэгт 4.1

2008 оноос 2011 оны зардлын төсөв (сургууль)

д/д	Оноор	ХУД 63	БГД 70	СБД 25	БЗД 55	СБД 116	Нийт
1	2008 онд	269 446	275673,5	310083,4	430850,8		1 286056,7
2	2009 онд	255049,2	239860,5	317214,9	434176,6	286397,8	2423653,2
3	2010 онд	282680,7	243871,1	390954,6	492363,3	278156,2	2702623,7
4	2011 онд	267949,3	227627	318823,2	453661,7	286397,8	2445413,2

Хүснэгт 4.2

2008 оноос 2011 оны зардлын төсөв (цэцэрлэг)

д/д	Оноор	ХУД 4	СХД 41	БЗД 40	БЗД 10	Нийт
-----	-------	-------	--------	--------	--------	------

1	2008 онд	119961,6	104184	133055	190965,5	548166,1
2	2009 онд	115287	92353,2	130651,2	180956,4	519247,8
3	2010 онд	150722,6	108828,7	158913,3	224391,8	642856,4
4	2011 онд	179644,6	160873	201667,5	214872,5	737057,6

2011 оны улсын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчныг бүрдүүлэх зорилгоор 400,0 сая төгрөгийг улсын төсөвт тусгасан бөгөөд уг санхүүжилтээр СБД-ийн 116-р сургуулийн бие засах газар, зам талбайг бэрхшээлийнх нь онцлогт нийцүүлэн засварлах ажлыг зохион байгуулна гэжээ. Мөн тус сургуулийн сантехникийн иж бүрэн засварт 70,0 сая төгрөгийг төсөвлөсөн.

2008 оноос хойш үндсэн цалингийн доод хэмжээ, суурь үнийн өөрчлөлт тодорхой хувиар нэмэгдсэн ч сургууль, цэцэрлэгийн төсвийн санхүүжилт төдийлөн хангалттай нэмэгдээгүй байна. Тусгай сургалттай сургуулиудын жилийн төсвийн санхүүжилтийг СБД-ийн 25 дугаар дунд сургуулиар жишээ болгон төлөөлүүлэн үзүүлэв:

Жилийн нийт төсвийн 60 хувь нь багш ажилтан нарын цалинд, 40 хувь нь бусад хувьсах болон тогтмол зардлуудад зарцуулагддаг.

Тусгай сургалттай СБД-ийн 25 дугаар дунд сургуулийн 2011 оны төсвийн санхүүжилт:

Тус дунд сургууль 20 бүлэгт 252 суралцагч, 56 багш, ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг.

• Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд	229 355 900
• Ажил олгогчоос НДШ	25 229 200
• Үдийн цай хөтөлбөр	11 779 100
• Бичиг хэрэг	176 800
• Гэрэл цахилгаанд	4000 000
• Түлш халаалт	15 000 000
• Тээвэр шатахуунд	750 000
• Шуудан холбоонд	176 800
• Цэвэр, бохир ус	5 500 000
• Ном хэвлэл авах	147 300
• Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	702 200
• Эд хогшил худалдан авах	226 400
• Нормын хувцас зөөлөн эдлэл	589 300
• Эм авах	58 900
• Урсгал засварт	439 200
• Биеийн тамирын уралдаан, тэмцээнд	147 300
• Төлбөр хураамж болон бусад зардалд	1 004 600
• Нэг удаагийн тэтгэмж урамшуулалд	23 392 900
• Нийт төсвийн санхүүжилт: 318 823 200	

Хувьсах зардалыг тооцоходоо Засгийн газрын 2010 оны 342 тоот “Зардлын дундаж

норматив батлах тухай” тогтоолын дагуу нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, бусад хувьсах зардлын дундаж нормативаар, Сангийн сайдын 2007 оны 8 дугаар сарын 31-ний 306/237 тоот “Итгэлцүүр батлах тухай” тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг тооцох итгэлцүүрийг 1,07-оор нэмэгдүүлэн тооцохоор батлагдсаны дагуу санхүүждэг байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,3 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” хэмээн заасан. Мөн Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдалын шаардлагыг хангасан байна” гэж заасан байдаг.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөл бүрдүүлэх эрхийг хэрэгжүүлэх боломж олгож байгаа хэдий ч төрөөс олгож буй санхүүжилт, төсвийн хэмжээг хархад бүтэн жилийн урсгал засварт 439200 төгрөг, ном хэвлэл авах зардалд 147 300 төгрөг, эд хогшил худалдан авхад 226 400 төгрөг төсвөлсөн байгаа нь сургуулиудын ном сурах бичиг тусгай хэрэгцээг хангахад хангалттай төсөв биш юм. Иймд төсвийн хүрээнд тусгай сургуулиудын багтаамжийг өргөтгөх, тусгай тохижилтыг сайжруулах, уншлагын болон соёл урлагийн танхим, тэргэнцэртэй хүүхэд орох багтаамжтай ариун цэврийн өрөөтэй болгох зэрэг наад захын арга хэмжээг авах санхүүжилтийг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг идэвхтэй суралцаж амьдрах бололцоог хангах шаардлагатай байна.

Сүүлийн 3 жилд бүх мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагсдын сургалтын зардал (2008 онд Засгийн газраас нэг суралцагчид ногдох зардлыг 465-495 мянган төгрөгөөр баталсан), тэтгэлэг (сард 45 мянга, жилд 450 мянган төгрөг)-ийг төрөөс санхүүжүүлэх болсноор мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв байгуулах, иргэдийн суралцах сонирхол нэмэгдэх хөшүүрэг болсон. Тусгай сургуулиуд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгайлан зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох (оёдол, эсгүүр, гар хивсчин, мужаан, үсчин) сургалтууд явагдаж байна.

Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7,4-т “Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардалыг төрийн сан хариуцна” гэж заасан. Энэ заалтын дагуу сургалтын зардалыг төр хариуцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай мэдээлэл одоогоор алга байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх” гэж заасан. Энэ заалтын дагуу унааны зардалыг хөнгөлсөн мэдээлэл мөн алга байна.

8. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, орлого

СБД-ийн 116 дугаар дунд сургуулийн захирлын 2011 оны 02 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан багш ажилтан нарын цалингийн хэмжээ: (төлөөлүүлэн түүвэрлэн үзүүлэв)

Хүснэгт 5

Албан тушаал	Албан томилолтын зэрэглэл	Ажилласан жил	Үндсэн цалин	Тусгай сургуулийн нэмэгдэл	Мэргэжлийн зэргийн нэмэгдэл	Анги даалт	Заах аргын нэмэгдэл	Сарын нэмэгдсэн цалин шимтгэл тооцоогүй
Багш	ТҮБД4-II	6	301440	90432		30144		391872
Багш	ТҮБД4-IV	17	328502	98551	32850	32850		459903
Багш	ТҮБД4-V	38	350157	105047	35016	35016	17508	490220
Багш	ТҮБД4-I	1	298428	89528		29843		387958
Асрагч багш	ТҮ 2-III	14	201477	60443				261920
Асрагч багш	ТҮ 2-I	2	194526	58358				252884

Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 162 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7,8 дахь хэсэгт заасны дагуу цалингийн хэмжээг “Тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын арга зүйч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, согог зүйч, багш эмч, сувилагч, асрагч, багш, сурган хүмүүжүүлэгч, дотуур байрны хүмүүжүүлэгчид үндсэн цалингийн 30 хүртэл хувиар, Захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежер, сургалтын үйл ажиллагааг шууд гардан зохион байгуулдаг инженер техникийн болон үйлчилгээний албан хаагчдад үндсэн цалингийн 20 хүртэл хувиар, захиргаа гүйцэтгэх болон үйлчилгээний албан хаагчдад үндсэн цалингийн 10 хүртэл хувиар” нэмж тооцдог.

Тусгай дунд сургуулийн багш нар албан томилолтын зэрэглэлээр Багш нар ТҮБД, Хүмүүжүүлэгч багш ТҮБД3, Асрагч багш ТҮ- ний сүлжээ цалингаар ажилласан жил, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, тусгай сургуулийн нэмэгдлээ нэмж тооцоод 490220-252884 төгрөгийн (шимтгэл тооцоогүй) цалин авдаг. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад анхаарал халамж арчилгаа, илүү цагаар ажиллах шаардлагатай ч нэмэгдэл хөлс төдийлөн хангалттай биш учраас эдгээр хүүхэдтэй багш нар ажиллах дургүй төдийгүй эмч хүртэл зайлсхийдэг байна.

Иймд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад тохирохуйц харилцах ур чадвартай, тэдний онцлог хэрэгцээг ойлгодог, тулж дэмжих, анхаарал халамж тавих, ёс суртахууны боловсролтой боловсон хүчин бэлтгэх сургалт арга зүйн төв бий болгож, багш нарын цалин хөлсний урамшуулалын системийг боловсронгуй болгон нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.



**ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНСЫГ ӨВЛҮҮЛДЭГ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**(Судалгаа - мэдээлэл)

Б. Ариунжаргал, Т. Мягмаржав

ОРШИЛ

Судалгааг Улсын Их Хурлын гишүүн З. Алтайгийн ирүүлсэн захиалгын дагуу Тэтгэврийн нэрийн дансыг өвлүүлдэг бусад улс орнуудын туршлага, хууль эрх зүйн зохицуулалтын талаар Герман, Япон, Эстони, Украин улсын туршлагаас судалсан болно.

Анх “Монгол Улсын тэтгэврийн хууль” -ийг 1958 онд Ардын Их Хурлын чуулганаар баталсан. Одоо 1994 оны “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай”

хууль, 1999 онд батлагдсан “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийг мөрдөж байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс гэдэг нь тухайн хүний ажилласан бүхий л хугацаанд төлсөн шимтгэлийг үндэслэн тэтгэвэр тооцох арга юм. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс”-ны хуулийн дагуу нэрийн дансаа 592.1 мянган хүн нээлгэж 416.7 тэрбум төгрөгийн хуримтлал тооцогдсон боловч тэтгэврийн даатгалын санд энэ хөрөнгө байхгүй байгаа нь зөвхөн хийсвэр тооцооллын хэмжээнд байна.

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 38 дугаар тогтоол Монгол Улсын тэтгэврийн шинэчлэлийн үндсэн чиглэлийн дагуу 1960 оноос хойш төрсөн иргэд хуваарилалт хуримтлалын хосолсон шинэ тогтолцоонд 2005 оноос шилжсэн бөгөөд нийгмийн даатгал төлж байгаа хүн бүрийн нэрээр нь данс нээж, төлсөн мөнгийг нь хуримтлуулж, тэтгэврийн насанд хүрэхэд тэр данснаас нь мөнгийг нь олгох, өөрөөр хэлбэл, хэдий чинээ ихийг хуримтлуулна, төдий чинээ ихийг хүртэх боломж нээгдэх, шударга тогтолцоо юм.

2001 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн нэрийн дансыг хөтөлж ирсэн. Нэрийн дансанд эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, нэрийн дансны орлогод тооцсон хүү тусгагдах ёстой гэдгийг хуульчилсан.

ГАДААД ОРНУУДЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОНЦЛОГ

Нийгмийн даатгал гэдэг нь төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх механизм, хүн амын нийгмийн хамгааллыг зохион байгуулах үндэс юм. Энэ тогтолцоо нь дэлхий нийтийн практикт зохион байгуулалтын дараахь хэлбэртэй байдаг. Үүнд:

1. Улсын нийгмийн даатгал (заримдаа төвлөрсөн даатгал гэдэг)
2. Хамтын даатгал (төвлөрсөн бус даатгал)
3. Холимог даатгал
4. Хувийн даатгал

Улсын даатгал нь зохион байгуулалтын хувьд заавал байх нийтийн шинжтэй, улсын нийгмийн даатгалд зонхилох байр эзэлдэг тогтолцоо юм.

Хамтын даатгал нь: Хамт (төвлөрсөн бус)-ын даатгал нь ажил олгогчид, хөлсөөр ажиллагчдын эрх ашгийг хохироож байснаас төр үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран бий болгосон заавал болон сайн дурын хэлбэрээр байх даатгал юм. Энэ загвар Япон АНУ зэрэг улс орнуудад байдаг.

Холимог даатгал нь: Холимог шинж чанартай байна. Холимог загвар нь улсын нийгмийн даатгалын болон хамтын даатгал нийгмийн чанартай эрсдлийг арилгахад тэнцүү үүрэг гүйцэтгэдэг. Холимог хэлбэрийн даатгал анх Швейцарт бий болсон бөгөөд Франц, Швейцар, Герман зэрэг улс орнууд хэрэглэдэг байна.

Хувийн даатгал нь: Хувь хүн бүртэй даатгалын гэрээг байгуулж уг гэрээ нь түүний хэрэгцээ, хүсэлтийг харгалзан даатгалын хэлбэр шимтгэлийн хэмжээг тусгасан байна. Хувийн даатгалын хүрээнд хувь хүн даатгалын ямар компанитай гэрээ хийж, өөрийгөө ямар эрсдлээс хамгаалахаа чөлөөтэй сонгоно. Хувийн даатгал тэнцэх зарчмын үндсэн дээр хэрэгждэг. Даатгуулагчийн авах тэтгэврийн хэмжээ нь түүний төлсөн шимтгэлийн хэмжээтэй тэнцүү байдаг.

Дараахь хүснэгтээс тэтгэвэр тогтоолгох нас болон төлөх шимтгэлийн хувь хэмжээг харж болно.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ

Д/д	Улсын нэр	Тэтгэвэр тогтоолгох нас		Төлөх шимтгэлийн хувь, хэмжээ (хувиар)		Засгийн газрын оруулах хувь, нэмэр
		эр	эм	Даатгуулагч	Ажил олгогч (эзэд)	
1.	Австрали	65	60	10.25	12.55	Зөрүүг олгоно
2.	Канад	65	65	2.50	2.50	Бүх нийтийн тэтгэвэр олгоно
3.	Франц	60	60	6.55	8.20	-
4.	Герман	65	65	8.75	8.75	Нийт зардлын тавны нэг хувийг олгоно
5.	Япон	60	58	7.25	7.25	Захиргааны зардал олгоно
6.	БН СУ	60	60	2.00	2.00	Захиргааны зардал олгоно
7.	Пакистан	60	55	-	5.00	5.0 хувийг төлнө
8.	Филиппин	60	60	3.30	4.70	Зөрүүг олгоно
9.	АНУ	65	65	6.20	6.20	-
10.	Монгол улс	60	55	10.0	10.0	-

Дээрхи хүснэгтээс харахад өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад Монгол улс нийгмийн даатгалын шимтгэл өндөр байгааг харуулж байна.

ГЕРМАН УЛС

Герман улсын нийгмийн даатгалын тогтолцоог Австри, Англи, Орос, Япон зэрэг улс орнуудад авч хэрэглэсэн ба АНУ, Канад, Латин Америкийн орнууд мөн авч хэрэгжүүлсэн. Германы нийгмийн даатгалын тогтолцоо нь 1889 оноос эхтэй бөгөөд орчин үеийн тэтгэврийн тогтолцооны шинэчлэл нь 1957 онд хийгдсэн байна.

Герман улс нь эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын нэгэн адил тэтгэвэр тэтгэмжийн асуудалд 2001 онд шинэчлэл хийсэн. Уг шинэчлэл нь дараахь 3 асуудлыг тулгуур зарчмаа болгосон:

- Бусад хадгаламжийн татварыг нэмсэнээр өндөр настны хадгаламжинд зориулагдсан татварын хөнгөлөлттэй нөхцлөөр санхүүжих
- Уг хөтөлбөрт тэтгэвэрт гарах цагт тэтгэврийг (annuitization) насан эцэстэл нь тогтмол мөнгийг олгож байхаар заагдсан
- Одоогийн гэр бүлийн статус буюу өрхийн орлого бага, хүүхэдтэй өрх гэр бүлд

шууд тэтгэмж олгох

Нийт ажиллах хүчний 85 хувь нь (Public retirement insurance) Нийтийн тэтгэврийн даатгалд хамрагддаг байна. Герман улсад хэрэгжиж байгаа тэтгэврийн тогтолцоо дараахь 3 хэлбэртэй:

1. Төрийн тэтгэврийн даатгалын тогтолцоо
2. Төрийн бус байгууллага болон хувийн компаниудын хөтөлбөр
3. Нэрийн тэтгэврийн буюу хувийн тэтгэврийн хөрөнгө оруулалт

Ажиллаж байх хугацаандаа тэтгэврийн даатгалын санд шимтгэл тогтмол төлж байсан иргэн тэтгэврийн насанд хүрэх болон хөдөлмөрийн чадвар алдах үед тэтгэвэр авдаг. Хуулиараа тэтгэвэрт гарах нас 65 байдаг ч хүсвэл 67 нас хүртэл ажиллах эрх нь нээлттэй байдаг. Мөн 35 жил даатгуулсан иргэн 63 насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй. 45 жил ажилласан хүнд тэтгэврийг дундаж цэвэр цалингийн хувиар тогтоодог ба энэ нь Германд ихэнхдээ дундаж цалингийн 70 хувь байдаг. 1992 оноос эхлэн даатгуулагчийн хүүхдээ асарсан, 1995 оноос эхлэн гэрийн ажил хийсэн хугацааг оруулж тооцдог болсон байна.

Тахир дутуу болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүс 35 жил даатгуулсан нөхцөлд, мөн эмэгтэйчүүд 15 жил даатгуулсан, 40 наснаас хойш 121 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн бол 60 настайдаа тус тус тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Ажилгүй иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол дараахь болзлыг хангасан нөхцөлд тэтгэвэр нь олгогдоно. Үүнд:

- Сүүлийн бүтэн хагас жилд нэг жилээс багагүй хугацаанд ажилласан.
- 60 нас хүрсэн.
- 15 жилээс доошгүй хугацаанд даатгуулсан.
- Сүүлийн 10 жилийн 8-аас доошгүй жилд нь шимтгэл төлсөн.

Германы тэтгэврийн хуулинд хувь хүний хөдөлмөрийн хөлснөөс тухайн хүний тэтгэврийн хэмжээг тодорхойлдог байна.

Герман улсын “Тэтгэвэр тэтгэмжийн шинэчлэлийн акт” (Pension Reform Act 1992) нийгмийн хамгааллын тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 97 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийн даатгалтай иргэн нас барсан тохиолдолд нийт төлсөн мөнгөний 60 хүртэлх хувийг эхнэр, нөхөр болон өнчин хоцорсон үр хүүхдэд нь буцаан олгохоор заасан. Мөн тус хуулийн 6 дугаар бүлгийн 103-105 дугаар хэсэгт тэтгэврийн даатгуулагчийн мөнгийг гэр бүлийхэнд нь буцаан олгохгүй нөхцлийг заасан:

- Тухайн даатгуулагчийг нас барахад нөлөөлсөн
- Сэтгэцийн өөрчлөлттэй, гэмт хэрэг үйлдсэн хүнд олгохгүй г.м.

ЯПОН УЛС

Япон улсад 40 түүнээс дээш жил шимтгэл төлж даатгагдсан иргэн 65 насанд хүрэхээс өмнө тэтгэвэр тогтоолгох боломжтой байдаг. Япон улс эрэгтэйчүүдийн тэтгэврийн насыг 2013-2025 онд 65, эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг 2018-2030 онд 60 нас хүргэх чиглэл баримталж байна. Японд - тэтгэврийн даатгал гурван шатлалтай:

- Улсын - суурь даатгал
- Байгууллагын даатгал

- Хувийн даатгал

Япон хүн бүрт тэтгэврийн нэрийн данс байж, ажилласан сар, жилийн тоогоор тэр нь өсөж байдаг. Гол зүйл нь тухайн хүн өөрийн хүсэлтээр тэтгэврийн хувийн даатгалд даатгуулсан мөнгөө бусдад шилжүүлэх, бэлэглэх, гэрээслэх, өвлүүлэн үлдээдэг. Өөрөөр хэлбэл ид насан дээрээ ажиллаж байгаад гэнэтийн байдлаар амь насаа алдвал уг мөнгө нь төрд харьяалагдах бус тухайн хүний аль нэг төрөл төрөгсөд, хамаатан саданд өгдөг байна.

Япон улсын “Тэтгэврийн хувийг тодорхойлох тухай хууль”⁴⁴-ийн

Дэд дөрөвдүгээр хэсэг

Нас барагсдын тэтгэврийг өвлүүлэх хэлбэр

41 дүгээр заалтад: Тэтгэвэр авагч нас барсанаас хойш дараахь байдлаар тэтгэвэр (үлдсэн хүмүүст) өвлөгдөнө. Тухайн хүн гэрлэсэн болон нас барахаас өмнө гэрлэлтээ цуцлуулсан ч эхнэр, нөхөр, хүүхдүүд, эцэг, эх, ач зээ, эмээ өвөө төрөл төрөгсөд энэ заалт үйлчилнэ. Үүнд:

- Эхнэр, нөхөр,
- Хүүхэд, эцэг эх, ах эгч, ач зээ, өвөө эмээ болон тэдэнтэй хамт амьдарч байсан төрөл төрөгсөд г.м.,
- Дээрх хүмүүсээс гадна хамаатан садан, нас барагчаар тэжээлгэж байсан хүмүүс,
- Тэр хүнээс хамааралгүй мөртлөө хамаатан садан.

Мөн онцгой тохиолдолд өргөж авсан эцэг эх нь төрүүлсэн эцэг эхээс илүү давуу эрхтэй. Өргөж авсан эцэг эхийн өвөө эмээ нь мөн давуу эрхтэй. Хоёр болон түүнээс дээш хүмүүс тэтгэвэр өвлөх бол хүний тоонд харьцуулан хувааж өгөх зарчимтай. Өвлөхөөр санал гаргагч байхгүй бол үлдсэн хэн нэгэн хүнд өвлүүлэн өгч болно. Нас барсанаас хойш 5 жилийн дотор тэтгэвэр авагч тогтоогдохгүй бол “өвлөх хүнгүй” гэж тооцно. Уг хуулийг 2001 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

ЭСТОНИ УЛС

Эстони улс нь тэтгэврийн нэрийн дансаа өвлүүлэхийг “Тэтгэврийн сангийн тухай хууль”⁴⁵-аар зохицуулдаг. Энэ хуулийг 2004 оны 5 дугаар сарын 1-ээс мөрдөж эхэлсэн байна. Энэ хууль нь тэтгэврийн даатгалаас гадна нэрийн дансанд нэмэлт орлогоос төлбөр тооцоо хийх нөхцлийг бүрдүүлдэг.

Нэрийн данс нь доорхи төрлүүдтэй:

- Мандаттай (Тэтгэврээ тогтмол хугацаанд авдаг)
- Нэмэлт (тэтгэврээ календарийн сараар авдаг)

Тус хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт нэрийн данс шинээр нээх зарчимд:

1. Тухайн хүн жилд нэг удаа нэрийн дансаа нээлгэхийн тулд өргөдөл гаргаж санхүүгийн менежер холбогдох хүмүүст хандана.
2. Жилийн эхний 1дүгээр сарын 1-нд гаргаж өгөх эрхтэй.
3. Өргөдлийг доор дурьдсанаар бүрдүүлнэ.
 - а) Овог нэр

⁴⁴ Pension Reform Act, 1992.

⁴⁵ Defined Contribution Pension Law, 2001.

- б) Хувь хүний код, баримт бичиг
- с) Холбоо барих утас, хаяг гэх мэт (эрх бүхий газрын шаардлагыг хангасан байна)

Өргөдлийн хүлээн авагч байгууллага:

1. Тэтгэвэр авагчийн нэр
2. Мандатын эрхийн дагуу хүлээн авагч байгууллага нь дүрэм журмын дагуу баталгаажуулна.
3. Тухайн хүний зөвшөөрсөн эсэхийг баталгаажуулна.
4. Өргөдөл гаргасан он сар өдөр гарын үсгийг баталгаажуулна. Хэрэв тухайн хүн ирж гарын үсэг зурах боломжгүй бол интернэтээр гарын үсгийг явуулж болно.
5. Шаардлага хангасан өргөдөл ирүүлээгүй бол бүртгэхээс татгалзаж болно.
6. Өргөдөл хүлээн авахаас татгалзсан байгууллага өргөдөл гаргагчид ямар шалтгаанаар татгалзсанаа хариу мэдэгдэнэ. Өргөдөл хүлээн авахаас татгалзсан хуулийн заалтаа тодорхой бичнэ.
7. Шалтгаан
8. Он сар өдөр, хугацаа, жил бүрийн 1 дүгээр сарын 1-ээс 10 дугаар сарын 31 хүртэл хүлээн авна. 11 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ний хугацаанд ирсэн өргөдлийг дараа жилд нь тооцно.
9. Тус байгууллагын санхүү дүрэм журмын дагуу баталсан маягтаар мэдээллээ өгнө.

28 дугаар зүйл: Өв залгамжлагчийн тухай

- Нэрийн дансыг өв залгамжлуулж болно.
- Нэрийн дансыг зөвхөн хувь хүнд гэрээслэнэ.
- 29.1-д заасны дагуу өргөдлийг тухайн хүний хуулийн төлөөлөгч гаргана. (хөгжлийн бэрхшээлтэй иргэн)
- Тэтгэвэр авагч өв залгамжлагчгүй бол тухайн хүний эзэмшсэн нэрийн данс нь хуулийн тодорхой заалтуудын дагуу цуцлагдана. Цуцлагдсан тохиолдолд тэтгэврийн мөнгө нь тэтгэврийн сандаа үлдэнэ.
- Бүртгэгч нь энэ хуулийн 29.3-т заасны дагуу өв залгамжлагч 10 жилийн дотор гарч ирэхгүй бол цуцлагдана.
- Хэрвээ нэрийн дансаа нээж амжаагүй нас барсан тохиолдолд тэтгэврийн мөнгө тэтгэврийн сангийн дансруу шилжинэ.

УКРАИН УЛС

Украин улсад тэтгэврийг өв залгамжлуулах талаар харилцаа нь сайн дурын тэтгэврийн (төрийн бус) харилцааны хууль болон Иргэний хуулиар зохицуулагддаг байна. Украины **“Сайн дурын тэтгэврийн (төрийн бус) харилцааны хууль”**⁴⁶

10 дугаар хэсэг. Тэтгэврийг өвлүүлэх

66 дугаар зүйл. Хуримтлагдсан тэтгэврийг хуваарилах болон өв залгамжлах

1. Гэрлэлтийн гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрлэснээс хойшхи тэтгэврийг дундын

⁴⁶ Funded pensions act, 2004

өмч гэж үзнэ. (тэтгэврийн фонд, даатгалын байгууллагад даатгуулсан тэтгэвэр, тэтгэврийн нэрийн дансанд байгаа тэтгэвэр) Гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд аль нэг тал өөрийн нэрийн дансыг нээх тэтгэврийн фондыг сонгож, өөрт оногдох хувиа байршуулах тэтгэврийн фонд, даатгалын байгууллагад нэрийн дансаа нээхийг өөрсдөө сонгодог байна. Ингэхийн тулд урьд нь тэтгэвэр авч байсан байгуулагадаа бичгээр мэдэгдэл өгнө.

2. Тэтгэврийг өвлүүлэх нь Украины Иргэний хуулиар зохицуулагддаг байна. (өв залгамжлагчийг тодорхойлдог)
3. Даатгуулагчаас гэрээнд заасан хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл нь хугацаандаа орж ирэхгүй тохиолдолд тэтгэврийн фондын дарга, даатгалын компани болон банк шалтгааныг нь тодруулна. Энэ нь (тухайн хүн) нас барснаас болсон тохиолдолд тэтгэврийн шимтгэл төлж байсан хүний оршин сууж байсан газрын Нотариатын газарт ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Өв залгамжлагч нь (Иргэний хуулийн дагуу) нас барсан хүний харилцаж байсан фонд, байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
4. Банк болон даатгалын байгууллага нь (хуулинд заасны дагуу) энэ хугацаанд хориг тавиагүй бол өв залгамжлагчид тэтгэврийг өгнө гэж заасан байна.

Украин улс тэтгэврийн шинэчлэлийг Европын стандартад нийцүүлэн боловсронгуй болгосон байна. Засгийн газрын тэтгэврийн сангаас гадна сайн дурын тэтгэврийн системийг хэрэглэх болсноос гадна мөн тэтгэврийн насыг дээшлүүлэхээр тусгагдсан байна. Тэтгэврийн шинэчлэлд дараахи 3 хувилбарыг (систем) тусгасан:

1. Төрөөс заавал санхүүжихгүй
2. Төрөөс заавал санхүүжих
3. Сайн дурын хувийн тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх

Дээрхи 3 систем нь Европын ихэнх орнуудад байдаг. Украины хуучин систем нь тэтгэврийн ялгаа их байсан бөгөөд тэтгэврийн хэмжээ харилцан адилгүй дээд тал нь 5000 доллар авч байхад доод тал нь 90 доллар авч байсан тэтгэврийн ялгааг арилгасан байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд тэтгэврийн нэрийн дансыг өвлүүлэх эрх зүйн зохицуулалттай орнуудаас Герман, Япон, Эстони, Украин зэрэг орны бие даасан хуулийн зохицуулалтыг судлан үзээд дараахь дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. Өвлөх эрх бүхий субъект: Нас барсан тэтгэвэр авагчийн гэрлэлтээ батлуулсан эхнэр, нөхөр байх нийтлэг шаардлага байна. Үүнээс Япон улсад хүүхдүүд, эцэг эх, ач зээ болон эмээ өвөө нь тэтгэврийн өвлөгч байх боломж эрх зүйн зохицуулалтын хувьд нээлттэй байна. Украин улсын хувьд гэрлэснээс хойшхи тэтгэврийг дундын өмч гэж үздэг байна.
2. Өв залгамжлалын процесс: Тэтгэврийн нэрийн данс болон тэтгэврийн өв залгамжлалын нарийвчилсан процесс нь тухайн улсын Иргэний хуульд тусгайлан заасан зохицуулалтын дагуу явагдана.
3. Тэтгэврийг өв залгамжлуулахгүй байх тохиолдолд: Судалгаанд сонгосон орнуудын хууль тогтоомжид заасан дараахь тохиолдол өвлүүлэхгүй буюу өвлүүлэхээс татгалзана. Үүнд:
 - Өвлөгч тэтгэвэр авагчийн нас барахад нөлөөлсөн
 - Гэмт хэрэг үйлдсэн
 - Өв залгамжлагч нь тогтоогдохгүй (хуулиар заасан хугацаанд)
 - Дансаа нээлгэж амжаагүй байхдаа нас барсан зэрэг тохиолдлуудад өв

залгамжлалын харилцаа үүсэхгүй байна.

4. Хувийн тэтгэврийн даатгалын гэрээ байгуулсан тохиолдолд гэрээндээ заасны дагуу өвлүүлэх эрх үүсдэг байна.
5. Тэтгэврийн даатгалын эв санааны нэгдлийн тогтолцоотой үед төлсөн шимтгэлийг өвлүүлэх боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал:
6. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг
 - Төр
 - Даатгуулагч
 - Ажил олгогч

төлдөг тохиолдолд, бүх шимтгэлийг өвлүүлэх үү, зөвхөн даатгуулагчийн төлсөн шимтгэлийн үлдэгдлийг өвлүүлэх үү гэсэн асуудал гарч ирэх боломжтой юм.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Defined Contribution Pension Law, 2001.
2. Pension Reform Act, 1992.
3. Закон Украины. О негосударственном пенсионном обеспечении. 2003год.
4. Funded pensions act, 2004



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИНД ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ
(ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)**

*Б. Товуусүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг,
А. Пагма, Б. Хатантуул*

Агуулга



1. Европ, Азийн зарим орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалт
2. Энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуулиудад хэрхэн тусгасан тухай харьцуулалт
3. Монгол Улс, ОХУ, Япон, Швед, БНКУ, БНЧУ-ын хөдөлмөр эрхлэлтийн хуулийн энгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалтын харьцуулалт
4. Ашигласан материал:
 1. Эрх зүйн актууд:
 - Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, Ажилгүйдлын тэтгэмжийн тухай хууль
 - ОХУ-ын 1991 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай” хууль, 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” хууль, “Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай”
 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” 1966, “Хөдөлмөр эрхлэлтийн аюулгүй байдлын тухай хууль” 1947, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005
 - БНКАз Улсын 2001 оны “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хууль, 1997 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай” хууль
 - Швед Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт” (1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт”(1999) “Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт” (1991), “Ажилгүйдлийн даатал” (1997), “Ажилгүйдлийн сан” (1997) зэрэг эрх зүйн актууд
 - Чех Улсын Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль/2004/
 2. Ном:
 - Ч. Дагвадорж. Нийгмийн хамгаалал: онол арга зүй, харьцуулалт УБ. 2004 он.
 - П. Бямбацэрэн, Ч. Дагвадорж. Нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд 2000 он.

* * *

Европ, Азийн зарим орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи эрх зүйн зохицуулалт

Хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх гурван үндсэн үүргийг нийгмийн хамгааллын систем гүйцэтгэдэг. “Дэлхийн нийгмийн хамгааллын хөтөлбөр” /Social Security Program Throughout the World буюу “SSPTW” нь 178 орны нийгмийн хамгааллын асуудлыг нэгдсэн системд оруулсан. Энэ хөтөлбөрийг АНУ-ын нийгмийн хамгааллын захиргаа/ U.S.Social Security Administration “SSA”, /Олон улсын нийгмийн хамгааллын холбоо/ Internatiol Social Security Association “ISSA”/ хамтарч боловсруулдаг бөгөөд гишүүн орнуудын тайлан мэдээг

үндэслэн 2-3 жил тутам шинэчлэгдэж байдаг.

Энэ хөтөлбөрт Ази, Номхон далайн - 51, Европын 45, Америкийн 37, Африкийн 45 нийт 178 орнууд хамрагдаж нийгмийн хамгааллын асуудлууд нь нэгтгэгдсэн боловч Монгол улс одоогоор хамрагдаж чадаагүй байна. Үүнийг манай улсад зах зээлийн шилжилтийн үйл явц үргэлжилж байгаагаар тайлбарлаж болох боловч Орос, Киргиз, Казахстан, Вьетнам, Камбож, Польш, Унгар зэрэг пост социалист улс орнууд дэлхийн нийгмийн хамгааллын системд нэгдсэн байна.

Өндөр хөгжилтэй орнуудад хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудал төлөвшиж, ядуурал, ажилгүйдэл зэрэг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрджээ. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь нийгмийн зөвшилцөл дээр суурилсан сайтар бодож боловсруулсан нийгмийн хамгааллын системтэй холбоотой гэдэгтэй эрдэмтэд, судлаачид сүүлийн жилүүдэд санал нэгдэж байна.

Судалгаанд хамрагдсан Ази, Европын зарим орны хувьд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хөдөлмөр эрхлэлтийн тухай болон хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг хуулиудад хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх заалт нийтлэг тусгагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дор дурдсан үйл ажиллагааны чиглэлийг нийтлэг баримталж байна. Үүнд:

- а/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- б/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ
- в/ Ажилгүйдлийн тэтгэмж олгох

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар улс орнууд өөрийн онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалттай байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, тэтгэмжийн хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийн хэмжээг үзүүлэв.

№	Ангилал	Сар бүрийн мөнгөн төлбөрийн хэмжээ (руб.)	Нийгмийн үйлчилгээний төлбөрийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ (НҮТ=641 руб.)	Төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ	Үнэгүй эмээр хангагдах болон үнэ төлбөргүй сувицуулах эрхийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ
1	Тахир дутуугийн I групп (3 түвшин)	2162.00	1521.00	2091.00	1592.00
2	Тахир дутуугийн II групп (2 түвшин)	1544.00	903.00	1473.00	974.00
3	Тахир дутуугийн III групп (1 түвшин)	1236.00	595.00	1165.00	666.00
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд	1544.00	903.00	1473.00	974.00

5	Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс	772.00	131.00	701.00	202.00
---	--	--------	--------	--------	--------

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулинд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгасан байдал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль нь 2001 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийн 5,1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна гэжээ.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ
- Ажилгүйдлийн тэтгэмж олгох

Эдгээр үйл ажиллагааны төрлүүдэд энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрхэн тусгасныг дараах хүснэгтээр тоймлон илэрхийлье.


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл		Энгийн иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ	5.2.1 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судлах, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгаа гаргах, тэднийг бүртгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах	<p>7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.</p>	

	1.1.2 Ажилд зуучлах	<p>8.1 Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ОН-ийн алба бүртгэж ажилд зуучлана.</p> <p>8.2 ААНБ-ын хөдөлмөр зуучлалын алба нь төр захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр ажилд зуучлах үйлчилгээ гүйцэтгэж болох бөгөөд тайлан мэдээгээ хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлнэ.</p> <p>8.3 Ажлын байрны захиалга, түүнд тавих шаардлагын таалаарх мэдээлэл ил тод байна.</p> <p>8.4 Ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.</p>	8.5 Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилд жуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.
	1.1.3 Мэргэжил олгох, давтан сургалтанд хамруулах	<p>9.1.1 Эмзэг бүлэгт хамрагдах ажилгүй иргэн</p> <p>9.1.2 Ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй иргэн</p> <p>9.1.3 Осол хурц хордлого, мэрэгжлээс шалтгаалах өвчний улмаас мэргэжлээ өөрчлөхийг хүссэн ажил хайгч ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн</p> <p>9.1.4 Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй болсон иргэн</p> <p>9.1.5 Тухайн онд ЕБСийн 8,10 анги төгссөн, эсхүл хугацаат цэргийн албанаас халагдсан ажил сургуульгүй иргэн</p> <p>9.1.7 Сургууль завсардсан, насанд хүрээгүй иргэн</p>	9.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн
5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	1.1.1 Нөхөрлөл, хоршооны хэлбэр, хувиараа болон өрхийн АА эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	<p>10.1 Хувиараа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ.</p> <p>10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах</p> <p>10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох</p> <p>10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах</p> <p>10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах</p>	
	1.1.2 Ажил олгогчийг дэмжих	11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.	

		<p>11.1.1 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг</p> <p>11.1.3 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн</p> <p>11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн бүтэн өнчин хүүхэд</p> <p>11.1.5 ХЭАлбанд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаагаар ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн</p>	<p>11.1.2 Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн</p> <p>11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд</p>
		<p>11.2- Ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтанд хамруулж 3 сараас дээш хугацаанд ажлын байраар хангасан ажил олгогчид сургалтын зардлыг ХЭДС-аас нөхөн олгоно.</p>	<p>11.4- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулалыг ажлуулсан хугацааг харгалзан олгоно.</p>
			<p>12.3 ХЭА-нд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулна.</p>
	<p>1.1.3 Нийтийг хамарсан ажил зохион байгуулах</p>	<p>12.2 Тухайн орон нутгийн зам, гүүр, далан, суваг, худаг, усжуулалтын системийг байгуулах, засварлах, ой, голын сав, төв суурин газрын бохирдлыг цэвэрлэх, ХБИ-ийн тусгай зориулалтын зам орц, гарцыг барих зэрэг ажлыг ЗДТГ, ААНБ-ын оролцоотойгоор ХЭА зохион байгуулна.</p>	

	1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	12 ¹ .1 ХБИ-ний хөдөлмөрийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, ААН байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн ү/-нд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно 12 ¹ .2 ХЭ-ийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох сорилын аргаар ур чадварыг тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.
5.4 Ажилгүйдлийн тэтгэмж олгох	Энэ тэтгэмжийг НД- ын тухай хуульд заасны дагуу НДШ төлж ажилгүйдлийн даатгалд даатгуулагчид ажлаас гарсан тохиолдолд авна.	Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд: <ul style="list-style-type: none"> • 5 хүртэл жил төлсөн 15% • 5-10 жил хүртэл төлсөн 50% • 10-15 жил хүртэл төлсөн 60% • 15 ба түүнээс дээш жил төлсөн 70%

Дүгнэлт: Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тухай хуулинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны 3 төрлийг дараах байдлаар ангилсныг схемчлэн харуулвал:



Манай улсын энгийн иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг энэ 3 үйл ажиллагаанд аль алинд нь жигд хамрагдуулахаар дээрх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулиар зохицуулсан байна.

Европ, Азийн зарим орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Эрх зүйн зохицуулалтын агуулга

1. Нийт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

1.1. Монгол Улс

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль нь 2001 онд батлагдсан бөгөөд хуулийн зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт,

хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийн 5,1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна гэжээ.

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

8.1 Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ОН-ийн алба бүртгэж ажилд зуучлана.

8.2 ААНБ-ын хөдөлмөр зуучлалын алба нь төр захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр ажилд зуучлах үйлчилгээ гүйцэтгэж болох бөгөөд тайлан мэдээгээ хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлнэ.

8.3 Ажлын байрны захиалга, түүнд тавих шаардлагын таалаарх мэдээлэл ил тод байна.

8.4 Ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

9.1.1. Эмзэг бүлэгт хамрагдах ажилгүй иргэн

9.1.2 Ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй иргэн

9.1.3 Осол хурц хордлого, мэрэгжлээс шалтгаалах өвчний улмаас мэргэжлээ өөрчлөхийг хүссэн ажил хайгч ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

9.1.4 Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй болсон иргэн

9.1.5 Тухайн онд ЕБСийн 8,10 анги төгссөн, эсхүл хугацаат цэргийн албанаас халагдсан ажил сургуульгүй иргэн

9.1.7 Сургууль завсардсан, насанд хүрээгүй иргэн

10.1 Хувиараа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ.

10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах

10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох

10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах

10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвөлгөө өгөх, мэдээллээр хангах

11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.

11.1.1 16 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг

11.1.3 45-аас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн бүтэн өнчин хүүхэд

11.1.5 ХЭАлбанд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаагаар ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн

11.2 - Ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтанд хамруулж 3 сараас дээш хугацаанд ажлын байраар хангасан ажил олгогчид сургалтын зардлыг ХЭДС-аас нөхөн олгоно.

Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд:

-5 хүртэл жил төлсөн	15%
-5-10 жил хүртэл төлсөн	50%
-10-15 жил хүртэл төлсөн	60%
-15 ба түүнээс дээш жил төлсөн	70%

1.2. Япон Улс

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” 1966

4 дүгээр зүйл. Төрөөс авах арга хэмжээ

4.1 Мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх ажлын байрны үйлчилгээг нэмэгдүүлэх. Энэ ажлыг өөрт тохирсон ажил хийх, ажлын хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах зэргээр хангах;

4.2 Хүн болгон өөрийн ур чадварт тохирсон ур чадварын сургалт, үнэлгээг дэмжих;

4.3 Ажил олгогч нь хэцүү байгаа ажилчдад боломж олгох, ажлаа солихыг зөвшөөрөх;

4.4 Зайлшгүй шалтгааны улмаас ажилгүй болсон ажилтанд өөр ажил олгох;

4.5 Тэтгэвэрийн насыг бага багаар уртасгах;

4.6 Ажиллах нөхцлийг баталгаажуулах зорилгоор ажил олголтын хэлбэр болон бусад асуудлыг сайжруулах;

4.7 Ажилчид өөрсдийнхөө ур чадварыг бүрэн дүүрэн ашиглахад чиглэгдсэн арга хэмжээ авах зэрэг болно.

“Хөдөлмөр эрхлэлтийн аюулгүй байдлын тухай хууль” 1947

4 дүгээр зүйл. Мэргэжлийн зааварчилгаа гэж ажил хайж байгаа хүмүүст тохирсон ажил олох, шинээр ажилд ороход нь практик сургалт, зааварчилгаа, зөвлөгөөг дэмжих үйл ажиллагааг хэлнэ.

20 дугаар зүйл.

Ажил эрхлэлтийн аюулгүй байдлын байгууллага нь ажил хаялт болон зогсолт хийж байгаа байгууллагад шинээр ажил хайж байгаа иргэдийг танилцуулахыг хориглоно.

30 дугаар зүйл. Төлбөртэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага нь харьяалсан яамнаас тусгай зөвшөөрөл авна.

33 дугаар зүйл. Үнэ төлбөргүйгээр лицензтэй тусгай зөвшөөрөл авна.

1.3. ОХУ

1991 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуулиар энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг зохицуулжээ.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь төрийн үйлчлэгээг үзүүлэхийг хуульчилжээ. Үүнд:

- Иргэдэд өөрт тохирсон ажлаа олж хийхэд нь, ажил олгогчдод шаардлагатай ажилтанаа ажилд авахад нь дэмжлэг үзүүлэх
- ОХУ-ын субъектүүдийн хөдөлмөрийн зах зээлийн байдлын талаар мэдээлэх
- Ажлын байрны болон сургалтын ажлын байрны үзэсгэлэн яармаг зохион байгуулах
- Ажилгүй иргэдийг шинэ мэргэжил эзэмшихэд нь туслах мэргэжлийн сургалт зохион байгуулах, дахин бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тусалцаа үзүүлэх
- Ажилгүй иргэдэд тогтоосон журмын дагуу нийгмийн нөхөн төлбөр олгох
- Төлбөртэй нийгмийн тустай хөдөлмөр зохион байгуулах
- Ажилгүй иргэд ажлын байраа сонгохдоо шууд ажил олгогчтой харьцах буюу хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар үнэ төлбөргүй жуучлуулан ажилтай болох эрхтэй. –
- Иргэд ажлын байр, мэргэжлийн үйл ажиллагааны хүрээгээ сонгохдоо хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар дамжуулан үнэ төлбөргүй мэдээлэл, зөвөлгөө, үйлчилгээ авах, сэтгэл зүйн дэмжлэг, мэргэжлийн бэлтгэл, мэргэжлээ дээшлүүлэх, дахин бэлтгэгдэх эрхтэй. Мөн ажилгүй иргэдэд төрөөс ажилгүйдлийн тэтгэмж олгодог ба түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд энэ тэтгэмж мөн олгогдоно. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хугацаанд ажилгүй иргэдэд степенд олгодог байна.

1.4. БНКаЗУлс

БНКаЗУ-ын 2001 оны “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай хуульд “Төр хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүн амыг ажилгүйдлээс хамгаалахаа баталж байна” хэмээн хуульчилжээ. Энэ хуульд хөдөлмөр эрхлэлтийг нь төрөөс дэмжих зорилтот бүлгийг тодорхойлсон ба энэхүү зорилтот бүлэгт дараах хүмүүс хамаарч байна. Үүнд:

- Орлого багатай хүмүүс
- 21 нас хүртэлх залуучууд
- Асрамжийн газар хүмүүжигсэд,
- 23 хүртэлх насны өнчин, харах хандах хүнгүй хүүхдүүд
- Олон хүүхэдтэй ганц бие, өрх толгойлсон хүмүүс
- Хуулийн дагуу тогтоогдсон байнгийн асарч хамгаалах шаардлагатай хүнийг асардаг хүмүүс
- Өндөр насны тэтгэвэрт гарах дөхсөн хүмүүс (насны хувьд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 2 жил дутуу байгаа)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
- Хугацаат цэргийн албанаас халагдсан хүмүүс
- Хорих газраас суллагдсан болон албадан эмчилгээнд орсон хүмүүс
- Оралманууд зэрэг болно.

Дээр дурьдсан зорилтот бүлгийн хүмүүст зориулан орон нутгийн захиргааны байгууллага, ажил олгогчидтой гэрээ байгуулан үйлдвэр, албан байгууллага дээр “нийгмийн ажлын байр” бий болгон эдгээр бүлгийн хүмүүсийг ажлын байраар хангадаг ажээ. Гэхдээ энэ ажлын байр нь байнгийн бус түр ажлын байр юм.

БНКаЗУ-ын төрөөс ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авч байна. Үүнд, нэмэлт ажлын байр бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг харгалзан ажилгүй иргэдийн мэргэжлийн бэлтгэлийг хангах, дахин мэргэшүүлэх уян хатан тогтолцоог бий болгох, олон хүнийг хамарсан нийгмийн тустай хөдөлмөрийг зохион байгуулах,

бүс нутгийнхаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн захиргааны үүргийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг хуулиар зохицуулан хэрэгжүүлж байна.

1.5. Швед Улс

“Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт” (1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт”(1999) “Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт” (1991), “Ажилгүйдлийн даатал” (1997), “Ажилгүйдлийн сан” (1997) -уудаар энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг зохицуулжээ.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь зүйлүүдийг хуульчилжээ. Үүнд:

- Хүйсээр ялгаварлахгүй-гээр эрэгтэй, эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг тэгш байлгах
- Иргэдэд өөрт тохирсон ажлаа олж хийхэд нь, ажил олгогчдод шаардлагатай ажилтанаа ажилд авахад нь дэмжлэг үзүүлэх
- Хүүхэдтэй гэр бүлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (Эцэг эхийн чөлөө олгох Акт-1995)
- Ажлын байрны болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулах
- Сурч боловсрох, цэргийн алба хаах нөхцөлд ажлийн байрыг хадгалах
- Иргэдийг тогтмол ажлын байраар хангахад нь ажил олгогчдыг дэмжих
- Ажилгүй иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн агентлагуудтай хамтран ажиллаж үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах
- Ажилгүй иргэдэд нийгмийн нөхөн төлбөр олгох
- Түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд тэтгэмж олгох

Швед улсад хөдөлмөр эрхэлж буй ажилтан хууль зүйн дараахь гэрээний эрх үүрэгтэй байдаг байна. Үүнд:

- “Эцэг эхийн чөлөө олгох акт”(1995)
- “Адил тэгш хөдөлмөр эрхлэх боломж акт” (1991)
- “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977)
- “Үндэс угсаагаар ялгаварлахгүй байх акт “ (1999)
- Шведын нийгмийн хамгаалалын үндсэн зарчим

1.6. Чех Улс

Чех Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг Хөдөлмөр нийгмийн хэргийн яам, хөдөлмөрийн газар эрхэлнэ (Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль/2004/-ийн 2 дугаар зүйлийн 3-ийн “а”, “б” заалт)

Хүний хөдөлмөлөх эрх чөлөөг гарал үүсэл, хүйс, сексийн чиг хандлага, арьсны өнгө, яс үндэс, харъяалал, нийгмийн байдал, төрсөн газар, хэл, эрүүл мэндийн байдал, нас, шашин шүтлэг, итгэл үнэмшил, өмч хөрөнгө, материаллаг эрх, гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, олон нийтийн үүсгэл санаачлагын, улс төрийн нам, бусад хөдөлгөөний, Үйдвэрчний эвлэл, бусад ажилчдын байгууллагын гишүүн гэдгээр нь шууд болон шууд бус аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, Жирэмсэн, хүүхэд хардаг гэх шалтгаанаар болон хүйсийн байдлаар ялгаварлахыг хориглоно. Янз бүрийн харьцаанд өдөөн турхирах, шалгах, хойш тавих, түүнчлэн бодлоготойгоор эдгээр

хэлбэрээр ялгавалахыг хориглоно.(Хөдөлмөр эрхлэлтийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1-д зааснаар ажил хайж байгаа хүмүүс дор дурдсан тэтгэмж авдаг:

- а/ 50 нас хүртэл 6 сарын тэтгэмж;
- б/ 50-55 насны хүмүүс 9 сарын тэтгэмж;
- в/ 55 –аас дээш насны хүмүүс 12 сарын тэтгэмж;

2. Хөгжлийн бэрхшээл-тэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар

2.1. Монгол Улс

7.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол явуулж иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн сургалтанд хамрагдах нөхцлийн талаар зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, **хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг** хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

7.2 Энэ хуулийн 7,1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

8.5 Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилд жуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

9.1.6 Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн

10.1 Хувиараа болон өрхийн АА, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ хүсэгч ажилгүй иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ХЭДС-аас дараахь дэижлэг үзүүлнэ.

10.1.1 А А эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулах

10.1.2 Үйлдвэрлэл үйлчилгээгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох өргөтгөх нь зориулан зээл олгох

10.1.3 Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах

10.1.4 Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвөлгөө өгөх, мэдээллээр хангах

11.1 Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй дор дурдсан иргэдийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчидод тухайн ажилтанд эхний 6 сарын хугацаанд олгосон цалин хөлсний 60%-ийг ХЭДС-аас олгоно.

11.1.2 Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн

11.1.4 ЕБС, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тухайн онд төгссөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

11.4- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшуулалыг ажлуулсан хугацааг харгалзан олгоно.

12¹.3 ХЭА-нд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шалгаруулна.

12¹.1 ХБИ-ний хөдөлмөрийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, ААН байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех,тасгийн ү/-нд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно

12^{1.2} ХЭ-ийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох сорилын аргаар ур чадварыг тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ

Даатгуулагч нь ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй шимтгэл төлсөн тохиолдолд:

-5 хүртэл жил төлсөн	15%
-5 - 10 жил хүртэл төлсөн	50%
-10 - 15 жил хүртэл төлсөн	60%
-15 ба түүнээс дээш жил төлсөн	70%

2.2. Япон

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005

28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад зориулсан тэтгэмж

- Гэр оронд нь очиж үйлчилгээ үзүүлэх;
- Үйл ажиллагааны дэмжлэг, эрүүл мэндийн хамгаалал
- Өдөр тутмын амьдралд үзүүлэх үйлчилгээ;
- Хүүхдийн өдрийн халамж, богино хугацаагаар асрах;
- Бүлгээр нь асрах байранд байлгах

28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Сургалтын төлбөрын тэтгэлэг:

- а/ Нөхөн сэргээх үйлчилгээ;
- б/ Хөдөлмөр эрхлэлтэд шилжихийг дэмжих;
- в/ Бүлгээр нь дэмжих;
- зэрэг тэтгэлгийг орон нутгийн байгууллага шийднэ.

29 дугаар зүйл. Зардлыг нь Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам төлнө. Тэтгэлгийг 90 хүртэл хувиар төлөхийг хуулиар тогтоосон.

2.3. ОХУ

Мөн ажилгүй иргэдэд төрөөс ажилгүйдлийн тэтгэмж олгодог ба түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд энэ тэтгэмж мөн олгогдоно. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан хугацаанд ажилгүй иргэдэд степенд олгодог байна.

ОХУ-д холбооны төрийн байгууллагууд болон ОХУ -ын субъектүүдийн төрийн байгууллагуудын зүгээс хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн дараахи тусгай арга хэмжээнүүдийг авах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангадаг байна. Үүнд:

- Өмчлөлийн хэлбэрээс үл хамааран ХБИ-ийг ажилд авахад зориулан тодорхой квот тогтоох, тухайлбал, 100 гаруй ажилтантай байгууллагын нийт ажилчдын 2-оос доошгүй, 4-өөс дээшгүй хувийг нь ХБИ-ээс ажилд авахаар хуульчилсан байна.
- ХБИ-ийг ажиллуулахад зохимжтой ажлын байрыг нөөцөнд байлгах,
- Үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагууд ХБИ-дэд зориулан нэмэлт, түүний дотор тусгай ажлын байр гаргахыг хөхүүлэн дэмжих, тусгай ажлын байр гэдэг нь ХБИ ажиллахад зориулан тэдний онцлогт тохируулсан нэмэлт тоноглол, төхөөрөмж хийх, нэмэлт зохион байгуулалтын арга хэмжээ авахыг хэлдэг байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх хувийн хөтөлбөртэй нь уялдуулан тэдний хөдөлмөрийн нөхцөлийг хангах, бусад ажиллагсадтай харьцуулахад ХБИ-ийн хөдөлмөрийн нөхцөлийг (хөдөлмөрийн хөлс, ажил, амралтын цаг, ээлжийн амралтын хугацаа, хөлс) дордуулсан хамтын болон хувийн хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно. I, II групптэй хүмүүст долоо хоногийн ажлын өдрийг богиногосон цагаар ажиллуулж (долоо хоногт 35 цагаас дээшгүй), хөдөлмөрийн хөлсийг нь бүрэн олгох ёстой. ХБИ-дэд жил бүр 30 ажлын өдрөөс доошгүй өдрийн ээлжийн амралт олгодог.

-ХБИ-ийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх,

-ХБИ-ийг шинэ мэргэжил эзэмшихэд нь тусламж үзүүлэх

-ХБИ-ийг ажилд авсан болон ажлын байрыг тэдэнд зориулан тусгайлан зохион байгуулсан ажил олгогчдод санхүүгийн хөнгөлөлт үзүүлэх,

-Ажил олгогчид нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан мэдээлэл өгөх, ажлын тусгай байр бий болгох үүрэгтэй.

“Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуулийн дагуу 1,2,3 дугаар групптэй хүмүүс тахир дутуугийн тэтгэвэр авдаг ба тэтгэвэрийн хэмжээ нь тогтоосон тахир дутуугийн группээс хамаарна. Үүнд:

-1 дүгээр групп- сард 5124 рубль

-2 дугаар групп- сард 25262 рубль

-3 дугаар групп- сард 1281 рубль

Түүнчлэн тахир дутуугийн тэтгэвэрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу тодорхой тохиолдол бүрт бусад шалгуурийг мөн харгалздаг. Түүнчлэн 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” Холбооны хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр нийгмийн үйлчилгээний төлбөр 641 рублийг олгодог ба үүнээс 570 рубль нь нэмэлт эмнэлгийн тусламж, 71 рубль нь төмөр зам болон эмчилгээний замын зардалд зориулан олгодог байна. ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийг дор дурдсан хэмжээгээх олгодог байна:

1. Тахир дутуугийн I групп /3 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 2162 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 1521 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 2091 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1592 руб.

2. Тахир дутуугийн II групп /2 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 1544 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 903 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1473 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувилалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 904 руб.

3. Тахир дутуугийн III групп /1 түвшин/

-сар бүрийн мөнгөн төлбөр 1236 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 595 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1165 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувидалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 666 руб.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

-сар бүрийн мөнгөн төлбөр 1544 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 903 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 1473 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувидалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 904 руб.

5. Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс

-сар бүрийн мөнгөн төлбөр 772 руб.

-нийгмийн үйлчилгээний төлбөр 641 руб. дээр сар бүр 131 руб.

-төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 701 руб.

-Үнэгүй эмээр хангагдах, үнэ төлбөргүйгээр сувидалд үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр 202 руб.

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

2.4. Казахстан

БНКаЗУлсын орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах арга хэмжээг авдаг байна. Үүнд:

-Үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагын нийт ажиллагсдын 3 хувьтай тэнцэх хэмжээний ажлын байрын квотыг ХБИ-д зориулан тогтооно.

-Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх замаар ХБИ-ийн аж ахуйн үйл ажиллагааг дэмжин нэмэлт ажлын байр бий болгоно.

-Казахстан улсын хууль тогтоомжийн дагуу ХБИ-дэд зориулсан ажлын тусгай болон нийгмийн ажлын байрыг бий болгох замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг хангана.

-ХБИ-дэд мэргэжлийн боловсрол олгоно.

-I,II групптэй хүмүүст долоо хоногийн ажлын өдрийг богиногосон цагаар ажиллуулж (долоо хоногт 36 цагаас дээшгүй), хөдөлмөрийн хөлсийг нь бүрэн олгох ёстой. ХБИ-дэд жил бүр 15 хүртэл ажлын өдрийн ээлжийн амралт олгодог.

-ХБИ-ийг өөрийнх нь зөвшөөрсөнөөр, эрүүл мэндэд нь хор учруулахгүйгээр шөнийн цагаар ажиллуулна.

-ХБИ-ийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, ажлаас халах, албан тушаал дэвшүүлэхээс татгалзах зэргийг хориглоно.

-Ажил олгогчийн буруугаас үүдэн тахир дутуу болсон ажиллагсдын ажил эрхлэх нөхцөл, бололцоог хангах (ажлын байрыг тоноглох, орон сууцыг нь тусгай тоног, төхөөрөмжөөр хангах) үүргийн ажил олгогч хүлээнэ.

-Ажил олгогчийн буруугаас үүдэн тахир дутуу болсон иргэдийн шинээр мэргэжил эзэмших, дахин сургах зардлыг ажил олгогч хариуцана.

Казахстан улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын асуудлыг 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”, 1997 онд батлагдсан “Бүгд

Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай” хуулиар тус тус зохицуулж байна.

БНКаЗУлсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэмж олгохдоо тэдгээрийг 5 ангилалд хуваадаг байна. 1 дүгээр ангилалд өвчний улмаас, хөдөлмөрийн явцад, мэргэжлийн өвчний улмаас тахир дутуу болсон мөн төрөлхийн тахир дутуу хүмүүсийг хамруулдаг ба эдгээрээс тахир дутуугийн 1 дүгээр групптэй хүмүүст сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 2 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,06 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 3 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0,74 –тэй тэнцэх хэмжээний тэтгэмж, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,00–тэй тэнцэх, төрөлхийн тахир дутуу хүүхдэд тахир дутуугийн группээс нь хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36-0,87-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна. 3 дугаар ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад хашиж буй албатай нь холбоогүйгээр золгүй явдлын улмаас тахир дутуу болсон цэргийн албан тушаалтнууд мөн тогтоогдсон тарих дутуугийн группээс хамааран 1 дүгээр ахглалын хүмүүстэй ижил хэмжээний иаигамж олгодог.

2, 5 дугаар ангилалын буюу хугацаат цэргийн алба хааж байхдаа тахир дутуу болсон хүмүүс ба иргэний болон цэргийн зориулалттай цөмийн объект дээр гарсан осолын улмаас, экологийн онцгой байдал, түүний дотор цөмийн дэлбэрэлт, туршилтийн үед цацраг туяаны улмаас тахир дутуу болсон хүмүүст мөн тэдгээрийн тахир дутуугийн группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,61-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

4 дүгээр ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад цэргийн албаны үүрэг гүйцэтгэж байхдаа осолын улмаас тахир дутуу болсон цэргийн албан хаагчдад тогтоогдсон группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2, 09-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгож байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн хамгаалал, түүний дотор нөхөн сэргээгдэх, нийгэмтэйгээ хөл нийлүүлэн амьдрах, тоноглогдсон орон байраар хангагдах, үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ хүртэх эрх эдэлдэг.

2.5. Швед

Швед улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тусгай Консул байдаг байна. Швед улсын хувьд хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дараахь тусгай арга хэмжээнүүдийг авдаг байна. Үүнд:

- ХБИ-н ажил олох боломж, ажлын байрны тоо чанарыг нэмэгдүүлэхийн тулд төрөөс тусгайлан зориулсан хөтөлбөрүүд зохион байгуулдаг. (хөдөлмөрлөх бэлтгэлтэй болгох нөхөн сэргээх хөтөлбөр; төрөл бүрийн техник мэргэжилийн сургалтад хамруулах хөтөлбөр гэх мэт)
- Ажиллах орчин нь аль ч хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хялбар дөхөм байх
- Ажил олгогч нь ажилд орох хүсэлт тавьсан ХБИ-г болон ХБ ажилтанг ялгаварлан гадуурхахгүй байх
- ХБИ-ийн техник, мэргэжлийн дадлагад хамруулах
- ХБИ-ийг шинэ мэргэжил эзэмшихэд нь тусламж үзүүлэх
- Ажил олгогчид нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулан мэдээлэл өгөх, ажлын тусгай байр бий болгох, нэгдсэн журмаар зохион байгуулж буй сургалт, семинарт хамруулах үүрэгтэй.

Швед улсын Үндэсний Статистикаас 2007 онд гаргасан судалгаагаар Швед улсын хүн амын 18,8 хувь буюу 1 сая орчим 16 - 64 насны иргэд ямар нэгэн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй гэжээ. Эдгээрээс ойролцоогоор 600 мянган хүн нь хөдөлмөрийн чадвар буурсан гэсэн тоо гарчээ. ХБИ-н хөдөлмөр эрхэлж байгаа ажлын төрөл чанарыг нь авч үзэхэд дээд боловсрол шаарддаггүй барилга болон аж үйлдэрийн салбарууд байна.

2.6. Чех Улс

Хөдөлмөр эрхлэлтийн хуулийн 67 дугаар зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 3 ангилалд хувааж үздэг :

- а/ Бүрэн тахир дутуу;
- б/ Хагас тахир дутуу;
- в/ Тахир дутуугийн зэрэглэл буурсан;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд сургах, давтан сургах , нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн газраас санхүүжүүлэхээр мөн хуульд заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулахад тохиромжтой ажлын барыг нөөцөд байлгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилуулж байгаа аж ахуйн нэгжийн татвар, хураамжийг хөнгөлж байхаар заасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 78 дугаар зүйлд нийт ажиллах хүчнийх нь 50-иас дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг ажил олгогчид хуанлийн жилийг 4 хуваасны 3-ын эхэнд тэтгэлэг олгох бөгөөд тэтгэлэгийн хэмжээ нь бүрэн тахир дутуу ажилтан бүрт улсын хэмжээний дундаж цалингийн 0.66, бусад тахир дутуу иргэний хувьд 0.33 байхаар зохицуулж, тэтгэлэг олгох нөхцөл журмыг тогтоосон байна. Мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 1-д 25-аас дээш ажлын байртай ажил олгогч нийт ажлын байрны 4 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулахаар зохицуулсан байна.

Мөн хуулийн 82 дугаар зүйлд Хуанлийн жилийг 4 хуваасны 3-ын эхэнд хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд улсын төсвөөс үнэсний хэмжээнд тогтоосон сарын дурдаж цалин 2.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөрийг заавал олгоно. Түүнчлэн ажил олгогч нь хөдөлмөрийн чадвараа алдсан тахир дутуу иргэнийг ажиллуулах үүрэгтэй гэж заажээ.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН





“Бодлогын судалгаа, шинжилгээ”
эмхэтгэл (IX боть) -ийн хавсралт

УИХ -ын 2011 оны хаврын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж
гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа

(Х ботид орсон бусад судалгааны жагсаалт)

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
Нэг. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР		
1	• Гадаадын зарим орны эрүүгийн хуулийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэрэг, “гэмт хэрэгт хамтран оролцох”, талаархи ойлголт, эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа	Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, П. Амаржаргал, Ө. Мөнхтунгалаа, О. Нарантуяа, А. Пагма
2	• Ард нийтийн санал асуулга (Лавлагаа, мэдээлэл)	Ц. Товуусүрэн, П. Амаржаргал
3	• Үндэсний хороо, зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, эрх зүйн статус, үйл ажиллагааны санхүүжилтийн талаархи мэдээлэл (Лавлагаа мэдээлэл)	Б. Мөнхцэцэг, Ө. Мөнхтунгалаа
4	• Улстөрийн намуудын бүтэц, гишүүнчлэл, санхүүжилтийн талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа)	П. Амаржаргал, Б. Буяндэлгэр, Ц. Товуусүрэн, Б. Хатантуул
5	• Хууль тогтоох байгууллага ба парламентын сэтгүүл зүйн харилцааны онцлог, олон улсын туршлага, жишиг хандлага (Харьцуулсан судалгаа)	Ц. Норовдондог (Ph.D), Ц. Болормаа, Д. Мягмарцэрэн, О. Нарантуяа
6	• Мэдээллийн аюулгүй байдлын тухай зарим улс орны эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа)	Ч. Базар (Ph.D)
7	• Монгол Улсын далайн эрх зүйн байдлын тухай мэдээлэл	Б. Мөнхцэцэг
8	• Нийслэл хот дундуур урсан өнгөрдөг гол мөрний ашиглалт, менежмент, нөхөн сэргээлтийн талаархи бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа)	Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Г. Чулуун
9	• Хотын тухай гадаадын зарим улс орны үндсэн хуульд зохицуулсан байдал (Харьцуулсан судалгаа)	Ц. Товуусүрэн, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал, Б. Хатантуул

10	<ul style="list-style-type: none"> Оросын Холбооны Улсын төрийн өмчийн талаахи эрх зүйн зохицуулалт (Лавлагаа мэдээлэл) 	Д. Мягмарцэрэ
Хоёр. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
11	<ul style="list-style-type: none"> Гадаадын зарим орны парламентын өргөдөл гомдлын болон сонгуулийн асуудал хариуцсан хорооны талаархи харьцуулсан судалгаа 	<i>Р. Хатанбаатар, А. Пагма Г. Алтан - Оч (Ph.D) П. Амаржаргал, Ч. Базар (Ph.D)</i>
12	<ul style="list-style-type: none"> Сонгогчдын ирц, саналын босгын талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт 	<i>Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Б. Хатантуул, Ө. Мөнхтунгалаа</i>
13	<ul style="list-style-type: none"> Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах асууд-лаар өдөр тутмын хэвлэлүүдийн нийтлэлд хийсэн контент анализ (Лавлагаа мэдээлэл, 1999 - 2011. 03) 	<i>Ж. Алтанцэцэг, Б. Ариунжаргал, Ө. Мөнхтунгалаа, Б. Мөнхцэцэг, Т. Мягмаржав, Р. Нургуль, М. Оюунтулга, Ц. Янжинцэрэн</i>
14	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн сонгуульд улстөрийн намууд оролцох нь (Харьцуулсан судалгаа) 	<i>Ц.Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал, Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул</i>
15	<ul style="list-style-type: none"> Дэлхийн зарим улс орнуудын парламентын сонгуулийн шууд зарчим (Мэдээлэл лавлагаа) 	<i>Ц. Товуусүрэн, П. Амаржаргал, Ч. Базар (Ph.D), А. Пагма</i>
16	<ul style="list-style-type: none"> Гадаадын зарим орны хоёр танхимтай парламен-тын талаархи харьцуулсан судалгаа 	<i>Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, Б. Буяндэлгэр, П. Амаржаргал, Б. Ариунжаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, А. Пагма</i>





UHH.MN
СУДАЛГААНЫ САН